# МЯНГА НЭГЭН ШӨНИЙН ҮЛГЭР

Өгүүлэх ину: Эрт урьд цагт Энэтхэг ба хятадын арал дээр, амь сахих цэрэгтэй, албат олон зарцтай , эртний Сасан хааны удмын нэгэн хаан байжээ. Тэр хаан хоёр хүүтэй юмсанжээ . нэг нь эр бие гүйцсэн нөгөө нь идэр залуу бөгөөд хоёулаа ихэд баатар зоригтой атал ах нь дүүгээ алдар гавъяагаар арай илүү байжээ . Ах нь улс гүрнээ эзэгнэж , албат иргэдээ захиран нутаг хошуу, улс гүрнээ их л хүндтэй бүлгээ. Ахы нь Шахрияр хаан, дүүгий нь Шахземан хаан гэдэг байжээ . Шахземан хаан Перс газрын Самаркандыг захирах бүлгээ . Ах дүү хоёр тус тусынхаа нутаг хошуунд суурин суж, албат иргэдээ ивээлтэй сайн гэгэдэж, амар жарган суусаар хорин жил болов. Ах хаан нэг өдөо дүүтэйгээ уулзъя гэж бодоод,я Явж дүүгий минь авчир гэж шадар сайддаа зарлиг буулгажээ . Шадар сайд нь эзэн хааныхаа зарлигийг ёсоор болгон явж Смарканд балгад эсэн мэнд хүрч Шахземан хаанд амгалан айлтгаад , ах чинь чамайг ихэд санаж, нэг хүрч ирж уулана уу гэж байна гэсэнд Шахземан даруй зөвшөөрч аян замдаа бэлдлээ . Асар майхандаа ачиж, тэмээ малаа хөллөж, зарц сахиулаа бараа болгоод шадар сайддаа улс гүрнээ захиж үлдээгээд ахын нутаг ус руу их аянд мордлоо. Шөнө дундын үед , шүлэг нойрны эхэнд , нэгэн чухал юм гэртээ мартсанаа санан буцаж ордон өргөөндөө орвол, авааль гэргий нь өөрийн албат нэгэн хар арьс боол зардсан лугаа тэврэлдэн нойрсож байхыг хараад ¤отор нь харанхуйлан “Намайг дөнгөж бөгс өндийхөд ингэж байг а юм, хэрэв урт удаан аянд явбал энэ муу өлөгчин ямар шүү байх нь вэ” хэмээн бодоод сэлмээ сугалан хоёулны нь толгойг тас цавчин алаад даруй мордож хөсөг дээрээ ирж, ахынхаа нутаг хүрэх аян замдаа оржээ .

Ахын хотноо ойртмогц элч илгээж “Би очиж явна” гэж хэлүүлсэнд Шахрияр хаан урьдаас нь тосож, амар мэндийг мэдэж нэн их баярлажээ. Дүүгээ ирлээ гэж хот орноо гоёж чимээд , зэрэгцэн сууж энэ тэрийг хүүрнэлдэн баясах атал, Шхаземан хаан гэргийээ алснаа дурсан санаж, их уй гашуунд автагдаад , царай нь нэг л цонхигор, бие нь нэг л сул байжээ . Орон нутгаасаа холдоод санаа сэтгэл зовиуртай байгаа байлгүй гэж ах нь бодоод юу ч хэлсэнгүй . Сүүлд нь нэг өдөр “Миний дүүгийн би? нэг л сул , царай нь нэг л муу харагдах юм” гэхэд, Шахземан хаан: “Дотор хорсоод байна” гэсэн атал гэргийгээ алснаа ярьсангүй өнгөрчээ . Тэгэхэд нь Шхарияр хаан: “Өнөөдөр чи надтай ан гөрөөнд яв л даа , сэтгэл чинь сэргэж юу магад” гэсэнд дүү нь явсангүй , ах нь анд ганцаараа морджээ . Хааны ордонд гадагш цэцэрлдэг тийш харсан нэгэн цонх байдаг ажээ . Шахземан хаан тэр уонхоор юм харж байтал ордны үүд нээгдэж хроин зарц хорин боол гарч ирсний дараа нь ахын гэргий ,- хомгүй үзэсгэлэнт авхай байжээ . Тэд усан оргилуурын тэнд очиж , цөм хувас хунараа тайчаад, боолчуудтай зэргэлдэн суусанд ахын нь гэргий “Ай Масуд аа!” гэж дуудсанд нэгэн хар арьст боол очиж , авхайг тэврэн авсанд ахай нь ч дуртайяа тэврэлдэн хоёул хэвтэн хэвтэн жаргах бөгөөд бусад боолчууд ч тийнхүү үйлдэн, наран хэлбийтэл тэврэлдэн озолдон байжээ . Үүнийг харсан дүү хаан:

“Аяа Аллах! Миний зовлон үүнийг бодвол юу ч биш” хэмээн санаад хамаг хор шар атаа хорсолд нэгмөсөн арилж нүүр учрахад дүүгийн царай туяаран

гэрэлтээд хуучин зандаа орсныг үзээд: “Аяа дүү минь ээ! Чиний царай базахгүйы билээ . Одоо сайхан болжээ . Юуны учир билээ” гэхэд Шахземан хаан өгүүлрүүн: “Би хэрхэн царай алдсанаа танд ярьсугай. Харин яагаад миний царай сайхан болсныг я ярихгүй шүү” гэхэд нь “Тэгвэл эхлээд юуны учир царай алдаж , бие сулахрсан тухайгаа яриач, би дуулъя” гэж Шахрияр хаан өгүүлэв. Шахземан хаан өгүүлрүүн:

“Ай ах минь мэдэгтүн! Та намайг ирж уулз гэж шадар сайд явуулсанд би аян замд төхөөрч нааш гартал, танд бэлэг болгон өгөх гэсэн эрдэнэ сувдаа гэртээ мартсанаа гэнэт санаад , буцан очоод ордондоо орвол мана гэргий миний орон дээр нэгэн хар арьст боол лугаа унтаж байхуй дор хоёулангий нј алаад нааш гарсан юм . тэгэд тэр явдлыг санхаас сэтгэд тавгүй, бие аягүй байлаа . харин яагаад царай засарсныг ярихаас хэлтрүүлэн соёрхно уу” гэжээ .

Дүүгийн энэ үгийг со-соод, Шхарияр хаан дуу алдан, “Бурхан амлая! Тэгээд яагаад гэнэт царай оров яриач дээ” гэсэн Шахземан хаан өдрийн үзэж харснаа цөмийг нэгд нэггүй ярилаа . “Тэгвэл тэ° явдлыг би нүдээрээ үзнэ ” гэж ах нь хэлээд: “Ан гөрөөнл явсан болоод миний дэргэд нуугд. Тэгвэл өөрийн нүдээр үзэж шнэмших болн” гэж дүү нь хэлжээ .

Хаан даруй аяны бүрээ татуулж , цэрэг цуухаа асар майхантай хотын гадна гаргаад, өөрөө бас нэг майхан шаалгаж суугаад “Энд юуг боловч эс роуулж ” гэж зарцдаа зарлиг буулгалаа . тэгээд зүсээ хувилгаж сэм оргон гарч ордондоо , дүү дээрээ ирээд цэцэрлэг тийш харсан цонхоор харж хэсэг суутал хатан нь шивэгчин эмсийн хамт гарч ирээд болчууд лугаа нийлэн мөнөөх Шхаземан хааны яртсанчлэан үдийн мөргөл болтол цэнгэл үйлджээ . үүнийг нүдээр үсзэн Шхарияр хаан ухаан алдтал хилэгнэн :”Одоо хоёул явж үзье . хэрэв өөр нэг хүнд ийм явдал тохиолддогийг эс олж үзвэл бидэнд хаан ширээ ч хэрэггүй . ингэж амьд яьснаас үхсэн нь дээр!” гэлээ . Тэгээл хоёул шөнө нууц хаалгаар сэм гарч нэгэн өдөр нэгэн шөнө явтал ногоон зүлэгний дунд ганц мод дайралдав. Данст далайн эрэг дээр нэгэн горхи хоржигнон урсана. Хоёул горхийн уснаас ууж амран байтал өдөр болж, гэнэт далайн дунд тэнгэрт тулам гозгор хар юм үзэгдэн нааш айсуй . Ах дүү хоёр ихэд айж модонд (тэр их өндөр мод байв) авиран гараад харвал нэгэн том толгойтой, өргөн цээжтэй бирид толгой дээрээ нэгэн авдар өргөсөөр гарёч ирээд, мөнөөхөн тодны ёроолд сууж, авдраа онгойлгон , дороос нь бас нэг хайрцаг гаргаж нээвэл, наран лугаа зүйрлэвч үзэсгэлэн гоо, сайхан нуруутай , залуухан хүүхэн гарч ирэв. Түүний үзэсгэлэн гоо нь яруу найрагч Атыйн бичсэнээр :

Тас харанхуйн дунд боловч өдөр мэт гэрэлтэн.

Таван өнгийн солонго тэнгэр өөд цацраанам.

Гэгээн тунгалаг царай нь гэрэлт наран мандах шиг

Гүн шөнийн одод боловч түүний дэргэд өнгөгүй

Хувцас юугаа орхиж, бие цогцсоо гаргаваас

Хамаг гайхамшигт бүхэн түүний үзэсгэлэнт булаагднам.

Харин атаа хорслын дунд цахилгаан мэт гялалзвал

Халуун нулимс гарч бороо мэт асгарах ажээ .

Мөнөөх бирид тэр хүүхнийг хараад, “Эрхмийн дээдийг эзэмдэгч чи юутай үзэсгэлэн бэ? ийм гоо авхайг хуримбн шөнө би хулгайлж жоохон унтъя” гээд, хүүхний өвдөг дэрлэн дороо унтжээ . Хүүхэн гэнэт тэргүүнээ өргөн модны оройд хоёр хаан сууж байхыг хараад, биридийн толгойг өвдөг дээрээс сэм өргөж газар тавин босоод”Үүнээс айх хэрэггүй бууж ирэгтүн!” гэж дохио өгөхд нь : “Аяа Аллах өршөө, бид чадахгүй нь” гэсэнд “Бууж ирэхгүй бол биридийг сэрээж үхлийн муугаар ална даа” гэжээ . Ах дүү хоёр модноос бууж ирвэл хүүхэн өмнө нь хэвтээд: “Намайг чанга тэвэрч хүслийг хангагтун , сэ тэгвэл биридийг сэрээнэ ” гэсэн¤Шахрияр хаан иххэд эмээж, өөрийн дүү Шахземан хаанд: “Аяа дүү минь энэ хүүхний тушаасан ёсоор чи үйлд” гэхэд нь “Би чадахгшүй , та урьдаар үйлд ээ” гээд бие биерүүгээ зовох байдал үзүүлсэнд хүүхэн: “Юу болов:. Та хоёрын нщдээ ирмэхийг би үзэж байна. Хэрэв та хоёр надтай миний хүслийг ээлжлэн ханагж сая гүйцвээс “Үүнийг харагтун” гэж хүүхэн өврөөс нэгэн хэтэвч гарган үзүүлээд “Энэ юу бөгж болохыг та хоёр мэднэ үү” гэхэд нь ах дүү хоёр “Мэдэхгүй ” гэсэнд “ЭНэ бүхнийг би, энэ биридийн өвөр дээрээс бусад лугаа цэнгэл үйлдэн авсан юм даа , та хоёр бас нэг нэг бөгж өг” гэлээ . Ах дүү хоёр гартаа байсан хоёр бөгжийг сугаож өгсөнд “Энэ бирид намайг, миний хуримын шөнө хулгайлж энэ хайрцагт хийгээд бас авдарт хийж долоон цооуоор цоожлон энэ давалгаалагч ыдалайн ёрооолльд хаясан атал эмэгиэй хүн юү хүсвэл , түүнийг хэн ч хорьж чаддаггүйг мэдэхгүй ажээ . Эм хүний тухай нэг яруу найраг:

Эм хүн битгий итгэ

Элдэв үгэнд нь бүү хуурт

Заяанаас тэд ганцхүү

Залилах, хорсох тавилантай,

Хуурамч дур сэтгэлээ

Хувцас юугаар халхалмуй

Иосифийн амьдралаас сурвал

Эдний хуурмагийг мэдмүй

Эцэг Адам чинь үүнээс болж

Үүрд зайлах болсон ажгуу”

гэсэн юм .

Өөр нэг яруу найрагч:

Хайрт хүний хараалаас дор заягүй чи минь.

Харин миний явдал чиний санасанд эс хүрьюү

Эм хүнл сэтгэлээ өгөхдөө би.

Эр хүний эртнээс сурсныг үйлднэм.

Эмсийн царайд автаагүй хүн л

Энэнийг нэн гайхах буй заа

Гэсэн юм угэлээ .

Энэ үгийг сонсоод ах лүү хоёр хаан нэн гайхаж , “Ай зайлуул энэ бирид бид хоёроор бүр дор залилуулжээ . ийм явдал өөр хэнд ч тохиолдоогүй биз” гэлцэв.

Тэгээд адруй эргэж , Шахрияр хааны ордонд ирсэнд Шхарияр хаан, өөрийн гэргий, боол шивэгчин нарын цөмийн толгойгий нь тас цавчив.

Тэгээд даруй эгж, Шхарияр хаан шөнө болгон гэнэн бага охидыг аваачиж эдлэн цэнгэж хоноол маргааш нь алдпаг болсоор гурван жил болоход амьтан хүн охин хүүхдээ авч зугтсаар ё сүүлдээ тэр хотод нас бие гүйцсэн нэгээхэн бээрч залуу хоид бараг эс үлджээ . гэвч хаан мөнөөхөн заншлаараа нэг хүүхэн авчир гэж шадар сайддаа тушаасанд өдөржин яваад олсонгүй , орой нь их л уруу царайтай гэртээ харьжээ . Энэ шадар сайдынх хоёр хоинтой бөгөөд эгчий нь Шхарзада , дүүгий нь Дуньязада гэдэгб айжээ . Эгч нь түүх шасдир эртний хаадын явадл , ардын үлгэр тууль их үзэж , эртний хүн ардын урьдын хаад яруу найрагчдын тухай мянган дэвтэр цуглуулсан байжээ . Тэр охин эцэгтээ: “Та нэг л санаа зовуурьтай , уруу царайтай байх чинь юуны учир билээ . Урьд нэг шүлэгч :

Гуниг зовлон мөнх биш гэж

Гуньсан хүн үүнийг мэдтүгэй

Хөхүүн баячр дуусахын сацуу

Хүнд бодол даруй аримуй

Гэсэн юм шүү гэхэд тэр сайд уг явдлаа нэгд нэггүй ярьсанд охин нь шууд дуун алдаж: “Ай эцэг минь Аллах тэнгэр мэдтүгэй. Тэр хаандаа намайг аваачиж өг . нэг бол би амьд гарна, нэг бол лалын шажинт бүх охидыг төлөөлөн , тэднийг хааны харгис цаазнаас аварна. Үүнээс өөр ямар ч арга байхгүй” гэсэнд “Нэгэн газрын эдний үхэр илжиг хоёрын үлгэр шиг юм болох бий гэж би их л эмээж байна дээ” гэлээ . “Тэр яасан юм бэ?” гэж Шахразада асуужээ .

## ҮХЭР, ИЛЖИГ ХОЁРЫН ҮЛГЭР.

“Охин минь мэдтүгэй! Урьд өнөр их бүлтэй, өтгөн сүрэг маотай, нэг баян худалдаачин байжээ . Бас Аллах тэнгэрийн өршөөлөөр адгуусан амьтан, жигүүртэн шувууны хэл мэддэг ажээ . хөдөө тосгонд суудаг атлаа гэртээ нэг үхэр, илжиг хоёр тэжээдэг юмсанжээ . Нэг өдөр үхэр, илжигний баранд орж үзвэл жигтэйхэн сахан цэвэрхэн бөгөөд эзэн хааяа юманд явбал унах боловч онц удаан явдаггүй ажээ . нэг өдөр эзэги дуулж байвал үхэр:

“Чи сайхан байна! Би их ядарч байхад чи амарч хэвтэх юм . Чамд шигшсэн тариа өгч , сайхан асарч, эзэн хааяа түргэн зуур юманд явбал унах юмаа . Тэгэхд би дандаа газар хагалж тээрэм эргүүлэх юм даа” гэж илжигэнд хэлэхэд: “Чамайг тариалан дээр аваачиж, хүзүүнд чинь буулга углахтай зэрэг хэвтчих. Тэгээд зодсон ч битгий бос, боссон ч дахиад хэвчих. Тэгэхрээр чамайг буцааж авчраад түрэг шош тавьж өгөх бий . Өвчин хүрсэн байдал гаргаж битгийидээрэй. Тэгээд

хоё, гурав хоног юм идэхгүй , ус уухгүй байж хүнд ч ажил ч хихйгү амарч орхихгүй юу" гэж илжиг хэлжээ . ингэж ярилцахыг нь х худалдаачин сайн сонсожээ . маргааш орой нь а аилчин үхэртээ тэжээл тавь¦ өгсөнд тун бага идсэн агаад өглөө болж үхрээ хөдөлөх хэмээн ирвээ± өвчин туссаныг үзээд ихэд гашуудан"ай залуул , энэ үхэр өчигдөр даанч ажил хийж чадахгүй байсан юм! Үхэр маань ажилд гарч адахгүй болжээ . Өчигдөр оройноос х®йш хэлэн дээрээ юу ч тавьсангүй гэж хэлжээ .

Эзэн уг явдлыг мэдэх тул "Үхрийн оронл тэр илжигийнг хөллөөд өдөржин газар хагал" гэжээ . илжиг өдөржин угазар хагалж орой ирэхэд нь тэр өдөр хүнд ажлаас ангижрууллаа гэж үхэр тал өгөхөд илжиг юу ч хэлсэнгүй . маргааш нь бас өпөржин газар хагалсан илжиг орой нь хүзүү нь холгогдоод, үхтэл ядарсан байжээ . Үхэр мөнөөхөн илжгийг хаараад магтан тал зассанд илжин "Би тэрийтэл амарч хэвтдэгсэн. Урт хошуунаасаа боллоо доо" гээд "Харни чамд би юм нуулгүй хэлдэг шүү . хэрэь үхэр босож өгөхгүй байвал яргачинл өгч орхи. Яргасан алж, арьс ширий нь зүсэж орхино биз гэж эзэн ярьж байна билээ . Чамайг хайрласандаа би хэллээ дээ" гэжээ .

үхэр илжигний энэ үгийыг сонсоод "Тэгвэл маргааш би ажилд гарна" гэж хэлээд тавьж өгсөнн тэжээлий энь цөмий нь идэж тэвшийг долоожээ . Тэгж яриалцахы нь эзэн бас дуулсан байжээ . Маргааш өгдөө худалдаачин хараад инээд алджээ . Тэгэхээр нь эхнэр нь "Чи юунд инээв?" гэхэд нь "Би нэг нууц юм дуулаад инээд хүэр.в Гэвч хүнд хэлэх юм бол би өөрөө үхэх юм" гэхэд "Үхсэн ч хамаагүй тийнхүү инээсэн учраа заавал ярьж аль!" гэхэд нь "Би тэр нууцыг хэлж чадахгүй , үхэхээс айж байна" гэлээ . Тэгтэл эхнэр нь бүр сүйд болж "Чи тэгвэл намайг шоолсноос зайлахгүй" гээд нойтон хамуу шиг шала д салхгүй б болохоор нь аргаЈүй ярих болж , урьдаар хүүхдүүдээ дуудаж, айлынхаа улсыг цуглуулж , гэрээс захиагаа захиад мөнөөхөн нууцаа эхнэртээ хэлээд үхэхээр шийджээ . Тэр худалдаачин уул нь эхнэртээ туйлын хайртайы бөгөөд өөрөө зуун хорин нас насалжээ . Тэгээд худалаачин садангийнхаа улс, гудамжныхаа хүмүүсийг цугий нь дуудаж авчраад уг болсон хэргийг яриад "Хэрэв тэр нууцаа хэлбэл би өөрөө үхэх юм" гэхэд нь

"Ая бурхан тэнгэр минь ! Түүнийг хэлүүлж эр нөхрөө , үр хүүхдүүдийнхээ эцгийг үхүүлж юу хийнэ " гэж цугларсан улс цөм нэгэн зэрэг өгүүлэхэд "Би хэлүүлэхээс наш салахгүй, үхсэн ч хамаагүй! гэж эхнэр нь өгүүлжээ . Тэгэхээр нь худалдаачин гарч тэнгэо бурханд мөргөж ирээд нууцаа ярьж үхэхээр болж гада гарчээ . Тэднийх тавин эм тахиа, нэг азарган тахиа бас нэг нохой тэжээдэг байжээ .

Тэгтэл нохой нь азарган тахианд уурлан хуцаж "Эзэн маань өнгөрөх гэж байхад чи баярласан юм шиг бархирч байна гэлээ!" гэсэнд "Яагаад үхэх гэж байгаа юм бэ?" гэж азарган тахиа асууасанд нохой ийм ийм хэрэг болсон гэж цугий нь ярьсанд "Аяа Аллах! Манай эзэн ютай ухаан муутай билээ . Би тавин эхнэртэй нэгІээ нь муудвал нөгөөтэй нь наалдаж орхино. Манай эзэн ганц эхнэртэй атлаа түүнтэй яаж байвал таарахыг мэдэхгүй юм даа? Ялман модны мөчир хугалж аваад эхнэрээ илүү гэрт оруулж дахиад юм асуухгүй болтол нь үхтэл нь ороолгож олроолгож орхихгүй юу" гэжээ .

Худалдаачин азарган тахианы үгийг сонсоод, эхнэрээ хэрхсэн шиг би чамайг тэгнэ дээ гэж хааны шадар сайд Шархразада охиндоо яртал, “Тэр худалдаачин тэгээд яасан бэ? ” гэж Шархразадаг асуухад хааны шадар сайд өнгөрүүлэн:

- Тэр ялман модны мөчир хугалж илүү гэртээ нуугаад эхнэрээ дуудаж: “Энд яръя, миний үхэхийг хэн ч бүү хараг” гээд эхнэрээ оруулж үүдийг нь түгжиж байгаад балбаж гарсанд эхнэр нь арайл ухаан эс алдсан бөгөөд “Би хаширлаа!” гэж байдгаараа хашгаран эр нөхрийн хөл гарыг үнэсэж гуйсан юм гэнэ. Тэгээд тэр хоёрыг гарч ирэхэд төрөл, садан , айл хунарын улс ихэд баярлаллдсаэн агаад тэр хоёр ч насан турш их эвтэй болсон юм гэдэг гэлээ .
- Охин эцгийнхээ үгийг сонсоод “Би ямар ч гэсэн санасанаа хийнэ” гэжээ .
- Хааны шадар сайд охиноо гоёж, Шхарияр хаанд аваачих болов. Шхаразада дүүдээ сурган: “Би хаанъл очоод чам руу хүн явуулна . Чи ороод , хаан надаар зугаагаа гаргаж гүйцсэн шиг байвал “Ай эгч минь ээ , энэ шөнийн уртад бидэнд сонин үлгэр ярьж өг гээрэй. Тэгэхлээр б ямар нэг юм ярьж Аллах тэнгэрийн хишгээр бид хоёр амь нас гарах болно” гэжээ .
- Хааны шадар сайд охиноо дагуулж хааныд орвол хаан баярлан угтаж “миний хэлснийг олов уу? ” гэсэнд шадар сайд “Оллоо!” гэжээ .
- Шхарияр хаан Шахразада охиныг авч орох гэтэл охин уйлсанд “Юу болов” хэмээн хаан асуужээ . “Аяа хаан минь, би нэг бяцхан охин дүүтэй билээ . Түүнтэйгээ эцсийн удаа уулзах юмсан” Јэсэнд хаан Дуньязада руу хүн явуулж авчруулсанд Шахразада дүүгээ тэврэн хааны түшлэгийн дэргэд шалан дээр суулгажээ . Хаан Шахразадатай цэнгэл үйлдээд ярилцаж суухад дүү нь эгчдээ: “Чамайг бурхан өршөөх болтугай! Эгч минь энэ шөнийн уртад нойр хрэхгүй хэцүү тул үлгэр ярьж өгөөч” гэв.
- “Хаан зөвшөөрвөл би дуртайяа ярихад бэлэн байна” гэсэнд хаан нойр нь хүрэлгүй ядаж байсан тул энэ үгийг сонсоод баярлан үлгэр ярь ярь гэлээ .

АНХНЫ ШӨНӨ

**Шахразада өгүүлрүүн:**

“Аяа жаргалтайхан хаан минь ээ! Урьд эрт цагт ертөнцийн олон орноор явж худалдаа намаа хийдэг туйлын баян нэгэн худалдаачин байжээ . Нэг өдөр өөр улс гүрэнд очиж өр нэхэхээр гарч, халуун наранд ядраад нэгэн модны сүүдэрт бууж, богцоо уудлан боов боорцог, хасарваанийн жимс гаргаж тамшаалан илдэж суужээ . Хасарваанийн жимс идэж ясы нь хаяад харвал өмнө нь илд далайсан нэг их өндөрбирид гарч ирээд “Чи хүүгий минь алаь. Би чамайг ална даа!” гэсэнд: “Би хүүгий чинь чаж алав?” гэхэд “Чи хасарваанийн жимс идэхдээ ясы нь чулуудахдпаа миний хүүгийн цээжинд онож дор нь алав” гэлээ Худалдаачин дуу алдаж : “Чин үнэнээс бид хүчин төгс Аллах тэнгэрийн дор шүү! Хэрэв би хүүгий чЁнь алсан бол санамсаргүй хэрэЈ мөн” гэсэнд: “Ямар ч гэсэн чамайг заавал ална ” гээд бирид худалдаачинг гуд татаж газар унагаад , илдээ далайсанд хуладаачин уйлж “Аллах тэнгэр өршөөх болтугай!” гээд нэгэн шүлэг хэлсэн нь:

Хувь зохиолд аюултай өдөр ч бий , амгалан өдөрч бий,

Хзний амьдралд баяр ч бий, гуниг ч бий,
Эндүү ташаа явдлаар бид бүхнийг зэмлэгч
Эрхтэн ямбатан хүнд ингэж хэлбэл таарна.
Хуй салхин дэгдэн эрчлэхийн цагт
Хүчирхэг том мод боловч эрх биш бөхийдөг биш үү.
Их далай дээгүүр үхдэл хүүр хөвж харагдаюч
Эрдэнэ сувд нандин нь ёроолдоо байдаг биш үү !
ХУвь заяагаар минь тоглож
Хойчийн зовлонд унагах гэвэл чи
Хурмаст тэнгэрт түг түмэн од мичид байтал
Үнэндээ наран саран хоёр л хитэдгийг мэдтүгэй.
Үхсэн амьд үй түмэн ургамал ногоо байтал
Үр шимтэйгий нь олж хөнөөдгийг мэдэгтүн
Хувьта төрсний эрхээр чи, муу хөнөөлийг үзэлгүй
Хорвоогийн олон хоногийг амгалан сайн өнгөрөөжээ .

Гжэ шүлэглэн , бирид “Олон юм бүү ярь! Ямар ч гэсэн чамайг заавал ална ” гэсэнд худалдаачин, “Ай бирид чи сонс! надад эд мөнгө, эхнэр хүүхэд, өр шир, өглөг авлага цөм бий. Би харьж өр ширээ өгөөд он жилийн адгаар ирье. Заавал эгж ирнэ гэж чамд Аллах тэнгэрийг барьж ам өгсүгэй. Тэгээд чи яавал ч яагаарай . Аллах тэнгэр гэрч шүү” гэлээ .

Бирид худалдаачны энэ тангаргийн сонсоод, түүнийг тавилаа . худалдаачин нутагтаа ирж өр ширээ өгя, хэрэг явлаа дуусгаж энэ бүхнЅэ эхнэр хүүхэддээ хэлж захиа занаа болж жил дуустал хамт байгаад гэр орон айл саахалт төрөл садангийн улстайгаа салах ёс гүйцэтгээд , дүүрсэн хэрэг явахад нь тэд уйлж хайлан хоцорчээ . Худалдаачин мөнөөхөн модны дэргэд очиж уйлан суутал нэг шаргачин хөтөлсөн өвгөн ирж амар мэндий нь асуугаад “Биридээс өөр амьтангүй энэ газар чи ганцаар юунд суунам?” гэсэнд уг явдлаа цөмийг тоочвол “Аяа тэнгэр минь, чи хойч хойчийн үед сургаал болмоор юутай үнэнч хүн билээ . тэр бирид яамайг яахыг үзэхээс нааш би эндээс явахгүй” гэж өвгөн хэлэв. Тэр хоёр хүүрнэлдэн сууж худалдаачин эмэн чичрэн их л гаслан суутал, хоёр хар нохой хөтөлсөн бас нэг өвгөн ирж “Биридээс өөр амьтангүй энэ газар та хоёр юу хийж суунам? ” гэсэнд уг явдлыг эхнээс нь аваад адаг хүртэл цөмийг ярьтал бас нэгэн алаг илжигтэй өвгөн ирж, тэднийг юунд энэ газар банам гэхэд нв учир явдлыг цөмийг нь хэлжээ . Гэтэл гэнэт тэнгэрт тулсан хуй эргэлдэн ирж замхартал мөнөөхөн бирид нүднээс нь оч манаруулан илдээ сунган гарч ирээд худалдаачны гараас шүүрэн авч “Бос! Чи голт зүрхний хайрт хүүгий минь алсанчлан чамайг би одоо ална даа!”гэсэнд худалдаачин , гурван өвгөн цөм уйлж, халж смүйд боллоо .

Мөнөөхөн шаргачин хөтөлж ирсэн өвгөн босож биридийн гарыг үнсээд , “Би энэ шаргачин лугаа нэн сонин учир явдал болсныJ ярьж өгвөл чи энэ худалдаач-ы халуун цусны гуравны нэгхувийг хэлтэрүүлэх үү?” гэсэнд “Хэрэв чиний ярих зүйл үнэхээр гайхалтай сонин санагдваас өгнө” гэжээ .

*НЭГДҮГЭЭР ӨВГӨН ӨГҮҮЛРҮҮН:*

”Энэ шаргачин бол миний нагацын охин билээ . Залуу ахуйд нь би гэргий болгож аваад гучин жил суусан атал үр заяасангүй . тэгэхээр нь нэгэн татвар эм авсанд наран саран лугаа адилтгаваас зохилтой сайхн хүү төрүүлж , тэр хүү маань торнисоор арван таван нас хүрэхийн цагт би элдэв сайхан эд бараа авё өөр нэг хол орохоор явлаа . миний нагацын охин , одоо энэ шаргачин илбэ шид сураад миний хөвгүүнийг тугал, мөнөөхөн татвар эмийг үнгээ болгоод малчинд өгчээ . Олон жил аян явдал хийж буцаж ирэхэд минь манай авааль гэргий : “Эхнэр чинь үхэж, хөвгүүн чинь оргоод явсан, хаана явсныг мэдэхгүй” гэжээ .

Олон сар энэлэн санаж явтал Аллах тэнгэрийн их баярынг өдөр болж , би малчин хүнд , нэгэн тарган үнээ аваад ир, алж идъё гэсэнд нэгэн тарга үнээ авчирсанд тэр нь минийммөнөөхөн татвар эм байжээ . Би хормой шууж хутга барьсаар очиход минь их л зовлонтойгоор энэлэн шаналан мөөрөхөөр нь өрөвдөөд тавьж “Өөр үнээ авчир! ” гэж малчин хүнд хэлсэнд миний энэ гэргий “Заавал үүнийг ал, өөр тарган юм байхгүй” гэлээ . Тэгэхээр нь алъя хэмээн очтол бас л учиргүй энэлэн мөөрөхөөр нь үүнийг чи алж өвч гэж малчиндаа тушаалаа . Малчин Малчин тэр үнээг алч өвчсөнийг үзвэл ёстой яс арьс байсанд ихэд гэмшин мөнөөхөн малчинд өгөөд “Нэг тарган тугал авчир” гэлээ . Малчин нэг тугал авчирсанд хүзүүвчээ мульлан миний дэргэд гүйж ирээд над эрхлэн шөргөөсөнд би нэн уярч өрөвдөөд “Өөр тугал авчир!” гэж хэ«сэн боловч миний нагацын охин , одоо энэ шарг чин “Энэ тугалыг заавал өнөөдөр алж идье. Бурхны сайн өдөр хамгийн тарган сайны нь алж идэх ёстой атал үүнээс өөр илүү тарган тугал хаана байх билээ” гэв.

“Чиний ал ал нгээд байсан үнээ ямар байлаа даа, ямар чүр ашиг гараагүй нь гэмшивч баршгүй хэрэг болсон шүү . Энэ тугалыбг яасн ч алахгүй ” гэсэнд “Аяа тэнгэр минь бурхны энэ ариун өдөр энэ тугалыг заавал алж идэх билээ . Эс тэгвэл чи бид хоёр сална” гээд салахгүй тул би түүний далд санааг яахин мэдэх билээ . Хутгаа бариад очтол..” гээд Шахразадагийн хувьд нэг шөнө өнгөрч үлгэрээ таслан зогстол дүү нь дуу алдан, “Юутай сайхан сонин үлгэр вэ? ” гэсэнд Шахразада :

“АХэрэв хаан таалж намайг өршөөн соёрховол сонин үлгэр ярина!” гэлээ .

Хаан “Энэ үлгэрийг гүйцэд дуулахаас нааш, Шахразкадаг хороохгүй ” гэж охин лугаа өглөө болтол жарган жарган унтаал, өглөө төрийн хуралд морилон орохд шадар сайд нь бэлбэрсрэлийн цагаан хувцса сугавчилан ирсэн байжээ . Хаан, төрийн хэрэг шийтгэсээр үдэш бож өөр юм хэлсэнгүй гэртээ харихад шадар сайд ихэд гайхжээ .

## ХОЁР ДАХЬ ШӨНӨ

Дуньязада “Аяа эгч минь ээ!” Худалдаачин бирид хоёрын үлгэрээ ярьж өгөөч!” гэхэд Шахразада : “Хаан соёрхон айлдваас дуртайяа ярьсугай” гэсэнд Хаан “Ярь ярь ” гэлЅэ .

Шахразада үргэлжлүүлэн өЈүүлрүүн:

“Өвгөн тэр тугалыг адах гэтэл сэтгэл түвдсэнгүй. “Буцааж тавь , ер нь чи ав гэж малчинд өгчээ. Маргааш нь тэр малчин ирж, “Ноён минь, би танд гайхалтай хачин юм яривал та лав таалж өчүүхэн над хишиг хүртээх буй за” гэхээр би за ярь гэсэнд “Аяа ноён минь ээ, би хар багаасаа ид шилд сурсан нэгэн охинтой билээ . Өчигдөр таны өгсөн тагалыг авч харьсанд миний охин хараад нүүр амаа даран цурхиртал уйлснаа учиргүй инээж эцэг минь ээ, та айлын хар хүн над авчирч өгдөг нь юу билээ? ” гэхэд нь юуны чинь айлын хар хүн хаана байна, чи юунд уйлж инээв? гэхэд минь энэ тугал бол манай эзэн худалдаачины хүү байна. Ид шидээр энүүнийг тугал бол манай эзэн худалдаачны хүү байна. Эх үнээг энэ хүүгийн эцэг нь алжээ хэмээсэнд би нэн гайхаж өглөө наран мандмагц яаран гүйн ирж танд айлтгаж байгаа минь энэ билээ гэв.

Би малчны энэ үгийг сонсоод тэсгэлгүй баярлан түүний гэрт очиход малчны охин гары минь үнэсээд, бас нөгөө тугал ирж намайг ихл тааламжтай шөргөөв. “Энэ тугалын тухай чиний хэлдэг үнэн юм уу? ” гэж асуусанд “Аяа эзэн минь , энэ таны хүү яах аргагүй мөн” гэхэд нь “Аяа охин дүү минь , хэрэв чи энэ тугалыг хуучин занд нь оруулж өгвөөс байдаг мал хөрөнгө зөөрөө чам¤ өгье” гэлээ . Охин инээмсэглэн , аяа ноён минь би мөнгөнд шунадаг хүн биш, харин нэгд хүүгээ надтай суулгавал , хоёрт энэ хархүүг тарнидаж мал болгосон хүнийг бас тарнидаж өөр амьтан болгохыг соёрхвоос энэ хүүг дор нь хүн болгож чадна гэв.

Энэ үгийг сонсоод”Энэ юуч биш , миний мал хөрөнгийг цугий нь аваад ч багадна. Миний гэргийг яасан ч хамаагүй” гэсэнд охин нэгэн аяганд ус хийж, шившин тугалд цацаад, “Аяа тугал чи их Аллах тэнгэрийн заяаснаар угаас ийм дүрстэй байсан аваас тэр, хэрэв өөр байгаад ийм болсон бол хуучин зандаа ор!”гэтэл тугал биеэ нэгэнтээ сэгсрээд хрүн дүрсээ олсонд би тэврэн аваад”Аяа Аллах тэнгэр минь , миний нагацын охин гэргий та хоёрыг сүйд болгожээ . Аяа Аллах тэнгэр өршөөж хүүгий минь хуучин занд нь оруулж хүн болголоо доо!”гэлээ .

Тэгээд мөнөөхөн малчны охиныг эхнэо болгон авч өгсөнд бэр маань миний нагацын охиныг энэ шаргачин болгоод ”Энэ бол тийм ч зэрлэг муухай дүрс биш” гэж билээ .

Тэр охин манай бэр болж олон жил жаргалтай суугаад насан эцэс босонд миний хүү одоо энэ худалдаачны нутаг Энэтхэг оронд одсон бөгөөд би энэ төрөл арилжсан шаргачинтайгаа орон орон хэсэж явсаар энд иртэл , энэ худаолдаачин уйлан хайлан сууж байгаа нь энэ буюу гэсэнд Бирид “Энэ үнэхээр нэн сонин явдал байна. Чиний төлөө энэ худалдаачны мах цусны гуравны нэг хувийг чамд өгье” гэлээ .

Гэтэл мөнөөхөн хоёр нохой дагуулсан хоёр дахь өвгөн хэрэв , би миний ах болох энэ хоёр нохойн тухай илүү хачин гахалтай үлгэр хэлбэл яи энэ худа«даачны гуравны нэг хувийг хэлІрүүлэх биз” гэсэнд бирид зөвшөөрч чиний ярих үлгэр үнэхээр хачин сонин болбол өгнө гэв.

*ХОЁРДУГААР ӨВГӨН ӨГҮҮЛРҮҮН:*

“Энэ хоёр нохой бол миний хоёр ах билээ . манай эцэг үхэхдээ бид гуравь гурван мянган динар үлдээсэнд бид нэг нэг пүнз гаргаж наймаа хийлээ . гэтэл манай нэг ах одоо энэ нохой , байдаг юмаа нэгэн мянган динараар зараад эд бараа, элдэв зөөр авч алс газар арилжаа наймаа хийхээр гарсан билээ . Жил болсны хойно манай пүүсэнд нэгэн гуйлагчин орж ирсэнд би түүнийг ихэд өрөвдөөд , “Тэнгэр чамайг танихгүй байна уу?” гэхэд нь сайтар ажиглан харвал ах минь байлаа . Би ихэд баярлан амар мэндийг асууж , пүүсэндээ ашиг хожоог бодож үзвэл хоёр мянган динар болсон байхад, нэгэн мянгыг ахдаа өгч “За үүнийг ав, харь оронд битгий яваарай!” гэсэнд тэр тэсгэлгүй баячрлаж , бас нэгэн пүүз гаргалаа .

Гэтэл тэр ах одоо энэ нохой нь бас “Хамаг юмаа худалдаад их аян замд явна” гэхэд нь бид хоёр “хэрэггүй” гэж хичнээн хэлээд болсонгүй эд бараа худалдан авч ачаад, аян явдал хийхээр явлаа . Нэг жил болоод бас л нөгөө ахын адил гуйлагчин болоод буцаж ирэхэд нв “Явж хэрэггүй гэж эс хэлэв үү” гэсэнд “аяа дүү нар минь би тийм заяа муутай бажээ . Одоо сохор зоос ч үгүй , өмсөх цамц ч үгүй гуйлагчин боллоо” Јэж ихэд уйлав. Би биеий нь угааж хувцас өгөөлд гартаа аваачиж сайн хоол идүүлэв. Би жилдээ нэгэн удаа дансаа боддог билээ . “Энэ удаагийн олз хичнээн болсон арваас хоёцул хувааж авна” гээд дансаа бодсонд хоёр мянган динар зоосны олз олжээ . нэгэн мянган динар коосыг ахдаа өгсөнд тэр бас нэгэн дүүз гаргаж хоёр удтал амвдран суулаа .

Гэтэл нэгэн өдөр хоёр ах орж ирээд “Хоёул аянд явъя” гэхэд нь “Чи түрүүнд яваад ямар олз ашиг олсон билээ? Би явахгүы ” гээд явсангүй , гэтэл хоёр ах намайг жил болгон “аянд явъя” гэсээр зургаан жилийн нүүр үзэхэд , сүүлдээ би “явбал ч явъя” гээд, “харин бидэнд хичнээн хөрөнгө байгааг тоолж үзье” гэлээ тэгсэн чинь хоёр ахад нэг ч зоосны олз гарсангүй. Би юм хэлсэнгүй, ирж өөрийн пүүзний дансгы бодвол нийт зургаан мянган динар зоосны олз ашиг олсон байлаа . Би нэн их баярлаж , тэн хувааж гурван мянган динар зоосыг , хэрэв аянд яваад ” олз ашиг олсон байв. Би нэн их баярлаж , тэн хувааж гурван мянган динар зосыг , хэрэв аянд олз омоггүй балран ирвээс бидахин пүүз гаргах болно гэж газар булаад, үлдэх гурван мянган динар зоосыг үзүүлэн энэ бол бидний аянд хэрэглэх хөрөнгө хэмээн мянга мянгаао нь хуваан авч эд бараа авч , далайн онгоц хөлслөн их аянд хөдлөв. Сар хиртэй явж нэгэн хотноо хрсэнд нэгэн зоосыг арван зоос болтол олз ашиг олж буцах хэмээтэл далайн эрэг дээр уранхай хувцастай залуу бүсгүй дайраолдан “Аяа ноёнтон танд тал өгвөөс над хишиг буян хүртээх үү?” гэсэнд би “Хүнд өглөг буян өгөх дуртай хүн , чи тал эс өгсөн ч хамаагүй” гэхэд минь “Тэгвэл та намайг гэргий болгон авч нутагтаа аваач, би бүх амь биеэ танд зориулна . Би сайн санааны үүднээс ханилан таныг хэрхэвч хууран мэхлэхгүй” гэлээ .

Залуу хүүхний энэ үгийг сонсоод миний сэтгэл ихэд уярч, Аллах тэнгэрийн өршөөснөөр түүнийг авч сайхан хувцаслаад хөлөг онгоцонд нэгэн сайн байр гарган өгч цааш хөдөллөө . Сүүлдээ би түүнд их хайртай болж өдөр шөнө боловч цуг бадаг босон тул митний хочр өдө шөнө боловч цуг байдаг болсон тул миний хоёр ах над жөтөөрхөн эд мөнгөнлд минь шунаад намайгш алж мөнгий минь авахаар сэт явцгаажэ . тэд ийнхүү чөтгөрийн муу санаа өвөрлөн намайг гэргийн хамт унтаж байх үед сэм орж ирээд бид хоёрыг далайд хаяжээ . Миний гэргийгг сэрж , нэгэнтээ хөрвөөгөөд айшхи эм болон хувирч намайг нэгэн арал дээр гаргав. Тэгээд нэгэн хэсэг алга болж өгдөө болсон хойно эргэж ирээд "Би нэгэнл чиний гэргий тул Аллах тэнгэрийн өршөөлөөр амий чинь аварлаа . Би хэдийгээр айшхи эм боловч чамайг анх үзээд хайртай сэтгэлтэй болсон агаад аугаа их хүчит Аллах тэнгэрт их сүжигтэй билээ . Харин гагцхүү чиний хоёр ахад ихэд өших тул заавал амий нь хорооно" гэхэд миний амийг авсанд чинь баярлавч баршгүй , харин миний хоёр ахыг битгий алаарай гээд хоёр ахынхаа явдлыг нэгд нэггүй яртсанд тэр бээр "Би энэ шөнө нисэн очиж хөлөг онгоцыг живүүлэн, тэр хоёрыг хөнөөнө" гэхэд нь би, "Хэрэггүй битгий тэг , үйл муутын заяа муу гэж байх боловч, тэр хоёр ямар я гэсэн миний төрсөн ах шүү дээ" гэлээ . тэгээд өршөөн хэлтрүүлэхийг гуйсаар байтал нэг мэдэхэд намайг байшингийн минь дээвэр дээр авчираад тавьчихсан балаа . Гэрт орж мөнөөхөн булсан мөнгөө гагаж дахин пүүз гаргаад, амар сайхан жаргаж байхдаа нэг орой гэртээ буцаж ирэхэд минь манай хашаанд энэ хоёр нохой уяатай , намайг харангуут гингэнэн гаслан эрхэлж билээ . Гэтэл манай гэргий гарч ирээд энэ хоёр нохой бол чиний хоёр ах мөн гэхэд нь "Хэн ингэв?" гэвээс "Би эгчээ ирүүлж , ийнхүү үйлдэв. Арван жил болохоос наашэнэ хоёр хүн төрөхдөө буцаж орохгүй " гэлээ . Тэгээд би тэхүү эгчий нь олж энэ хоёроо буцааж хүн төрөлд нь оруулахаар явтал энэ худалдаачин дайралдаап , "Бирид чөмайг яахы нь үзэх гэсэн минь энэ бүлгээ гэсэнд бирид "Энэ тун хачин явдал байна. үүний тул худалдаачны амины хувийг хэтрүүлье" гэсэнд мөнөөхөн илжиг хөтөлсөн өвгөний ээлж болж "Би энэ хоёрын үлгэрээс улам сонин явдал яривал чи энэ худаолдаачны үлдсэн амийг хэлтрүүлэх үү" гэсэнд "тэгнэ" гэжээ .

*ГУРАВДУГААР ӨВГӨН ӨГҮҮЛРҮҮН:*

"Энэ илжиг бол миний гэргий билээ . Би урьдаас алс холын аянд яваад жил болж , нэгэн шөнө буцаж харьсанд эхнэр минь хар арьст боол лугаа нэгэн өвөрт их л таалажтай озолдон хэвтсэн агаад намайг орж ирэхийг харангуут шанагтай ус аўч "нохой бол" гээд над дээр ца¶санд би тэр дороо нохой боллоо . Тэгээлд намайг гэрээс хөөж гагасанд би тэнэсээр нэгэн махны худалдаачны гадуур очиж, яс мэрж байтал тэр худалдаачин харж, намайг гэртээ оруулсанд худалдаасны охин нүүрээ таглан дуу алдаж "Аяа та юунд эр хүн дагуулж над дээр орнмо?" гэхэд нь эуэг нь "Юун эр хүн?" гэж хариу асуужээ . охин "Энэ нохой бол эр хүн бөгөөд эхнэр нь илбэдпэн ийнхүү нохой болгожээ . Би дахин хүн төрөлд нь оруулж чадна" хэмээвээс эцэг нь охиныхоо энэ үгийг сонсоод дуун алдан өгүүлрүүн "Аяа охин минь чамайг Аллах тэнгэр таалах болтугай, энэ хүнийг дахин хүн төрөлд нь оруулаач" гэлээ . Охин шанагтай ус авчран хуучин төрөлдө ор

хэмээн нохой дээрээс цацсанд би даруй хуучин зандаа ороод “Миний эхнэрийг шившин төрөл арилжжул өгнө үү хэмээн охиноос гуйваас охин над жаахан ус өгөөч , эхнэрийнхээ унтаж байх зуур үүнийг дээрээс нь цацаж , юу болгох гэснээ хэлэгтүн . Тэгвэл ёсоор болно гэлээ . Би ус авчирч эхнэрээ унтаж байхад нь “Илжиг бол!” хэмээн цацсанд одоо илжиг болсон нь энэ буюу хэмээсэнд бирид “Үнэн үү?” гэж илжигнээс асуув.

Илжиг үнэн гэж толгой дохив. Гурав дахь өвгөний энэ явдлыг сонсоод “худалдаачны амийг хэлтрүүлье” гэжээ… гээд Шахразада энэ шөнийн ярих үлгэрийг дуусгасанд охин дүү нь “Аяа эгч минь таны энэ үлгэр юутай сайхан билээ” гэсэнд “Хэрэв хаантан амийг минь өршөөн хэлтрүүлэх аваас шөнө би үүнээс илүү сайхн үлгэр ярьж өгөхсөн” гэхэд ньв хаан тэр сайхан үлгэрий нь дуулахаас нааш цаазаар хороохгүй гэжээ .

Тэгээд хаан охинтой шөнөжин тэврэлдэн хоноод өглөө төдий хээг шийдэл , зарлиг тушаал буулгасааар үдэш хариад охин лугаа ажрган жарган сэтгэл ханав.

## ГУРАВ ДАХЬ ШӨНӨ

Дуньязада охин “аяа эгч минь түрүүчиын үлгэрийн сүүлчийн нь яртьж өгнө үү” гэв.

Шахразада өгүүлрүүн:

Бирид, өвгөний явдлыг сонсоод ихэлд сонирхож төлөөснөө худалдаачны амийг өршөөжээ . Худалдаачин гурван өвгөнд тал өгөөд нутаг улсдаа явцгаажээ . Гэвч загасчны үлгэр үүнээс илүү сонин доо, гэхэд хаан

“Тэр ямар учиртай юм бэ?” гэв.

## ÇÀÃÀÑ×ÍÛ ¯ËÃÝÐ

Шахразада өгүүлрүүн:

Урьд эрт цагт нэг ядуу загасчин гурван хүүхдийн хамт амьдран суух бүлгээ . Өдөр болгон далайн захад очиж дөрвөн удаа өгөөш тор тавина . нэгц өдөр далдайн эрэгт очиж тороо усанд тавиад хүлээн суутал торонлд мю орсон бололтой хүндэрч чангаагаад чангаагаад дийлсэнгүй , гадас шааж өгөөш торны нэг үзүүрийг уяад уснаа шумбан орж ноцолдсоор арайхан гаргаж ихэд баярлан үзвэл нэгэн үхсэн илжиг байсанд ихэд гутран Аллахыг дурсаад:

Аяа , шөнийн харанхуй ухдийн дунд шумбагч аа!

Ажил ахуйгаар хувь зохиол болдоггүйг чи мэдмүй

Хоосон шөнийн гүн харанхуйгаар загасчин би

Ходоод тэжээхийын эрхээр, далай тийш ирнэм биш үү?

Давалгаанд балбуулан , ойлон шумбагч би.

Данзан өгөөшөөс нүдэн эс салганам

Алгуур төмөр хоолойд зоож нэг нь олсныг

Амгалан нойрсогч нөгөө нь цадтал идью!

Аяа, нэг нь зүдрэн барсныг нөгөө нь

Жарган идэх ёс Аллах тэнгэрээс заяасан тавиал.

Төөрөг даруй мөн ажгуу .

Гээд үхсэн илжгийг өгөөш торноос салгаж хаялд , урагдсаныг сэлбэн дахин тавилаа . нэг хэсэг байтал тор нь бас л хүндрээд лав загас орсон бололтой . Их далайд шумбан ноцолсоор арай хэмээн чирч гаргаваас элс, шавар дүүрсэн нэгэн муу домбо гарсанд ү загасчин ихэд гуниглан, ийн өгүүлрүүн.

Аяа, догшин заяа чи болиоч!

Арай багадсан бол зөөлөн байгаач!

Гэдэс тэжээх гэж ирлүгээ би

Гэтэл заяа минь дуссан ажгуу .

Плеядад тэнэг хүн олон гэвч

Булшаа цэуэн нь бас олон хэмээмүү.

Гээд мөнөөх шавартай ваарыг салгаж хаяад дээд тэнгэрт залбиран өгөөш тороо дахин уснаа тавьжээ . гэтэл бас нэг яст мэдхий гарч ирсэнд:

Аяа, үйлийн үрийг тогоох эрх

чамд байхгй бүлгээ

Өнгө зүс , эрдэм ном ч чамд

хувь заяасангүй!

Энэ хорвоогийн хүн болгонд

Жаргал зовлон хуваахад

Эрхбиш нэгэнд нь их, нөгөөд нь

бага ноогджээ .

Хуудам нэг нь чадалтайгаа элбэн бөхийлгөөж

Хуурамч болгон өндөрт мандан жигшүүүрт хүрмүй

Үхэл чи намайг аваач, амьдрахад бэрх боловай .

Үнэндээ, шонхор дор нь галуу дээр нь нисэх ажгуу .

Хорт муу нь бүхнийг захирах байхуй дор

Хоосон ядууг үзээд гайхах хэрэг юун!

Жигүүртэн боловч ганцхүү дорно өрнөөс эргэлдэхэд

Жич бусад нь нэгэн дор хэвтэж хамгийг эдэлмүй.

’энгэрт хандаж, Аяа бурхан минь , би өдөр дөрвөнтөө өгөөш тор тавьдаг билээ . одоонэгэнт гурвантаа тавиад юу ч барьсангүй , энэ удаа над ирэх юм хайрлаач гээд өгөөш тороо далайд хаяж хээг болоод татвал басхүү далайн ёрооолд юмнаас ороолцолдвоос Аллахыг дуудан дуудан ийн өгүүлрүүн.

Ая золиг , амьдрал гэж юунд дандаа ийм ажаам.

Аливаа гуниг хоосон хоёроос өөрийг эс үзлээ .

Үүрийн гэгээнд эрийн ахуй тунгалаг бүлгээ .

үхлийн аяганаас шөнө заавал уух учиртай ажаам.

Харин үүний урьд болбоос

Хамгаас ужаргалтай хүн би агсан ажгуу .

Далайд шумбан орж өгөөш тороо арай хэмээн гаргаж ирвээс цагийг эзэлсэн их хаан Ибн Даудын хүү Сулейманы* бөгжин тамгай тугалган бөглөө бүхий нэг том зэс домбо өгөөшинд нв байжээ . Үүнийг үзээд загасяин ихэдб аярлан , зээлийн газар аваачиж зарвал лав арван динар зоос хрнэ хэмээн өгүүлээд өргөж үзвээс нэнэ хүнд бөгөөд бас ч сайар тагсаныг үзэж, урьдаар дотор ву буйг нээж үзэх сэтгэл төржээ. Хутга гаргаж тугалган бөглөөг ханзлаад , газар бөөрөөр тавьж сэгсэрэн зайлбаас тийнхүү хүнд атал дотр нь хоосон байхад загасчин өвгөн ихэд агйхаю. Гэтэл домбоноос их утаа суунаглан , тэнгэрт улам хөөрөөлд хуйларч бөөгнөрсөөр толгой нь үүлэнд тулсан нэгэн өндөр биридп болон хувирчээ . ЁСатар ажиглабаас уул шиг толгойтой савх шиг гар хөлтэй , агуй шиг амтай, асга хал шиг шүдтэй , яндан шг хамартай , цог шиг нүдэй аюулт хар бирид болсныг загасч муу өвгөн ихэд эмээн хамаг бие дагжин , хоолой хатаад яах учраа олохгүй болжээ .

Бирид “аяа Аллах тэнгэрийн ивээлт Сулейманын үг юутай үнэн бэ? Аллах тэнгэр наайг битгий алаарай дахин таны зарлигаас хэрхэвч гарахгүй” гэхэд нь загасчин өвгөн “Аяа бирид чи Сулейманын үг юутай бэлэгтэй вэ гэв үү? Сулейман хаан ертөнцөөс халиад нэгэн мянган найман зуун жил болсон биш үү? Ер нь чи яагаалд энэ домбонд орсон хэрэг билээ? ” гэсэнд “Аяа Аллах тэнгэтр юутай үнэн бэ, одоо би чамайыг дор нь ална даа гэж бирид хэлжээ . Өвгөн айх гайхах зэрэгцэн , би чамайг далайн ероолоос татаж, домбон дотроос гаргасан атал яагаад чи намайг алах билээ . Миний утсан чинээ улаан амь чамд ямар хэрэгтэй юм . Би ямар нүгэл хийсэн юм гэхэд , “Ямар ч болов ямар үхэл сонгон авахаа үтэр түргэн хэл” гээд “миний намтрыг сонсогтун, би Сир газрын Даудын хүү Сулейманы үгийг эс дагадаг Сахр нэрт бирид билээ . Сулейманы шадар сайдаа явуулж намайш элдвээр хүчлэн барьж аваачаад, үнэн сүжигтэй бол миний боол бол гэхэд нь би болоогүй юм . Тэгэхээр намайг энэ домобнд хийгээд тугалаг хайлан бөглөж ,Их Аллахын нэр тавьж битүүмжилж далайн ёроолд хаяулжээ . Би далайн ёроолд зуун жил болж нэг өдөр ингэж бодлоо. Хэрэв одоо намайг хэн нэг этгээд гаргаж тавих ав ас үүрд баян тансаг болгоно доо гэж бодов. Тэгээд зуун жил болоход намайг хэнё гаргаж тавьсангүй . Тэгэхээр нь хэрSв одоо хэн нэг хүн намайг суллан тавих аваас дэлхийн баян санг нээж түүнд өгнө дөө гэж бодов. Гэтэл бас зуун жил болоход хэн ч ирсэнгүй . Тэгсээр байтар бас дөрвөн

зуун жил болов . Одоо намайг гагаж тавьсан хүний гурван хүний хүслийг биелүүллнэ дээ гэж бодов. Гэиэл хэн ч йнамайг тавьсангүй . Тэгэхээр нь уур хилэн нь хүрч бадраад, одоо хэн бловч намайг гаргаж тавих аваас дор нь ална гэж шийдсэн юм . Гэтэл чи одоо намайг гаргаж тавилаа . Чамайг ална даа" гэжээ . Загасч өвгөн энэ үгийг дуулаад "Аяа, Аллах! Юутай жигтэй хэрэг билээ . Өчүүхэн намайг өршөөн соёрхоно уу. Чиний амь насыг Аллах тэнгэр өршөөх болтугай" гэсэнд, Бирид "Ямарч болов чамайг үг дуугүй ална" гэхэд загасч өвгөн "Би чамд сайн үйл хийж байхад чи над хамгийн муу санажээ" гээд.

Тус болохын цагт, усаар хариулдаг.

Тун гэнэн ёс байдгийг насан үүрд санамуу.

Өөдгүй му амьтад сайн үйл бүтээсэн ч

Үнэндээ араатны аманд өөрөө орох ёс бий .

гэдэг сургаал юутай үнэн билээ" гэсэнд бирид "Битгий олон юм ярь , чиний үхэл зайлшгүй ирнэ" гэлээ . Тэгэхээр нь загасч өвгөн , энэ муу бол бирид , би бол Аллах тэнгэрээс оюун ухаан заяасан хүн шүү дээ . Энэ хүйтэн сэтгэлээр намайг алах гэж бааа бол бич юун ухаанаар үүнийг залилан хөнөөе хэмээн бодоод "Хэрэв миний үхэл зайлшгүй болсон аваас чамаас нэгэн юм асууя. Чи яг үнэн мөнөөр хэлээрэй" гэсэнд бирид зөвшөөрч , харин үтэр асуусугай гэхэд нь : "Чи ер нь энэ домбонд намайг багтана гэж "Чи үнэмшихгүй байна уу?" гэхэд нв нүдээр үзэхээс нааш яасан ч үнэмшихгүй б гэтэл бирид биеийг сэгсэрэн их утаа болоод домбонд шингэн шингэсээр алга бомогц загасч өвгөн мөнөөхөн Сулейман хааны тамга бүхий тугалганбөглөөг авч даруй таглаад ямар үхэл шилж авахаа хэл! Чамайг далайн ёроолд буцаан хаяж , энд сахин суугаад хүн ирвээс "Энд бирид бий. Гаргасан хүнийг ямар үхэл сонгон авах вэ?" гэдэг юм гэж хэлнэ гэжээ .

Бирид энэ үгийг сонсоод амаа барьж домбоноос гарах хэмээн хичнээн оролдовч Сулейманы тамгатай тус эс чаджээ . Тэгэхээр нь арга бараад би тогослон юм хэмээвэл загасчин өгүүлрүүн: "Биридийн дороос хамгийн адгийн бузар амьтан чи бас худал хэлнэ бий " гээд домбыг далайн эргийн тийш чиртэл бирид"Чи намайг яах гэж бана даа" гэхэд нь загасчин өгүүлрүүн:

"Чамайг тэнгис далайд хаясугай . Чи далайн ероол мянга найман зуун жил болсон аваас энх цаг иртэл байсугай . Намайг хайрла тэгвэл Аллах чамайг хайрлах болно . Намайг бүү алагтүн , тэгвэл Аллах чамайг үл алмуй" гэж би хэлсээр байтал чи үгэнд орохгүй харин чи ганцхүү хуурах мэхлэхийг хүссэн тул Аллах чамайг миний мэдэлд өгчээ " гэв.

Бирид: "Намайг гаргаж тавибал чинь би хишиг хүртээнэ шүү" гэхэд нь загасчин : "аяа бузар амьтан чи худал хэлнэ. Чи бид хоёр Юнан хааны шадар сайд оточ Дубоны үлгэр лугаа адил болжээ " гэсэнд

"Юнан хааны шадар сайд оточ Дубан гэжхэнб э? Ямар намтар түүхтэй улс бэ? " гэж бирид асуужээ .

*ЮНАН ХААНЫ ШАДАР САЙДЫН ТУУЖ*

Заг сЧин өгүүлрүүн: Урьд эрт цагI Персийн хот, рум*/ газар Юнан гэдэг нэгэн хаан байжэээ. Цэргийн олон жанжинтай , амь сахиул нартай их баян хаан атал уяман өвчтэй ажгуу . хаан э«двийн эм тан ууж тос тэргүүтэн түрхэвч огт үл эдгэх агаад нэгээхэн бээр оточ эс анагжээ . Тэр хотод оточ Дубан нэртэй нэг сүрхий оточ байжээ . Тэр бээр Грек, Перс, Вазиант, Араыб, Сир, таван хэл мэдэх агаад анагаах ухаан, одон мичдийн орны үндсийг мэдэх бүлгээ . Бас амьд ба хатсан тустай ба хортой бүхий л өвс ургамал цөмийг танина . Бас гүн ухаан мэднэ.

Тэр хотод ирж хэд хонотол тэр газрын хаан уяман өвчтэй агаад нэгээхэн бээр оточ , мэргэд анагааж эс чадав гэж дуулаад маргааш өглөө хамгийн сайн хувцас юугаа шилэн өмсөөд Юнан хаанд бараалхаж өлмийн дор сөгдөн амрыг эрэд “аяа хаан, ёи муу өвчинтэй агаад нэгээхэн бээр оточ домч улс эс эдгээн чаджээ . хэмээн дуулав. Би нэг ч эм тан өгөлгүй , нэг ч удаа тос эс хүгэн анагаасугай хэмээвээс хаан өгүүлрүүн:

“Чи хэрхэн анагаах вэ?Хэрэв чи намайг эдгээх аваас чамайг үр хүүхдий чинь өнөр баян болгож юу хүссэн есөн хүслий чинь хангаж хамт зоог барьдаг хүндэт зочин болгоно” гээд ямбны хувцсаар * шагнав. Тэгээд “Ай оточ минь, ямар өдөр , ямар цагт намайг эмнэх вэ? Яарч ү§ээрэй” гэхэд нь оточ маргааш анагаамуй гэжээ .

Оточ тэндээс хот орж нэгэн байшин хөлслөн аваад ном судар эм тан өвс ургамал зөөж хураагаад өвс нухаж эм болгон нэгэн модон алхны ишинл сайтар түрхэж бас нэг бөмбөг зэхлээ . Маргааш өглөө нь хаанд бараалхаж “гадаа уралдах талбайд гарсугай” гээд ийн өгүүлрүүн: “Энэхүү модон алхны ишнээс сайтар атгаж, энэхүү арьсан бөмбөлөгийн цохиж элдсүгэй . Бүх биеийн хөлс гарч алхныб ишинлд шингээсэн эм биед тарахын сацуу даруй халуун усаар биеийг сайтар угаагаад сайн хуичж унтвал эл муу өвчин нэгмөсөн арилмуй” гэжээ .

Юнан хаан зогсоогоороо алх ба бөмбөлөгийг авч моринд мордоод элдэж гартал хамаг биед хөлс цуигаж алхны ишинд түрхсэн эм бүх биед тарахын хэр халуун усаар биеийг сайтар угаагаад, харьж таг унтжээ . дубан оточ маргааш өглөө хаанд бараалхан өлмийн дор сөгдөн ёслоод ийн шүлэгрүүн:

Сайн бүхнийг чи өргөж эцгээ гэж нэрлэвч

Сааргүй бас үл нэрлэх хүн буй ажаам.

ГЭрэл шатсан сайхан царайгаар чи одоо

Гэнэ муугийн харанхуйг заяаны магнайнаас тонилгоюу

Цагийн нүүр ямагт хүйтэн кэвүүн атугай ч

Чиний царай үргэлж гэгээн тунгалаг болой!

Элбэг баян өгөөмөр уулс уул толгодыг дэвтээхийн адил

Энгүй их хишиг буянаа чи над хайрлажээ .

Баян тансгийн хязгааргүй их ойлд чи өглөөгүүр

Дээдийнг хүссэн ёсоор болгодог ажаам.

Гэж битүүхэн өгүүлэв.

Хаан угтан тосож хажуудаа залж суулгаа¤ үнэт хувцсаар шагнаь. Юнан хаан өчигдөр халуун усаар биеэ угаасны дараа мөнөөхөн уяман яр алга болж, бие нь цалин шиг цагаахан болсонд сэтгэл сэргэж , бие ихэлд амарсан байжээ . Тэгээд сайхан ширээ засаж Юнан хаан Дубан оточ энэ хоёр энэ тэрийг хүүрнэлдсээр өдрийг бараад үдэш орой болсон хойно хоёр мянган динар зоос шагнаж ,, мориор гэрт нь хүргүүлжээ . Юнан хаан отчийн уран мэргэн, аргатайг нэн магтжээ . “Энэ оточ миний өвчнийг гаднаас жигтэйхэн мэргэн анагаав. Ийм хүнийг ихэд тахин хүндэлж , насан турш хамт зоог барьж байх хэрэгтэй” гэж өгүүлжээ . хаэан дараа нь шөнө бие өвчингүй туйлын амар жаргалтай нойрсоод маргааш нь бас л Дубан отчийг дуудан ирүүлж сайхн ширээ засуулан өвөржин жаргаад, үдэш орой болсон хойно ямбын таван хувцас мянган динар зоос шагнаад хариулжээ .

Юнан хааны нэгишадар сайд туйлын харамч хорт муухай санаатан нэн атаач өөдгүй хүн байжээ .

Хаан дубан отчийг машид дотночлон асар их хишиг хүртээхийг үзээд атаархан сэтгэл, төрж дотроо смуу сансан хүний чадал нь ил дорой нь нууц явдаг г гэж үг байдаг билээ . ТЭрхүү шадар сайд Юнан хаанд бараалхаж , өомийн тус газар үнэсээд , “Аяа цагийг эзэлсэн хаан минь, чиний ивээлээр би өдий зэрэгт хүрлээ . Одоо чамд нэг зүйл зөвлөхийг хүснэм. Чамайг хэл хэмээвээс эхлмүй, бүү хэл хэмээвээс эс хэлсүгэй гэхэд нь хаан энэ үгэнд нь сэтгэл зовнин”Чи хэлэхийг хүснэ үү?” гэсэнд урьдын үгэнд “Хэрэг явдлын үүсгүүрийг эс бодох хүн хувь заяаны нөхөр биш” гэдэг билээ . Чинийоточ бол чиний хаан байх хугацааг хороох гээд байхад ёчиний хишиг хүртээдэгш нь буруу мэт санагдана. Түүнийг хэт өргөмжлөвөл биедээ ихэд татах нь би хажуунаас их лайна

Гэжээ .
хааны царай барсхийж , “Чи хэнийг хэлээд байнам?” гэсэнп “Ай хаан та унтаж байвал сэрэгтүн! Би оточ Дубаныг хэлнэм” гэхэд нь Хаан өгүүлрүүн.

“Ай муу заяат тэрбээр миний бүхнээс дотночлон үзэх нөхөр даруй мөн. Өөр ямар ч оточ эдгээж эс чадах өвчин надад туссаныг гагцхүү тэр хүн анагаасан билээ . Одоо цагт тийм эрхэм хүн дорно хийгээлд өрнөдийн гүрэнд хаана ёч байхгүй . Чи дэмий юм ярина . Өнөөдрөөс эхлэн би түүнд сар бзриын мянган динар зоосны цалин өгмүй . Ер нь би түүнтэй хаан ширээгээ хуваан эзэлсэн ч багадмуй . Би ас Синдбад хааны тухай мэдэх тул чамайг лав атаархсны улмаас ийнхүү ярьж байна гэж бодож байна...” гэжээ гээд Шахразада үлгэрээ таслав.

Тав дахь шөнө эхлэхэд Дуньязада , “Ай эгч минь нойр чинь эс хүрэх аваас үлгэрээ гүйцээн ярьмуу” гэсэнд Шахразада өгүүлрүүн:

“Юнан хаан , ай шадар сайдаа, чи энэхүү оточ хүнд атаархан түүнийг алахыг хүсжээ . Хэрэв тэгвэл , Ас Синдбад хаан шонхорыг алаад хожим хэрхэн гэмшсэн лүгээ алил больюу” хэмээвээс “Ай Цагийг эзэлсэн хаан минь, намайг өршөөгөөрэй! Тэр яасан юм бол ?” гэж шадар сайд асуужээ .

*АС – СИНДБАД ХАА□Ы ҮЛГЭР.*

Юнан хаан өгүүлрүүн: Урьд эрт цагт перс газар наадам зугаа, ан гөрөө их дуртай нэгэн хаанбайжээ . Нэг шонхор тэжээж,түүндээ их хайртайн учир өдөр шөнөгүй дэргэд байлгах агаад анд явахдаа авч явна. Хүзүүнд нь алтан аяга зүүж , түүнд хоол хийж өгдөг байж . Хаан нэг өдөр анд явж нэгэн их хөндий хүрээд өгөөш тор тавьсанд нэг шаргачин оржээ . Хаан “Үүнийг толгой дээгүүрээ харайлгаад алдсан хүнийг ална” гэжээ . “Анчид торыг хуимсаар байтал мөнөөхөн шаргачин хааны урдаас ирж урд хоёр хөлөө нугалан яг л мэхийн сөгдөх адил болж хаан дохитол толгой дээгүүр нь харайн гараад алга болов. нөгөө анчингууд өөр хоорондоо нүд ирмээд ярилцан бахыг хаан харж, “Аяа шадар сайд эд юу ярилцнам бэ?” хэмээвээс “Шаргачиннг толгой дээгүүрээ харайлган алдсан хүний толгойг авна” гэж хаан хлэсн гэлцэн байна гэсэнд , Хаан, ”Би заавал тэр шаргачинг намнан алмой” гээд мөрдөн хөөж оджээ . Шрагчин нэгэн хонхорт далд орохын даваан дээр бүргэдийг тавьсанд гүйцэн очиж далавчаараа нүдийг сох цохитол хаан хүчр очоод бороохойгоор цохиж алаад дор нь өвчиж ганзаглав.

Жин үдийн алдад тэрхүү их цөл газар усгүй учир хаанч цангаж , морь ч ихэлд цангажээ . Эргэн тойрон харталд нэгэн өндөр модноос тос мэт өтгөн ус гоожин буй дор бүргэдийн хүзүүнээс алтан аяга авч тосоод уух гэтэл бүргэд далавчаараа аягыг цохиж хөмрүүлэв. Бүргэдийн ам бас цангажээ гэж бодоо¤ дахин тосон дүүргэж өмнө нь тавитал далавчаараа цохиж хөмрүүлэв. Хаан баахан хилэгнэ, дахин тосож дүүргээд морины аманд тавьтал бүргэд аанай л далавчаараа ццохиж хөмрүүлжээ . Хаан аяа муу заяат жигүүртэн чамайг Аллах залхаах болтугай! Чи надад миний моринлд өөртөө юунд унд эс уулгана! Гэж хилэгнэн сэлмээ сугалан д лавчийг нь тас цавчив.

Бүргэд дээш заах маягтай өлийсний дагуу харваас модны оройд хоёр хорт могой зулзага хороо гоожуулж байжээ .

Хаан тэндээ мордож майхандаа очоод уламаар хотдоо буфцав. Харьж мөнөөхөн алсан шаргачинг тогоочид өгөөд ордондоо ирж суутал бүргэд нь нэг удаа амуухай хашиграад үхжээ . Хаан аминд орсон бүргэдээ алав гэж ихэд гашуудсан гэдэг.

Юнан хааны энэ үгийг сонсоод шадар сайд өгүүлрүүн: “Эрхэм дээдийн хаан минуу оточ чамд ямарч гэм хийсэн юм гэнэ Надад хорт муу юм эс хийсэн атал ганцхүү таныгаа бодох юм даа . мин йүгийн үнэнг эс мэдэх аваас нэгэн хааны шадар сайд хааны хөвгүүний эсрэг муу үйл үйлдээд хэрхэн үхсэний адил та үхэх болно доо” гэсэнд “Тэр юу болсон юм бэ?” гэж юнан хаан асуужээ .

*МУУ САНААТ ШАДАР САЙДЫН ҮЛГЭР.*

Шадар сайд өгүүлрүүн:

“Ай хаан минуу, урьд цагт нэгэн хаанб айжээ . Ан гөрөөнд их дуртай нэг хөвгүүнтэй юмсанжээ . Хаан шадар сайдыгаа миний хүүгийн хаана явсан газар цуг явж бай гэж зарлиг буулгасан байжээ . нэг өдөр хөвгүүн хааны шадар сайдын хамт анд явж шадар сайд нэгэн том гөрөөс хараад “За чи тэр гөрөөсийг элдэж

алаад ир!" гэсэнд хөвгүүн гөрөөс хөөсөөр бараа тасартал гөрөөсч гүйцэгдсэнгүй алга болжээ. Хаан хүү тэндээс төөрч хаачихыг мэдэгүйы явтал замын хажууд нэг хүүхэн уйлж сууж буйг үзээд "Чи хэн бэ? гэсэнд, "Би Жагар хааны охин билээ . Энэ цөл газар явтал үүрэглэн мориноосоо ойчоодд хамт явсан улсаас гээгдэв" гэжээ . Хаан хөвгүүн өрөвдөж , сундалдаад цааш явж нэгэн эвдэрхий балгасын хажуугаар өнгөртөл охин, "Би бууж морь хараад ирье" гэжээ .Охин эвдэрхий балгасанд ороод гарч ирэхгүй болохоор нь хүлээж ядаад хойноос нь сэм ортол мөнөөх хүүхэн махчин авгай агаад хүүхдүүдээсээ "За хүүхэд минь , би нэг тарган хархүү авчирлаа " гэхэд нь цаадуул нь "Ээжээ, түүнийгээ төхөөрч өгөөч!" гэцгээхийыг хаан хөвгүүн сонсоод одоо өнгөрчээ хэмээн туйлын эмээн өвдөг чичирч атал махчин гарч ирээд , "Чи юунаас ийнхүү айв. " гээд . "Мин йдайсан байна, би түүнээс айнам" гэсэнд, "Чи тэгвэл их мөнгө өгөөд түүний сэтгэлийг засчихүй юу гэхэд нь тэр миний дайсан, мөнгө тоохгүй гагцхүүү миний толгойг авч байж сая сэтгэл нь ханана" гэжээ . махчин өгүүлрүүн: "Тэгвэл чи өндөр Аллахт айлдагтун!Аллах чамайг өстөн айдснаас чинь аварч , чиний айж байгаа заналаас ангижруулах болн" гэхэд хаан хөвгүүн тэнгэрт залбиран "Аяа Аллах тэнгэрминь зовлонд унасан хүн чамайг дуудахад чи хорт мууг зайлуулж авардаг биш үү? Намайг дайснаас өмгөөлж энэ дайсныг зайлуулаад өгөө·! Үнэндээ чамд дйилэхгүй юм үгүй билээ! Гэтэл махчин сонсоод зугтан алга болжээ . хөвгүүн гэртээ харьж , шадар сайдыг даруй дуудаж толгойгий нь авчээ .

"Хаан та үнэхээр энэ отчид итгэж байгаа бол таныг аль муугаар алах биз. Та хүнд хичнээн сайн байж өглөг буян өгөх нь өөрийгөө алах хүнийг бэлдэж байгаа нь тэр! Тэрхүү оточ зөвхөн гарт чинь юм бариулахын төдий анагаасан бол хэрэв алах гэвэл гарт чимнь хүрэхгүй хөнөөж чадна" гэжээ .

Юнан хаан өгүүлрүүн: "Аяа шадар сайд чиниы хэлдэг туйлын үнэн! Тэр оточ намайг алах гэж заншлан тагнахаар ирсэн ажээ . Үнэхээр тэр миний гарт эм атгуулахын төдий эдгээсэн болохоор намайг хөнөөе гэвэл эм үнэртүүлэхийн төдийгөөр чадах буй заа" гээд "Ая шадар сайд тэгээд түүнийг одоо яахав? " гэсэнд "Яах юу байхав дуудаж авчраад толгойгий нь авагтун. Түүнийг хуурахын урд хуурё амжвал үхлийн аюулаас мултрах болно" гэж шадар сайд өгүүлжээ . Юнан хаан шадар сайдын хэлдэг үнэн байна гээд отчийыг дуудуулсанд Дубан оточ яах гэж буйг үл мэдэх тул.

Аяа, найр тавьсан хэнд боловч чи хувь заягаа даалгаад

Насан турш сүрдэх зовлонгүй амар болжээ чи!

Аллахын тогтоолт үйлийн үр зайлшгүй ноогдох тавилантай

Алидаа шудрага бусаас чи намайг ангижруулахсан шүү

эзэн минь гэсэн мэт маш баяртай бараалахан ийн өгүүлрүүн.

Яріу эгшиг зохиолыг хэнийы тул бүтээв би.

Ямар их хариу бодож чамайг би өргөнөм?

Өглөг ба хишиг хайрлахдаа та ямагт

Өршөөл ба хугацаа хоёрыг эс мэдэх ажгуу .

Эл учир эрхэм хүнийг хэрхэн эс алдаршуулж

Ил ба далд магдахгүй байж хэрхэн чадах билээ би

Өгсөн буян хишигий чинь санахад

Үүрэг минь хүнд ч санаа амар болох ажгуу .

гээд басхүү ийм санаагаар нэмж хэлсэн нв:

Зовох сэтгэлд нүүрээ буруулагтун

Зол заяанд буянаар цэнгэн жаргаваас

Өнгөрсөн явдлаа цөмийг даруй мартьюу!

Үйлээ үзсэн өдөр над олон биш

Үнэхээр ханах цаг бас ирмүй!

Тэнгэр Аллах санаснаа бүтээж чадьюу

Түүний үгнээс би хэрхэвч үл зөрьюү

гээд бас :

“Цэцэн мэргэн, буянт анд үйлсээ даатгаваас

Санаа сэтгэл насан үүрд амар явьюу

Миний бие санааны зоргоор үйлдэж эс чадьюу “

гээд бас:

Олныг бодвоос цэцэн зүрхэнд боловч гуниг тогтмуй

Огт амгалан зол наргиантай байваас зохилтой

Харц боол би учрыг олох гэж санаваас талаар буй

Харин цэнгэлтэй аваас насан турш жаргах бий

гэсэнд

Хаан өгүүлрүүн: “Чамайг юуны учир дуудсаныг мэдэж байна уу? гэхэд нь “Ай хаан би ямар нүгэл хийсэн билээ?” гэсэнд хаан , “Чи намайг заншлан тагнахаар иржээ гэж хүн хэлэв. Эл учир чи намайг алахаас урьд би чамайг алах хэрэгтэй болов” гээд зандалчин хүнийг дуудаж , “Энэ зальт харын толгойг авч билнийы сэтгэлийг амраагаад аль!” гэжээ .

Оточ өгүүлрүүн: “Чи намайг өршөөх аваас Аллах чамайг өршөөх болно. Хэрэв чи намайг албаас Аллах чамайг алах болно” гэжээ . Бирид чи тэр хаан лугаа адил сая намайг заавал ална гээд байсан даа . Тэгэхээр хаан хэлжээ : Чмаайг амьд агсан цагт миний амь насанд аюултай болод байна.Яагаад гэвэл чи миний өвчнийг эдгээхдээ гарт минь нэг юм бариулсан бол надад нэг юм үнэртүүлэхийн төдий намайг алах биз

Гэхэд оточ “Ай хаан минь, би чамлд ач болсны учир хорт муугаар алагдах болжээ” гэсэнд Хаан:

“Чамайг олон таван үгүй заавал ална” гэжээ . Хаан намайг заавал алахр ажгуу гэж мэдээд оточ Дубан ийм шүлэг хэлрүүн:

Меймун мунхаг хүн атал.

Эцэг нь ухаантай хүн гэтэл

Хуурай, нойтон ямарваа замаар азнаж яваагүй цагт

Хальтарч ойчих нь аргагүй нэгэн ёс билээ .

гэжээ

энэ үеэс зандалчин ирж оточ Дубанб нүдийг боогоод хороох зөвшөөрөл асуутал Дубан өгүүлрүүн: Чи намайг албаас Аллах чамайг алах бий . Чи наайыг өнгөрөөвөөс Аллах чамайг өнгөрөөх бий гээд ийн шүлэгрүүн:

Үнэнч нь золгүйы , хуурамч нь азтай ажгуу .

Үнэнээр явсаар би гунигийн хүлээсэнд автав.

Өнөөдөр зхэвч би хэзээд үнэн явахгүй

Өөр хэлийн улсад үүнийг зөөвөл дуулгасугай .

гээд оточ Дубан хаандаа өгүүлрүүн:. “Аяа хаан , чи намайг ийнхүү шагнана уу? Энэ болбоос гүмбэр матрын үлгэр лүгээ адил болжээ .” гэсэндп хаан, тэр гүмбэрматар часан юм бэ% гэжээ . Оточ өгүүлрүүн: “Би өөрөө ий бадалтай байж хэрхэн ярих билээ . Харин чи намайг алах аваас Аллах чамайг заавал алмуй” гээд цурхиртал уйлтал хааны шадар дотнын нэгэн хүн өгүүлжээ. “Ай хаан минь энэ хүнийг өршөөн соёрхоно уу? Энэ хүн гэм хийснийг бид үзээгүй . Харин ямарч эмч домчиыын эдгээж чадаагүй өвчнийг энэ хүн анагаасныг бид харсан” гэсэнд хаан өгүүлрүүн: “Энэ отчийыг яагаад алах гэж байгааг тануус мэдээгүй хэрэг үү? Үүнийг өршөөх аваач би өөрөө хөнөөгдөнө. Яагаад гэвэл энэ хүн миний өвчнийг гартминь юм түүлэхмйн төдий анагаасан бол надад нэг юм үнэртүүлэхийн төдий хөнөөж чадна. Энэ хүн намайг хороох гэж заншлан тагнахаар ирсэн хүн болох тул намайг заавал алах байх гэж би айж байна.Хэрэв энэ отчийн толгойг авсан цагт миний санаа амрах болно” гэжээ .

Оточ Дубан “Чи намайг албаас Аллах чамайг алах болно. Хэрэв чи намайг өршөөх авааёч Аллах чамайг өршөөх болно” гэж гуйж яваав ийн өгүүлрүүн. “миний үхэл зайлшгүй болсон аваас надад түр чөлөө хайрла. Би харьж өөрийн биеийг хэрхэн оршуулахыг айлын хүмүүст хэлж сэтгэлээ зүшрүүлээд ирсүгэй. Бас налдад эм домын ховор судар нэн их тул заримыг тарааж, онц чухал танд барьсугай .

Та “эрдэнийн сандаа хадгалаарай ” хэмээвээс Хаан: “Тэрхүү суадрт юу бичсэн байдаг вэ? ” гэсэнд “Тэр сударт тоо тоомшгүй сонин юм байх агаад толгой дахин амитлж тантай ярих болно гэсэнд хаан нэн гайхаж чиний толгой авсан хойно ч бас надтай ярина гэж үү? Жигтэй хэрэг байна дээ ! гэжээ .

Оточ Дубаныг хуягаар харгалзуулан гэрт нь хариулсанд тэр өдөртөө захЁа занаагаа захиад маргааш нь хааны хуралд очвоос бүхий л шада сайд түшмэлүүд , Эмир ноён цөм цугласан нь эрээн алаг цэцэгс шиг харагджээ . Оточ Дубан нэгэн хуучин судар, бас бяцхан добмотой нунтаг эм авч очоод таваг авчруулан өгчэS .

“Аяа, хаан, наад судраа сөхөгтүн!” гэжээ . Хаан сулдрыг сөхө гэтэл цаас нь наалдсан тул хуруугаа шүлсээрээ сайтар норгож хуудсыг сөхөж үзвээс бичиг гарсангүй Дубаны толгойг цааш эргүүлэгтүн!”

гэжээ . хаан бас хоёр гурван хуудас эргүүлтэл хор сая бие биед тарж хаан: “Аяа бие хордлоо!” хэмэн дуу алдваас Дубаны толгой өгүүлрүүн.

Хатуу зарлигаар тэд газар орныг захирмуй

Харин эцэст хаан эзэн нь унавай .

Үнэн ёсыг барьсан бол хаанаас тийм байх билээ?

Үнэндээ хорт муу үйлээр гаслан зовлонд учирвай!

Одоо хаана боловч цагийн эрхийг дагалгүй

Олон хэл дээр энэ явдал дамжих болъюу!”

гээд оточ Дубан дуугй болмогц Юнан хаанб ас хордож үхжээ .

“Тэгэхээр ай бирид чи мэдтүгэй” гэж загасчин өгүүлрүүн: Юнан хаан хэлэв. Дубан отчийг амьд үлдээсэн бол Аллах түүнийг өршөөх байжээ . Эстэгсний учир Аллах бас хааныг хөнөөжээ . Бирид чи намайш өршөөх гэсэн бол Аллах чамайг өршөөх байж …

гэж ярьж байтал өглөө болж Шахразада охин үлгэрийг таслав.

Зургаа дахь шөнө эхлэхэд Дуньязада өгүүлрүүн:

“Ай эгч минь мөнөөхөн үлгэрээ цааш ярих уу” гэсэнд Шахразада “Хаан соёрхвоос ярьсугай” гэсэнд хаан “яригтун!” гэлээ .

Шахразада үлгэрийг үргэлжлэн ярь±ан нь: мөнөөхөн загасчин биридэд хэлсэн нь “Бирид чи намайш өршөөсөн бол би чамайг өршөөх байсан . Чи ганцаараа намайг заавал ална гэсэн тул одоо чамайг доымбон дотор хийж далайд хаясугай!” гэсэнд Бирид Аллах тэнгэрийг дуудан , “Ай загасчин миний хэлсэн үгэнд өс санаж битгий намайг далайд хий. Хэрэв би хортон бол чи ачтан агаад “Хортон, ачтан хүн хэзээд үйлээрээ дйилнэ” гэж эртний сургаал бадаг билээ . хэрэв чи намайг далайд хаяваас Умама Атика хоёрын үлгэрийн адил болно” гэхэд нь: “Тэр хоёр яасан юм гэсэнд “ай энэ гяндан шиг юман дотор байж яаж ярих билээ .

Намайг гаргаж орхивол ярьсугай” гэжээ .

**Загасчин өгүүлрүүн:** “ийм үг хэлээд дэмий . Чйамайг заавал хаях тул тэндээсээ хэн нэг хүн чамайг гаргах ямар ч найдлага байхгүй гэж мэдсүгэй! Би чамаас өчүүхэн амиа хичнээн гуйж мөргөн сөгдсөн билээ . Би харин чамайг гяндан шиг юмнаас гаргаад яамд ямар ч муу юм хийгээгүй атал чи намайг заавал ална гэсэн шүү дээ . Тэгэхлээр чинь би чамайг туйлын хорт муу санаатай амьтан гэж мэдлээ . Чамайг далайд хаяж дахин гаргаж ирэх хүн байвал наадах чинь гаргасан хүнийг ална гэж ярина. Тэгэхлээр чи далайн ёроолд он жил удсаар үхэх болно.” гэжээ .

Бирид өгүүлрүүн: “Чи намайг суллан гаргасугай . Би чиний үгэнд ямагт орж чамайг баяжихад чинь тус бөолно гэж ам алдсугай” гэжээ .

Гаргаж тавьсан хойно ямар ч хор хийхгүй , ямагт сайн санаж явна гэж бирид Аллах тэнгэрийг дурдан дпурдан ам шүд лдваас загасчин сая домбын таглааг автал дээш бөөн хар утаа олгойдсоор сая барагдаад өмнө нь бирид биеэр болж мөнөөхөн хоосон домбыг өшиглөн хаяжээ . Тийнхүү домбо өшиглөн далайд хаяхыг загасчин хараад “Энэ лав муу ёрын шинж тэмдэг!” гэж зүрхийг чангалан ийн өгүүлрүүн: Ай бирид, “амласнаа биелүүлэгтүн” гэж Аллах хэлсэн юм . Чи намайг хуурё муу юм хийхгүй гэж мөргөн мөргөн ам алдсан бөгөөд үүний тулд чамайг Аллах тэнгэр боловч огт өршөөхгүй шүү !” “Чи намайг өршөөвөөс Аллах чамайг өршөөх болно” гэж Дубан оточ Юнан хаанд хэлсэн юм гэж би сая ярьсан юм даа гэхэд нь бирид инээж, “Намайг дагаав яв!” гэжээ .

Загасчин биридийг дагаж хотын захал хрээд тэндээс нэг уул давж цааш буутал их талын дунд ус ихтэй цөөрөм дайралдав Биридийг дагаж цөөрмийн тэхий дунд нв хүрч харваас цагаан, улаан цэнхэр , шар дөрвөн өнгийн загас байх ажээ . Бирид “За энд өгөөш тороо тавь баригтун!” хэмээсэнд загасячин тор тавьж татан гаргатал дөрвөн өнгийн загас орсон байжээ . Бирид өгүүлрүүн: “За чи эдгээр загасыг Султан хаанд баригтун . Чамд мундахүы хишиг хайрлах биз” гээд би тэнгэис далан ёроолд найман зуун жил болоод дөнгөж сая гарсан тул зүг чигээ сайн үл мэднэ. Гэвч ингээд би замаараа явлаа . Чи энэ цөөрмөөс өдөрт нэг удаагаас илү загас барьж үл болно. Чамайг мөрөөдөн санах байхаа даа .

Гээд газар дэвстэл их ангал гарч бирид ортол хагарсан газар дахин нийлжээ .

Тэндээс агасчин гэртээ харьж модон саванд ус дүүргэн загасынг хийгээд хаанд аваачтал хаан урьд хожид тийм жигтэй сонин загас үзээгүй тул нээн гайхаж “Одоохон тогооч хүүхэнд аваачиж тушаагтун! Гэжээ . Тэр тогооч хүүхнийг Рум газрын хаан гурав хоногийн өмнө энэ хаанд бэлгээр ирүүлсэн агаад ирснээс хойш хоол хийжэ үзүүлээгүй юм байжээ . Хааны шадар сайд тогооч хүүхэнд , Май энэ хэдэн загасыг шарагтун! Гээд “Ай ноёнтон нүдэт минь чамайг шалгаж үзье . Өнөөдөр Султан хаанд бэлэг хүргэж хүн ирсэн тул хэрхэн сайхан хоол хийдгээ гараа гаргаж үзүүлэгтүн” гэж хаан хэлж байна гэжээ .

Хаан загасчинд дөрвөн зуун динар зоос өгсөнд загасчин тэсгэлгүй баярлан гэрийн зүг ухаан жолоогүй унантусан гүйхдээ би арай зүүдлээгүй байгаа гэж бодож явжээ . Тэр өдөр гэрийнхэндээ их юм худалдан авч нэн баяртай эхнэртээ аваачив.

Энэ үеэс мөнөөх тогоочин хүүхэн загасыг цэвэрлээд халдуун тогошн хайрч өрөөсөн талыг нь дөнгөж борлуулан эргүүлтэл тогооны байшингийн туурга дундуур салаад нэгэнмаш гоо үзэсгэлэнтэй залухан хатагтай гарч ирсэн нь гоолиг сайхн биетэй , гонзгой зууван царатай , том давхартаатай нүдтэй тун ч цэвэрхэн хүүхэнб өгөөд торго дээлтэй , цэнхэр хантаазтай , бас чихэндээ том алтан ээмэгтэй , хөлийн шилбэнд бүдүүн мөнгөн бугуйвчтай хуруундаа эрждэнийн чулуун шигтгээтэй алтан бөгж, бас хулсан таяг тулжээ . Хатагтай таягаар тогоо руу чичилж “Ай загаснуудаа , урьд ярилцсанаа санагдун!” гэхэд нь тогооч хүүхэн уханүй айж , мөнөөхөн дөрвөн загаё тогоон дотроос толгой өндийлгөж .

“Чи ирвээс би ирнэ. Чи үнэн бол бид үнэнч,

Чи биднийг хаяваас бид чамайг бас хаяна…”

гэжээ .

Мөнөөхөн хатагтай таягаар тогоог хөмрүүлж орхиод гарсны хойно тогооны байшингийн туурга хуучин янзаараа нийлэв.

Тогооч хүүхэн ухаан орж загасыг үзтэл галд цөм шатаж нүүрс болсонд “Анхны байдлаанд жадаа хугалав” гэж гасалжээ .

Хааныб шадар сайд хоол юу бол байна гэж орж иртэл тогооч хүүхэн мэл гайхаж цэл хөхөрсөн , өдөр хоногийн үл ялгах төдий хөгшин чавганц болсныг үзээд нэгэнтээ өшиглөөд автал сая ухаан орж саяыэ болсон хэргийг яриваас шадар сайд “Үгүй ба жигтэй юм!” гэж нэн гайхааад загасчинг дуудан ирүүлж , “аай загасчин чи саян авчирдагийн яг адил загас авчирсугай!” гэжээ . Загасчин мөнөөх цөөрөмд очиж өгөөш тор тавьтал түрүүчийн яг ижил дөрвөн кагас орсныг хааны шадар садад аваачиж бариваас µааны шадар сайд тогооч хүүхэнд май энэ дөрвөн загасыг намайг харж байхад шарагтун!

Гэжээ . Тогооч хүүхэн загасыг цэвэрлээд халуун тогоонд хийтэл тогооны байшингийн туурга ярагдаж мөнөөхн хатагтай яг хэвэр таяг тьулан гарё ирээд, таягаар тогоо руу хатгаж . “Ай загаснууд минь , урьдын ярилцсан үгийг тануус санана уу?” гэсэнд тэдгээр дөрвөн загас тогооны дотроос толгой өндийлгөн :

“Чи буцваас, бид буцна Чи үнэн бол бид үнэнч,

Чи биднийг хаяваас бид чамайг орхино”

гэтэл

Хатагтай таягаар тогоог хөмрүүлээд гарч одсоны дараа байшингийн хана бүтэн болжээ .

Долоо дахв шөнө эхлэхэд Шахразада үргэлжлүүлэн ярьсан нь :

“Ай цагиыг эзэлсэн хаан минь, тэндээс хатагтай таягаар тогоог хөмрүүлээд гарч одсоны дараа байшингийн хана бүтэн болжээ . Шадар сайд үнэхээр гайхаж, “ийм хэргийг хаанд эс айлтгаж үл болн” гэж үзсүгэй!” гэжээ . Шадар сайд загасчныг дуудан түрүүчийн адил загас авчирсугай хэмээн гурван хүнээр харгалзуулан явуулсанд загасчин төдөлгүй дөрвөн өнгийн загас авчирсанд хаан загасчинд дөрвөн зуун динар зоос шагнажээ . Тэгээд , хаан “Энэ дөрвөн загасыг намайг харж байхад чи өөрөө шарагтун!” гэж сайддаа зарлиг болов. Шадар сайд “За” гээд халуун тогоонд тос хийж дээрээс нь загасаа хийтэл тогооны байшингийн хана туурга ярагдан , Ад омгийн хүн лугаа адил нэгэн хар арьст боол ногоон модны мөчир барин гарё ирээд “Ай загаснууд аа, урьдын ярилцсаныг мартав уу?” гэсэнд дөрвөн загас тогоог дотроос өндийж

“Чи буцваас, бид буцна Чи үнэн бол бид үнэнч,

Чи биднийг хаяваас бид чамайг орхино”

гэжээ .

Бол модны мөчрөөр тогоог хөмрүүлж орхиод далд ороь. Хаан шадар сайд хоёр мөнөхөн дөрвөн загасыг үзвээс хар нүүрс болсон байжээ . Хаан өгүүлрүүн: “Ийм sм үзсэн хүн дуугүйы байж үл зохилдоно. Энэ дөрвөн загасанд лав учир бий!” гээд загасчныг дуудуулан “Чи энэ загасыг хаанаас барив?” хэмээсэнд “Хотын захад байх дөрвөн уулыбн дундах цөөрмөөс барив” гэсэнд “Хэр хол газар бэ?” гэтэл “Хоёрхон мөч явах газар даа” гэхэд нь хаан бараа бологчдоо дагуулж загасчнаар газарчуулж тийш явахад загасчин гайта биридээс болж ийм хэрэг гараь гэж бодож явжээ . Султан хаан тэдний бараа бологчид нэгэн уул давж , цааш тонгойтол дөрвөн уулын хооронд урьд хожид үзээгүй нээн цөөрөм байх бөгөөд дотроо улаа, цагаан% шар, цэнхэр дөрвөн өнгийн загастай ажээ .

Хаан ихэд гайхаж, та нарын хэн нэг нь урьд энэ цөөрөм үзсэн үү? Гэсэн “Ай цагийг эзэлсэн хаантан минь бид ерөөсөө үзсэнгүй” гэжээ . Нутгийн нэн өнөдр настан улсаас асусанд бас л эс үзжээ . хаан өгүүлрүүн : Би энэ цөөрөм ба загасны учрыг оохоос нааш хот орж хаан ширээндээ суухгүй гэж Аллах тэнгэрийг дурдан өгүүлэв.

Хаан бараа бологчдыг тэр дөрвөн уулыбндөрвөн талд §огсоогод шада сайдаа дуудаж “Хааны сайд ийм юманд их дадлагтай , ухаантай хүн ажээ” өгүүлрүүн: “Би бээр нэгэн үйл хийхийг хүсч байна. Би энэ шөнө энэхүү жигтэй загас бүхий цөөрмиыг ганцааро ирж ажиглана. Чи миний майхны аманд ёууж, аливаа сайн Эмир ноён хэн боловч эс оруулсугай гэсэн гээрэй . Миний энэ явдлыг хэнд ч хэлж үл болно. гээд хувцаёыг сольж илд бүслээдп нэг уулын оройд гарё нэгэн шөнө, нэгэн өдөр харуулдваас нэгээхэн ч амьтан эс үзэгдэн бөгөөд дара нэгэн өндөр хор юмны бараа хэрээд: “Энэхүү цөөрөм ба загасын учир сая тайлдана” биз гэж ыодоод ойртон очвоос нэгэн гахамшигт чулаан орд харш байж түүний хоёр хаалганы нэг нь онгорхой , нөгөө нь түгжээтэй байв. хаан түгжээтэй хаалгыг олонтаа дэлдвээсм хариу үл гарах тул энэ орд харж хоосон юм байна” гэж санаад зүрхлэн дотогш орж, “Аяа энэ орд харшгийн эзэн байна уу? Би харь газрын аянчин билээ . Идэх юм эрнэм!” гэж хашгартал бас л аанай хариу алга. Хаан зүрх гарган ордны бүр тэг дунд хүртэл явтал өнгийн торгон одтой хивсээр чимж сахан хөшиг буулгаатай атал эзэн хүнгүй ажээ . Ордны дунд хэсэгт басхүү дөрвөн өнөдр багана, дөрвөн вандан байв. вандан тус бүрд дөрвөн хар алтан арслан өөд өлийж амнаас нь ус оргилрн буй нь яг сувд эрдэнэ очир алмасаар цацрах мэт ажээ . Бас хэдэн жигүүртэн шувуу эргэлдэн наадах атал дээвэрт тор татаагүй нисэн одохын аррагүй . Энэхүү жигтэй дөрвөн уул, цөөрө¬ , дөрвөн загас орд харшийн тухай асууж мэдэх хүнгүй арга тасраад гуниглан суутал нэгэн хүн арга буюі гунигт сэтгэлийн угаас ёолон дуун гарч ийн шүлэглрүүн:

Аяа зүүдэнд үзэгдэх сэтгэлд ил бүхнийг би нууцалдаг билээ .

Амттайяа зүүдийг эдүгээ нойргүй шөнө орлодог билээ .

Хувь зохиол минь эс энхрийлнэ.Эс хайрлана намайг

Хүслэнт сэтгэл зовлон аюулын дунд банам.

Янагийн замаар явж, ядуугийн зовлонд учрав.

Ямбатын эрхэм та минуу өршөөн хайрлах буй за .

Талын салхинаа боловч таныг жөтөөрхдөг билээ .

Тавилан хувь унахад , таг сохор болох ажээ .

Атаат дайсаан тулгарё сумаа онилохын цагт

Алаг нум нь алга бол хэрхэн харвах билээ?

Залуу нас түмэн гунирхалд нэгэн унаваас

Заяа зол , үйлийн үрээс хэрхэн зайлах билээ?

Хаанду гасран тийш очиж амгалангийн хаалганаа дүүжлээстэй хөшигт тулж үзвээс газраас нэгэн тохоы өндөр суурь тавиур дээр нүүрэндээ галтай нүдэндээ цогтой , хацартай энгэсэгтэй, хажууд нь мэнгэтэй нэг гол шиг цэвэрхэн хархүү сууж байв. Тийм сайхан хөвгүүнийг шүлэгт:

Магнай үс нь гэрэлтсэн юутай сайхан төрөө вэ?

Магад бүх хүний гэгээнийг биедээ шингээжээ .

Хацар дээрээ мэнгэтэй гэж түүнийг бүү басамжил

Хар цэг бүхнийг яргүй цэцэг тэмдэглэжээ гэдэг билээ .

Тэр хөвгүүн Мисир газрын алтан хатгамал бүхий хантаазтай бөгөөд эрдэнийн чулуун эмжээртэй титэм өмсчээ . хаан амрыг эрвээс хөвгүүн өгүүлрүүн: “Ай ноён минь та тосон босож хүндэтгэлтэй эхэс мөн атал өчүүхэн нам йг өршөөгөөрэй” гэхэд нь хаан:

“Хөвгүүн чамайг би хэдий нь өршөөв. нэн чухал хэрэгтэй айлчлан ирсэн минь гэвэл, энэ нуур түүний дөрвөн загас , энэ орд харш ямар учиртай юм ыэ? Чи өөрөө юуны учир ганцаараа энд уйлан сууна вэ? Эл бүгдийн учир шалтгааныг ярьж өгнө үү? ” гэсэнд хөвгүүний нулимс өөрийн эрхгүй хацрыг даган урсаж хоолой зангиран ийн шүлэглэрүү:

Үйлийн үрд өртөх хүн олон, өндийх хүн олон

Үнэндээ хүний тавиланг гайхах хэрэг юун!

Хэн ямагт гэгээн бэ, хэдий урт настай вэ? гэж

Аллах тэнгэр нүд анилгүй хардгийг унтагч хүн яахин

мэдэх билээ

гээд хөвгүүн бас уртаар санаа алдаад:

Сэдэх үйлий чинь хамгийг мэдэгч тэнгэр мэдмүй,

Сэтэглийн зовлонг орхиж элдэв бодлыг март!

Яагаад юу болсныг мэдэхийг бүү оролд!

Ямарваа юм гагцхүү үйл зохиолоор болдог билээ .

гэжээ .

Хаан: “Хөвгүүн чи уны учир ийнхүү шаналан уйлнам” гэсэнд “Хаанаас би ийм байж эс уйлах билээ” гээд хөвгүүн хормойг сөхтөл цээжин бие нь хүн бөгсөн бие

нь чулуу бажээ . Хаан үзээд туйлын их өрөвдөн , сэтгэл зүрх шимшрээд дуун алдан өгүүлрүүн:

“Чамайг үзээд миний өрөвдөн гуних сэтгэл улам их нэмэгдэв. Тэр дөрвөн загас хаанаас хэрхэн бий болсныг мэдэх гэсэн атал одоо болоход чи яагаад ийм болов , тэд яагаад тийм болов гэж мэдэхийг хүснэ. Аугаа Аллахаас илүү хүчтэй юм үгүй билээ . Аяа, хөвгүүн чи, энэ үлгэр түүхээ ярьж өгөөч !” гэсэнд хөвгүүн: “Та тэгвSл харах нүд , сонсох чихийг хайрла!гээд миний нүд , чих энд бэлхнээ байна. ” гэхэд нь хөвгүүн өгүлрүүн: “Үнэндээ энэ дөрвөн загас бидэнд гайхалтай хачин явдал тохиолсоныг хүний нүдний буланд зүүгээр бичиж үлдээвээс хожим сургамж хүмүүн дор сугаал болно гэжээ .

*ҮҮН ХЭРХЭН ЧУЛУУН БӨГСТЭЙ БОЛСОН ҮЛГЭР. ”*

Хөвгүүн өгүүлрүүн:

“Аяа ноён минь , миний эцэг энэ хотын хаан бүлгээ Түүнийг Мухамуд хэмээх бөгөөд хар арлыг эзэгнэн суудаг байв. Энэ дөрвөн уулыг захиран далан жил хаан ширээнээ суутал насан өөд болж би султан хаан болов. Би нагацын охиныг гэргий болгон автал нададнээн хайрта намайг эс байвал хоол унд ч эс ууж идэх бүлгээ . ийнхүү таван жил болтол нэг өдөр гэргий халуун усанд биеэ угаахаар орсонд би тогооч нарыг захиран сайхан хоол хийлгээд амгалангийн өргөөнд орж хоёр шивэгчин дуудаж нэгийг толгойн тушаа нөгөөг хөлийн тушаа суулгаад унтахыг завдваас гэргийн эзгүйд нойр хулжиж дэмий л нүд аньж хэвттэл толгойн тушаа суугаа охин нөгөөдөө ярих нь :

“Масуд аа, манай ноён хайран залуу! Заяа муутай хатан нь даанч завхай амьтан даа! ” гэхэд нь “Тийм ээ, хатан нэн хуурамё садар самуун эм ажээ . шөнө болгон гадуур чвж хонодог тэр садар самуунг эм манай ноён шиг сайхан залууд эс таарах ажээ” гэж нөгөө толгойд суугаа охин: “манай ноён тэнэг болоод хааш явдгийг асуухгүй юм” гэхэд нь нөгөө охин нь “Ай чи юү хэлнэм . манай ноён мэдсээр мөртөө эс тооно гэж чи бодно уу. Тиым биш Муу заяат хатан үдэш болгон унтахын өмнө дарёс уулгах нэрийдлээр бани* хольж согтоон орхиод хувцсыг өмсөөд сэм гарё өглөө болтол алга болох бүлгээ. Өглөө ирээд нэгэн зүйл үнэртүүлээд ноёныг сэрээдэг юм гэжээ .

Энэ үгийг сонсоод дотор харанху©лаад шөнө болсынш эс сэдэв. Гэргийг халуун уснаас илэхийн хамт хоёул оройн зоог барьтал нь энэ тэрийг жаахан хүүрнэлдэж агаад унтахын болж энгэрийн цаагуужр хөндөрч даруй согтсон болж үхэтхийн унаж унтагч болж хэвттэл миний гэргий ганцаараа ярих нь: “Ингээд шөнөжин болсогүй унтаж хэвтвэл тааран! Аяа, Аллах минь чамайг харахаас нүдэн хорсож , чамтай унтахад сэтгэлд тавгүй гуниг төрөх ажээ . Аллах хэзээ нэг чиний сүнсийг зайлуулж намайг амраах бол!” гээд хамгийн гоё хувцасаа шилж өмсөөд үнэртэн хүжис биедээ анхилуулан , миний хутгыг авч бүсэндээ зүүгээд гарч одлоо. Би ухасхийн босож даган гартал миний гэргий хотын зээлийг өнгөрөн хэрмийн хаалгад хүрээд нэгэн үг хэлтэл хаалга нээгдсэн түүгээр нэвтэрч ядуу хосон хүүсийн суух эвдэрхий балгас хүрэв. Тэнд бургасан сүлжмэл хашаатай нэгэн муу урд дор

орохтой нь зэрэг би дээвэрт сэм авиран харвал доторнь нэг уруул нь гутал шиг , нөгөө нь хөнжил шиг бөгөөд бас уяман өвчтэй ажээ .

Туйлын ядуу, уранхай ноорхой хувцасны тамтаг нөмөрч нишингийн ишээр сүлжсэн дэвсгэр дээр хэвжээ .

Минийгэргий өмнө нь өлмийн дор сөгдөн хар арьст боол өгүүлрүүн: “Чи өдий орой болтол юунд эс ирэв? Миний хамаатнууд хар арьст зоёитд ирж дарс ууж байгаад сая эхнэрүүдийн хамт харив. Чамайг ирээгүй болохоор би уусангүй” хэмээвээс миний гэргий өгүүлрүүн:

- Айн ноён минь сэтгэлийг булаасан хайрт минь, би өөрийн нагацын хөвгүүн лугаа нэгэнт раг барилдсаныг чи мэдэх билээ . Түүн лүгээ унтах гэхээс дргүй минь хүрэх атал басхүү чинийхээ амийг хайрлах бүлгээ .
- Чамайг үнэхээр эс хайрладагсан бол энэ газар дандаа шөнө балгаж . Энэ хотыг ууль, хэрээ үнэг чононы үүр эвдэрхий балгас болгож чулуугий нь Каф уулын цаана хаях сан ” гэлээ .
- хар арьст боол өгүүлрүүн: “Ай муу заяат эм чи худал хэлжнэ. Бид хоёрын үйлдэх эр эмийн ёсон болбоос цагаан арьстан лугаа адилгүй гэжмэдэгтүн. Хэрэв чи дахин өдий орой болтол ирэхгүй байваас тэр өдрөөс хойш амрагийн холбогоо тасалж дахин хэзээ ё чам дээр мордохгүй ” хэмээн хар арьстны бардам зангаар ам алдсугай . Аяа, цагаа арьстны үаар, өмхий гичий чи зөвхөн өөрийн дур хүслийг хангахын үүднээс надаар тоглоом хийнэ үү ! гэжээ .
- Тэр үгийг сонсоод дотор харанхуйлаад хаана багаагаа ч мэдэхгүй болов. Миний нагацын охин мөнөөхөн боолын өмнө зогсон уйлсаар “Зүрхний минь үр, хайрт минь чи над уурлаваас өөр хэн намайг өрөвдөх билээ? Чи намайг хөөх аваас хэн намайг авч байх билээ” хэмээн уйлан уйлан үглэсээр өршөөл тал олж , хувцас юугаа тайчин, “Дорд зардсан над ууж идэх юм алга уу” гэсэнд боол “Тэр аяганди чанасан жимс ба хулганы яс байгаа Домбонд дарсны шавхруу бий уул даа” гэлээ . Тэгээд заасныг нь ууж идээд, чармай нүцэглэн ноорхой тааран хөнжил сөхөж өвөрт нь оров. Түүнийг хараад би ухаанаа олохыг баж дээврээм сум буугаад хүүхний зүүж ирсэн өөрийн хутгыг авч хоёулангий нь алъя гэж бодоод эхлээд хар боолын хоолойг огтолжээ .
- Өглөө болж Шахразада үлгэрээ зогсов.
- Найм дахь шөнө болоход Шахразада үргэлжлэн ярьсан нь “Аяа жаргалта хаан минь уу гээд чулуун бөгстэй хөвгүүн хаанд ярьсан нь “Би мөнөөхөн боолйын хоолойг огтлов гээд дутуулж мөгөөрсөн хоолойн наагуур тас оготолсон байжээ . Боол учиргүй янцгаагаад миний нагацын охин хөвдөлөхөөр нь хутгыг тавиад тэдндээс сэм гарч ордондоо ирж орондоо оров. Өглөө манай гэргий ирж намайг сэрээсэнд харваас үсийг нь тайрч бэлбэрсэлийн хувцас өмсөөд “Миний нагацын хөвгүүн чи надад саад хийх хэрэггүй шүү Миний эх нас өөд болж эцэг ариун дайнд амь үрэгдээд хоёр ахын нэг нь хилэнцэт хорхойд хатгуулж , нөгөө нь нүхэнд унажээ . гэж дуулав. Тэгэхлээр нь би их гашуу болж цуйлах бий! ” гэхэд нь “Чи дураара бол би саад болохгүй” гэлээ . Нэг жил уй гашуунд унаж,

эцэст нь ийн өгүүлрүүн. Би ордонд чинь нэг бунхан бариулж ”Уй гашуудлын орон гэж нэрлээд мөнөөхө- үхэгсдийг оршуулахыбг хүснэм.”

- Гэхэд нь би “Дураараа бологтун!” хэмээвээс миний нагацын охин өөртөө тусгай өргөө бариулж дунд нь бүрхүүл бүхий бунхан хийж нөгөө боолыг оруулсан атал тэрхүүхар боол дарс уухаас өөр ямар ч ашиггүй байжээ . Миний ах хутгалсанаас хойш тэрхүү боол үг ч дуугарах тэнхээгүй үхсэн амьдын хооронд агсаар жил болсон байв. Охин өглөө үдэш болгон шөл өгч дэргэд нь уйлан уйтгарлан суух бөгөөд басхүү дарс өгнө. Ингэсээр бас нэг жил болоход нв би ихэд тэвчин мэдэгүй юм шиг байлаа . Тэгээд нэг өдөр санамсаргүй ортол миний нагацын охин учиргүй уйлж боолд өгүүлэх нь: “Аяа, зүрхний минь бал бурам чи юунд надаас буруу харнам? Ай, хайрт минь надтай юм яриач!” гээд.

Чи намайг огоорч, янаг амрагийн тэвчээр алдавч

Чухамхүү зүрх сэтгэл минь өөр хэнд ч эс дурлаю?

Хаана одовч чи сүнс бо цогцсы минь авч яваад

Хамаг бүгдээр зогсож, намайг газар тушаагтун.

Тэгээд нэрий минь хэлэгтүн, сонссон хүн болгон

Тэсгэлгүй ёолох ясны минь дуу хариулах болъюу

Чам лугаа янаглах өдөр надалд жаргалын дээд билээ .

Чиний салан одох өдөр надад үхлийн цаг билээ .

Аяа, би шүхлийг далайлган чаддаг болосой!

Амрагтайгаа , амттайяа жаргах бимлээ .

Хотол жаргалыг эдэлдэг болосой!

Хорвоог эзлэн хосрой хааныгш захирах билээ .

Эрхэм чамайг харж суух өнгөх юм бол

Эл бүхэн шумуулын давалвчны үнэгүй буюу .

Гээд цурхиртал уйлахда нь “Аяа миний нагацын охин чи ий-хүү шаналан гуньж суугаад юу хийнэ . Ямарч тус болохгүй дээ” гэхэд минь , намайг яаж байваас битгий саад хий! Садаа болбол би өөрөө үхнэ . Би дуугүй болж, түүнээс хойш бас нэг жил болов. гэрэв дахь жилийн нүүрэн дээр би нэг өдөр уур ихэд хүрч тэнд ортол “Ая ноён минь чи юунд эс дуугарнам?” гэж бас л усан нүдлээд:

Аяа , булш түүний гоё сайхныг чи биедээ шингээв үү?

Тэргүүний нь туяаруудагч гэгээ чинь унтарав уу?

Аяа, булш чи эгэнт огторгуйн мандал , газрын түвшин биш атал

Алиман саран алтан наран чамд юунд шингэнэм?

Гэж шүлэглэхэд нь миний хилэн улам бадраад хэдий болтол иймхүү уй гашуу болон суух билээ! хэмээгээд би иймхүү шүлэглэлээ .

Аяа, булш түүний хар царай чамд шингэв үү?

Тэргүүний нь бараа боловч гэгээ чинь унтраа юу?

Аяа, булш чинь нэгэнт тогтмол цөөрөм, тогоо бишү атал

Ногоон замаг, хар хөө нь чамд юунд шингэнэм..

Гэсэнд миний нагацын охин энэ үгий минь сонсоод босон харайж "Ай муу нохой, миний зүрхний дурлалт хүнийг чи шархлуулж түүний хайран залуу нас хийгээд миний хайрын сэтгэлийг чи гунигт унагасан уу! Гурван жил үхсэнгүй , сэхсэнгүй!" гэхэд нь би , "Ай , завхай явдалд бузар амьта, муу ёрын садар самуун эм ! Түүний чиэь би ингэж" гээд илдээ сугалан гэргийгээ алах хэмээн давшилтал тэр нэгэнтээ инээгээд өндөр дуугаар өгүүлсэн нь "Ай муу, нохой зайл!" Өнгөрсөн юм эгдэггүйы , үхсэн юм сэхдэггүй! Миний сэтгэлд унтрашгүй гал бөхөшгүй дөл бадраасан хүнийг залхаах эрхгийг Аллах тэнгэр надад хайрлажээ

Гээд амандаа үл мэдэгдэх хэдэн үг үглээд "Тал бие нь чулуу, тал бие нь хүн болтугай!" гэхэд нь би ийм болчихсон юм . Одоо босож үл чадна , сууж үл чадна. Үхэж эс чадна. Сэхэж эс чадна. Намайг ийм болгоод зогссонгүй , манай хот балгад , зах зээл , цэцэрлэг модыг бас тарнидан хувилгажээ . Урьд манай хотод лат хистос , ерей магууё дөрвөн омгийн иргэн оршин суудаг билээ . Миний нагацын охин тэдгээрийг загас болгосон агаад цагаан нь лал , улаан нь магуус , хөх нь христос , еврей магуус дөрвөн омгийн омгийн иргэн оршин суудаг билээ . Түүгээрё үл барам намайг ихэд трарчилган зовоох бөгөөд өдөр бүр намайг зуунтаа ташурдан дал мөр улаан нялга болж цус урсахын цагт миний биед бүдүүн таар өмсгөж дээрэс гоё хувцас нөмөргөнө гээд хөвгүүн уйлж

Аяа бурхны шүүлт , үйлийн үрд тэсвэртэйея би

Бурхан чамд таатай аваас хойшид хүлцэн чадна би.

Үйл лай надад ийнхүү догшин бардам байвч

Үнэндээ , диваажингийн оронд би очиж юуны магад

Шаналах ланчиг тулих зовлон минь хэдий даагдашгүй боловч

Сайн нөхөр , өршөөлт хүнд хэзээд би очно.

Гэжээ . Хөвгүүний энэ үгийг сонсоод мөнөөхөн хаан өгүүлрүүн : Ай хөвгүүн чи үгээр эл мийний гунигийг хөнгөрүүлсэн атал санаагий минь улам зовоов. Тэрхүү шархтай боолын хэвтэх булш одоо хаа байна?

Гэсэнл хөвгүүн өгүүлрүүн: Тэрхүү боол булшин доторхи бүрхүүлийн дор хэвтэнэ . Миний нагацын охин урдаас харсан хаалганад сууж өглөө нарнаар босож миний хувцасыг тайчин нэвширтэл занчин өшөөг аваад мөнөөхөн арабдаа шөл дарс хийж өгнө. Одоо маргааш өглөөнөөс нааш ирэхгүй гэхэд нь хаан , Судapт бичигт үллдэж миний нэрийг дуурсах тийм сайн үйл хөвгүүн ёиний төлөө бүтээсүгэй гэж Аллахыг ам алдан өгүүлсүгэй гэжээ .

Хаан тэндээ хөвгүүн лүгээ ярилцан хоноод маргааш өглөө үүрээр хувцасыг нь тайчин, илдийг барьсаар боолын х боолын хэвтэх газрыг очивоос лаа дэнлүү хүж тэрүүтэн асаасан, бас савтай тос байна. хаан тэр боолйыг алж хутагт хаяад

боолын хувцасыг нөмрөн булшинд илдээ сунган хэвттэл хүүхэн босож хөвгүүнийг нэвүширтэл ташуурдаад “Ай нагацын минт охин одоо намайг зовоохыг болиоч! Намайг өршөөгөөч !” гэхэд нь “Ай чи намайг миний сэтгэлтэй хүнийг өрөвдсөн үү? ” гэж орйоолгон цус нөж нь шүүрсэн хойно сая больж ширүүн таар өмсгөж хувцасы нь нөмөргөөд доош бууж булш дор очоод Аяа ноёнтон минь надтай ганц удаа боловч яриач гэж аргадаад

Аль болох чи надад ийнхүү ширүүн байх юм бэ?

Асгаруулах нулимсы минь хэмжжэ гүйцсэн бишүү?

Аль болтол чи надаас зориуд хагацах юм бэ?

Атаархагч хүндээ сайныг хүссэнээр тэр эдгэрчээ .

Гээд уйлан өгүүлэхэд нь хаан дуугаа зориул өөр болгож, хар боол хүний дуугаар : “Аяа аугаа иах Аллахаас өр хүчтэй юм үгүй билээ” гэсэнд хүүхэн баярлан , “аяа ноёнтон минь, энэ чи ярьж байна уу” гэхэд нь “Ай муу заяат эм чи хэнтэйы боловч ярих өгүүлэх эрхгү©” гэсэнд “Яагаад тэр билээ” гэхэд нь “Чи эр нөхрөө өдөржин зоддог тул тэр бээр Аллах тэнгэрээс хараж, эс унтуулна . Үүнээс болод миний бие үл тэнхрэнэ” гэсэнд “аяа , тэгвэл чи тэр хөвгүүнийг зовлонгоос ангижруул гэж байн уу?” гэхэд нь “Даруй суллан санаа сэтгэл амраагаалд өгөөч!” гэжээ . Хүүхэн “За” гээд өргөөндөө орж нэг аяганд ус хийгээд амандаа тарина унштал аягатай ус аянлаа оргилон , тогоотой ус адил бургилан буцалсанд хөвгүүн дээр цацаж “Миний хараалаар ийм болсон аваас буцаж хуучин зандаа орогтун!” гэсэнд хөвгүүн биеийг сэгсэрэн босож ирээд Аллах тэнгэр ба түүнийг төлөөлчг Мухамед хамгаас илүү хүчтэй одо би үзэв. Аллах өршөөх болтугай хэмээвээс хүүхэн “Одоо чи энздээс зайл!” Эргэж ирвэл чамаг ална

Гэжээ . Хүүхэн тэндээс нөгөө бунханд очиж, “аяа ноён минь нэг гараад ирээч, гэгээн царайгий чинь нэгэнтээ боловч харъя” гэхэд нв хаан, дуугаа нам болгон өгүүлрүүн:

“Чи сая тэр хөвгүүнийг сулласнаас миний зовлонг өюхөн мөчрөөс нь ангижруулжээ . Би бүр үндэснээсээ ангижрахыг хүснэм” гэсэнд . “Аяа ноён минь үндэс нь энэ хотын иргэд дөрвөн арал билээ . Тэр олон загас шөнө тутам уснаас толгой өндийлгөн Аллах тэнгэрээс өршөөл эрч чи бид хоёрыг хараах тул бие огт тэнхрэхгүй байна. Чи одоохон очиж тэдгээрийг хуучин ёсоор нь ыболгоод миний гараас татаж босгогтун . Би үзтэл илаарь болж байна гэжээ .

Хүүхэн энэ үгийг сонсоод, үнэхээр хар арсьт боол ярьж байна гэж үнэмшээд ихэд баярлан “Аяа ноён миньв чиний зарлиг над адис мөн. Аллахын төлөөнөөс цөмийг гүйцэтгэсүгэй!” гээд нуурт очиж уснаас нэг аяганлд хийж үл мэдэх үг амандаа үгдлэн цацатал хууёин хот балгад хэвээр бий болж ард иргэд нь цөм хөдлөн худалдаачингууд арилжаа наймаагаа хийж хуучин арад хэвээр болов.

Хүүхэн тэндээм буцаж ирээд “Аяа хайрт амраг минь эрхэм сайхан гаар аль, би татаж босгогтун” гэтэл хаан, “Чи над бүр ойр бологтун!” гээд илдийыг гарган хүүхнийг тас цавчин хоёр болгов.

Хаан бунхнаас гарч иртэл хөвгүүн хүлээн зогсох бөгөөд амь авасрна гэж туйлын баярлан тал өвгөөс хаан: “Чи эл хотдоо үлдэх дуртай юу? Миний хотод очих дуртай у?” гэсэнд Хөвгүүн

“аяа цагийг эзэлсэн их хаан минь эндээс хэдий хэрийн газар гэж та сана ?” гэхэд нь “Эндээс хоёр хоногийн газар даа”гэжээ . хөвгүүн өгүүлрүүн: танай их хот хүэрэхэд саадгүй явахад жилийн газар болой. Энэ хот илбийн хүчинд автагдсан байснаас та хоёр хоногийн дотор хүрэлцэн ирсэн болой. Тэгэвч би танаас хормын төдий ч салахгүй хэмээвээс хаан баярлан дуун алдаж, “аяа Аллах тэнгэр чамайг надав заяажээ . Би үр хүүхэдгүй учир чи миний ганц хүү болсугай” гэжээ

Хоёул тэсгэлгүй баярлалдан ордонд морилон орцгоовол залуу Султан хуучин сайд түшмэл хэвээр бий болсон байх тул тэднийг захииран их аянд арван µоног зэхүүлээд их бэлэг авч , тавин зарц дагуулан замд хөдлөөд өдөр шөнөгүй довтолгосоор нэг жил аяолж Аллахын өршөөлөөр хааныг эсэн мэнд эгж ирэв хэмээн баярлалдан сөгдөн мэхийж амрыг эрсэнд хаан тэр хөвгүүн лүгээ учирсан намтраа ярьж цөм санаа сэтгэл амарцгаалаа .

Султан хаан олон хүнд шан өгөөд мөнөөхөн дөрвөн загасчиныг дуудаж , их хишиг хүртээгээд рдрр хэн хэнтэй хэрхэн амь зуух буйг асууваас хоёр охин нэг хүүтэй гэсэнд хоёр охины нь авчруулж нэгийг өөрөө гэргий болгож нөгөг хөвгүүнд өгөөд загасчинйы хүүүг хааны сангын нярав болгожээ . Тэгээд шадар сайдаа мөнөөхөн хөвгүүний хуучин хотын Султанаар томилон , бараа болж ирсэн таювин зарцын хамт тийш илгээгээд хөвгүүнийг дэргэдээ авч үлдэв. Загасчин хамгийын баян хүн болж , хоёр охин нь хааны хатан болоод үхлийг иртэл амар сайхан жаргах нь тэр бүлгээ .

# ÃÓÐÂÀÍ ÀËÈÌÍÛ ¯ËÃÝÐ.

Харун Рашид Халиф нэг өдөр шадар сайд Жафарыг дуудаж ийн өгүүлрүүн: Би хотоор засаг ноёдыг ард иргэд хэрхэн үздэгийг асууж мэдэхийг хүснэ. Муу гэгдэснийг нь огцруулж сайн гэгдэснийг нь шагнаа гэсэнд шадар сайд нь за гэж Халиф , Жафар, Масрур гурав хотын гудамж зээлээр хэчжээ . Нэгэн гудамжнаа насан гуйлын өндөр болсон өвгөн толгой дээрээ өгөөш сагс тавьж таяг тулан явна.

Тэр өвгөн шүлэглэх нь:

“Сартай шөнө лугаа адил саруул номтой хүн байна” гэж

Сайшаан тэд намайг өгүүлэх нь буй .

Эрдэм номыг гагцхүү эрх баригчид мэднэ.

Энэ дэмий үг гэж би тэдэнлд хэлнэ.

Бэр, цаас эрдмээр минь дэнчин тавьсан ч тэр ,

Би нэгэн өдрийн идэх хоол үасан ч олж эс чадна.

Золгүй хоосон ядуу хүний

Зовлон их, амьдрал бүрхэг ажээ .

Зуны цаг хоол олж үл иднэ. Зөвхөн хоовон юугаар өвөл биеийг ээнэ. Золбин нохой харан дайран Дамын хүн жигшин хараана.Ядуу зовлонгоо гомдон мэдүүлбэл Ямар амьтан эс тооно. Ядуу хүнийы зовлон дандаа ийм аваас Яс амар авсанд хэвтвэл дээр буюу . гэж шүлэглэхийн Халфи сонсоод, өвгөн дээр олчиж чи ямар ажил хийдэг хүн бэ ? гэсэнд өвгөн өгүүлрүүн: “Айноён минь би загасчин хүн билээ . Гэр бүлээ тэжээх хэмээн өдөр бүр гартал өдий болтол Аллах бидэнд идэх юм хайрласангүй заяандаа хормон гомдож үхвээс дээр гэж бодож байна гэсэнд Халиф: За чи бидэн лугаа буцаж хамт оч! Тигр мөрний эрэг дэр очоод өгөөш тороо тавигтүн. Чиний өгөөшинд юу гарч ирвээс нэг зуун динар зоосоор би авсугай гэжээ . Өвгөн за гээд тэдний хамт очиж өгөөш тороо усанд тавиад гаргатал нэн хүнд цоожтой авдар гарчээ . Өвгөннэгэн зуун динар зоос өгч буцаагаад , мөнөөхөн авдрыг ордонд авчраад Жафар, Масрур хоёр эвдлэн үзвэл дотор нь дал модны навчаар сүлжин хийсэн сагс байх бөгөөд улаан мяндсаарр хамгамалдсан ажээ . Сагсыг адлан үзвээс нэг жижигхэн хивс, түүнийг сөхтөр цалин мөнгөн адил цав цагаан залуу эмийн хэрчин алж орхимжонд боосон байжээ . Халиф ихэд гуниглан хацрыг даган нулмс асгаруулаад , Жафарт өгүүлрүүн: Ай муу нохой чи! Минийүед хүн алж усанд хаядагш хүн бий хэрэг үү ! Энэ болбоос хоижм хойно миний нэрийг хөөдөх тул энэ эмийг ийнхүү аль муугаар тамлан алсан хүнийг би заавал олж зохих цээрлэл үзүүлэх ёстой гээд Халиф нэн хилэгнэн , энэ эмийг алсан хүнийг чи заавал олж ирэгэтүн! Эс олж ирвэл чамайг, чиний садангийн дөчин хүний хамт ордны хаалган дээр дүүжлэн ална гэж аль- Абаасын хөвгүүд бүх Халфиийн нэрийг барьж ам алдсугай ” гэжээ . Жацар тэндээс гарч ихэд гутран “Энэ эмийг алсан хүнийг би хаанаас хэрхэн олох билээ. Өөр хүн аваачвал хожим хойно нэрд муу болно. Одоо ядаг билээ” гэж бодсоор харьж гурван хоног гэрээс гарсангүй . Дөрөв дэх өдөр Халиф дуудуулж “За тэр эмийг алсан хүн хаа байна” гэхэд нь Жафар “Тэр эмийг алахыг би харж байсан биш хэрхэн мэдэх билээ?” гэсэнд Халиф ихэд хилэгнэн Жафарыг дүүжилсүгэй хэмээн зарлиг буулгаад энэ тухай хотын иргэдэд зарла гэсэнд зарлагч хүн Багдад хотын гудамжнаа гарч өндөр дуугаар: “Халифийн тэргүүн шадар сайд Жафар Бармакадыг, Бармакидпийн удмын дөчин хүнийг хамь Халифийн ордны үүдэнд дүүжлэн алахыг үзэх хүн байвал очиж үзэгтүн” гэж зарлан тунхагласанд хотын иргэдл учрыг эс мэдэрч цөм цуглажээ. Ордны үүдэнд дүүжлүүр засаж дор нь Жафарын төрөл садангийн аваачаад ганцхүү Халифын алчуур дохихыг хүлээхүес улс амьтан тэднийг өрөвдөн уйлцгаана. Энэ үеэр арван тавны сар мэт цэвэрхэн царайтай гоё сайхан хувцастай, өргөн магнайтай , ягаан хацартай сарнай цэцэгийнг баглаа адил залуу хуран цугларсан хүмүүсийн дундуур чихэлдэн гарч ирээд “Аяа бүх эмир ноёдын ноён ядуу биднийг тэтгэч чи энэ лайнаас мултарчээ

. Тэрхүү авдарт хэвтсэн эмийг би алсан хүн биибиеэр байна. Намайг дүүжлэгтүн” гэсэнд Жафар өөрийн бие суллагдах болсонд баярлан өрөөл хайран залуу дүүжлэгдэх болсон гомдон бас нэг насан дээр гарсан хариугүй өвгөн гарч ирээд Жафарт өгүүлрүүн :”Хааны шадар сайд эрхэм ноён минь , энэ хөвгүүн худал хэлж байна . тэрхүү эмийг жинхэнэ алсан хүн би энэ зогсож байна . Намайг даруй дүүжлэн , тэр эмийн хариуг авагтүн гэж Аллахыг дурдан дурдан өгүүлье” гэсэнд хөвгүүн “Ай хааны шадар сайд аа, энэ муу зөөнөг өвгөн билний ярьж байгааг юу мэдэх билээ . Намайг дүүжлэн цээрлүүлэгтүн” гэхэд нь өвгөн: “Ай хүү минь чи бол амьдын жаргалыг дөнгөж амсаж яваа сайхан залуу хүн байна. Би бол өтөлж үхэх болжээ . Чиний амь , шадар сайдын садангийн энэ олон хүний амины төлөөнөөс би үхсүгэй. Тэр эмийг чухам алсан хүн би зогсоогоороо байна. Намайг шалавхан дүүжлээд аль!” гэжээ . Жафар хоёулангий нь дагуулан Халифт бараалахад өлмийн дор сөгдөн “Аяа үнэн шажинтны их хаан мөнөөхөн эмийг алсан хүнийг авчрав ” гээд “Энэ хөвгүүн тэр эмийг би алсан хэмээн биеэр өчих атал энэ өвгөн хөвгүүнийг худал хэлж буй , чухамхүү алсан хүн нь би байна гэж батлан өгүүлэх ажгуу ” гэжээ . Халиф, “Та хоёрын хэн нь тэр эмийг алав? Гэсэнд хөвгүүн “Би алсан ” гэтэл өвгөн “Би алсан” гэжээ . Халиф , “Хоёуланг дүүжлэн хороосугай” гэсэнд Жафар өгүүлрүүн “Хэрэв энэ хоёрын нэг нь алсан байтал нөгөөг дүүжлэх нь зүйд үл нийцнэ” хэмээвээс, хөвгүүн “тэр эмийг би алсан гэж ” гээд мөнөөхөн сагс дотор хийж орхисон байдлыг нэгд нэггүй тоочин өгүүлбээс “Лав эхэ хөвгүүн алсан ажээ” гэж Халиф итгээд учир шалтгааныг слнирхон , “Чи ямар учраас тэр эмийг дураар алаададаг сүүлд нт ямар шүүлтгүйгээр өөрийн алаад адаг сүүлд нь ямар ч шүүлтгүйгээр өөрийн алсныг хүлээн өчив?” гэж хөвгүүнээс асуув. Хөвгүн өгүүүлрүүн: “Аяа үнэн шажинтны их хаан мэдтүгэй! Тэр эм бол миний гэргийг манай нагацын охин билээ . Энэ өвгөн бол охины эцэг миний нагац бүцлгээ . Бид хоёр ханилан суутал Аллах тэнгэр өршөөж гурван хөвгүүн заясан агаат тэр минь надад хайртай, би ч түүнввлд хайртай байлаа . харин энэ сарын эхээр сүрхий айхтар өвчлөн оточ домч нар ангаан арай гэж илээрь болтол, би түүнийг халуун усанд оруулж биеийг угаахыг хүсвээс ийн өгүүлрүүн. Би халуун усанд орохын өмнө жаахан алимны үнэр авч нэг хоёр хазах юмсан гэлээ . Маргааш өглөө нь би алим эрж хотйн бүх цэцэрлэгээр яваад олсонгүй . Нэгэн жимсчин өвгөнтэй уулзаж сураглаваас: “Ай хүү миэнь одоо алим олдоход тун бэрх . гагцхүү Баср хот хүрвэл тэнд үнэн шашинтны их хаанд таввьж хадгаласан цөөн алим байдаг” гэлээ . Би гэргийдээ их хайртай учир тийшээ явахаар шийдээд Баср балгад орж тэндэхийн цэцэрлэгчээс гурван алим гурван динар зоосоор худалдан авч ирэх очихын арван таван хоног явж авчраад гэргийдээ өгвөөс ихэд баярлан хажуудаа авч тавилаа . Би зээлийн газар мухлагийн нээж арилжаа наймаагаа хйж байтал , нэгэн хар арьст боол мөнөөхөн гурван алимтай адил нэгийг барьж явахыг үзээд , “Ай сайн санаат боол , чи энэ алим хаанаас олов? Над бас олох жхэрэгтэй байна” гэсэнд боол өгүзүлрүүн . “Би сэтгэлтэй хүүхнээсээ авлаа . сая хэдэн хоног юманд яваад иртэл тэр минь өвчтэй байна. Хажуудаа гурван алим тавьж “Миний эр нөхөг _ Барс балгад орж гурван алим гурван динар зоосоор худалдан авчрав” гэж байна. “Над нэгийг өглөө” гэв. Боолын үгийг сонсоод дотор харанхуйлаад яаран мухлагийг хааж, гэртээ хариваас хоёр алим үлдсэн байлаа . миний хилэн нэнэ бадарч “Нэг алим яасан

бэ" гэсэнд "Би мэдэхгүй хараагүй" гэлээ . хар арьст боолын хэлсэн үнэн болохйг мэдээд би гэргий юугаа үг дуугүй хоолойг тас хэрчин толгойг салган орхимжоор ороогоод жижиг хивсээр бүтээн сагсанд хийж авдарт хадаад Тигр мөрөндө аваачиж хаяь гээд хөвгүүн үргэлжлүүлэн өгүүлсэн нь: "Аяа , үнэн шашинтны их хаан , намайг шалавчхан дүүжлээд өгөөч! Бодохоос айдас хүрнэ . Гэргий хүүрийг сэм тигр мөрөнд хаяад ирэхэд миний том хүү уйлчихсан зогсож байв. Эхийгээ тийм болсон гэж огт мэдээJүй атал ямар учиртайг гайхан "Миний хүү яав?" гэсэнд миний хүү хэллээ ."Ай би эхиын дэргэд байсан гурван алимны нэгийг авч гадаад гудамжинд тоглож байтал нэгэ- өндөр хар боол ирж шүүрэн аваад "Чи үүнийг хаанаас олов? Гэхэд нь "Миний ээж өвдөхөд аав Баср балгад орж гурван алим гурван динар зоосоор худалдан авч ээжид авчирч өгсөн юм хэмээсэнд намайг тоолгүй коож орхиод алимыг аваад явчихлаа . Би эхээм айгаад хоёр дүүгийн хамт хотын захад гартал орой болж бас айгаад буцаж ирсэн. Аваа , ээжид битгий хэлээрэй . Өвчин нь илаарь болсон атал дахин лдордож мэднэ" гэлээ .Хүүгийн энэ үгийг сонсоод тэрхүү хар боол санаанаас зохион худал ярьжээ гэж мэдмэгц би ихэд гашуудан уйлж суутал энэ миний нагац өвгөн орж ирсэн юм . Би учрыг нуулгүй ярьсанд хоёулаа уйлж гашуудал үйлдээд яг таван хоног болов. Би гэргийдээ ямар ч гэмгүй байхад алсан минь үнэн, энэ явдал ганцхүү тэр хар арьст боолоос боллоо. Ингэхлээрээ одоо намайг даруй алагтүн! Би нэгэнт гэргийдээ алсан хойно надад амьд яваад ч ямар хэрэг байх билээ гэжээ . Халиф үүнийг сонсоод нэнэ гайхаж , "Тэр муу ёрын боолыг олж дүүжилсүгэй!" гээд шадар сайд Жафартаа ийн өгүүлрүүн: "Чи явж тэр мууг заяат боолыг олж ирсүгэй Эс олж ирвэл чамайг оронд нь дүүжилнэ" гэжээ . Жафар "Би заавал үхэх тавилантай ажэ . Ваар домбо нэг унахад тэсэх боловя дахин унагаваас үйахин тэсэх бимлээ . ХэрхэхийJ Аллах тэнгэр мэдтүгэй. Ямар ч боловч гурав хоног гэрээс үл гарсугай" гэж бодсоор харьжээ . Дөрөв дэх өдрийн өгөөл шүүгч гэрчийг дуудаж гэрийнхэтэйгээ салах ёс хийж байтал Халифиын зарлага ирж маш их хилэнтэй , таныг дуудаж , өнөөдрөөс хэтрүүлэхгүй дүүжлэнэ !" гэж байна гэлээ . Энэ үгийг сонсоод Жафар ба Жафарын болон хүүхэд боол зардсан нар цөм уйлав. Жафар хамгийн бага охиндоо их хайртай байжээ . Бага охиноо яаж орхин одно гэхээс зүрх шимшрэн уйлж тэврэн тэврэн үнэстэл өвөрт нь нээн хатуу бөөрөнхий юм байхыг мэдээд "Өдөрт чинь юу байнам?" гэсэнд "Ай аав аа, энэ бол хаьсан дээр нь манай Халифийн нэр бичжээстэй алим байгаа юм гэжээ . Жафар өврөөс алим гаргаж ихэл баярлан "Ай бурхан минь ямар а ачтай вэ?- гэж дуун алдаад боол Рейханыг даруй дуудаж "Ай чи энэ алим хаанаас олов?" гэсэнд Рейхан өгүүлрүүн: "Аяа ноёнтон минь худал үг нэг улдаа аврах боловч үнэн үг үүрл аврах бүлгээ . Энэ алимыг би чиний шилтгээн эрхэмсэг хаан их Халифийн шилгээнээс хулгайлсан бус үүнээ с таван хоногийн өмнө хотын нэг гудамжнаа явж байтал хэдэн хүүхэд тоглож байсны нэг нь алим барьж байхыг үзээд би булаан авсанд тэр хүүхэлд уйлж:"Ай сайн эр, чи сонс! Миний эх өвчтэй хүн, Аав Баср балгад орж ээжид гурван алим, гурван динар зоосоор авчирч өгсний нэгийг би хулгайлан тоглож байна" гэхэд нь би тоосонгүй алгадаж орхиод алимыг авчирсанд манай хамгийн бага хатагтай хоёр динар зоос®ор авсан юм дээ" гэжээ . Жафар өөрийн нь боолоос болж тэр эмийг алсныг мэдэж хэд, гайхаж, бас гуниглавч өөрийн толгой мэнд үлдэх болсонд ихэд баярлан ийн шүлэгрлэрүүн: Золгүй явдал чамд

тохиолдохын цагт чи . Золиосонд боол зардсан нараас гаргагтүнОлон зарц олъё гэвэл чи чадна Ондоо ссэтгэл олъё гэвэл чи эс чаднаГээд мөнөөхөн броолйыг хөтөлсөөр Халифт бараалхан эл болсон намтрыг ярьсанд Халиф ихэд сонирхон тас гэдрэг хөхрхөн унаж энэ үлгэр түүхийг бичиж улс иргэдэд тараагтүн" гэхэд нь Жафар өгүүлрүүн: "Аяа, үнэн, шашинтны их хаан минь та бүү гайхагтүн! Энэ бол Мисир

ÍÓÐÓÓÃ¯É Õ¯ÍÈÉ ¯ËÃÝÐ

газрын шадар сайд Нур-ад-Дин Аль ба Шамс-Ад Дин Мухаммед, түүний дүүгийн үлгэрийг эс гүйцэнэ " хэмээвээс Халиф , "Тэр гайхалтай сонин үлгэрээс ярь" гэхэд нв "Аяа их Халиц аа, хэрэв чи миний боолыг фаазаар авахаас хэлтрүүлнэ гэвэл ярина" гэсэнд "Тэр үлгэр чинь нэн сонин аваас чиний боолын амийг хэлтрүүлнэ тиймгүй бол толгойгий нь заавал авна" гэжээ . НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Өгүүлэхнь : Эрт урьд цагт хятадын нэгэн хотноо найр наадамд маш дуртай нэгэн үйлчин хүн суудаг байжээ . Тэр үйлчиэн эхнэрээ дагуулж зугаалахаар явнам билээ . Нэгэн өдөр хоёул өглөө эрт гадагш гараад, орой наран шингэхэд гэртээ харьж явтал замд нь уйдсан хүнийг сэргээх, гашуудсан хүнийг инээлгэх тийм сонин ббайдалтай нэгэн нуруугүй хүн тохиолдсонд үйлчин эр эм хоёр түүнийг үзээд манай гэрт очиж хоол идье хэмээн гэртээ аваачсанд үйлчин зээлийн газраас шарсан загас, боов нимбэг , ээзгий худалдан авч ирээд ширээ засаж гурвуулан хоол идтэл үйлчин эм загасны махнаас ачвч тэр нуруугүй хүний аманд чихээд амыг гараар бөглөж өгүүлрүүн: Би чамд зажлах чөлөө өгөхгүй , чи үүнийг нэгэн амьсгаагаар залгиг тун хэмээсэнд тэр нуруугүй хүн загия гэтэл ясанд нь хахаад насны хэмжээ гүйцсэн тул үхэв. үйлчин хүн үүнийг үзээд ихэд айсанд эм нь сурган өгүүлрүүн: Чи үтэр босож миний торгон алчуур авчрагтун: Үүнийг ясынн алчуурт ороож миний хойноос тэврэн явсугай . Хэрэв замд хүн тохиолдвол миний хөвгүүд гэнэт өвчин туссан тул бид хоёр хүүхдзийг эмчид аваачиж явна хэмээсүгэй хэмээн арга заасанд үйлчин яаран босож тэр нуруугүй хүнийг гартаа тэврэн явсанд эм нтзамд хүн уулзваас ай хүүхээ чиний бие хаа өвдөнө. Цагаан бурхан чиний хаана гарав хэмээн асуусаар явахад үзсэн хүн бүхэн энэ хоёр өвчтэй хүүхдийг авч яьна гэж бодох ажээ . ингэж явсаар зам гудмын хүнээс эмчиг сураглан асууж, , нэгэн евхрей эмчийн гэрт очиж хаалгыг тогшсонд нэгэн хар царайт шивэгчин хаадга цнээж, та нар юун хүн б? Хэмээн асуусанд, бид хоёр энэ өвсчтэй хүүхдийг эмчид үзүүлэхээр ирэв та энэ харамжийн зоосыг эмчид баригтун хэмээн алтан динарын дөрвөн хувийн нэгийг барьсанд тэр шивэгчин гэрт орсон завсарт, үйлчний эм яаран дотогш оруулж нөхөртөө өгүүлрүүн: "Тэр нуруугүй хүнийг энд түшүүлээд зайлсугай хэмээсэнд үйлчин тэр үхдэ«ийг отчийн байшингийн тууртанд түшүүлэн сэм зайлав. Тэр завсар шивэгчин эм , эмчийн дэргэд очиж мана хаалганы гадна нэгэн өвчтэй хүүхэдтэй эр эм хоёр ирээд эм залах гэж энэ алтыг өгөв хэмээсэнд еврей тэр алтыг үзээд тэсгэлгүй баярлаж яаран сандран дорогш буутал харанхуйд тэр нуруугүй хүнийг дайран унагаж цочин өгүүлрүүн: Ай их Богд минь ! ай Моисси минь, ай Арван зарлиг минь , ай Аарон минь , ай Нуйн хөвгүүн Иисус минь , би энэ өвчтөн хүнимйг дайран унагаж алсан байнам. Одо яадаг билээ хэмээн тэр нуруугүй хүнийг гэртээ тэврэн оруулж

эхнэртээ хэлбээс эхнэр нь сурган өгүүлрүүн: Ийм хэрэг гарсан атал чи юунд лаглайн сууна. Хэрэв чи өглөө болто ингэж сууыаас чи бид хоёрын амь үрэгдэнэ. Энэ хүүрийг авч гэр дээр гаргаад манай хамар хашааны лал айлд ориё хэмээв. Султаны догооны гэрээс тос өөх гэртээ авчирдаг ажээ . Тэр авчирсныг хулгана муур байлгадаггүй тас иднэм бөгөөд сайн тарган хониняы сүүл байваас нохой хулгайлан их л залхаадаг бүлгээ . Еврей эмч эхнэртэйгээ , тэр нуруугүй хүнийг үүрч, мөнөө айлын байшингийн тууринд сэмхнээ түшүүлж яаран зө зайлтал тэр гэрийн эзэн буцаж ирээд зцл барьж гэртээ ортол буланд нэгэн хүн буйг үзээд аяа миний хүснийг энэ хүн хулгайлдаг аж. Миний мах шөлийг нохой мигуй хулгайлна хэмэн сэтгэж Јудамжны олон нохой , мигуй ал¦ хичнээн хилэнц хураасан билээ . Үзвээс хулгайч нь энэ байна хэмээн том алха барьж тэр нуруугүй хүнийг нэгэнтээ дэлмэгц унасанд их айн эмээж ай тэнгэро ээ, энэ муу сайн өөх сүүлийн төлөө би хүний аминлд хүрэв хэмээн нарийвчлан үзвээс тэр үхсэн хүн нуруугүй ажээ . үүнд тэр тогооч нарын дарга хараан өгүүлрүүн: Чи нуруу бэртэнэ болоод бас хулгайё болж бусдын мах тос хулгайлна уу? Ай тэнгэр минь наанаа наана гэж нуруугүй хүнийг үүрэн гарч зээлийн газар хүрч нэгэн дэлгүүрийн хажууд түшүүлэн зогсоож , зайлсанд нь Султан хаанд бараа нийлүүлэх нэгэн согтуу эрхүүд (Христосын шашаинтай хүн) өглөөний мөргөлийн цаг ойртов. Халуун усанд очж осругай гэж нагалзан алхсаар тэр нуруугүй хүний тушаа хүрч ирээд шээж суутал гэнэт дэргэдээ нэгэн хүн үзээд урьд үдэш малгайгаа хулгайд алдсан тул энэ хүн бас миний малгайг хулгайлах гэж байна хэмээн нудрагаа зангидаж тэр хүний хүзүүн тус газар нэгэнтээ хүчлэн дэлсмэгц , унасандп тэр согтуу эрхүүд зээлийн манаачийг хашгиран дуцдаж , тэр нуруугүй хүнийг нудрагадан занчтал манаач ирж үзвээс нэгэн эрхүүдп хэн нэгэн лал хүнийг өвдөглөн занчиж буйг үзээд энэ юу болов хэмээсэнл эрхүүд өгүүлрүүн. Энэ хүн миний малгайг хулгайлсугай хэмээсэн бүлгээ гэсэнд манаач бос хэмээн зандран босгож тэр нуруугүй хүнийг үзвээс хэдийн үхсэн утл ай аллах , энэ муу эрхүүд манай лал хүнийг алж байнам хэмээгээд тэр эрхүүдийн гарыг хүлж заргчийн гэрт хүргэсэнд эрхүүд, ай тэнгэр минь, ай тэнгэр минь би ахин түүнийг санамсаргүй алав. Тэр миний ганц шаахыг даахгүй юутай хялбар үхэв хэмээн гасалж согтуу нь гарав. Өглөө болсонд тэр ялт эрхүүдийг дүүжлэн алсугай хэмээн тушаан зарласанд зандалчин хүн тэр эрхүүдийн хүзүүнд олс орхиж дүүжлэн алсугай хэмээтэл, олны дотроос тогооч нарын дарга гарч ирээд энэ хүнийг бүү алагдтун . Тэр бэртэнгэ нуруутыг би алсан юм . Өчигдөр орой би гэртээ харьж ирвээс энэ нуруугүй хүн миний гэрт өрхөөр давж ороод хоол хүнс хулгайлсанлд би тэвчиж ядан хорсож алахаар нэгэнтээ хүчлэн өвчүүний тус дэлссэнд унаж үхсэн тул хүүрийг зээлийн газар аваачиж , тийм тийм газарт түшүүлэн орхисон билээ . Эдүгээ би нэгэн лалыг алаад бас ямар сэгэлээр нэгэн эрхүүдийг үхүүлээлэхэд хүрүүлэх вэ?. Албал намайг алтугай гэсэнд заргач тэр эрхүүдийг суллан тавьж, ялаа нэгэнт хүлэсэн энэ хүнийгш цаазаар аваачигтун гэсэнд зандалчин , олсыг тэр эрхүүдийн хүзүүнээс мулталж тогоочийн даргбн хүзүүнд орхитол гэнэт олны дотроос еврей эмч түлхэлдэн гарч ирж хашгиран өгүүлрүүн: Тэр нуруу муутыг өчигдөр үдэш би үхүүлсэн билээ . Ороо нэг эр эм хоёр энэ нуруу муутыг авч ирээд манай шивэгчинд мөнгө өгч надаам эм гуйж өвчтэй хүнийг миний шатан дээр үлдээн явсанд , би харанхуйд түүнд торж шатан дээрээс унагаж үхүүлээд эм лүгээ

хоёулан хүүрийг авч энэ тогооё нарын даргын гэрийн өрхөөр оруулсанд гэрийн эзэн удалгүй ирээд тэр хүүрийг хулгайч хэмээн алахаар дэ«сэн унагаж, түүнийг цохиж алав хэмээн санасан бүлгээ . Би нэгэн лалын санамсаргүй алсан атал , бас нэгийг ямар аймшЁгггүй мэдсээр үхүүлнэ гэсэнд заргаё зандалчинд тушааж , урьтах хүнийг суллан , энэ еврей цаазаар аваачигтүн хэмээсэнд, зандалчин еврейг барьж олсыг хүзүүнд өлгөтөл олны дотроос үйлчин ургаш давшүин гарч ирээд хашгиран өгүүлрүүн: Аяа энэ хүнийг тавигтун . Тэр бэртэнгэ нуруутай хүнийг би үхүүлсэн билээ . Өчигпөр үдэш тэр бэртэнгэ нуруутыг зээлийн газар согтуу явахыг үзээд гэртээ аваачиж зочилбол , миний эм загасны махнаас авч бэртэнгэ нуруутын аманд чихсэнд хахаж үхсэн бүлгээ . Хүүрийг эм бид хоёр энэ эмчийн гэрт аваачиж орхисон билээ . Энэ эмч харанхуйдп хүүрэнд торж унаснаа өвчтэй хүнийг дайрч алав гэж санажээ . Миний энэ үнэн үү гэж эмчээ асуусанд эмч өв зөв гэнэ. Төдий тэр үйлчин заргачин зүг өгүүлрүүн: Энэ еврейг тавьж намайг алагтун гэсэнд, заргач их л гайхаж , ийм сонин хэргийг үнэхээр дансанд тэмдэглэлтэй хэмээгээд зандалчинд тушааж энэ еврейг тавьж үйлчнийг дүүжлэгтүн хэмээсэнд зандалчин , үйлчин хүзүүнд олс орхиж бид алах гэтэл, нэгийг барьж нэгийг таэвин хичнээн цаг өнгөрөөж дэмий л зовов хэмээснийг үл өгүүлэх нь : Тэр нуруугүй хүн Султан хааны шадар алиа хүн бүлгээ . Урьд өдөр архи ууж үгүй болсонд хаана очсон билээ . гэж асууваас тэр нуруугүй міутиын хүүрийг хаанаас хэрхэн олсон ба заргаёч үхүүлсэн хүнд үхүүлэх ял оноож цаазаар аваачих хэмээтэл , хоёр гурван хүн гарч ирээд цөм би алсан хэмээн мэдүүлснийг Султанд айлгавал , Султан хаалгачийг дуудаж тэр бүгдийг авч ирэгтүн хэмээн тушаасанд бүгдийг Султаны өмнө авч ирсний хойно , Султан хаан, заргачаас хэргийн учрыг ихэд гайхан сонсож алтан бэхээр тэмдэглүлэн бичүүлээд олны зүг энэ нуруугүй хүний явдлаас илүү гайхамшигтай сонин түүх сонссон хүн байна уу хэмээн асуусанд тэр эрхмүүд урагша давшин гарч айлтгаруун: Айцагийн эзэлсэн хаанаа. Миний явдал бол энэ нуруу муутын явдлаас илүү сонин гайхамшигтай гэж айлгасанд хаан явдлаа өгүүлтүгэй хэмээв. Энэ эрхүүдийн гахамшигт явдлыш мэдьүгэй хэмээгчизд дараах бүлэгт үзтүгэй. ХОЁРДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь: Хаар тэр эрхмүүдэд явдлаа өгүүлтүгэй хэмээсэнд трэр эрхүүд айлтган өгүүлрүүн: Ай цагийг эзэлсэн хаанаа ! Би энэ газар элдэв зүйлийн бараа авчирч эртний хувь зохиолоор та бүхэнтэй учран золгосон боловч миний төрсөн газар Киарт бүлгээ . Би тэр газрын Копта угсаатны хүн . Миний эцэг худалдааны зууч билээ . Эцгийг нас нөгчисөнд мөн би зууч бож нэгэн өдөр худалдааны газар суутал , ертөнц хосгүй сайхан царайтай , гоёмсог хувцастай нэгэн залуу хүн илжиг унаж миний өмнө ирээд нэгэн алчууртай хүнждийн үр үзүүлж үүний нэгэн ардив ямар үнэ хүрнэ хэмээн асуусанд зуун динар хрнэ гэсэнл тэр залуу хүн алчууртай хүнждийг өгч Ялгуусан хаалгын Альжбалийн дэн ачих хэмжих хүнийг дагуулан очигтун. И тэнд буув хэмээгээд явсанд би тэр алчууртай хөнжлийг авч олон худалдааны хүнд үзүүлэн ардив бүрийг нэгэн зуун хорин дирхэмээр хэлэлцэн тогтож, ачих хүн дөрвийг дагуулан очиж хүндийг хэмжин үзвэл таван мянган дэрхэмийн үнэ хүрэх тавин ардив хүнжид байсан тэр залуу хүн өгүүлрүүн: Чиний зуучилсанд нэгэн ардиваас арвин дирхэм чамд идүүлье. Тэр мөнгийг бодож аваад, дөрвөн мянган таван зуун дирхэмийг хадаглагтүн. Би наймаа хийж дуусмагц сүлүд нэг мөсөн авна

гэсэнд би тэрц өдрийн наймаанаас нэгэн мянган дирхэм олов. Тэр залуу нэгэн сарын эцэст ирж миний мөнгө хаана байна хэмээсэндп энд байна хэмээн гаргаж өгсүгэй гэвэл, тэр залуу би түр зуур гарч ирээд аюкъя хэмээн гарч явсанд хичнээн хүлээвч ирсэнгүй . Нэгэн сар өнгөрсөнд нэгэн өдөр маш сайхан хувцас өмсөж, арвантавны саран мэт гялбаан нэгэн сайхан луус унаж ирсэнд угтан соёрхож чи мөнгөө авна уу хэмээвэл надад мөнгө яаралгүй , хойно хэрэг дуусмагц нэгмөсөн авъяа гэж буцсанд би гайхан өгүүлрүүн: - Ай Аллах юутай сайн хүн билээ . Би түүний мөнгөөр наймаа хийж энэ завсар их ашиг олсон тул дараа ирэхэд нь эрхгүй ширээ засаж зочилсугай хэмээсэн бүлгээ . Тэр залу жилийн эуэст урьдынхаасаа нээн илүү сайхан хувцас өмсөж ирсэнд зочилсугай гэвэл ца ргалан маргасанд дахин дахин гуйвал тэр залуу өгүүлрүүн: Надад идүүлэх будаа зуушийн сүтйгэлийн чамд хадгалан буй михний мөнгөнөөс гарах бол би сая хүлээнэ гэсэнд, зүйл бүрийн идээ ундааны бэлтгэл засаж хуримлан суухад тэр залуу солгой гараар идсэнийг дотроо их гайхаж хуримлаж байсан хойно тэр учрыг асуувал залуу ханцун дотроос баруун гарыг сугалж үзүүлэн өгүүлрүүн: Чи намайг их зан гаргаж солгой гараар идсэн гэж ыүү бодоорой . Миний эн гарыг царвуугаар нь тас цавчсан тул би арга буюу солгой гараар иднэ гэсэнд, чиний гар тийм болсны учир буй хэмээн асувал. -Миний гарыг цавчсанд нэгэн гайхамшигтай учир буй . Би бол Багдад хотын нэгэн урвалжит гэрийн хүн бүлгээ . Олон аянчин жуулчин , бадарчин худалдаачлдид дотроос их л хүсэх тул эцэг нас нөгцсөн хойно Багдад Мосулын элдэв бараа , мөнгө зоос авч таны энэ Киар хотноо хүрч фирэхэд Масрурын дэнд бууж хоноод, зах зээлийн нэгэн хэсгийг зарцад бариулж , Жиржисийн зээлд хүрсэнд худалдааны олон зууч намайг ирсэн гэж сонссон тул угтан тосож миний барааг зарлан худалдвал үнэ дуудах хүн нэг ч гарсангүй . үүнд санаа зовж сууиал зууч нарын дарга иржэ өгүүлрүүн: Би чамд сайн санаж энгэн эрхэм арга зааж өгье. Чи өөрийн авчирсан эдийг бусад зочдын нэгэн адил бичээч, гэрч хэдэн хүний нүүрийн өмнө хэдэн сарынф зэSл тавьж худалдагтун. Чингэвэл долоо хоног бүр адъяа, барх сбадь тутам мөнгө хурааж нэгэ- дирхэм хоёр дирхэм олохоос гадна, Манай Киар хот болоо Нил мөрний сайхан үзэсгэлэнт үзэж чадна гэсэнв чиний тэр арга маш зөв арга хэмэн олон зууч, бичээч, гэрч нарын дэнгийн газар дагуулан аваачиж барааг зээлээр худалдсан бичиг хий өдөр бүр хурганы мах, амттан жимс идэж дарё уун уусааро мөнгө авах сар болсонд адъяа бархасбади гариг бүхэнд зээлийн газар очиж гэрээний ёсор авах мөнгийг хураах бүлгээ . Нэгэн өдрийн адъяа гаригт халуун усанд орж ирээд нэгэн хундага дарж ууж , хоол идээд унтаж боссоны сүүлд нэгэн тахианы мах идэж элдэв үнэртнийг шүршиж Бедр-ад-дин Аль бүстанын хэмээх нгэн хдалдааны хүний дэлгүүрт очиж энэ тэр хэмээн хэлэлцэн суутал гэнэт нэгэн сайхан биетэй эм , тэргүүнийг ман сайхан алчуураар бүтээж сайхан үнэртнийг анхилуулан хэйвэрис алхан ирээд нүүрийн бүтээлгийг сөхөж Бедх-Ад-динг ёслон тал өгч хэлэлцэн зогсоход би тэр эмийн хар нүдийг дотроо ихл хүсэв. Тэр эм, Бедр-Ад-динг гээс, Чамд алтан саатай торго бий юу? хэмээн асусанд надаас худалдан аваан торгоны дотроос нэгийг үзүүлж, нэг мянга хоёр зуун дирхэмээр хэлэлуэн тогтсонд тэр эм өгүүлрүүн: Би энэ торгыг одоо автугай мөнгийг дара хүргүүье гэсэнд худалдаачин өгүүлрүүн: Болохгүй, торгоны эзэн хүн энэ сууна . Би түүнд мөнгө иушаах болзоотой тул зээлдэн өгч чадахгүй

гэсэнд эм өгүүлрүүн: Би чамаас үүний урьд хичнээн юмыг үнээр авч мөнгийг эс хүргүүлсэн удаа үгүй, Чингэтэл энэ нэгэн зах торгоны үнийг ямар нүүрээр хүлээхгүй хэмээнэ гэсэнд худалдаачихн өгүүлрүүн: Авхайн үг түмэн зөв боловч энэ өдөр цав хэмээн мөнгө төлөх болзооны өдөр мөн тул энэ удаа үнэхээ чадахгүй гэсэнтд тэр эм торгыг Бедр-Ад-динг өмнөөс, хаяж таны худалдааны хүн үнэхээр ёс мэдэхгүй хэмээн хараан гарч явлаа миний сүнс тэр эмийн хойноос дагалдан гарах мэт болсонд яаран босож ай авхай өршөөн нигүүлсэгч эгж, чиний нүүрийг бодож дахин ирэв хэмээсэнд Бедр-Ад-динг ээс тэр торгыг авя үнийг хойч өдөр өгнө үү. Хэрэв эс өгвөл би чамд бэлэг барьсан болтугай хэмээсэнд тэр эм ерөөн өгүүлрүүн. Энэ торгоны үнийг хэлэлцэхээ болъё. Хэрэв чи бүрхүүлийг сөхөн шүүрийг үзүлэн гийгүүлбэл бас нэгэн зах ийм торго барина хэмээн тэр эмийн үзэсгэнэлт царайг гайхан үзэж их л хүссэнд тэр эм торгыг авч нүүрийг бүрхүүлээр дарж , аяа намайг битгий гундаагтун: хэмээгээд гарч явсан хойно тэр эмийг хүсэмжлэн санасаар ухаан баларч зээлийн газар үд өнгөртөл суув. Бедр-ад- дингээс тэр эмийнучир асуувал ийн өгүүлрүүн: Энэ их баялаг хүн бүлгээ . Түүний эцэг нэгэн эмир сайд агсан бгөөд нас нөгцсөнд энэ хүүхэн түүний хамаг өв хөрөнгөгийг эзлэн сууна гэсэнд би дэнд буцаж ирээд тэр охиныг хүсэн нойр хоолгүй хоножь, өглөө босоход өөр зүйлийн хувцас сольж өмсөөд нэгэн хундага архи ууж өглөөний хоолноос яаран амсаж сутал тэр хоин урьдахаас илүү сайхан хувцасыг өмсөж, нэгэн шивэгчнийг дагуулан ирээд намайг ёслон өгүүлрүүн: Би торгоны үнэ нэг мянга хоёр зуун дирхэмийг тушаан өгье. Та нэгэн хүнийг наймайг дагуулан явуулна уу хэмээсэнд надад мөнгөний яаралгүй гэж тэр охинтой үг хэлэлцэн суухын завсар түүнийг их л хүсэж буй санааг сэмхэн дохиогоор нэвтрүүлсэнд охин түүний мэдмэгц цочин босож яаран зайлсанд хойноос нэхэж гартал гэнэт нэгэн охин миний өмнө ирж өгүүлрүүн: Манай авхай эрхэм хүнтэй уулзахыг хүснэ гэсэнд их л гайхаж энэ газар намайг таних хүнгүй гэтэл охин өгүүлрүүн: Эрхэм хүн, хүнийг умартуулахад юутай хялбар . миний авхай надад тийм, тийм худалдаачны пүүсэндп орсон билээ . хэмээсэнд тэр охины хойноос дагаж мөнгө арилжах пүүсний гудамжинд очвол тэр авхай намаг хараад өгүүлрүүн: Би чамайг үзээд сэтгэл санаанд ихэд хүсэж нойр хоол алдав гэсэнд би өөрийн сэтгэлийг илтгэж харилцан янаг амрагийн үг хэлэлэхэд охин асуураан: Аяа янаг минь чи, бид хоёр хаана болзоно. Би чамд очих уу . Чи ирэх үү гэсэнд би газрын хүн биш тул надад нэгэн буудлын дэнгээс өөр тохиромжтой газар үгүй, тиймийн тул эрхмийн гэрт очихыг хүснэ гэсэнд охин өгүүлрүүн: Тэр болно. Ганцхүү энэ өдр сугар гаригийн мөргөлийн өмнөх өдөр болох тул энэ бүтэхгүй харин маргааш мөргөлийн сүүлээр болно. Чи мөргөж дуусм гц илжгээ унаж Аль-хав-банийг сургалан очиж, Абу Шама цолтой Баракат ноёны гэргийг асуугтүн. Би тэнд сууна. Битгий осолдогтүн хэмээгээд салах ёс гүйцэтгээд явсанд би тэсгэлгүй баярлаж дэгд буцаж ирээд тэр шөнө нойргүй хоножь, өглөө болмогц биед сайг үнэртнийг түрхэж шинэ хувцас өмсөөд, тавин алтан динар зоосыг алчуурт боож, Масрурын дэнгээс гарч Зүвейлийн хаалганд хүрч илжиг хөлслөн унаж, Аль-хавбанид хүрч АльМункарийн хорооны хаалганы өмнө зогсож илжгийн эзнийг явуулан тэр хооронд буй ноёон гэрийг асуувал , илижгний эзэн удалгүй буцаж ирээд миний асуусан газар хүргэсэнд илжигээр бууж тэр илжигчинд өлгөө эрт ирж намайг миний гэрт хүргэгтүн гэж алтан

динар зоосны дөрөвний нэгийг шагнан өгч хаалгыг тогшсонд саран адил үзэсгэлэн , өндөр цээжтэй хоёр залуу охин угтан гарч өгүүлрүүн: Ортугай , манай авхай чамайг хүсэн хүлээж нойргүй хонов гэсэнд би дотогш орж долоон үүдэт нэгэн давхар байшингийн дээр гарав. Тэр байшингийн олон цонх үзэсгэлэнт цэцэрлэгийн зүг ханджээ . Тэр цэцэрлэгт бялхам дүүрэн суваг татаалаар ус урсч зүйл бүрийн цэцэг жимс дэлгэрэн, сайхан дуут шувууд донгодоно. Байшингийн дотор султан шохойгоор будсан нь хүний нүүр үзэгдэнэ. Дээврийг алтаар бүрхэж, хөх будгаар ерөөл магтаал бичсэн нь үзэгчдийн өмнө гялбан гийнэ . Шалыг эрээн цасан дусал чулуугаар хийж төв дунд энь усан цөөрөм үйлдэж захаар нь алтаар цутгасан шувуу босгосон нь амнаасаа усыг цөөрөмд олгойдуулан гаргана. Байшингийн дотор зүйл бүрийн өнгөт торгон хивс дэвсэж олбог засжээ . Тэр сахан байшинд орж суумагц гэрийн тэр эзэн авхай тэргүүнд сувд эрдэнэсийн чимэг зүүж нүүрт оо энгэсэг тавин гарч ирээд чи үнэхээр ирэв үү хэмээн намайг тэврэн амаар миний хэлийг шимсэнд би түүний хэлийг шимж : - За би боол ирлээ гэсэнд охин өгүүлрүүн: Ирсэн чинь юутай сайн. Би чамайг үзсэнээс хойш нойр хоолыг ц өм гээв гэсэнд би ичингүйрэн тэргүүнийг дорогш дарж энэ зовлон надад бас тохиолдов хэмээн хэлэлцэн суутал удалгүй ширээ засаж зүйл бүрийн амттан сайхан хоол авчирч цадтал ирээд угаалгын газарт гараа угаааж , биед тэргүүлэгч цэцгийн заарт ус шүршиж харилцан мөрөөдсөнийг хэлэлуэн суухад миний хамаг мөнгө хөрөнгө цөм өчүүхэн мэт санагдаж гагц охиныг янагдан хүснэ . Тийнхүү үнсэлцэн наадсаар шөнө болсонд шивэгчин охид архи зууш авчирч ширээ засаанд шөнө дунд болтол хуримлан цэнгэлдэж тэр охин лугаа хонов. Хүн болсон урьд хожид тийм шөнийг би үнэхээр үзсэнгүй Тэндээс өглөө болсонд динарыг ороосон алчуурыг охины дэвсгэрийн дор орхиж салах ёс хийж гарахад охин уйлан асууруун: Чиний энэ хайртай улаан нүүрийг дахин хэзээ олж үзнэ хэмээн асуусанд би энэ орой ирнэ нгэж гадагш гарч өчигдпөрийн илжигч , хаалганы өмнө цнамайш хүлээн буйг үзээд илжийг унаж масрурын дэнд хүрч тэр илжигчид наран шингэхийн үе±т амайг энд хүлээгтүн гээд хагас динар шагнан өгөв. Тэндээс олон худалдаачин зээлдэн худалдааслан барааны үнийг авч охинд хүргэх амттан жимс зууш худалдан авч ынэгэн үүрэгч хүнийг хөлслөн хүргүүлж , илжигчин хүн хүрч ирсэнд тавин динарбг нэгэн алчуурт боож авхайн гэрт очвол , цасан дусал чулууг хэдийний арчиж зэсийг өнгө ортол зүлгээд олон дэн зул, шатааж зүйл бүрийн архи дарс , идээ зушийг засжээ . Миний тэрстгэл зүрхний янаг хүн намайг үзмэгц намайг их л мөрөөдүүлэв хэмээн тэвэрч хамт суун хоол идэж бармагц жаргах танхимд орж унтсанд өглөө болоходр урьд ёсоор тавин динарыг үлдээн гарч, илжиг унан дэнд ирж баахан амарч унтаад зүйл бүрийн цэцэг, жимс , амттай илдээ зууш худалдан авч охины гэрт хүргүүлээд тавин динарыг алчуурт боож урьд адил илжигчнээр хүргүүлэн охины гэрт очиж идээ ундааныг цэнгэлдэн ууж идээд унтаж өглөө болсонд динартай зоосыг орхиж илжигчний илжгийг унаж дэнд буцав. Энэ мэтээр цэнгэн жаргаж суутал нэгэн өглөө босвол харин нэг ч зоосгүй болсон ажээ . Үүнд гаслан гашуудаж дэнгээс гараад Бейн- аль- Касрейн гудамжаар явж Зүвейлийн хаалганд хүрвэл маш олон хүн чихцэлдэн зогсоно. Тэнд хүрч олны дунд шахцалдан ороход эртний хувь зохиолоор энгэн цэргийн хүнтэй тохиолдож гараар санамсаргй нэгэн цэргийн хүнтэй тохиолдож гараар

санамсаргүй түүний өвөрт хүрвэл мөнгөний сав миний гарт баригдсан тулсэмхэн сугалж авсанд тэр цэргийн хүн өвөрт гэнэт хөнгөн болсонд сэжиглэж гараар тэмтрэн үзвэл мөнгө үгүй болсонд минийзүн эргэж бялгуугаар тэргүүнийг уохиж унагсанд олон хү шуугилдан тэрг цэргийн хүний жолоо цулбуураас барьж чи и энэ залууг чихцэлдэн түлхэнэ гэж занчина уу хэмээн шуугилдсанд тэр цэргийн хүн хараан : Энэ хар хулгайч миний мөнгийг хулгалав хэмээтэл би баахан сэхээ орж сонсвол хүн намайш энэ залуу сайхан царайтай сайн хүн , юм хулгайлах ёсгүй гэнэ. Зарим нь мөн мөн хэмээн итгэнэ. Зарим нь биш биш хэмээн сэжиглэн маргалцаж намайг тэр цэргийн гараас аван салгасугай хэмээн эртний хувь зохиолоор Вали зэргэгч дарга цэргийн дагуулсан тэр хаалгаар орж ирээд олон хүний шуугиолдан буйг үзэ энэ юу болов хэмээсэнд тэр цэргийн хүн өгүүрүүн: Би энэ нэгэн хулгайчийг барив. Миний өвөрт хорин динартай хөх хэтэвч байсныг энэ хүн сэм хулгайлан авав гэсэнд Вали заргач үүнгийг нэгжигтүн хэмээн хуяг цэргээ тушааж нэгжүүлсэнд тэр цэргийн алдсан эд мэдүүлсэн тооны ёсоор гарсанд заргагч их д хилэгнэн уурлаж чи энэ мөнгө хулгайлсанааа хүлээнэ үү хэмээн зандран асусанд би тэргүүний ичингүйрэн дарж үүнийг хулгайлаагүй гэвэл нэгэнт тэр мөнгөний миний хувцсан дотроос гарсан тул хүн итгэхгүй бизээ . Хулгайлсан үнэн хэмээсэнд заргач, зандалчинд тушааж энэ хілгайчийг тогтсон цаазын ёсоор барун гарыг цавч хэмээн итушаасаар миний баруун гарыг цавчсанд тэр цэргийн хүн өрөвдөж намайг заргачаас гуйн авсанд зөөлөн сэтгэлтэй хүмүүс надад дарс уулгаж тэнхрүүлэ . ’эр цэргийн хүн, чи сайхан царайта залуу хүн байнам. Үүнээс хойш битгий хулгай хийгтүн хэмээн хэтэвч , мөнгийг над өгч явсанд би иас цавчсан гараа бөсөөр ороож өврлөөд авхайн гэрт очиж муужран хэвтсэнд авхай, миний зүс царай шарлан муудсаныг үзээд чамд ямар өвчин тусав. Чиний царай их л муу байнам хэмээсэнд миний толгой өвдөж дотор муу байна гэвэл тэр авхай өгүүлрүүн Чи үнэнийг хэлэгьүн: Чиний царайг үзвэл өөр нэгэн учир буй . Би чиний төлөө их л санаа ковно гэсэнл, миний бие муу байна. олон үг хэлэлэхээс хэлтргүүлнэ үү гэсэнд уухилан бгүүлрүүн. Чиний зан ааш надад нэгмөсөн хувьсав. Чи намайг гээнэ үү хэмээн байн байн миний өвчний учрыг асуусанд би огт хариу өгсөнгүй шөнө болсонд оройн хоолд авчирвал би гаргүй болсныг мэдэгдэхэс зовж, би энэ өдөр хоол идэхээс хэмээсэнлд авхай асууруун: Чи энэ өдөр ямар нэгэн хэрэг тарьж биесэтгэлээ зовоов. Надад түүний учрыг нэгд нэгэнгүй хэлж өгнө үү гэсэнд яаралгүй хэлье гэтэл дарс авчирч өгүүрлүүн: Үүнийг уувал чиний дотор уужим болох буй за . Чи эрхгүй энэ дарснаас амсаж ямар хэхрэг гарсныг надад хэлүүлэгтүн гэхэд чи миний энэ явдлыг заавал хэлүүлье гэвэл би их л сонсохыг хүснэ гэсэнд чи миний явдлыг үнэхээр сон±охыг хүсвэл надад өөрийн гараа архи хийж уулгагтун хэмээсэнд нэгэн хундага уулгаж дахин нэг хундага барьсанд солгой гараар тосон авч уйлахад авхай их дуун алдаж өгүүлрүүн: - Чи юунд уйлна . Чиний гаслах гашуудахыг үзээд миний элэг зүрх эмтэрэнэ гэсэнд миний гарт хатиг гарав хэмээсэнд одоо шахах цаг хараахан болоогүй тул үзүүлээд яахав хэмээн хундагатай архи уусанд авхай байн байн архи хийэ шаардан уулгасаар намайг согтоон унаган нэгжин үзэхэд миний өврөөс тэр цэргийн хүний өгсөн адттай хэтэвчийш олж гаргүй болсынг үзээд учрыг мэдэж миний төлөө сэтгэл санаа зовсоор нойргүй хоноу өглөө намайш боссонд дөрвөн тахианы шөлд чанаж

идүүлэн нэгэн хундага архи уулгасанд өчигдрийн алтыг үлдээж явсугай хэмээтэл авхай хориглон суулгаж өгүүлрүүн: Чи нада халуун сэтгэлтэй болж алть мөнгийг бараад гаргүй болоход хүргсэн ажэ . Би чамаас хагаццан садахыг үнэхээр түвдэхгүй хэмээн олон гэрчийг дуудан ирүүлж өгүүлрүүн: Би энэ залуу хүнтэй ханилан суухыг санаа энгэнт тогтов. Энэ авдранад буй миний алт мөнгө болоод орон сав , боол шивэгчин цөм энэ залуу хүний хөрөнгө болсныг гэрчлэн тэмдэглэгтүн хэмээн батлан тэмдэглэх бичиг хийж надад тушаан өгөөд гараас хөтлөн дагуулж сангийн байшинд аваачин нэгэн их авдрыг нээн үзүүлж түүний доторхийг таних уу хэмээн авдар дүүрэн авчууртай юмыг зааж өгүүлрүүн: Энэ цөм чиний авчирсан алт болой. Би түүнийг энд хураан хадгалсаар нэгэн авдао дүүрэв. Эдүгээ энэ алтыг авёч дахин баян болтугай . Чи миний төлөө зовлонд унаж баруун гарыг алдсан атал би ямар аймшиггүй чиний энэ их ачийг үл хариулна хэмээн хамаг эд эрдэнэсийн зүйлийг бүрнээ надад тушаан өгч миний төлөө сэтгэл зовж хоносонд би тэр шөнө хамаг явдлаа тоочиж хохсныг үл өгүүлэх нь: Миний эм удалгүй хүнд өьчин тусаж тавин хоногийн дотор нас нөгчсөнд Коран ном уншуулан өглөг бцуян үйдлэж оршуулаад өв хөрөнгийг бүртгэн үзвэл гацаа, хуй орон сав, эд эрдэнэсийн сан хөмрөг маү арвин ажээ . Чамд худалдсан хүнжид бол тэр олон сангийн доторхи нэгэн хүнждийн сангаас гарсан нь билээ . Бусад олон санд хадаглагдсан юмыг худалдсаар үнийг эдүгээ хүртэл бүрнээ хураан авч завдаагүй тул чамаас тэр хүнждийн мөнгийг шаардсангй билээ . Эдүгээ би нэгэнт чиний идээг амссан тул тэр мөнгийг чамд бэлэг болгон барья . Миний солгой гараар хоол идэж, баруун гаргүй болсон учир энэ билээ хэмээгээд чи намайш дагаж манай газар очих үгүй юу . Би танай Киар Александрия газрын эд барааг худалдан авяч нутагтаа буцахыг завдан буй хэмэсэнд гарах сарын шинэдээр болзоо тогтож буй бүхий хөрөнгө хогшлыг худаодан зүйл бүрийн бараа авч мисир газар худалдаа хийхээр одсонд би энд үлдэж хонтод ийм хэрэг гарчээ . Ай цагийг эзэлсэн хаан аа ! Миний энэ түүхэнд нуруугүй хүний явдлаас илүү сонин биш үү хэмээсэнд хятадын хаан өгүүлрүүн: Та нарыг цөм цаазаар аваачилтай хэмээсэнд тогооч нарын дарга ургаш дэвшин айлтгаруун: Хаан зөвшөөрон соёрхвол би энэ нуруугүй хүнийг олохын өмнө гарсан явдлаа хэлсүгэй. Хэрэв миний энэ түүх нуруу муутын түүхээс илүү сонин бол хаан миний амийг хэлтрүүлнэ үү хэмээсэнд хаан зөвшин хэлэв. Үүнээс хойш ямар сонин түүх гарахыг дараа бүлэгт үзсүгэй. ГУРАВДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь : Тогооч нарын дарга олны дундуур давшин гарч өгүүлрүүн: Би өчигдөр үдэш нэгэн айлд оявол тэр гэрийн эзэн олон хуувьч нарын урьж Коран номыг уншуулан төгссөнд ширээ засаж хурагсдыг зочлоход олон зуушийн дотор цуунд дарсан чихэртэй бүйлс тавьсныг олон хүн идтэл нэгэн залуу тэр бүйлсийг үзмэгц яаран зайлсанд олон түүнийг энэ бүйлсээс амсагтүн хэмээн баалахад би үүний урьд бүйлс идэж залгисан тул одоо хэрхэвч идэхгүй хэмээн ам алдахад олон түүнийг идэгтүн хэмээн дахин дахин шаардсанд тэр залуу өгүүлрүүн: Хэрэв би энэ бүйлсийг идэх албатай бол гарыг дөчин удаа саван, дөчин удаа сот, дөчин удаа шүлтээр ыбүгд зуун хорин удаа угааж, ширээний өмнө их о зэвүүцэн очиж гар нь чичрэн , эмээн сарвайж хар хүчээр залгин идсэнд олон цөм гайхан үзьэл тэр залуугийн гар эрхий хуруугүй ажээ . Үүнийг үзээд Аллах чамайг ийм заяав уу, хойно ийм болов уу хэмээсэнд тэр залуу өгүүлрүүн: Миний ганц эрхий бус, нөгөө

гар бас ийм . хоёр хөл мөн үүний адил хэмээн үзүлсэнд бид бүгд гайхан асууруун: Чи яахин хуруугүй болов. Үүнд лав нэгэн сонин учир бий биз дээ Бас гарыг зуун хорин удаа угаасан нь юу билээ . үүний учрыг сонсохыг хүснэ хэмээсэнд тэр залуу өгүүлрүүн: Миний эцэг Харун р Рашида- гийн үеийн Багдад хотын нэгэн их баялаг худалдааны хүн бүлгээ . Арµи дарс, дуу хөгжимд их дуртай тул эцгийг насан эцэс болсонд хүүрийг оршуулан ном уншуулж пүүсийг нээн олсон ашгийн өр нэхэгчид хэсэг хэсгээр төлсөөр эцгийн тавьсан өр ширийг бзрнээ дарж өдөр шөнөгүй хичээн оролдож суутал нэг өдөр гэнэт нэгэн маш сайхан залуу авхай өмнө хойноо нижгээд боол дагуулан луус унаж ирээд олон пүүс хараахан нээгдээгүй тул миний пүүсийн өмнө луунаасаа бууж “Ай залуу транай энэ дүүсэнд сайн торго бий юу” хэмээн нүүрийн бүрхүүлийг орхисонд тэр авхай саран мэт сайхан царайг үзээд тэсгэлгүй янагдан хүсэж- аяа боол би ядуу тул манай үгээгүү пүүсэнд эрхмийн санаанд тохирох сайн торго үгүй болов уу баахан хүлуэн хүлээвэл олон пүүс нээсэн агт аль дуртай торгыг авчирч өгье хэмээн тэр авхайн гэрэлтэй сайхан царайг их л хүсэж үзэж хэлэлцэн суутал олон пүүс нээгдсэнд тэр авхайн захисан зүйлийг бүрнээ авчир өгвөл дагаль боолд тушаан өгч луусыг унан үг дуугүй явсандп би торгоны үнийг нэхэж чадсангүй , таван мянган дирхэмийн үнийг биедээ хүлээв. Тэндээс гэртээ буцаж ирээд таэр авгайн гоо сайхынг санах бүр улам нойр алдсанд авхайг хүлээвэл огт үзэгдэхгүй , чингэтэл олон дүүсийнхэн урьдын авсан торгоын үнэ таван мянган дирхэмийг байн байн шаардан нэхсэнд арайхан хэмээн доло хоногийн болзоо гуйж хүлээж суутал авхай луус унаж хочр боол нэг тайганг дагуулан ирж ёслон өгүүлрүүн. Аяа бид эрхэмийн торгоны үнийг удтал хүлээлэглээ хэмээн мөнгийг тушаанөгч бас тийм тийм зүйлийн эд авна хэмээснийг олон дүсээс нийлүүлэн өгвөл бүгд үнэ нэгэн мянган динар болжээ . Тэр авхай захисан зүйлийг хураан авч урьд адил үг дуугүй явсанд би их л гашуудаж надад таван мянган дирхэм өгч нэгэн мянган динарын эд авах ямар с этгэлтэй хүн билээ . Би энэ их үнийг юугаар төлж дуусгана. Олон дүүсний хүн намайг танихаас биш түүнийг мэдэхгүй буй заа . Энэ авхай д лва намайг өөрийн сайхан өнгө зүсээр бачлан мэхэлж дарла±ан байх нь Би түүнд мунхгадаж нэр ус, гэр хороог асуусангшүй бачлагда хэмээн саанаа зовж илүү хүлээвэл олон пүүсийн хүн эдний үнийг байн байн шаардан нэхэж их л хавчсанд одоо балран мөхөв хэмээн хэмэг г зар ус, эд хөрөнгөө худалдахаар тогтож гашудан суутал нэгэн өдөртэр авхай гэнэт орж ирсэнд урьдах зовлонг цөм умарта- түүний сайхан үгийг сонссон тэсгэлгүй баярлан жаргасанд арайхан эс үхэв. Тэр авхай урьдах мөнгийг илүүтэй өгч ч амд эм бий юу хэмээвэл үгүй хэмээгээд уйлсан чи юунд уйлав гэхэд нь гайгүй гайгүй миний уйлах бага хэрэг хэмээн хэдэн динар авч миний энэ хэрэгт зуучлан туслана уу хэмээн тайганд сэм өгч гуйван дайван инээн өгүүлрүүн: Миний туслах хэрэг өчүүхэн буй заа . тэр чамайг хүсэх нь чиний түүнийг хүсэхээс хэдэн хув илүү болой. Чамаас байынга торго худалдан авах нь угтаа торго хэрэглэх нь бус тусгайлан чамайг олж үзсүгэй хэмээсэн нв буюу . Чамд хэлэх үг буй бол шууд хэлэгтүн. Тэр үл хүлээх ёсон буюу хэмээн хэлэлцэж динар өгснийг тэр авхай сэмхэн үзсэн бүлгээ . түүний өмнө очиж сэтгэлийн үгийг илтгэн хэлбэл зөвшин хүлээж чи энэ тайганы үгээр явагтун хэмээгээд тайганд чи миний захидлыг энэ хүнд хүргэгтүн хэмээн тушааж одсонд урьд авсан торгоны үнийг олон пүүсэнд

тушаан өгч авхайг хүлээн мөрөөдсөөр хэд хонсонд нэгэн өдөр тайган ирж авхайг бие өвчтэй гэсэнд шаардан асуувал өгүүлрүүн. - Чиний тэр авхай Харун ар –Ра-шид- Халифийн хатан Ситт Зубейдагийн тэжээн хүмүүжүүлсэн нэгэн дотно шивэгчин бүлгээ. Ордноос өөрийн дураар орох гараџ зөвшөөрөл хатнаас гуйн олж удалгүй харшийн тэргүүлэгч болоод хатанд чамтай сэтгэлтэй болсныг гарган хэлж нийлүүлэхийг гуйсанп Ситт хатан , би тэр залуу хүнийг үзээгүй атал энэ хэргийг хэрхэн хүлээнэ. Хэрэв тэр хүн үнэхээр чамтай адил бол чамайг түүнд сая боготлож болон гэсэн тул бид чамайг сэмхэн ордонд оруулсугай хэмээжээ . Хэрэв чи ордонд орвол чиний хэрэг бүтэх нь алга урвуулах адил хялбар Гагцхүү ордонд ортол баригдвал чи толгойгүй болно Энэ хэрэг чиний санаанд ямар хэмээсэнд юу ч болсон буцахгүй . Үхэх сэхэхийг чамайг дагаж ялган үзнэ гэсэнд тайган өгүүлрүүн: Чи Ситт хатны Тигр мөрний хөвөөнд байгуулсан сүмд энэ үдэш мөргөөр очиж хонотун хэмээсэнд эрхмийн захиаг хичээнгүйлэн дагасугай хэмээн үдэш болсонд тэр сүмд очиж мөргөн хоносонд өглдөө гэгээрхийн үест гэнэт хоёр тайган хэдэн хоосон авдар авчирч сүмд оруулан нэг тайган авдрыг сахин үлдсэнд үзвэл нада зууч болсон тайган хүн мөн байжээ . Удалгүй миний сэтгэл үзрхний янаг хүн ирж уяран уйлж тэврэн золгосонд янаг амрагийн үгийг хэлэлэн намайг нэгэн авдарт хийж бусад авдарт элдэв юм хураан дүүргэж олон авддрыг онгоцноо ачиж Ситт хатны ордны зүг одсонд би авдран дотор хэвтсээр сэтгэл зовж аяа миний санасан хэрэг бүтнэ үү үгүй юу хэмээн тэнгэрт залбиран уйлбал онгоц усчлан явсаар Халифын ордны тушаа хүрч авдрыг ордонд оруулан хааны хатны үйлчлэх тайгачдын х жуугаар өнгөрөн гартал нэгэн өвгөн тайган нойрноос сэрч охиныг дуудан асууруун: Чиний энэ авбдар дотор ямар юм буй гэвэл хатны юм гэсэнп тайган өгүүлрүүн: Энэ аврыг дараалан нээж доторхийг надад үзүүлэгтүн: хэмээсэнд чи үзээд юу хийнэ гэсэнп олон үг бүү нуршигтун , хурдан үзүүл хэээсэнд миний хэвтсэн авдрыг нээн задалмагц сүнс зайлтал айн, шээс алдсанд охин өгүүлрүүн: Ай дарга чи болгоомжгүй хөдөлж энэ авдран буй нэгэн түмэн динарын юмыг эвдээд намайг чиргэдүүлэн, өөрийн биеийг ялд унагав. Энэ авдар дотор зүйл бүрийн торгон хувцас хийж , дээр нь дөрвөн манн земземын ус тавьсаныг чи бүдүүлгээр хөдөлж асгасан уд авдар доторхи сайхан торгон хувцасны өнгө будаг цөм эвдэрсэн буй заа . Чи энэ гоожин гарах усыг үзэгтүн хэмээсэнд тайган сандран мэгдэж заа каа бушуу явагтун. Би чиний энэ авдар үзэхийг байва барав хэмээн өнгөрөөн тавьсанд олон зардас авдар өргөж цааш явьал гэнэт ай халаг халаг Халифц эзэн ирлээ хэмээн шуугилдахыг сонсож сүг сүнсгүй айж одоо надаас Аллахаас өөр аврах боломжгүй . Энэ цөм надаас гарсан зовлон миний толгой дээр ирэв хэмээн гаслан хэвттэл сонсхул Халиф миний янаг хүнээс асууруун: Чи энэ авдаранд ямар юм хийж аймшиггүй ордонд оруулна оруулна хэмээвэл охин өгүүлрүүн: Энэ олон авдар дотор цөм Ситт хатны гоёлын хувцас бий гэсэнд Халиф авдрыг надад нээн үзүүлэгтүн хэмээн өгүүлснийг сонсоод үхІэл айж за одоо миний насны тоо гүйцэв. Хэрэв би энэ удаа бүтэн гарвал үг дуугүй энэ охиныг богтлон авсугай . хэрэг одоо задарвал би толгойгүй болов заа . Аяа, Аллахаас өөр тэнгэр үгүй буюу Мухаммед гэгч Аллахын заясан их богд мөн буюу хэмээн итгэл унштал охин өгүүлрүүн: Энэ авдруудад надад итгэмжлэгдэн захисан Ситт хатны хувцас хэрэглэл буй бололтой . ХАтнаас бусад хүнд хэрхэвч үзүүлж болохгүй хэмээн захисан бүлгээ хэмээсэнд Халиф би энэ

авдрыг заавал үзнэ хэмээн олон тайгачдйг дуудаж энэ авдруудыг авчирч нээгтүн хэмээн яиярэн дагжин хэвттэл олон тайган авдрыг Халифийн өмнө дамжлан авчирч нээсэнд зүйл бүрийн торго, үнэртэн тансаг эд хувцас тэргүүтэн гарсанд дараалан үзсээр миний авдарнд хүрсэнд тайгчид гарыг сарвайж өгсүгэй хэмээтэл охин яаран Халифын өмнө очиж айлтгаруун: Энэ авдрыг хэрхэвч энд нээж үл болно . Хэрэв та үзссүгэй хэмээвэл түүний дотор хатны нууц зүйлс буй тул бид гагцхүү Ситт хатны өмнө нээж үзүүлнэ гэсэнд Халиф сая охины үгийг дагаж тавьсанл олон тайган авдрыг өргөж дотогш оруулан нэгэн газар тавьсанд миний янаг хүн авдрыг нээж өгүүлрүүн: Одоо хоёул нэгэнт өнгөрсөн тул цээжээ тэнийлгэж сэтгэлийг тавиун болгогтун . Ситт хатан энд ирж чамайг үзнэ. Хувь буй бол чи бид хоёрын хэрэг бүтэх нь юуны магад үзэсгэлэн сайхан шивэгчин эмс ирээд тэв тэвэрээ эсэргэлдэн зогссонд өндөр цээжит хорин шивэгчин эм± Ситт хатныг дундаа хавчин гарч ирээд миний өмнө хүрч хатныг тойрон зогссонд үзвээс хатанд зүүсэн чйимэг, өмссөн хувцас маш олон тул арай гжэ хөдөлж явна. Хатны өмнө ёслон мөргөсөндп суу хэмээн дохиж миний гэр сурвалжийг нарийвчлан асуусанд цөм хариулбал баярлан өгүүлрүүн: Манай сурган хүмүүжүүлсэн энэ охин сонгоход ташаарсангшүй хэмээгээд миний зүг өгүүлрүүн: Би энэ хүүхнийг өөрийн хүүхний адил тэжээсэн бүлгээ . Эдүгээ Аллах чамд заяав хэмээн тэр охин бид хоёрын эр эм болохыг зөвшин хүлээсэнд хишигт мөргөн ёсолбол хатан өгүүлрүүн: Чи манай энэ газарт арав хоногтун. Би Халиф лугаа хэлэлцэн энэ хэргийг нэгэн тийш болсугай гэсэнд хатны ордонд охиныг үзэлгүй арав хонсонд нэгэн шивэгчин өглөө үдшийн хоолыг авчирч өгнө. Халиф миний хүсэх хэргийг зөвшин тогоож охинд инж болгон сангаас нэгэн түмэн динар шагнан олгосонд арав хоногийн эцэст Ситт хатан олон гэгч зууч заргач нарыг дагуулан ирж охин бид хоёрын холбох бичиг зохион тогтоож хорин хоногийн их найр хийсний эцэст охин халуун усанд орж ирсэнд шарсан тахиа , цуунд дарсан чихэртэй бүйлсийг тэргүүлэгч цэцгийн заартай усаар шүршсэн хоолн зэрэг зүйл бүрийн зууш бэлтгэж ширээ зассанд би бүйлсийг амтархан цадтал идээд гар угаахыг мартан суутал харанхуй болсонд олон дууч эмсийн гэц барьж царгил дэлдэн ирээд охиныг ордны дотор дагуулан үвж алт бэлэглэсээр ордныг эргэж гүйцмэгц охингы дагуулан ирж хувцсыг тайлан хөнглж бүгдээр зайлсанд тэсгэлгүй баярлаж охиныг тэвэртэл миний гараас анхилах бүйлсний үнэрийг мэдмэгц их дуу тавьсан олон шивэгчин яаран сандран гүйн орж ирж юу болов хэмээн охин намайг зааж өгүүлрүүн: Үүнийг зайлуулагтүн : Би үүнийг ухаантай хүн гэж санасан билээ . Үзвэл галзуу тэнэг хүн байнам гэсэнд би яахин галзуу тэнэг болном хэмээн асуувал өгүүлрүүн: Чи бүйлс идээд гарыг угаасангүй нь галзуутэнэг бус уу? Чамаас үүний хариуг заавал авна. Чам шиг хүн намайг эдлэх хувьгүй хэмээн мушгимал ташуур авч нуруу бөгсгүй ташуурдан с муужруулж олон шивэгчид тушаан өгүүлрүүн: Энэ мууг аваачиж хотын мэдэч ноёнд тушаан бүйлс идээд эс угаасан гарыг цавчуулагтүн гэсэд би гашуудан өгүүлрүүн: Аяа би угаахыг оролдсонд гарыг цавчих нь юутай гашуун хилс вэ хэмээн гасалсаанд олон шивэгчин гуйн өгүүлрүүн: Эгч та энэ нэгэн удаа түүний осолдсоныг хэлтрүүлэн өршөөж хилэнг тайтгаруулна уу гэж гуйсанд тийм бол тэнгэр мэдтүгэй. Би үүний биеэс эрхгүй нэг юм огтолж хорсдыгш тайлна хэмээн уурсан босож одоод арван хоногийн эцэст ирж зандран өгүүлрүүн: Аяа хар царайт би чамайг залхаан

цээрлүүлж хашраана. Чи үүнээс хойш бүйлс идээд гараа угаахыг осолдоно уу гэж олон шивэгчинийг зандран тушааж, миний гарыг хүлүүлээд хурц хутга авч гар хөлийн эрхий хурааг огтолсонд би мууҗран inаж сэхэ орвол охин шарханд э¬ тавьж цусыг зогсоосонд би ам алдан өгүүлрүүн: Аяа би үүнээс хойш бүйлс идвэл га°ыг дөчин удаа сод, дөчин уд а саван, дөчин удаа шүлтээр угаахаас нааш идэхгүй хэмээсэнд охин миний ам тангаргийг авч тавьсан бүлгээ . Энэ хуримт бүйлс базаасныг үзээд үүнээс болж би эрхий хуруугүй болсон билээ хэмээн царайг хувиогаж зайлсанд та нар намайг албадан шахсанд арга буюу ам алдсан ёсоор гарыг угаасан билээ гэсэнд олон асууруун . Чиний тэр хуруу огтолсон хойно юу болсон билээ гэсэнд тэр залуу өгүүлрүүн: Миний ам алсдан хойно охины уур тайгарч тэр шөнө хам т хоножхааны ордонд хэд хонотол миний эм өгүүлрүүн: Чи бид хоёр одоо хүртэл Халифын ордонд нь ёсонд нийлэхгүй . Энд гадны хүн орж болохгүй бүлгээ . Чиний орж ирсэн нь гагцхүү Ситт хатны ач билээ гэж үүгээр нэгэн уудам сайхан байшин худалдан авагтун хэмээн таван түмэн динар өгсөнд нэгэн уудам багтаамжтай үзэсгэлэнт сайхан байшин худалдан авч, хамаг эд эрдэнэсийн зүйлийг зөөн аваачиж нүүн орсон бүгээ . Миний эрхий хуруугүй болсон учир энэ болой хэмээсэнд олон бүгдээр хуримлан найрлаж тараад гэр гэртээ харьтал би энэ нуруугүй хүнтэй тохиолдож энэ хэрэгт холбогдпсон билээ . Миний хэлэх үг одоо дуусав хэмээсэнд хаан өгүүлрүүн: Чиний эн эүг нуруугүй хүний явдлаас илүү сонин үгүй харин бэртэнгэ нуруутын явдал илүү сонин гайхамшигтай тул та бүгдийг дүүжлэн алтугай хэмээсэнд еврей ургаш давшин гарч айлтган өгүүлрүүн: Ай цагийг эзэлсэн хаан аа! Би энэ нуруугүй хүний явдлаас илүү сонин гайхамшигтай явдлыг хэлсүгэй хэмээсэнд хятадын хаан үг буй бол өчитүгэй хэмээн зөвшин хүлээв. Энэ еврейн гайхамшигт явдлыг мэдсүгэй дараа бүлэгт үзтүгэй. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Өгүүлэх нь : Еврей оточ олны дотроос ургаш даьшин гарч хаанд айлтган өгүүлрүүн: Миний залуу цагт үзсэн нэгэн сонин хэргийг өгүүлбээс, би урьд Сирийн Дамаска хотноо сургууль хийж бүхийд нэгэн өдөр Дамаскийн эзний нэгэн боол ирж манай ноён чамайг дуудлаа гэж ордонд дагуулан аваачиж зурвас алтаар чимсэн арц модон орон дээр хэвтэх нэгэн гоо сайхан залууг үзүүлэн, гарын судсыг барьж үзсүгэй хэмээвэл тэр залуу солгой гарыг үзүүлсэнд ийм сурвалижт гэрийн сайхан залуу хүн атал ёс мэдэхгүй нь гайхалтай гэж дотроо гайхаж судсыг бариад эм өгч арван өдрийн дотор эмчлэн сувилсанд өвчин илээрь болж тэр залуу халуун усанд орж биеийг угаан гарсанд ноён их шан хишиг хүртээж Дамаск хотын өвчтөний газрын даамал болгожээ . Үүний үл өгүүлрүүн өгүүлэх нь: Тэр залуу хүнийг дагалдан халуун усанд орохд олон зарц нар түүний хувцас хунарыг тайлсан хойно үзвэл тэр залуугийн баруун гарыг саяхан тас цавчсан сорьи бүхий бөгөөд өвчин олсон нь түүнээс болсон болой. үүнд гайхан үзтэл бас нуруунд нь ьашуурдса- сорви биы тул түүнийг засах тосон эм хэрэJлэсэн ажээ . Үүнийг гайхан үзтэл тэр залуу хүн өгүүлрүүн: Ай их эмч та бүү гай : Бид энэ халуун уснаас гарсан хоной хэлж өгье хэмээн гэртээ харьж идээ умдааны идэж уугаад давхарлаг байшнгийг дээр гарч, жимс зуушийг цэнгэлдэн идэж суухад тэр залуу явдлаа хэлж өгнө үү хэмээсээд өгүүлрүүн: Эмчээ! би бол Мосулын хүн бүлгээ . Миний эцгийн эцэгт арван хөвгүн буйн дотор ахмад нь миний эцэг бүлгээ . Арвуулаа эрийн цээнд хүрч эм авсанд би гарсан бүлгээ .

миний есөн авга нар цөм хүүхэдгүй тул намайш их л энхрийлэн өршөөнө. хойно эрийн насанд хүрсэн нэгэн цагт би эцэг авгын хамт мосул хотын цогчин дуганд сугарын мөргөл хийж , олныг тарсанд эцэг авга нар хоцрон үлдэж олон газар орон хот балгадын гайхамшиг сониныг хэлэлцэн суутал Край хотыг дурдсанд миний авга өгүүлрүүн: Олон жиуулчны хэлэлцэхийг сонсвол дэлхий дээр Киар хот Нил мөрөн хоёррос сайхан газар үгүй гэнэ гэж хэлэлцэн үгийг сонсодд Киарыг үзээсэй хэмээн хүстэл эцэг өгүүлрүүн: Киарыг үзээгүй хүн юу ч үзээгүй хүн гэж болно. Киарын шороо алтт мэт бөгөөд түүний орчин дахь Нил хэмээгё үнэхээр гайхамшигтай мөрөн болой. Тэр газар олон эмё тэнгэрийн дагинас мэт сахан бөгөөд орон байшин нь орд харш мэт үзэсгэлэнтэй буюу, Бас уур амьсгал нь найртай бөгөөд агар зандангйн адил сайхан үнэр анхилна . Та нар Киарын олон сайхан цэцэрлэгийг наран хэлбийх цагт үзвэл юутай гайхах билээ хэмSэн Киар Нил хоёрыг түмэн зүйлээр магтан хэхэлцэж гэр гэртээ харьсанд би тэр шөнө Киарыг хүссээр нойр алдан хоножь, идээ ундаанаас гарав. Удалгүй миний авга нар мисирийн зүгг одохыг завдсанд би дагалдан явсугай хэмээнэцгээс уухилан гуйсанд үнийг дагуулан аваачвал Дамасак үлдээн , Киарт бүү аваачигтүн хэмээн намайш авга нарт захиж явуулсанд Мосулаас гарч Халиф хүрээд тэндээс Дамаск хүрвэл тэнгэрисийн цэцэрлэг мэт сайхан хот ажээ.Мөн хотын нэгэн дэнд бууж авчирсан барааг худалдсанд нэгэн дирхэм бүрд таван дирхэмийн ашиг олж миний авга нар Мисирийн зүг одсонд би нэгэн сайхан байшинг сарын хоёр динараар хөлслөн сууж, идэх уухаар цагийг нөхцөөж жарган сууиал нэгэн өдөр хаалганы гадна гарсанд тансаг хувцас өмссөн нэгэн гоо сайхан авхайг үзэж нүзээр дохимогц дотогш орсонд хаалгыг дарж авхайг үзвэл нүүрийн бүрхүүлийг орхиж гэгээн царайг үзүүлсэн нь ертөнцөд хосгүй засаад архи дарс уун согтон цэнгэлдэн хоноод өгүүлрүүн: - Танай Мосулын хүн, ёс мэдэхгүй ажээ . Намайг чиний мөнгөнд шунаж ирэв хэмээнэ үү чи, үүнийг авахгүй бол Аллах мэдтүгэй . Би дахин буцаж ирэхгүй хэмээн өвөр дотроос арван таван динар гаргаж чи үүгээр идэх уух юм базаагтүн. Би гурван хоногийн эцэст наран шингэх үес ирнэ хэмээн захиж салах ёс ёслон гарсанд гурва- хоногийн эцэст урьдахаас улам сайхан хувцас өмсөж ирээд би сайхан байн уу хэмээсэнд Аллах мэдтүгэй . Чи үнэхээр сайхан байнам гэсэнд охин өJүүлрүн: Би дараа өөр нэгэн хүнийг дагуулан ирж гурвуулан цэнгэлдсүгэй . Тэр хүн хэдийнээ уйтгардан суух тул намайг нэгэн шөнө дагуулсан гарч уйтгарлан суух тулнамаш энгэн шөнө дагууланг гарч уйтгарыг сэргээнэ үү хэмээн гуйсан бүлгээ . Зүс царай надаас илүү , нас бас дүү тийм хүн бүлгээ хэмээсэнд чингэсүгэй хэмээн тогтож, найрдан цэнгэлдэж хоносонд өглөөгүүр арван таван динард өгч, үүнээс хуримын зуушийг бэлтгэгтүн хэмээн одсонд урьд ёсоор бэлтгэн суутал, охин болзооны цагт нэгэн хүнийг дагуулан ирсэнд дэн ноцоож баярлан үзвэл бага охины царай арван тавны саран мэт үзэсгэлэнтэй сайхан тул бахдэн хүсэж ядан ширээ засаад хамт сууж , хундага өргөн дарс уусанд урьдах охин битүүгээр хорсон жөтөөрхөж ай Аллах мэдтүгэй энэ охин надаас илүү сайхан биш үү хэмээсэнд Аллах мэдэг, энэ охин үнэхээр сайхан байнам хэмээсэн өгүүлрүүн: Чи энэ шөнө түүн лүгээ хонон уу гэсэнд баярлан хүлээвэл охин бидэнд ор дэвсгэр засаж унтуулсанд өглөө сэрвэл бүх бие нойтон болсонд хөлс гарсан биз гэж өндийн босож охиныг мөрнөөс түлхэн сэрээтэл толгой нь тээр дээрээс өнхрөн унасанд сандран мэндэн босож урьдах

охиныг үзвэл огт өөр үзэгдэхгүй тул хүүхнийг надад харамсан жөтөөрхөж алсныг мэдээд олж Аллах одоо хэрхэн хэмээн бодтол нэгэн арга олэ байшингийн доIор гүн нүх ухаж охины хүүрийг булаад, цасаан дусал чулуун шалыг урьд хэвээр засаж биеийг угаан шинэ хувцас өмсөөд үлдсэн мөнгөө авч гэрийн эзэнд тэр байшингийн нэгэн жилийн хөлсийг хураалгаж, би Киар хотноо авга нар лугаа золгоор очно хэмээн Киарт очиж авга нар лугаа энэгэн жил суутал нутагт буцах цаг ойртсонд сэмхэн зугтан зайлбал миний авга нар намайг эрж олсонгүй тул Дамаск хотноо буцсан буй за хэмээн эгсэнд би бүгдэн газраас гарч Дамаск хот дахь тэр гэрийн эзэнд байшингийн хөлсийг жил бүр явуулсаар гурван жил Киар хотонд суутал мөнгө зоос барагдсанд Дамаск хотноо эргэ мөнөөх башинд буувал доторхи юм нь урьд битүүсжилсэн хэвээр байсан тул засаж хөдөлгөтөл дэвсгэрийн дороос тэр шөнө алагдсан охины эрдэнийн чулуу шигтгэсмэн хүзүүний алтан чимэг гарсанд наалдсан цусыг арилгаж охиныг өрөвдөн баахан уйлаад нэгэнт мөнгө зтос барагдсан тул нэгэн өдөр зуучид өгвөл тэр чимгийг надаас нууж бусдад сэмхэн үзүүлсэнд хоёр мянган динарын үнэ хүрэх эрдэнийн чимэг хэмээн олж мэдээд хуурмагаар өгүүолрүүн. Чиний энэ чимэгу бол Франкуудын хийсэн хуурамч хэрэглэл ажээ . Зэсээр хийсэн тул мянган дирхэмээс хэрхэвч хэтрэн чадахгүй хэмээсэнд бид үгээр нэгэн эмийг бачлан элэглэсүгэй гэж хэлсэн билээ . Түүнийг одоо миний эхнэр олж аваад худалдсугай гэх тул тэр мянган д ирхэмийн үнээр өгсүгэй. Мөнгийг авчрагтун хэмээсэнд тэр зууч дотроо сэжигвлэж тэр чимгийг зээлийн даргад өгсөндп зээли©н дарга Валт заргачинд очиж мэдүүлрүүн: Би энэ чимгийг хулгайд алдсан бүлгээ . Эдүгээ хулгайчийг олбол худалдаачин хүнийы дүрээр явнам хэмээсэнд Вали заргач албаны хуяг цэргийг томилон гаргаж намайг бариад байцаан асуусанд зуучид хэлсэн үгийг хэлбэл Вали хүйтнээр инээж чиний энэ үгийг худал хэмээн ташуурдан занчуулсанд энэ чимгийн эзнийг миний гэрт алсан хэмээн үнэнийг хэлбэл намайг бас ална буй заха хэмээн бодоод хулгайлсан хэмээн мэдүүлбэл өчгийг дансанд тэмдэглэж тогтоосон цаазын ёсоор баруун гарыг тас цавчиж буцалсан тосноо дүрсэнд муужран унаад дарс уулгаж тэнхрүүлэн тас цавчисан гарыг авч гэртээ харивал гэрийн эзэн чи нэгэнт хулгайн хэрэгт холбогдсон тул манай гэрээс гаргатун хэмээн хөөхөд өөр гэр орон олдтол түр зуур суух зөвшөөрөл олж би нэгэнт гаргүй болсон тул ямар нүүрээрээ гэртээ харьж төрөл садны хүмүүстэй золгоно. Эд намаыг лав хулгайч гэнэ биз хэмээн гауудан уйлсаар өвчин олж хоёр хроног хэвтсэнд олон хуяг цэрэг, гэрийн эзэн зээлийн дарга нарын хамт ирж чиний тэр хулгайлсан чимги йг Дамаскийн эзэн Везир , заргач нарт хүргэвэл Дамаскийнй эзэн тэр чимгийг өөрийн хүүхний хамт алдснаар гурван жил болсон хэмээн гэсэнд , цөс хэмхэртэл айж, одоо үхэх цаг ирсэн буй заа . Аллах мэд , Дамаскийн эзэнд үнэнийг өчсүгэй. Тэр намайг албал алж , аварвал авартугай хэмээн сэтгэл хүзүүнд гинж орхиж гарыг хүлээд ДамаскЁйн эзний өмнө хүргэсэнд намайг нүдний булангаар үзэж олны зүг өгүүлрүүн: Энэ хөөрхий хүн огт ялгүй бүлгээ. Та нар яахин түүний гарыг хилс цавчив хэмээсэнд миний дотор онгойж ноён минь, Аллах мэд, би хулгайч биш бүлгээ . Зээлийн газар олны дунд намайг ташуурдан занчихад тэсвэрлэн эс чадаж хилсээр хулгайн хэрэг хүлээсэн билээ хэмээсэнп чамд ял зэмлэлгүй хэмэгээд зээлийн даргад чи энэ хүний гарыг хилсээр цавчуулсан тул төлж өгөтүн. Хэрэв эс төлбөл чамайг дүүжлэн алж хөрөнгийг санд хураана хэмээн

хуяг цэргийг зандран дуудсанд зээлийн даргыг үхсэн нохой адил чирч гараад гянданд хорьж , миний хүзүүний гинжийг авч, гарын хүлээсийг тайлаад Дамаскийн эзэн өгүүлрүүн: Ай хүүхдээ чи нада үнэнийг хэлэгтүн энэ чимгийг хэрэхэн олсныг нэгд нэгнээр хэлэгтүн хэмээсэнд үнэнийг тоочин мэдүүлбэл уйлан өгүүлрүүн: Ай хүүхдээ тэр нас эгчмэд охин нь миний төрсөн хүүхэн бүлгээ . Киар хотноо очиж эрийг үхсэнд гэртээ буцаж ирсэн бүлээ . Урьд Киар хотноо бүхийд бузар юм сурсан тул чамд дөрвөн удаа очиж , дараа дүүгээ дагуулан аваачсан бүлгээ . Нэгэн өдөр гашуудан уухилж дүүгээ хэрэхэн алсныг эхдээ сэм хэлсэнд би дэргэд нь байсан тул сонссон бүлгээ . Эдүгээ би чамайг хөвгүүний адил үзэж өөр эхээс гарсан бага охиноо богтлон өгч, тэжээл тавин олгосугай. Чи миний үгийг хүлээгтүн хэмээсэнд даруй зөвшөөрөн хүлээвэл заргач, этгээдийг зарлан ирүүлж , хүргэн орох бичгийг гэрчлэн бичүүлж зээлийн даргаас миний гарын төлбөрт өчнөөн төчнөөн мөнгө авсанд би нэг мөсөн баян эрхэм олэж жарган суутал тэр жил миний эцэг үхсэнд Дамаскийн эзэн элч довтолгож миний эцгийн үлдсэн эд хөрөнгийг Дамаск хотноо татаж ирүүлсэндп би жаргал цэнгэлээр аж төрөн суух болов. Миний баруун гаргүй болсон учир им бүлгээ хэмээсэнд би маш их гайхаж тэр залуу хүний гэрт гурав хоносонд надад их мөнгө өгснийг авч танай энэ хотод ирээд жарган суутал энэ нуруугүй хүний хэрэгт холбогджээ хэмээсэнд ХЯтадын хаан өгүүлрүүн: Чиний энэ үг тэр нуруугүй хүний явдлаас илүү сонин гайхамшиг үгүй тул та бүгдийг дүүжлэн албал зохих бүлгээ . гагцхүү хамаг хэргийг өдүүлсэн үйлчниы үгийг сонсоогүй тул түүний үгийг сонссогай . хэрэв энэ үйлчний үг тэр нуруугүй хүний явдлаас илүү гайхамшигтай бол та бүглдийг члыг хэлтрүүлсүгэй хэмээсэнд тэр хэргийг өдүүлсэн гайхад үйлчин ямар сонин үг хэлэхиг дараа үзтүгэй. ТАВДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь: үйлчин хүн олны дотроос ургша давшин гарч айлтган өгүүлрүүн: Ай цагийг эзэлсэн хаан аа! Би өчигдөр нэгэн сонин гайхамшигт үг сонссон нь энэ бэртэнгэ лүгээ уулзахын өмнө өгдөө эрт нэгэн айлд хуримлаар очсон бүлгээ . Тэр айлд үйлчин, ёрогчин , модочны зэрэг энэ хотын хориод хүн хуралдан цуглаж наран мандахад ширээ засаж хуримлан суутал гэриын эзэн нэгэн сайхан хувцас өмссөн үзэсгэлэнт царайт залуу дагуулан ирсэндп тэр залуу олны зүг мэхэсхийн ёсолж суусугай хэмээтэл үсчнийг үзэж зайлсанд чи нэгэн ирээд зайлхийн явах чинь юу вэ хэмээн барьж үлдээсэнд тэр залуу өгүүлрүүн: - Ая , намайг тавигтун Би энэ муу үсчнийг үзээд энд сууж болохгүй боллоо гэсэнд гэриын эзэн гайхан өгүүлрүүн: Энэ Багдад хотын залуус нэгэн үсчнийг үзээд ийм болох нь юу билээ хэмэсэнд олон тэр залуугийн зүг өгүүлрүүн: Чи энэ үсчнийг үзээд уурлан хорсох нь ямар учиртай вэ хэмээсэнп залуу өгүүлрүүн. Би Багдад хотонд энэ муугаас болж хөлөө хугалж доголон босон тул үүнимй явсан суусан газар хэрэхэвч хамт байхүй хэмээн ам алдаж энд хүрч ирсэн бүлгээ . Энэ үсчин эдүгээ мөн энд ирсэн тул энэ шөнө би хотоос гар аялан хонон гээнд олон тэр залуу хэрхэн доголон болсон учрыг хэлж өгнө үү хэмээн гуйсанд үсчний нүүр шарлаж үг дуугүй сууна. Тэр залуу олон хүслийг дагаж өгүүүлрүүн: - Миний эцэг Багдад хотын нэгэн их баялаг худалдааныб хүн бүлгээ . Эцэст надаас өөр үр хүүхэдгүй тул эрийн насанд хүрч эцгийн их өв хөрөнгийг эцэн болоод хувцасны сайныг өмсөж , идээний сайныг идэж жарган суух бүлгээ . НЭгэн өдөр Багдад хотын олон зээлд хэсэн явтал замд нэгэн сүрэг эмсиыг үзэж, язгуураасс эмст дургүй тул нэгэн гудамжны мухарт зайлан орж

айлын гаднах бандaнд суутал , нэтэг тэр айлын байшингийн цонх нээгдэж арвны тавны саран мэт сайхан залуу охин үзэгдэн ирж цонхон дээрх цэцгийг усалж , би урьд хожид тийм сайхан хүнийг үзсэнгүй тул эмсийн жигшин үзэх сэтгэл хэдийн үгүй болж тэр охиныг дотроо хүсэн санаглазаж наран шингэтэл хүлээн суувал манай хотын Кади өмнө олон боол, хойноо олон зардасыг дагуулан ирж тэр гэрт орсонд миний хүсэх тэр охины эцэг лав энэ Кади мөн хэмээн охиныг мөрөөдсөөр гэртээ буцаж царай барайлган хэвтсэнп миний олон шивэгчин эмс орж ирээд намайг гайхан тойрч уухилан суухад нэгэн эмгэн орж ирээд намайг үзмэгц учрыг мэдэж ятган Хүүхээ чи надад учрыг нэгд нэгэнгүй хэлж өгөгтүн: Би яиний төлөө зуучилж өгье гэсэн тэр өдрийн хэргийг хэлбэл эмгэн өгүүлрүүн: Чиний тэр үзсэн хүн манай Багдад хотын Кадийн охин байнам. Эцэг нь тэр байшингийн дор сууна . Би тэр Кадийн гэрт ордрог тул чиний хүслийг би хангаж чадна. Санаа бүү зовогтун хэмээсэнд дотор онгойж баярланг суутал тэр эмгэн нэгэн өдөр царай хувьсагнан ирж өгүүлрүүн: За хэрэг биш болов. Чи надаас олон үг бүү асуугтүн. Би тэр охинд чиний үгшийг сэм нэвтрүүлэн , смуу заяат чавганц чи надпад дахин ийм үг хэлбэл би чамайг залхаан цээрлүүлнэ хэмээн зандран хараж хөөн гаргав. Энэ удаа хэрэг бүтсэнгүй болов дараа бас нэг үзнэ хэмээн одсонд би сэтгэлийн өвчтэй болж уохиныг мөрөөдөн хэвттэл нэгэн өдөр эмгэн ирж, за хүүхээ чи надад бэлэг шагнагтүн хэмээн өгүүлрүүн: Өчигдөро би тэр охины н гэрт царайд зовних байдал гаргаж уйлан очсогд охин асууруун: Авгай чамд ямар зовлон байгаад ийнхүү уухилан гашуудна хэмээсэнд чамаас болж нэгэн залуу хүн аминаас хагацахад ойртов гэсэнд охрин уяран асууруун: Тэр аль газрын хүн бэ гэсэнд тэр залуу миний хөвгүүн билээ . Хэдэн өдрийн өмнө цонхонд чамайгш цэцэг услахыг үзэж тэсгэлгүй янаглан хүссэнд чиний урьд өдөрийн үгийг хэлбэл сэтгэлийн өвчин олж дэ дээрэс босохгүй болов. Одоо лав шхнэ хэээсэнд охины царай шарлаж энэ цөм надаас болов уу хэмээвэл цөм чамаас гарсан хэрэг хэмэсэнд охин өгүүлрүүн: Чи тэр хүний амрыг минь төлөөнөө асууж намайг түүнээс хэдэн хувь зовж буй хэмээгтүн! Сугар гаригийн мөргөлийн өмнө ирвэл би хаалга нээж, эцгийг мөргөлөө буцаж ирэхийн өмнө уулзъя хэмээн захисныг өгүүлсэнд би тэсгэлгүй баярлаж, эмгэнд өмссөн дээл хувцасыг тайлж шагнан өгснийг үлү өгүүлэн өгүүлэх нь: Сугар гаригт сайн хувцас өмсөж, сайн үнэртийг биедээ шүршээд олон хүн мөргөлийн газар очих цагийг хүлээж суутал эмгэн ирж өгүүлрүүн: Цаг бас болоогүй, чи халуун усанд орж үсээ касагтун хэмээсэнд, чиний үг зөв , би урьдаар үсийг засуулж , дараа усан орсугай хэмээн гэрийн хүнд тушаал чи зээлийн газар орчиж дэмий үг чалин хүний толгой өвтгөхгүй тийм нэг томоотой үсчин олж ирэтүн хэмээсэнд энэ муу хар өвгөнийг дагужулан ирсэн бүлгээ . Энэ өвгөн ирмэгц чиний үсийг засах уу, эсвэл цус ханах уу гэв. Эртний богдын өгүүлсэн нь: Сугар гаригт үс авсан хүн далан өвчнөөс тонилно . Цус ханулсан хүн нүдний хараа муудах тэргүүтьэй олон өвчний аюулгүй болно гэс-ийг Иби Аббас уламжилсан бүлгээ хэмээсэнд бит бие муутай хүн болой. Энэ олон үгээр яана. Үтэр босож миний толгойн үсийг засагтүн хэмээсэнд өвгөн өврөөс гариг цаг үзэх хүрдийг гаргаж нарыг шинжлэн өгүүлрүүн : Энэ өдрийн одон гариг нарыг шинжлэн үзвэл үс авах сайн цаг даруй мөн бөгөөд бас үзвэл чи нэгэн хүнтэй уулзахыг их л хүсэж буй нь цөм чиний сансан ёсоор бүтэх боловч ээст элдэвтэй болохыг би энд илтгэн хэлэхгүй хэмэсэнд , чи ямар муу ёрт хүн билээ .

Би ч чамайг ирүүлсэн нь үсээ засуульъя хэмээхээс бус чамаас үг асууя хэмээсэнгүй . Олон үг хэлүүлж яах юм , миний үсийг засагтун эмээсэнд үсчин өгүүлрүүн: Ай Аллах мэдэг. Хэрэв чи энэ хэргийн эцэст юу болохыг урьдаас мэдэх аваас , чи энэ адар яахин гэрээс гарах билээ . Миний үгийг сонс, одон гаригийн тохиол тоог дагаж явагтун. Би үүнийг чамдс айн санаж хэлнэ хэмээсэнд би урьд чамаас өөр зурхайд сайн үсчнийг үзээснгүй боловч энэ удаа чамайг ирүүлсэн нь чиний зурхайг хэрэгх нь бус, тусгайлан үсээ засуулаастай хэмээсэн бүлгээ . Чи даанч илүү згтэй хүн байнамм хэмээсэнд үсчин өгүүлрүүн: Аллах намайг ёамд явуулсан нь зурхайч бөгөөд хвилхын ухаан цагаан илбэ, дуун ухаан учир шалтгааны ухаан , тэнЈэрийн утга , хэмжих ухаан, ц аз хууль , Коран номын дилүв тэргүүтнийг судалсан үсчнийг явуулсан нь чамд завшаан биш үү. Чиний эцэг чамайг чалчаагүй хэмээн их л дотно үзэх бүлгээ. Тиймийн тулд чамайг үйлчлэх нь минийүүрэг буюу . Би язгуураас зг цөөн тул намайш цөөн үгт томоотой гэдэг. Би чамд сайн санаагаар үйлчлэн тусалж энэ жил зарагдахыг хүсэх тул зүй нь чи Аллахыг магтан ерөөж миний үгнээс зөрчихгүй явбал зохих бүлгээ гэсэнд ай чи энэ олон үг чалчилж намайг ална уу хэмээвэл үсчин өгүүлрүүн: Олон намайг миний зургаан ах нараас ялгахын тулд цөөн үг гэж дуудна. Миний ахыг Аль-Бакбук гэнэ.Чалчаа гэжээ . Хоёрдугаар ахыг аль-Хаддар гэнэ. Оворгон хэмээжээ. Гуравдугаар ахыг Факик гэдэг. Олон үгт хэмээнэ. Дөрөвдүгээр ахыгАл Куз Асвани хэмээнэ. Асванийн домбо хэмээсэн үг, ам нь домбоны амсар мэт ангайн буйг хэлжээ . Тавдугаар ахыг аль Шакашик хэмээнэ . Далан худалч хэмээжээ . Долдугаар ас-Самит буюу цөөн үгт хэмээгч нь би бүлгээ хэмээсэнд , би зарцыг дуудаж үүнд нэг хэдэн зоос өгч миний нүдэн далд оруулагтун хэмээн тачъяадан өгүүлсэнд үсчин өгүүлрүүн: Чи ямар үг өгүүлнэ . Би яиний үс засахаас өмнө мөнгө авахгүй . Чи намайг мэдэхгүй боловч би чамайг мэднэ . Чиний эцэг их уудам сэтгэлтэй хүн бүлгээ . Урьд намайг нэгэн өдөр дуудаж миний цус ханагтун гэсэнд , би одон гариг үзэх хүрдийг авч үзвэл тэр цагт цус ханаж болохгүй тул сайн цагийн тохиолыг хүлээсүгэй гэсэнд чиний эцэг иэсгэлгүй баярлаж үүнд гурван зуун динар хувцаснб хамт шагнагтун хэмээн шагнан өгч сайн цагийг хүлээн хануулсанд , чи надад гурван зуун динар шагнасан нь юу билээ хэмээн асуувал нэгэн динарыг чамай үг хэлэлцэхэд сайн хэмээн шагнав. Нэгэн динарыг цус ханасны шан болов. Бусад зуун динарыг хувцасны хамтаар намайг магтасны шагнал болгов хэмээн шахан өгсөн бүлгээ хэмээсэнд чиний мэт хүнийг биедээ ойртуулсан миний эцгийг Аллах үл өршөөх болтугай хэмээсэнд үсчин өгүүлрүүн: Би чамайг цэцэн хүн хэмээсэн бүлгээ . Үзвэл өвчнөөё хойш чиний ухаан муудаж дэмий үг өгүүлнэ. Би чамайг үйлчлэн энд зогсоход чамаас уйдахгүй атал чи надаас уйдах нь юу билээ . Би чиний эцгийн нүүр бодож тэсвэрлэн хүлцье хэмээсэнд чи юутай олон үг чалчих илжигний сүүл билээ . Миний үсийг хурдан авч эндээс зайлагтун хэмээсэнд үсчин миний үсийг норгож өгүүлрүүн: Чи надаас уйдсан боловч би чамааг буруушаахгүй . Чи оюун мөхөс хүү биш үү. Би чамайг саяхан ардаа үүрч сургуулийн танхимд хүргэж явсан бус уу хэмээн хутга авч хичнээн болтол билүүдээд сая миний үс авч эхэлтэл гарыг авч эхэлтэл гарыг өргөү яарах хэмээгч шулмасаас гарчээ, алгуур хэмээх өршөөл ихтээс гарчээ . Чи яарна уу хэмээвэл тийм тийм би яарна хэмээн хаёгиран өгүүлсэнд яарлаас гашуудал гэмшил төрнө. Алгуураар хөдөлбөл эрхэм.

Би санавал чиний энэ хэрэгт сэ¦иглэлтэй зүйл олон тул надад тайлбарлан хэлж сэжиглэлийг таслана уу. Мөргөлд эхэлтэл лав гурван цагийн зай байнам хэмээн хутгыг хойш тавьж нарныг үзсүгэй хэмээн гарч хичнээн болоод одоо мөргөл эхэлтэл илүү ч үгүй , дутуу ч үгүй яг гурван цагийн зай байнам хэмээсэнд , ай Аллах чи миний элгийг эвдэв. Үгээ тат гэсэн хутга авч урьд адил их л удтал билүүдэн нийлж нэг баахан үс аваад өгүүлрүүн: Би чиний яарахад санаа их л зовно. Урьд чиний эцэг өвөг алив хэрэгт цөм миний санааг урьдаар авна. Чи яарах урыг нада хэлбэл чамд тустай биз хэмээсэнд би тэр үсчний гараас мултран кайлах аргагүй болсныг ухаж нэгэнт мөргөлийн цаг болсон тул осолдон саатвал сэтгэл зүрхний хүнтэй учран золгох аргагүй болно заа хэмээн гаслан зовж үгээ товчлон хурааж, бүү хэрэггүй чалчигтун. Би энэ өдөр нэгэн нөхрийн гэрт хуримлан очно гэсэнд үсчин өгүүлрүүн: Урьд өдөр би бас хэдэн нөхрийг урьсан атал илээ зууш бэлтгэхийг огт умартав. Одоо чамаас хурим хэмээн сонсож сая олж саналаа . аяа би олон нөхдийн өмнө нүүр алдахад хүрсэн аж хэмээсэнд чи миний үсийыг хурдан авбал энэ хэрэгт бүү зовогтун. Миний гэрт буй идээ ундааны зүйлээс гаргаж өгсүгэй гэсэнд үсчин өгүүлрүүн: Чиний энэ их ачийг Аллах хуриалтугай . Чиний гэрээс ямар зүйлийн идээ зууш авч болохыг надад хэлэгтүн хэмэсэнд шарсан тахиа , хурганы мах зэрэг таван §үйлийн хоол буй гэсэнвд үсчи- тү%үнийг үзсүгэй хэмээвэл з рцад тушаан авчруулж үзүүлсэнд бас ундааныб зүйл дутуу гэсэнд мөн авчирч үзүүлбэл өгүүлрүүн: Аяа яи юутай сайхан сэтгэлтэй хүн билээ . Эдүгээ ганц үнэртэн утлагын зүйл дутуу байна гэсэнд тавин динарын үнэ хүрэх арга зандан , заарын зэрэг үнэртний зүйл буй нэгэн боодлыг өгч энэ бүгдийг аваад миний үсийг хурдлан авч өгтүгэй гэсэнд үсчин өгүүлрүүн: Аллах мэдлэг, би энэ боолыг доторхийг үзэхээс нааш авахгүй гэсэнд карцад тушааж тэр боодлын доторхийг гаргасахнд үсчин гартаа барьсан одон гаригийн хүрдийг алдаж тэр боодлы доторхи агар зандан үнэрт утгагыбг удтал гайхан үзсэн миний дотор их л цухалдан суутал үсчин хутгыг барьж миний үснээс бас нэг багаханыг аваад мод үндэснээс нь ургана, хөвгүүн эцгийг дууриан өснө. Миний энэ өдрийн хурим цөм чиний хишиг тул эцэг хөвгүүн та хоёрын алинд зүслэн биширч тал өгвөл зохих бизээ . Миний хуримд суух зочид цөм томоотой сайн хүмүүс бүлгээ . Нэгий нь халуун усны эзэн Зенгут гэнэ. Нэгий нь амуу худалдах Салия гэнэ. Нэгий нь буурцаг худалдах Салит гэнэ . нэгий нь ногоо худалдах Икрийш гэнэ. Нэгий нь хогч Хомайд гэнэ. Нэгий нь тэмээн суайд гэнэ. Нэгий нт үүрэгё Сувейд гэнэ. Нэгий нь халуун усны угаагч Абумут Кариш гэнэ. Нэгий нь манаач К сим , нэгий нь асуугч Карим гэнэ. Эдгээрийн дотор чалёаа агсан буюу бусдыг хашруулан уйдуулах хүн нэгч үгүй бөгөөд хүн бүрд өөрийн бүжиглэх бүжиг шүлэг бий . Цөм миний адил цөөн үгтэй томоотой хүмүүс билээ . Халуун усны эзэн гэц дэлдэж , ээж би очиж добо юугаа дүүргэнэ гэж бүжиглэн дуулна. Амуу худалдагё нь бусдаас илүү чадал үзүүлж ай уухилагч, ай хатан минь чи юу ч дутаасангүй хэмээн дуулахад сонссон бүхэн элгээ хөштөл инээлдэнэ . хогч зугаатай нариантай үзэсгэлэн бөгөөд дуулахад минь маш сайн тул шувуу боловч түүний сонсвол зогсоно. Миний эдгээр нөхөд хүний ухаан оюуныг инээдэмтэй наргиантай зүйлээр сэржгэлэн цэнгэлдэхэд маш чадмагайг энд тоочив ч барахгүй Чи тэдний чадал эрдмийг бүрнээ мэдсүгэй хэмээвэл өрөө очи ж үзсүгэй . Би үзвэл чиний бие тэнхэл өвчйнөөё хойш төдий л сайжирч

ёадаагүй тул тэр очих айлд илүү үгтэй чалчаа хүн байх бол чиний толгой өвдүүжин. Манайд очигтун гэсэанд би дотроо уурлавч инээмсэглэн байдлаар өгүүлрүүн: Би хожим очъё, та харин миний үсийг түргэн авагтун Надад хэрэг буй тул би бас яарна. Бодвол чиний олон нөхөд чамайг мөн нэгэн адил хүлээж буй за гэсэнд үсчин өгүүлрүүн: Ай эрхэм минь би чамайг тэр сайн язгууртны хөвүүд цөөн үгтэнтэй учруулан золгуулсугай хэмээн хүсэх бүлгээ . Би өсөх наснаас эдүгээ хүртэл илүү үгтэй хүнтэй нөхөрлөсөн удаа нэгч үгүй гагцхүү бие лүгээ адил цөөн үгтэй хүнтэй ханилна. Хэрэв чи миний нөхөдтэй нэгэнт золговол өөрийн хуучин нөхдийг цөм нэгмөсөн тэвчих буй за гэсэнд би хожим нэгэн өдөр эрхгүй чиний нөхөдтэй очиж танилц хэмээвэл үсчин өгүүлрүүн: Би чамайг энэ өдөр дагуулан аваачихыг хүснэ . хэрэв чи үнэхээр манай гэрт очих болбол чиний шагнасан юмыг нөхөддөө хүргэж өгсүгэй . хэрэв чи надад эрхгүй урьд болзсон нөхөддөө очсугай гэвэл чиний энэ хишгийг нөхд¤өө хүргүүлээд би чаймаг дагасугай . миний нөхөд намайг хүлээлгүй идэж уувал болно гэсэнд миний нөхөд эдүгээ намайг хүлээн буй тул эс очвол болохгүй Чи нөхөддөө очиж нөхөдтэйгээ хуримлагтун гэсэнд үсчин өгүүлрүүн: Би ямар аймшигтай чамайг ганцаар явуулна гэсэнд миний тэр очих газар надаас бус хүн очиж болохгүй гэвэл үсчин өгүүлрүүн: Чи лав нэгэн эмтэй болзсон буй заа . Бус ямар учраас чи намайг дагуулахгүй хэмээнэ. Би чамайг бусдын эмд эзгүйчлэн очиж хэрэг гаргауузай гэж эмээх тул чиний энэ хэрэгт туслаар дагалдан явахыг хүснэ манай энэ Багдад хотод ийм хэргийг ялангуяа ийм өндөр хийхэд их л хэцүү , бас энэ Багдадын Вали түшмэл маш чанга цаазтай хүн биш үү гэсэнд энэ муу өвгөн ямар аймшигггүй надад ийм үг хэлнэ эндээ зайлагтун гэвэл үсчин өгүүлрүүн: Би чиний дэлд санааг бүрнээ мэдэв. надаас нуух ньдэмий гэсэнд тэр үсчний үгийг миний айл ах дүүгийн хүн сонсуужин хэмээн айн эмээн удтал үг дуугүй суутал мөргөл номын цаг босон тул үсчНий үс авч дуу±магц түүнд идээ зууш өгч үүнийг нөхөддөө хүргэгтүн . Би чамайг энд хүлээж хамт явсугай хэмээн элдвээр аргадвал энэ муу өгүүлрүүн: Би чиний санааг мэдэв. Чи намайг мэхлэн зайлуулж ганцаар яваад гайд унахыJ хсүэж байна. Чи намайг иртэл хичээж хүлээ гэсэнп энэ муу миний өгсөн идээ зуушийг үүрэгч хнээр хүргүүлж өөрөө сэм гудамжинд нуугдсан ажээ . Би яаран гадагш га°ч тэр охины гэрийн зүг очвол зууч эмгэн хэдийнээ намайг хүлээн буй тул дотогш удирдан оруулсанд гэнэт гэрийн эзэн мөргөлөөс ирээд хаалгыг дарсанд цонхоор доош үзвэл энэ муу үсчин хаалганы гадна хүлээн сууж буйг гайхан үзэж, энэ золиг намайг энд буй гэж яахин мэдэв хэмээн гайхан бодвол Аллах миний нууцыг илрүүлэх гэсэн тул гэрийн эзэн нэгэн шивэгчний осолдсоныг мэдэж занчин зодсонд тэр гэрийн нэгэг боол ирж шивэгчнийг занчихаас хэлтрүүлсүгэй гэсэнд бас занчуулж өнөдр дуугаар бархирсанд энэ муу үсчин тэр гэрийн эзэн намайг занчиж байна хэмээн санаж өмссөн хуцасаа урж , толгойд шороо цацан гасалж энэ Кадийн гэрт миний эзнийг аллаа хэмээн өндөр дуугаар гашуудан дуудаж миний гэрийн олонд сонсгон дуулгаэ ирсэндп бүгдээр аяа тэр хөөрхий тасдаж , зсээ сэгсийлгэж ирсэнд гэрийн эзэн тэр чимээг сонсож гадна юу болов хэмээн нэгэн зарцыг явуулбал удалгүй сандран мэгдэн гүйн ирж мэдүүлрүүн: Манай хаалганы гадна түм илүү эр эм хүн хуралдан цуглаж, аяа тэр хөөрхий алагдав хэмээн манай гэрийг чиглэн зааж шуугилдана гэсэнд Кади хилэгнэж хаалгыг цэли©тэл нээн гармагц олон хүнийг үзээд сүрдэн эмээж юу

б®лов хэмээн асуувал миний зарц нар хараан өгүүлрүүн: Ай муу заяат , ай нохой , ай гахай чи манай эзнийг алав гэсэнд Кади өгүүлрүүн: - Би танай эзнийг яалаа гэж адах билээ . миний гэр энэ байна, орж үзье гэвэл орж үзэгтүн гэсэню үсчин өгүүлрүүн: Чи түүнийг ташуурдан занчсан биш үү . Би түүний бахирахыг сонссон бүлгэ. Кади асууруун Түүнийг миний гэрт хэн хаанаас хэрхэн оруулсан билээ . Би түүнийг яалаа гэж алах билээ гэвэл гэвэл үсчин өгүүлрүүн: Чи энэ хэргийг битгий нуугтун. Би түүнийг тов тодорхой мэднэ . Чиний охин тэр хүн хоёр харилцан амраг сэтгэлтэй болсонд чи түүнийг гэрт оров гэж мэдээд олон зарц нарт тушааж түүнийг занчуулсан бишүү. Чи манай эзнийг гаргаж өгөхгүй бол би биеэр дотогш орж эзнээ олоод энэ хурсан олны өмнө чамайг ичээнэ гэсэнд , Кади олноос ичиж өгүүлрүүн: Чиний үг үнэн бол миний гэрт орж үзтүгэй гэсэнд энэ үсчин яаран дотогш гүйн орсныг үзээд зайлсугай хэмээтэл завдсугай , сандран мэгдэн нэгэн их авдрын дотор орж амьсгалаа даран хэвттэл үсчин ирж намайг эрэлхийлэн цааш нааш үзьэл авдрын хажууд очиж гэнэт авдрыг толгой дээр өргөн гарсаанд энэ муу надаас салахгүй аж хэмээн яаран авдрыг нээж үсрэн Ўуухад хөлөө хугалж хаалганд хүртэл маш олон хүн цугларсныг үзээд ханцуйн дотор бэлтгэн авч явсан алтыг цафсанд олон хүн тэмцэлдэн түүх чөлөөнд сэмхэн гадагш гарч зугтаасанд энэ му үсчин миний хойноос салалгүй дагалдан явж өгүүлрүүн: Тэр муусайн миний эзнийг хорлож намайг сөнөөх гэсэн билээ . Аллахын өршөөлөөр би эзнээ тэдний гараас мултлав. Аяа чи өөрийн болгоожгүйгээр ийм хэрэгт орсон биш үү. Аллах намайг эс явуулбал чи энэ зовлонгоос яахин гарах билээ . Ганцаар явна хэмээн намайг алан алдав шүү. Чиний нас бага, томоожоогүй тул энэ нэгэн удаагийн мунхгийг авё хэлэлцэхгүй болгоё гэсэнд би тачъяадан хорсож, би чамаас болж ийм хэрэгт орсныг чи бас бага хэмээн миний хойноос гүйж зах зээлийн газар олны өмнө ийм үг хэлнэ үү хэмээн зээлийн газар нэгэн дэнд орж , намайг энэ муу үсчнээс салгаж амь авар хэмээн дэнгийн эзнийг гуйсанд тэр үсчнийг дотогш оруулсангүй амсхийж сууж, аяа энэ муу үсчнээс өдөр ч шөнө ч хагацахын заяагүй болов гэж гэрч нарыг дуудан ирүүлж өөрийн өв хөрөнгийг төрөл садан хүмүүст хуваан тушааж , орон сууцыг худалдах , их багыг тэжээн тэтгэх , захиа заавар өгч грэээ бичиг батлан бичээд энэ муугийн нүүрнээс зайлсугай хэмээн танай энэ хотонд ирж суусан бүлгээ . Таны урьсныг хүлээж энд ирвэл энэ муу харин хойморт ямбатай , хүндтэй сууж байна. Энэ муугийн уршгаар миний хэрэг ийм болж, хөлөө хугалсан атал, би яахин үүний хамт энд сууна гэсэнд бид их л гайхаж тэр үсчнээс энэ хүний үг үнэн үү гэж асуувал үсчин өгүүлрүүн: Аллах мэлэг! Би ухаан мэдэл зориг ихтэйн тул чингэсэн бүлгээ . намайг үгүй бол энэ лав үхсэн биз . үүний амьд гарсан нь гагцхүү миний гавъяа болой. Алагдсангүй хөл хугарсан нь бас завшаан биш үү . Би олон үгтэй бол үүнд яахин туслаж чадах билээ . Би та нарт өөрийн явдлаас хэлж өгсүгэй . Түүнийг сонсвол намайг үнэхээр бусад зургаан ах нараас цөөн үгтэй гэ мэднэ Энэ үсчний чалчаа мөн бусыг хойд бүлэгт үзтүгэй . ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь: тэ үсчин өгүүлрүүн: Би аль- мустади Биллахын хөвгүүн аль- Мустансир Биллах хааны үед Багдад хотноо суусан бүлгээ . Нэгэн өдөр хаан , их замд хулгай хийсэн арван хүнд хилэгнэн уурлаж, Багдадын ноёнд хулгайг баригтун хэмээн тушаасанд зарлигийн ёсоор барьж онгоцонд суулган хүргэж явсныг үзээд энэ хуриманд очиж яваа хүмүүс болов уу , би хамт очилцъя хэмээн тэр олны

дотор хутгалдан орж мөрнийг гатлан гармагц гэнэт олон хуяг ирж тэр хулгайн хүзүүнд гинж орхиж хааны өмнө хүргэхэд намайг бусдын хамт гинжилсэнд би үг цөөн, зүрх их тул үг дуун гарсангүй аль- Мустансит Биллах эзний өмнө сөгдсөнд , энд арван толгойг ав хэмээн хивсэн дээр сөгтгөн суулгаж сэлэм далайн арван хүний толгойг авсанд ганц би үлдэв. Халиф үүнийг үзээд чи юунд есөн хүний толгой авав хэмээвэл зандалчин өгүүлрүүн: Би ямар аймшиггүй эзний зарлигийг зөрчиж арав гэхэд есөн хүний толгой авах билээ хэмэсэнд Халиф эзэн өгүүлрүүн: Би бодвол чи есөн хүний толгой авсан буй заа . Аравдугаар нь чиний өмнө суунам бус уу хэмээсэнд зандалчин би арван хүний толгой авсан билээ хэмээн тоолж үзвэл үнэмээр арван хүний толгой авсан тул Халиф намайг гайхан үзэж асууруун: - Чи энэ ялтны дотор яахин оров. Үг дуугүй суух чинь юу билээ . Чи нас их боловч үнэхээр тэнэг хүн ажээ хэмээсэнд би өгүүлрүүн: Аяа үнэн шашинтны эзэн минь, би бол нэгэн цөөн үгтэй цэцэн ухаантай өвгөн билээ . Үс авч амь зууна. Энэ арвыг онгоцноо сусныг үзээд хурим найрт очих хүмүүс хэмээн тэдний дунд хутгалдан ортол гэнэт олон хуяг цэрэг ирж барьсанд язгуураас их зүрхтэй хүн тул огт дуун дуугарсангүй . чиний өмнө ирж бусдын хамт сөгдёөнд чи арван хүний толгой ав хэмээсэнд боловч би огт дуун гарагасангүй нь үнэн их зүрхтэй бус уу гэсэнд Халиф минийүгийг сонсож үнэхээр зүрх ихтэй, цөөн үгтэй хүн аж гэ мэджээ. Чингэтэл миний ачаар өчнөөн төчнөөн зовлонгоос гарсан энэ залуу хүн намаг чалчаа гэнэ . халиф эзэн, миний үгийгсонсоод гэдрэг унатал инээж, асууруун: Ай цөөн үгт ээ! Чиний бусад зургаан ах нар мөн адил цөөн үгтэй , ном эрдэмтэй юу хэмээн асуусанд тэр муусайнуудыг яахин надтай адилшааж болно. тэд бүгд зүрхгүй чалчаагаас болж нэг нь өрөөсөн нүдгүй лалар, нэг нь хоёр нүдгүй сохор, нэг гь салга хазгар, нэг нь хамар чихгүй , нэг нь уруулгүй , нэг нь нуруугүй ийм зургаа бүлгээ . Нүд амгү» сохор доголон болсон нь цөм учиртай тул би тэдгээрийн явдлыг нэгд нэгнээр тайлбарлан хэлсүгэй. Намайг чалчаа хэмээн бүү санагтүн гэв. Үсчний ямар сонин зүйл хэлэхийг дараа бүлэгт үзсүгэй. ДОЛДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь: Үсчин өвгөн лал шашинтны эзэн Халифт айлтган өгүүлрүүн: Миний ах нуруугүй хүн бүлгээ Багдад хотын нэгэн баялаг гэрийн эзний байшингийн доод давхарлагийг хөлслөн сууж, үйл оёж амьдаран . Нэгэн өдөр толгшой өргөж дээш үзвэл ургах саран мэт сайхан царайтай нэгэн эм , байшингийн цонхны өмнө буйг үзэж оёхыг уматран үдэш болтол нүд шилжилгүй ширтэн үзэж дотро ихл хүсэв. Чингэсээр хоёр гурав өдөр тэр эмийг ширтэн үзэснд гэнэт тэр эм инээмсэглэн далд орсонд нэгэн шивэгчин ирж өгүүлрүүн: Манай хатан тусгалан намайг явуулж чиний амраг асуухын ялдам гуйсан нв энэ хэдэн зах торгоор хатанд хэдэн цамц оёж өгнө үү гэж намайг явуулав гэсэню миний ах яаран хүлээн авч мөн өдөр оёж дууссанд өглөө нь шивэгчин дахин ирж өгүүлрүүн: Миний хатан чиний амрыг эрж чамайг энэ шөнө сайн хонов уу хэмээн асуув. Манай ахаайтан чамайг сансаар нойргүй хоонв хэмээн шар хоргой өгч, үүгээр хоёр хос өмд оёж өгөгтүн хэмээн өгөв. Үүнгийг энэ өдөр заавал оёж дуусгагтун эмээсэнд миний ах тэр хоргойг авч өгүүлрүүн: Чи миний төлөө хатны түмэн амгаланг эрж, боол би хатны зарлигийг хичээнгшүйлэн дагасуJай хэмээнэ хэмээн уламжлагтүн гэж тэр сахан эм үзэгдэж элдвэо сэртэндэн өдөөсөнд миний ах тэр эмийг тэснгэлгүй хүсэж, өмдийг удалгүй оёж гүйцсэнд шивэгчин ирж өмдийг аваачвөал тэр эмийг хүлээн суухад

шивэгёчин ирж манай эзэн чамайг дуудав гэсэнвд миний ах тэсгэлгүй айв. Шивэгчин түүний цочсонд байдлыг үзээд өгүүлрүүн: - Чи бүү айгтун. Чамд огт гэмгүй болохгүй манай хатан чамайг гэрийн эзэнтэй танилцуулах гэнэ гэж дагуулан аваачсанд тэр сайхан эмийн эр өчнөөн төчнөөн тогрго өгч үүгээр надад цамц оёгтун гэсэнд хүлээн авч , хоол идэлгүй оёсоор хорин дирхэм хэмээсэнд шивэгчийг дуудаж үүнд хорин дирхэм өгөгтүн гэсэндв тэр эм мөнгө бүү авагтүн хэмээн дохиогоор сэм нэвтрүлсэнд миний ах мөнгө авахгүй хэмээн бас юм авч гараад гурван өдрийн эцэст сая оёж гүйцсэнд шивэгчин ирж шаардан аваачсанд гэрийн эзэн бас таван дээлийг оёулж миний ахад зоримог мөнгө өгсүгэй гэхэд тэр эм эрийн битгий автагтүн хэмээн тэдний үлй оёсоор мөрөнд өмысөх , гэдсэнд идэх юмгүй болж бачлагдан мэхлэгдээд өдий төдий зовлон үзсэн нь тэр гэрийн эзэн эр эм хоёр минй ахад шивэгчнээ богтлон өгч дэр нийлэх шөнө миний ахыг нэгэн тээрэмдп аваачиж чи энэ шөнийг энд хоновол маш сайн хэмээн үлдээж тээрмийн эзэнд ийм тийм хэмээн захиж явсанд тэр хүн шөнө дунд миний ахын өмнө очиж энэ муу үхэр тээрэм эргүүлSхгүй дэмийл зогсох нь юу вэ? ҮЗвэл энэ үхэр идэх уух , баах шээхээс өөр ажилгүй байнам хэмээн миний ахыг тээрэмд оруулж ташууран занчсанд уухилан гаславч огт амжрахгүй, энэ муу үхэр юу болов хэмээн нүүр нүдгүй занчих тул арга буюу тээрмийг эргүүлэн гурил татсаар хонов. Өглөө болсонд гэрийнээзэн ирж миний ахыг үзээд үг дуунгүй явсанд шивэгчин ирж би чиний төлөө их өрөвдөнө гэвэо миний ах занчуулан зовсондоо үг хэлж чадахгүй болж дэмий л зогсоход тээрэмчин ирж тавьсанд гэртээ харьталд урьд өдөр холбох бичиг хийсэн бичээч ирж өгүүлрүүн: Чиний насан хутаг уртсах болтугай . үдээш өглөө болтол янаглан амраглаж ажрган цэнгэлдсэн хүний царай ийм байдаг аж гэсэнд аяа мянган давхар малгайт минь юуны жаргалын царай гэнэ. Би энэ шөнө үхэр орлож тээрмийн чулуу эргүүлэв хэмээн тэр шөнийн явдлыг тоочин хэлбэл , та хоёрын одн гариг нийлэхгүй байжээ . Би чиний бичгийг засөж өгье гэсэнд , бас арга буюу юу байна хэмээн амьжрах аилж эрж суутал гэнэт тэр шивэгчин ирж, манай хатан чамайш дуудна гэвэл явагтугай, явтугай , чиний хатан бид хоёрт одоо хэлэлцэх хэрэггүй болсон билээ хэмээн уухилан дуудаж тэр тээрэмд гарсан хэрэг надад огт холбогдолгүй хэмээн тангаргалан ам алсданд миний ах түүний уран сайхан үгэнд автагдаж тэсгэлгүй баярласанд швэгчин ирж өгүүлрүүн: Миний хатны захих үг гэрийн эзэн энэ шөнө айлд хонох тул чи манай гэрт очиж нэгэн шөнө жарган унтана уу хэмээн үдэш болсонд бас ирж миний ахыг дагуулан оруулсанд гэрийн эзний эм зоримгоор аяа янаг минь би чамайг тэсгэлгүй хүсэн мөрөөдөв гэсэнд миний ах баярлаж юуны урьд намайг үтэр нэг сайн үнэсэгтүн хэмээгээд хэлж барахын өмнө тэр гэрийн эзэн нуугдсан газраас яаран гарч би чамайг цагдан сэргийлэхийн даргад тушаахаас нааш салахгүй хэмээн шуугилдахад миний ах хичнээн гуйвч үгийг огт авахгүй шууд Вали түшмэлд тушаав. Вали түшмэл миний ахыг ташуурдан занчиж тэмээнд унуулан зах зээлийн газар хэсүүлснийг олон хүн үзээд бусдын дотоод гэрт хулгайгаар орогсдыг цээрлүүлэх ял энэ ыцюц хэмээн хэлэлцэв. Тэндээс миний ах ял эдэлж хотоос хөөгдөн гараад хааш очихыг үл мэдэн дэмийл явтал би өрөвдөн зовж гэртээ дагуулан аваачиж эдүгээ хүртэл тэжээсээр буй хэмээсэнд Халиц эзэн их л инээж за цөөн үгт минь сайн сайн хэмээн намайг явтугай гэж шан өгсөнд би бусад ах нарын явдлыг хэлж дуусахаас нааш чамаас

юм авахгүй, чи харин намайг олон үгтэй гэж бүү сана. Энэ үсчин өвгөн бас юу хэлэхийг дараа бүлэгт үзсүгэй. НАЙМДУГААР БҮЛЭГ. Өгүүлэх нь : Үсчин өвгөн : Лал эзэн Халифт айлтгаруун : миний хоёрдахь ах салга хүн бүлгээ . Нэг Бакбак гэнэ. Нэгэн өдөр зээлийн газар явтал нэгэн эмгэн уулзаж өгүүлрүүн: Чи тзр зогсогтун! Надад нэг хэрэг буй . Хэрэв чиний санаанд нийлэлцэхгүй бол надад нүүтрр шагнаж тSр хэргийг биед хүлээн авах ажаамуу гэсэнд эрхмийн сургаалыг хүснэ гэсэнд эмгэн өгүүлрүүн: Урсгал, устай , анхилам үнэртэйцэцэрлэг, үзSсгэлэн сайхан байшинг ямар гэнэ Жимс дарс болоод өглөө болтол амраглан тэврэх сайхан хүний үзэсгэлэнт царайг ямар гэнэ. Миний үгийг дагавал чи двиш сайныг үзнэ гэсэнд миний ах асууруун: Өчнөөн олон хүний дотроос ганц намайыг сонгох нь юу билээ . Нмайг ямар хэмээн сонгов гэж асуусанд эмгэн өгүүлрүүн: Чи дэмий олон үг бүү асуугтун. Харин дуун үгүй намайг дага хэмээн миний ахыг дагуулан аваачсанд нэгэн сайхан ордон харшийн дотор оруулж сайхан танхимд суугасанд олон эмс угтан ёсолж зэрэгцэн суутал гээнт их чимээ гарч , олон шивэгчин эмс арван тавны саран мэт нэгэн гоо сайхан охиныг танхимд удирдан оруулсанд охин, миний ахаас асууруун: Аллах чамайг өргөмжилтүгэй. Чамд сайн юм буй юу гэсэнд ай авхай минь, миний сайн цөм надад буй гэсэнд охин олон шивэгчинд тушааж ширээ засуулаад зүйл бүрийн сайхан идээ ундааныг авчрав. Хурим идэж барсанд арван сайхан шивэгчин гартаа хуур барьж дуу хөгжим өргөсөнд миний ах тэсгэлгүй баярлан охины гараас хундагыг тосон авч хэ хэдэн удаа уусанд охин миний ахын шилэн хүзүүг нэгэн удаа алгадаж олон шивэгчинд зэргээр алгадагтун хэмээсэнд олон шивэгчин алгадан алгадсаар мууждруулан унагаав. Тэндээс миний ах босож гадагш гартугай хэмээсэнд би шилэн хүзүүгээ алгадуулсаар муiжран унав. Одоо бас бас хэдий болтол хүлээх билээ гэсэнд эмгэн ятган өгүүлрүүн: Чи охиныг согтохыг баахан хүлээгтүн . ’эр цагт чиний хэрэг лав бүтнэ гэсэнд миний ах эгж урьд суусан газартаа дахин суусанд тэр охин миний ахын биеийг үнэртнээр утуулж , нүүрт тэргүүлэгё цэцгийн ус шүршиж өгүүлрүүн: Аллах чамайг тэтгэтүгэй. Чи миний гэрт орж миний үгийг дагав. Урьд миний үг зөрчсөн цөм хөөгдөн зайлах тул гагцхүү хүлцэнгүй нь хүссэндээ хүрнээ гэсэнд миний ах өгүүлрүүн: Ай авхай минь , би чиний боол бөгөөд чиний гарт хэмээсэнд охин өгүүлрүүн: Би найр наргианд дуртай хүн бүлгээ . Миний үгийг дагагсанд цөм хүссэнээ олно хэмээн нэгэн шивэгчинд тушаан өгүүлрүүн: Чи энэ ноёноо дагуулан аваачиуж заслын зүйлийг бэлтгэж дахин миний өмнө хүргэж ирэгтүн хэмээсэнд тэр шивэгчин миний ахын хөмсгийг будаж сахлыг ширхэг ширхэгээр зулгаасанд миний ах охиныг ихэд хүсэх тул тэсвэрлэн хүлцэж нүүр хөмсгийг будуулан , сахалгүй болж танхимд дахин орсонд охин анхна цочтол гэдрэг унаж инээн өгүүлрүүн: Аяа , эзэн минь, би чиний энэ сайхан царайд автагдан дагав. Чи эдүгээ бүжиглэгтүн хэмээн гусанд босож дэвхцэн бүжиглэвэл охин миний ахыг олбог дэрэр цохилон наадсанд олон шивэгчин амттайхүчтэй жүрж нимбэг тэргүүтнээр цохилон дэлдсэнд муужран унав. Төдий эмгэн өгүүлрүүн: Одоо чиний хүсэл ханах цаг ойртов. Занчигдах зовлон нэгэн үүгээр өнгөрөв. Одоо бас нэгэн зүйл үйлдсэн нь охин согтвол өмд цамцыг тайчиж бүр нүцJэн болсон тэр цагт сая бусдын хүслийг дагана Чи тэр цагт охины үгийг дагаж нүцэглээд өнөөхийг бостол үлдэн хөөвөл охин часайг дагана. Үтэр түргэн нүцэглэгтүн гэсэнд миний ах хувцас тайлж чармай нүцгэн болсонд охин хувцасаа

тайлж  чамд хүсэл буй  ахул намайш  дагатугай  хэмээн зугтаан  гүйсэнд  миний  ах охины  хойноос  гүйсээр  нэгэн байшингаас  нгэн  байшинд дамжин  орж  гүйтэл  охин нэгэн  харанхуй  газар   орсонд  миний  ах   хойноос  нь   хөөн  гүйж   нимгэн  газар гишгэсэнд  гэнэт байшингийн  шал  цөмөрч  элдүүрчний зээлийн дунд  унасанд  олон элдүүрчин  , арьсчин,   нэгэн   чармай  нүцгэн   сахал  хөмсөггүй  , улаан  нүүртэй  хүн унасныг үзэж  хашгиран  шугилдан  алгаа ташицгааж  арьс  ширээр  занчин  унагааж илжигэнд ачаад  Вали  түшмэлд  хүргэвэл  түшмэл асууруун:  Энэ ямар хүн хаанаас гарав гэхэд  олон   элдүүрчин . Энэ хүн Визир  сайдын гэрээс  мана  зээлийн  газар унав  гэсэнд  Вали  түшмэл энэ хүний хүзүүг  зуу ташуурдан  занч Багдадаас хөөн зайлуулагтун  хэмээн  тушаасанд би  хотоос гарч  ах юугаа  гүйцээд  сэмхэн  хот оруулж  эдүгээ  хүртэл  тэжээн буй  нь миний сэтгэл уудмыг  илэрхийлжээ . Миний гуравдугаар  ахын нэр  Факик гэнэ. Нүд  сохор хүн  бүлгээ . Эртнйи  хувь зохиолоор нэгэн их   гэрийн өмнө ирж   хаалгыг   тогшвол   гэрийн эзэн дотроос   энэ хэн буй хэмээн   асуусанд   хариу өгсөнгүй   тул   дахин   асуувал   миний   ах бас   өчсөнгүй , төдий гэрийн эзэн   хаалгыг   нээж чи   юуг хүснэ   гэсэнд миний ах   өгүүлрүүн:   Ай гэрийн  эзэн надад  нэгэн юм  хайрла  гэсэнд  чи   сохор  μүн үү  хэмээн миний ахын гараас хөтлөн  дагуулж  олон шат  даван  дамжсаар  байшингийн хамгийн  дээр гарч асууруун: Сохор хүн чи  юуны  хснэ гэсэнд миний ах  өгүүлрүүн:  Ай гэрийн эзэн их Аллахыг бодож  надад  нэгэн юм хайрла  гэж өгүүлсэнд Аллах  чамд хайрлан өгмүй за хэмээсэнд миний ах  өгүүлрүүн:  Тийм бол  чи үүнийг надад дор  хэлэхгүй  яав гэсэнд гэрийн  эзэн өгүүлрүүн:  Би чамайгш  энэ давхарлаг гэрийн  дээрэс  хэд хэд дуудахад  чи хариу  өгөхгүй  бас яаь  гэсэнд чи  надад юм өгнө үү  гэвэл  гэрийн  эзэн өгүүлрүүн:   Чамд  өгөх  юм  надад  байхгүй   гэсэнд  миний  ах   олон  шат   дамжин буусаар   хаалга  хүртэл  хорин гишгүүр  үлдсэнд  хальтран  унаж  толгойг хагалаад гадгаш гарч  дэмий  л гайхан явтал  түүний нөхөр хань болох  хэдэн сохор  хүн гүйэн ирж  энэ   өдрийн   ашиг  сайн  уу   гэсэнд   явдлаа   тоочиж   өгүүлрүүн:   Би  энэ  өдөр хувийн   мөнгөнөөс   гаргаж   хэрэглэхийг   хүснэ гэсэнд   гэрийн эзэн   сэмхэн  тэдний хойноос  дагалдан  явсан тул  энэ үгийг  сонсож  хамт  явалцан  , тэдний  гэрт очсон миний ах   нөхдөд өгүүлрүүн: Бидний  хойноос өөр хүн дагалдан оруузай .  хаалгыг дарж  гэрийн   дотор  сайтар   нэгжигтүн   гэснийг  тэр  хнүн   сонсоод  байшингийн нуруунаас   унжин   дээснээс   авиран   унжсанд   тэр хэдэн сохор хүн   байшингийн дотор нэгжин  эрж хүн  олсонгүй  тул миний  ахын дэргэд  ирж  мөнгөө тоолбол  нгэн түм  ,  хоёр  мянган  дирхэм   зоос  байжээ  .   Түүнээс   хүн  бүр   хэрэглэхийг   авч үлдсэнийг  нэгэн буланд  газар  хаяж  өмнөө бага сага  идэх уух юм тавьж хоол  идэж суухад   миний ах дэргэдээ   нэгэн  өөр   хүний зажлах   чимээг   сонсоод   манай энд гадны хүн  бай-ам хэмээн гарыг  сарвайн  тэр зажлах чимээ  сонсдох  газар нэгэнт шүүрмэгц  нэгэн хүний гар баригдсанд  олон  сохор  хамт  хүчнээр  нийлж тэр  хүнийг хантал  занчаад  ай лал аа  манай энд  нэгэн хулгай  орж  манай хэдэн  сохор хүнийг хохируулсангүй   гэнэ хэмээн   хашгиран дудсанд  олонхүн цугларан  орж та нар  юу болов  гэсэнд тэр  бачит хүн нүдээ  хуурмагаар  аньж  бусад  сохор хүмүүсийн адил хашгиран шуугилдаж  ай лал аа,  надад Вали  түшмэлд  мэдүүлэх чухал хэрэг буй гэсэнд олон  хүн түүнийг  тойрон  бүсэлж  Вали  түшмэлийн өмнө  аваачсанд  бачит хүн  мэдүүлрүүн: Түшмэл чи эрүү хөдөлгөхгүй бол  бидний энэ хэргийг ялган таслах нь  тун бэрх.  Тиймийн  тул надаас  эхлэн миний дараа,  миний энэ  хөтчид  эрүү тулгагтун  хэмээн миний ахыг  заасанд  Вали  түшмэл тэр хүнийг дөрвөн зуун  банз

занчсанд сая нэг нүдийг нээв. Бас занчтал нөгөө нүдийг нээтэл түшмэл асууруун. Чи үнэн өчгөө мэдүүлэхгүй аль цагийг хүлээнэ гэсэнд тэр хүн өчрүүн: Аяа ноён өршөө нигүүлсэн үү . Бидний дөрвөн хүн сохор хүний дүрээр олныг бачлан мэхэлж хүний дотоод гэрт орж эмс охидыг бузарлан аж төрнө. Бидний олсон бузар ашиг нэг түмэн хоёр яманг дирхэм болсон би хувь ногдох гурван мянган дирхэ¬ийг авсугай гэсний улмаас энэ гурав миний мөнгийгш булаан авч намайш занчсан тул би арга буюу энэ хэргийг албаны газ°аа мэдүүлж ногдсон хувийг хуваан олгохыг гуйна . Миний өчгийн үнэнийг мэдсүгэй хэмээвэл энэ гурван хүнийг намайг занчсанаас илүү занчиж өгөгтүн: Цөм нүдээ нээнэ үү хэмээсэнд Вали түшмэл энэ муу хулгай ямар аймшигггүй сохор болж хүнийг бачилна гэвэл миний ах өгүүлрүүн: Аяа тэнгэр, мэдтүгэй. Бид үнэхээр сохор хүмүүс бүлгээ гэсэнд вали тшмэл хилэгнэн уурлаж тэр гурван хүнийг хэд хэдэн мод занчиж нүдээ нээгтүн хэмээвэл тэр гурав үнэхээр сохор тул юуны нүд нээх аж . Үүнд тэр залт хүн өгүүлрүүн: манай гурван нөхөр олны өмнө нүүргүй болохоос эмээж үхэвч нүд нээхгүй байх нв. Би нэгэн албанб хүнтэй явж тэр зоосыг тоо ёсоор хүргэж ирсүгэй гэсэнд вали түшмэл албаны хүнийг явуулж тэр зальт хүнд гурван мянган дирхэм тавьж олгоод үлдсэн зоосыг санд хурааж , гурван сохор хүнийг хотоос хөөж гаргасанд би сэмхэн ахын хойноос очиж хотод хулгайгаар оруулан гэртээ нуун тэжээсэн бүлгээ гэсэнд. Халиф хаан их л инээж үүнд шан өгч явуулагтун хэмэгээд гэсэнд тэнгэр мэдтүгэй. Миний бусад ах нарын явдлыг хэлэхээс нааш шан авч чадахгүй . Би язгуураас цөөн үгтэй хүн бүлгээ хэмээн дөрөвдүгээр ахын явдлыг өгүүлсэн нь: Минийдөрөвлүгээр ах өрөөсөн нүд сохор болой Багдад хотонд ярга хийж амьдрана . Сайд түшмэл баялаг гэрийн хүмүүс түүнээс маµ худалдан явах тул ярга хийж ашиг олоод орон байшин,и ачлага уналагтай байжээ . Нэгэн өдөр түүний дэлгүүрт урт цагаан сахалтай нэгэн өвгөн ирж мах худалдан авсанд синий ах тэр өвгөний өгсөн дирхэмийг үзьэл маш цагаан гялалзсан мөнгөн зоос тул тусгай хадгалж тэр өвгөний мөнгийгш таван сар хурааж нэгэн өдөр хонь худалдан авсугай хэмээн авдрыг нээн үзвэл авдар дүүрэн хэрчисэн цагаан цаас байсныг үзээд нүүрийг маажиж цохилон их дуугаа° гасалсанд олон хүн цуглаж учрыг мэдээд их гайхсанд миний ах урьд адил нэгэн хонь алаад махыг дэлгүүрийн өмнө өлгөж, ай тэнгэр тэр муу өвгөн ирэх болоосой хэмээтэл тэр өвгөн өнөөх мөнгөө барьсаар ирсэнд миний ах түүнийг ноцож, ай лал нөхөд нааш ирэгтүн: Энэхүү ёсон үгүй хүний явдлыг сонсогтун хэмээсэнд тэр өвгөн өгүүлрүүн: Чи олны өмнө надаас ичингүүрлийг хүлээхийг хүснэ үү. Нүүр бүтэн, дуунгүй салахыг хүснэ үү гэсэнд чи намайг яахин ичээх билээ гэвэл чамайг олонд хүний махы хонины мах гэж нүд хуурч худалдмуй хэмээвэл чиний нүүр эвдрэхгүй яах буй гэсэнд энэ муу худалчийг үзэгтүн хэмээвэл муу худалч хэмээгч хүний мах дэлгүүртээ өсгөж худалдагчаа чи мөн буй заа гэсэнд миний ах өгүүлрүүн: Хэрэв тийм бол би чамаас мөнгө нэхэх байтугай чи миний цусыг асгавч надад гомдох газаргүй гэсэнд өвгөн дуудан өгүүлрүүн: Аяа хүний чуулган миний үгийг үнэнийг үзсүгэй гэвэл энэ яргчны дэлгүүрт орж үзэгтүн хэмээсэнд энэ яргачны дэлгүүрт иорж үзэгтүн хэмээсэнд олон шуугилдан орж үзвэл миний ахын алсан тэр хонины мах нэгшЅнт дүүжилсэн хүн болсныг үзээд чи биднийг хүний махаар тэжээнэ үү хэмээн нүүр нүдгүй занчисанд тэр өвгөн миний ахын өрөөсөн нүдийг сох цохив. Олон хүн тэр дүүжилсэн хүүрийг цагдан хамгалах

түшмэлд хүргэж тушаасанд тэр өвгөн мSдүүлрүүн: Энэ зальт хүн, хүнийг алж хонины мах гэж худалдаалсныг бид барьж цээрлэг шийтгүүлэхээр хүргэж ирэв гэсэнд тэр түшмэл миний ахын үгийг сонсохгүй таван зуун банз жанч хэмээн зандран тушаагаад , миний аххамаг мөнгө зоосыг гарөгаж өгснөөр арай хэмээн амь мэнд гарч толгой хазайсан тийш явсаар нгэн их хотод ирж гуталчин болбол сайн бололтой хэмээн дэлгүүр нээж гутал оёж суутал нгэн өдөр гадгаш гарё зээлийн газар олон морин довтлох чимээг сонсоод энэ юун билээ хэмээвэл хаан авлаар морилов гэсэнд хаанбг үзээ өлзий бусыг хариулах соёрх гэж морины жолоон татаж гэдрэг буцсанд олон бараа бологчдод миний ахыг нэвширтэл жанчисанд арай голтой гэртээ харьж хойно хааныб нэгэн зарцаас асуувал тэр хүн миний ахыг үзээд ихл инээж өгүүлрүүн: Манай хаан өрөөсөн нүд сохор хүнээс их л зэвүүцэх болой. Ялангуяа чиний адил баруун нүд сохор хүнийг үзвэл хэрхэвё алахаас нааш тавихгүй гэсэнд миний ах ихэд айж , тэр хотооё зугтсан гарч түүнийг хүн танихгүй өөр нэгэн газар очиж удтал санаа амар мууж нэгэн өдөр гадгша зугаацахаар гарсанд олон хүн мроины довлох чимээ сонсож, урјд зовлон олсныг санан айн э¬ээж зугтаан зайлсугай хэмээн орох гарах газрыг олж ядтал гэнэт нэгэн хаалга үзээд яаран ортол хоёр хүн шүүрэн ноцож их дуугаар хашгиран өгүүлрүүн: Ай Аллах биднийг гурван хоног нойргүй зовоосон хүн баригдав гэсэнд миний ах та нар юу гэнэ гэж гайхан асуусанд чи бас биднээс энэ үгийг асууна уу. Чи элдэв арга занаж энэ гэрийн эзнийг алах хэмээсэн хүн биш үү . Биднийг шөнө бүр түйвээн занах хутгаа т түргэн гарга хэмээн нэгжин үзэж бүснээс зүүсэн хутгыг олсонд миний ах өгүүлрүүн: Аяа та нар Аллахбг бодож миний энэ гайхашигт явдлыг сонсохуй гэсэнд чиний явалд юу билээ хэмээн асуусанд намайг тавих ч магадгүй буй заа хэмээн явдлаа тоочвол ахын үгийг авсангүй жанчиж, хувцас хунарыг уртал ахын биед ташуурдсан сорвийг үзээд, энэ мууг ташуурдсаныг үзээч хэмээн Вали түшмэлийн газар хүргэсэнд түшмэл асуруун: Яи ямар санаагаар энэ хэргийг үүсгэв. Бусдын гэрт орсныг үзвэл чи лав хүний амь бусинуулах хэмээсэн буй заа гэхэд миний ах энэгн учрыг мэдүүлсүгэй . Би хэрэгт огт холбогдолгүй билээгэсэнд түшмэл хилэгнэн уурлаж хүний эд хөрөнгийг бусинуулсаан хулгайн үгийг үзвэл лав хилэнцтэй муу хэрэг өдүүлсэн хүн буйзаа хэмээн хоёр зуун мод занчуулж , тэмээнд унуулан бусдын гэрт хулгайгаар орогсдыг залхаан гэсгээх цээрлэли©г хамгийн бага нь энэ буюу хэмээн дуудуулж хотоос гадагш хөөн гаргасанд , би хойноос нь нэхэн гарч сэмэр хотноо оруулж нуун тэжээв хэмээв. Өвгөн бас юу хэлэхийг дараа бүлэгт үзтүгэй. ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. Өгүүлэх нь : Үсчин өвгөн лал эзэн Халифт тавдугаар ахын явдлыг тоочин өгүүлрүүн. Миний тавугаар ах чихгүй болсон билээ . Угаас хөрөнгө нимгэн ядуу тул үдэш гуйланчлан олсон эдийг сүйтгэх бүлгээ . манай эцэг насан зүг болсон хүн тул манай долоон хүнд бүгд долоон зуун дирхэмээр хувааж авсан бүлгээ . миний тавдугаар ах хувьд ноогдсон мөнгийгш аваад тархиа эргэтэл баярлаж энэ их мөнгөөр юу хийж билээ гэж багтаан ядтал гэнэт нэгэн арга олж тэр мөнгөөр элдэн шил сав худалдан авч түүнээс давхар их ашиг олсугай хэмээн зуун дирхэмийн шил авч нэгэн том тосгуур дээр тавиад зээлийн газар одож хэрмийн ёроолд нуруугаар түшин сууж сэтгэрүүн: Миний үндсэн хөрөнгө энэ зуун дирхэмийн шил болой. үүнийг х хоёр зуун дирхэмээр худалдаж тэр олсон мөнгөөр дахин шил худалдан авч дөрвөн зуун дирхэмийн үнэ хүргээд чингэж

наймаа хийсээр их ашиг олж элдэв эд бараа, тансаг эрдэнэ үнэртэн заартаныг худалдан авч түүнээс улам их ашиг олоод сайхан орон байшин боол шивэгчин , хурдан морь , алтан эмээл худадан авч хотын доторхи дууч хуурч нарыг эр эм хэмээн ялгахгүй гэртээ дуудан ирүүлнэ . Их Аллах өршөөвөл зуун мянган дирхэмийн хөрөнгөтэй болно гэж бодоод шилтэй тосгуур нь түүний хөлийн үзүүрт байжээ . Зуун мянган дирхэмийн хөрөнгөтэй болсон цагт хаанд тшмэдийн хүүхэнд зуучиыг явуулж , их түшмэлийн хүүхэн өнгө зүс маш үзэсгэлэн гэх тул түүнд сүй хэлэлцэхээр тогтож мянган динар өглөө . Түүний эцэг хүлээвэл төдий л буй заа . Эс хүлээвэл хар хүчээр булаан авч гэртээ аваачаад арван бяцхан тайгачинг худалдан авч хаад салтануудын өмсөх хувцасны сайнаас шилэн авч өмсөөд үнэ-ихт эрдэнийн чулуу шигтэгсэн алтан эмээл тохож, өмнө хойноо олон боол хөтчиыг дагуулан гарч хүүхний эцгийн гэрт ар өвөр зүүн барунгүй олон дагалтаар хүрээлүүлэн эрхэм суудалд суулган_, өөрөө миний дор сууна. Хоёр тайган нижгээд мянган динар авч миний хажууд зогсоно. Би тэр алтнаас нээн мянган динар аьвч хүүхний зүй хэмээн өгнө. нөгөө нэгэн мянган динарыг бэлэг болгон өгч ертөнциын вмыг тоохгүй , өршөөл нигүүлсэн ихтэй, ууч өгөөмөр сэтгэлийг илэрхийлнэ. Хадам эцэг надад арван арван үг хэлбэл би хоёр нэгэн үгээр хуриалж гэртээ буцна. Миний эхнэрийн төрхмөөс хү- ирвэл мөнгө хувцас шагнаж хариулна . хадам эцэг бэлэг хүргэж ирвэл би сэтгэлийн ихэмсгийг үзүүлж бэлгийг авахгүй гэрийн дотор элдэв чимгээр засаж магнаг дээл өмсгөөд ташаа тулж хэтэрхий ухаантай томоотойн тулд зүүн баруун тийш харахгүй төв ихэмсгээр сууна. Миний эм эрдэнийн хуцас чимэг өмсөж миний өмнө хүлээн зогсоход би их зан гагаж огт үзэхгүй сууна. Хажуугийн хү-, аяа эзэн минь , чиний дорд шивэгчин эм удтал хүлээн зогсож ихл зүдрэнэ. Үзэн соёрх хэмээн гуйж миний өмнөх газрыг хичнээн удаа үнэссэнд би сая нэгэн удаа тэргүүнийг өргөж нгэн үзмэгц тэргүүнийг дахин дахин дарахад олон миний эмийш унтах гэрт хүргэнэ. Би хувцсыг хальт өмсөөд хүнд ихэмсэг хэмээн гайхуулахын тулд огт үг хэлэлцэхгүй , үзэхгүй сууна . Охины эх чиний өмнө ирж аяа эзэн минь чамайг хүсэн хүлээх шивэгчийг нигүүлсэн үзэж түүний сэтгэлийг засна уу хэмээн миний гар, тэргүүнийг үнэсэхэд би огт дуугарахгүй , төдий босож миний хөлийг хэдэнтээ үнэсэж миний охин гэгч эр хүнийг үзээгүй гол сайхан хүн бүлгээ . Чиний сэтгэл ийм хатууг үзээд түүний зүрх хагаран хэмээн охинлд хундага дарс өгч надад бариулахдаа би хатгамалд дэрийг түшин сууж сэтгэл маш ихэмсэг тул охиныг огт үзэгдэхгүй өмнөө зогсоход аяа өнгдөр их алдарт эзэн миний шивэгчний гараас энэ хундагыг тогтооно уу хэмээн дахин дахин гуйхад би огт дуугарахгүй, бас дахин шаардан шавдаж энэ хундгыг эрхгүй тогтоо хэмээн миний аманд тулгаваас би хүүхний нүүрийг гараар ингэж түлхээд, хөлөөр ингэж өш иглөнө хэмээн өшиглөмөгц шилтэй тосгуур дайралпаж хэмхэрн унасахд миний ах гашуудан гасалж, аяа миний сэтгэл санаа ихэмсэгээс ийм болжээ хэмээн нүүрийг маажлан хувцас хунарыг урж уйлахад зарим хүн өрөвдөн µайрлана. Зарим хүн огт ажиггүй хажуугаар өнгөрөн явна. Ингэж сжутал нэгэн гоо үзэсгэлэнт эм заарын үнэр анхилан , алтан эмээлтэй луус унаж хэдэн зардас дагуулан ирээд миний ахыгш эвдэрхий шилэн дээр уухилан суухыг өрөвдөн үзэж учрыг асуусанд энэ хүн нэгэн тосгуур шил савыг худалдаж арай чамай амь зуудаг билээ . Энэ өдөр шилийг хэмхэлж иймд хүрэв гэсэнд нэгэн зардасыг дуудаж чамд мөнгө байвал

энэ хөөрхий амьтанд өг гэсэнд нэгэн хавигай дүүрэн алт өгснийг үзвээс таван зуун динар байсан тул зүрх хагаран алдтал баярлаж тэр эмийг ерөөн, гэртээ харьж их л баян болж суутал гэнэт хаалга тогшсонд нээн үзвэл нэгэн үл таних эмгэн озгсож гун өгүүлрүүн: Ай хүүхэн одоо нэгэнт мөргөлийн цаг ойртсон тулл би угаал хийх хэрэгтэй болов. Чи намайг гэртээ оруулна уу хэмээсэн за гэж угаалгын хумх өгсөнд эмгэн угаал үйлдэж мөргөхөд миний ахын төлөө сайнааро залбирсанд баярлаж хоёр динар өгвөөс чамаас сайн санах хүнийг чи гуйланчин хэмээн үзнэ үү. Чиний алт надад хэрэггүй, хэрэв чи энэ алт өгсөн хүнийг дахи-олж үзсүгэй хэмээвэл би та µоёрыг нийлүүлж чада. Тэр миний нөхөр болой хэмээсэнд аяа ээж минь тэр хүн лүгээ уулзах арга тал юу байна гэсэнд тэр баян хүнд дуртай тул чи атлаа авч мин_ий хойноос явагтун. Нүүр золгосон цагт эелдэг сайхнаар аашилбаас чиний хамаг хүсэл ханах цаг бий гэсэнд алтан динарыг авч эмгэнийг дагасаар эгэн их хаалганы өмнө хүрэн тогштол Эллин шивэгчиэ гарч хаалгыг нээсэнд эмгэн миний ахыг нэгэн сайхан байшинл удирдан оруулж суулгасанд алтыг өмнөө тавьж , малгайг өөвөр дээрээ тавин суутал ертөнц хосгүй нэгэн гоо сайхан охин ирж миний ахын гараас хөтлөн дэвссэн нэгэн аглаг тасалгаанд аваачиж ар лугаа хамт сууж баахан наадтал би түр галагш гарна чи намайш иртэлд битгий хөдөл хэмээн захиж гарсанд гэнэт нэгэн маш их биетэй хар арьст боол гартаа юлд барин ирээд чамайш энд хэн дагуулан ирэв. Чи энд юу хийнэ юу хийнэ хэмээн зандран асуусанд миний ах айж үг өчиж чадахгшүй болсонд хувцсыг хуу татаж илдийн хавтгайгаар занчсанд үхтхийн унасныг тэр муу боол үзээд амь тасарсан хэмээн давсч эм хаа байна гэсэнд нэгэн тэвш давс барсьан охин ирсэнд тэр боол миний ахын шархыг давсалсанд өвдөхийг тэсвэрлэн үхсэн мэт хэвтсэнд зоорьч эм хаана буй хэмээн дуудахад эмгэн ургша давшин гарч миний ахыг хөлөөс чирэн аваачиж зооринд олон үхсэн хний дээр орхисонд шархнаас цуврах цус дасванд тогтоод үхсэнгүй тул хоёр хоногийн эцэст нэгэн завсар чөлөөг олж зоорийн чулууг өргөж сэмхэн өглөөгүүр өөр хүнийг агнаар орох дашрамт хойноос сэмхэн дагалдан гарч гэртээ хариад биеийг эмчлүүлэн сувиож тэр эмгэнийг ажиглаваас өчнөөн төчнөөн хүнийг гэртээ аваачиж хорлоыхг үзээд эл учрыг бусдад хэлсэнгүй , өөрийн биений тэнхэл тамир сайжирсан хойно зүс бурулж иран хүний хувцас өмсөөд мөнгөний саванд шил дүүргэж бүснээс өлгөн хормой дотор сэлэм нууж эмгэний өмнө очиж иран хэлээр өгүүлрүүн: - Би өөр улсын хүн бүлгээ . Энэ хотод ирээд таних хүн нэг ч байхгүй тул эмгэн чамаас гуйяа надад есөн зуун динарын шижир алтыг дэнслэх сайн дэнс олж өгнө үү . Би ачийг хариулж шагнана хэмээсэнд эмгэн тсэгэлгүй баярлаж чи надаас асуусан нь сайн болов. миний хөвүүн дэнсний пүүстэй тул түүнд зүйл бүрийн дэнс буй . Тэр гадгаш гарч явах магадгүй , хурдан очиж чиний алттыг дэнслэе гэсэнд тийм бол миний өмнө удирдан явагтун хэмээн тэр эмгэний хойно дагаж их хаалганы өмнө хүрээд эмгэн хаалгыг тогшсонд урьдах хүүхэн хаалгыг нээсэнд эмгэн инээсэнд өгүүлрүүн: - Би энэ тарган мах хүргэж ирэв гэсэнд тэр хүүхэн миний ахын гараас хөтөлж өнөөх байшинд оруулан хажууд баахан сууталг, чи түр сууж бай . Чи удалгүй буцаж ирнэ хэмээн гарсанд өнөөх боол сэлмийг далайсаар ирээд чи смуу бос хэмээн зандран дуудаж өмнө зам удирдан, явахалд миний ах хормоы дотроос сэлмиыг сэмхэн гаргаж тэр боолын толгойг цавчин унагаж, хүүрийг зоорийн зүг чирэн аваачиж, давслагч эм хаана

буй хэмээн дуудахад тэвштэй давс барьсан хүүхэн орж ирээд миний ахыг үзээд цочин зугтаасанд хойноосм нь нэхэн гүйж , тэргүүнийг унагаж , зоорьё эмгэн хаана байна гэсэнд эмгэн орж ирэв. Ах асууруун: Муу эмжгэн чи намаг таних уу гэсэнв аяа ноён минь , би чамайг яахин таних билээ гэсэнд чи урьд миний гэрт угаал мөргөл хийхээр шалтаглан орж наайг энд авчирсан биш үү гэхэд , Аллах тэнгэрийг бодож миний амийгш өршөө хэмээн гуйсанд ах, тэр эмгэний үгийг авсангүй нэгэнт цавчмагц дөрвөн анги болгож хүүхнийг эрсээр олсонд тэсгэлгүй хүсэмжилж , алж түвдсэнгүй , чи энэ хар болтой юу үйлдэнэ гэсэнд хүүхэн өгүүлрүүн: Би урьд нэгэн худалдааны хүний шивэгёин бүлгэ . Энэ мэгэн үргэжл манай гэрт орох тул надтай ханилж нэгэн өдөр өгүүлрүүн: Манай гэрт нүгэлт хүн үзээгүй их найр хурим болно. Чи очиж үзэгтүн хэмээсэнд , сайн хувцас чигээ зүүж , нэгэн зуун динар алт авч энэ газар ирвэл муу хар арьст агшин зуур намайг дарж аваад энд хорьсоор гурван жил болов гэсэнд ах асууруун: Энэ айлд юм буй юу гэсэнд энэ айлын хөрөнгө маш их . Чи авах бол автугай хэмээн авдар савыг нээж үүүлэхэд миний ахын толгой эргэж дэмий л гайхан зогсоход хүүхэн өгүүлрүүн: - Чи одоо очиж энэ их алт мөнгө, эд хөрөнгийг зөөх хүнийг олж ирэгтүн гэсэнд гаднаас арван хүнийгш хөлслөн Ёрвээс хаалгыг цэлийтэл нээж, хүүхэн ч үгүй авадр сав ч үгүй болсныг үзээд хүүхний аргад унас-ыг сая мэдэж үлдсэн бага сага эд мөнгийг хоггүй шүүрэн авч баярлан хономонд өглөөгүүр хорин цэргийн хүн тэр байшингийн хаалгын өм-ө миний ахыг тосон барьж чамайг Вали түшмэл дуудна гэсэн¤ өчнөөн төячнөөн мөнгө өгч гэ°тээ харих түр чөлөө гуйваас огт хүлээхгүй, баглан хүлж түшмэлийн яамнаа хүргэхэд үам гудас миний ахыг таних нэг хүн тохиолдсонд түүний хормойг ноцож , тэнхрүүл хэмээн гуйсанд тэр хүн албаны хуяг цэргээс учрыг асуувал бид нарийн учрыг мэдэхгүй, Вали түшмэлийн тушаалыг дагаж явна гэсэнд , та нар энэ хүнийг тавьж Вали түшмэлд олсонгүй гэж мэдүүлбэл ямар буй . Та нарт таван зуун динар алт өгье гэсэнд хүлээсэнгүй миний ахыгш үхсэн нохой мэт чимсээр Вали түшмэлийн өмнө хүргэсэнд тшмэл асууруун: Чи энэ эд юмсыг хаанаас олов хэмээсэнд тэр эмгэн лүгээ анхан уулзасанаас эхлэн хүүхний оргосон хүртэл нэгд нэггүй тоочин хэож гуйн өгүүлрүүн: Миний олсон энэ эдээс авах нь чи өөрийн дураар автугай. Над ганц тэжээлийн төдийхнийш үлдээнэ үү гэсэнд Вали түшмэл миний ахыг хамаг эдийг хураан авч Султан хаан мэдүүзээ хэмээн миний ахыг чи энэ хотоос зайлахгүй бол би чамайгш дүүжлэн ална гэсэнд миний ах айн эмээн өөр хотноо очсугай хэмээн явтал замд олон хулгай тохиолдож нүцэглэн занчаад чихийгш огтолсонд би ахын сургийг олж хотод нуун оруулж сувилан тэжээв. Миний зіргадугаар ах уруулаа огтлуулса- бүлгээ . Урьд их ядуугийн тулд хүрч амј зуух атга эрэн явтал нэгэн сайхан орд харшийг үзээд хаалган» өмнө зогсох оон зардаснаас энд хэн сууна гэж асууваас энд Бармагид овогтой нэгэн хүн сууна гэж хаалгачаас юм гуйвал чамд эрэл хүсэл буй аваас манай эзний өмнө очсугай гэсэнд дотогш орж гайхамшигтай сайхан орд харш цэцэрлэгийн өмнө хүрээд хааш орхоыг мэдэхгүй гайхан явтал нэгэн үзэсгэлэнт бөгөөд сахалтай хүнийг үзэж түүний цуг очиход тэр хүн ахыг үзээд угтан очиж ёслон золгосонд миний ах гачигдлаа тоочив. Тэр хүн миний ахын үгийг сонсож, их л өрөвдөн дүрэх үзүүлж өөрийн өмссөн хувцсыг хага татан өгүүлрүн: Би энэ хотод суух атал чи энд өлмөх ажээ . Би үүний яахин тсвэрлэх билээ хэнээн элдвээр туслах мянган эхт түмэн үг

хэлсэнд аяа ноён минь миний бие их өлсөуж хүлээн тэсвэрлэх аргагүй болов гэсэнд гэрийн эзэн угаалгын газар хумх авагтүн хэмээгээд миний ахад гарыг угаагтун гэвэл хусх, огт үгүй тул ах их л гайхаж, гэрийн эзнийг үзвэл хоосон газар гар угаах дүрэм үзүүлэн , ширээ засагтун хэмээн дуудаж миний ахыг хоосон газар суулгаж , энэ тэр хоол идэгтүн хэмээн зочлдон хүндэлж хоосныг заан өгүүлрүүн: Энэ боовноос идэгтүн:. Их сайхан цагаан боов болой гэ ээд миний ах, энэ хүн , хүнийг дарлахад дуртай аж хэмэн сэтгэж, боод идэх дүрэм үзүүлэн , би хүн болсоор ий¬ сайхан боов идсэнгүй гэсэнд энгэ боовыг зургаан зуун динараар худадан авчсан шивэгчин хийсэн билээ гээд махтай боорцог авчирагтун . Бас цуунд дарсан тарган адууны мах авчир хэмээсэнд миний ахыг хүндлэх дүрэм үзүүлж зүйл бүрийн амттай зууш идээг нэрлэн дуудаж, ид ид гэж шахалд, миний ах зоримогоор идэх дүр үзүүлэн их зажилна. Гэрийн эзэн бас дуудан өгүүлрүүн: Хасарваань чавгаар шахсан тахианы зулзагын мах авчирсан гэж зүйл бүрийн хоол захиж , амтыг шагшин магтахад миний ах өлөн шүлсээ хазаж өлсөх нь улам нэмэгдээд би цадав гэсээд чингэвэл үүнийг хуааж элдэв амтат жимс авчрагтун хэмээн миний хагй үүнийг түүнийг идэгтүн хэмээн хоосны г чичиг заахад н ах дотроо их хорсож идэх аргагүй болов гээд лотроо би үүнийг хэрхэвч өнгөрүүлэхгүй , эрхбиш хариу авна хэмээн сэтгэгдэл гэрийн эзэнд зарцад дарс авчрагтүн гэж тушаахад олон зардас дарс авчирч байдал үзүүлж гарыг сарвайн өргөхөд гэрийн эзэн нэгэн хоосон хундага барьж эн дарснаас амсан чиний санаанд нийлэлцвэл надад хэлэгтүн гэсэнд миний ах өгүүлрүүн: Үүний үнэр сайхан боловч би хорин жил дарсан хууин сайн дарс уудаг билээ гэсэнд гэрийн эзэн хоосны зүг заан өгүүлрүүн: Тийм бол үүнээс амсаг тун гэсэнд миний ах уусан байдал үзүүлсэнд гэрийн эзэн бас нэгэн хундага баривал миний ах убж согтсон дүрэ¬ үзүүлэн суганы цагааныг үзэгдтэл гарыбг өөрбгөн далайж гэрийн дотор хангинатал алгадаж ,бас нэгэнт дэлдсэнд гэрийн эзэн энэ муу юу болов хэмээн дуудсанд ах өгүүлрүүн: Аяа ноён минь, чи дорд боолыг өршөөн нийгүүлсэн , гэр өргөөндөө оруулан хишиг хүртээж уух идэхийг шагнан , хуучин сайн дарс согттол уулгасан боол би өөрийн үггүй согтож агсагнав. Чи уудам сэтгэлтэй тул миний нэгэн удаагийн мунхагласныг өршөөн хэлтрүүлнэ үү хэмээсэнд гэрийн эзэн их л инээн өгүүлрүүн: Би хүнийг элэглэж , нөхөр ханийг шоглосоор их л удавч чиний адил хүлцэн тэсвэрлэж харицу авах сэргэлэн хүнийг нэг ч үзээгүй . Надад чамайс муу санах зүйлгүй . Үүнээс хойш миний хамт сууж, хоол будаанаас идэлцэн , хагацалгүй ханилах нөхөр бологтун хэмээн анханддурдсан олон зүйлийн амттан идээг авчруулж хуримлан хорин жил болсны эцэст гэргийн наснаас нөхчисөнв Султан, тэр гэрийн эзний хамаг хөрөнгийг хураан авч хоосон болгосонд амь гарахыг бодож зугтан зайлтал , замд нүүдэл аймгийн хүмүүс олзлон авч, амийг золих мөнгө нэхсэнд миний ах уйлан өгүүлрүүн: Аллах мэдтүгэй . Би хоосон хүн . Эдүгээ би таны олз болсон тул намайг хэрхвээс хэрхэгтүн хэмээсэнд нүүдлийн хүн хилэгнэн уурлаж, хутга шүүрэн давшилж миний ахын уруулыбг отглоод байн байн золих мөнгө нэхнэ. Тэр нүүдлийн хүнд нэгэн үзэсгэтэнтэй эм буй билээ . Эрийг гадагш гарах бүр миний ахад сэртэгнэн наалдахад ах ог т хүлээхгүй бүлгээ . Нэгэн өдөр тэсгэлгүй автагдаж тэр эмийг өвдөг дээрээ суулган наадахад гэнэт гэрийн эзэн ирж энэ муу миний эмий бузарлана уу хэмээн зандран харааж, хутга сугалан гаргаж миний

ахыг бэлгийг огтлоод , биеий нь тэмээнд ачаад ууланд аваачиж орхисонв завшаанаа таних аянчи- тохиолдоход идэх уухыг өгч надад мэдээ хүргэсэнд яаран очиж ахыг хотод аювчран тэжээсэн бүлгээ . Эдүгээ би энд ирээд ээзэнд эс айлтгаваас алдас болъюу хэмээн зургаан ахын явдлыг нэгшд нэгнээр хэлэв гэсэндХалиф ээзэн миний үгийг сонсоод инээж цөөн үгт чи үнэхээр чалчаа айварч хүн бус бололвч энэ хотооё зайлж өөр хотод суугтун хэмээн хуягт тушааж үлдэн хөөлгөсөнд олон хот муж эргэсээр нэгэн өдөр Халифыг нас нөгцчөнд өөр Халиц ширээнд суусныг олж сонсоод энэ хотод эгж ирээд миний ах нар хэдийн үхсэн ажээ . Чингэтэл би энэ залуутай уулзаж сайн хэрэг хийлцэн билээ . Намайг үгүй бол энэ лав алагдах байжээ . Чингэтэл энэ хүн намайгш элдвээр гүтгэж чалчаа айварч гэсэн н цөм худал болохыг та бүхэнд сонсгоё. Энэ залуугийн төдөө би өдий төдий олон улмыг эргэн хэсэж сая таны энэ газарт гүйцэж золгосон минь миний сэтжгэлийн уучийг үзүүлнэм бусуу гэсэнд би энэ үсчний явдал болоод түүний олон дэмий чалчаа үгийг сонсож, энэ залууг хохируулсаныгш мэдээд барьж далд хориод ь үдээш хойш мөргөлийн уриа хүртэл найрлан цэнгэлдэж тарсанд миний эм царай барайлган өгүүлрүүн : Чамайг цэнгэлдэн жаргахад би гагцаар гэртээ сууж уйдна . Энэ дөрийн эцэст чи намайг гадагш гаргаж уйтгарыг сэргэSн явахгүй бол би хэлхээг таслаж хагацуулсан шалтгаан чамас гарна гэсэнд , эсм юугаа дагуулан гарч зугаалдан явтал буцах замд нэгэн нуруугүй хүнийг үзэж гэртээ аваачсан билээ . Миний эм түүний аманд загас чихээд хахаж үхсэнд хүүрийг энэ отчиын грт сэмхэн аваачиж орхисонд оточ түүнийг тогоочийн даргын гэрт хаяжээ . Тэр нь энэ эрхүүдийн замд орхив. Миний өчигдрийн үзсэн өнгөрүүлсэн сонин зүйл энэ бүлгээ . Үүнийг энэ нуруу муутын явдлаас илүү сонин хэмээвэл үл болно уу хэмэвээс хятаын хаан үүнийг сонсоод толгой сэгсэрэн баярлаж гайхан өгүүлрүүн: Энэ чалчаа үсчин залуу хоёрын хоорондоос гарсан явдал нуруугүй худаолчийн явдлаас илүү сайхан аж хэмээгэд шадар нэгэн хүнд тушааж бгүүлрүүн: Энэ үйлчний хамт очиж үсчнийг хорьсон газраас гаргаж ирэгтүн. Би түүний үгийг сонсоод та нарыг суллан тавьсугай . нуруугүй хүний хүүрийг би эндээс оршуулна гэсэнд үсчнийг хааны өмнө хүргэж иирэв. ҮЗвэл ер гарсан настай муу өвгөн ажээ . Нүүр хар, сахал хөмсөг цагаан , чих хулгар , хамар урт бөгөөд цээж дүүрэн, зөнөг мунхаг тул хаан түүнийг үзээд инээж өгүүлрүүн. Аяа цөөн үгт өөрийн олон түүхийн нэгийг хэлж өгнө үү гэсэнд өвгөн асууруун : Ай цагийг эзэлсэн хаан аа, энэ эрхүүд , еврей , дад үхсэн нуруу муут энэ дөрвийн түүх явдал юу билээ . Та бүгдийн энд цуЈларсан учир юу билээ гэсэнд Хятадын хаан асуруун . Чи энэ ыүгдийг асууж юу хийнэ гэвэл үсчин өгүүлрүүн: Эд намайш чалчааа хэмээн гүтгэх тул хаан намайг тийм бус хэмэн мэдтүгэй гэж асуусан билээ . Миний нэр цөөн үгь гэсэнд хаан өгүүлрүүн: Энэ үсчинлд эд бүгдийн явдлыг хэлж өгөгтүн : гэсэнд үсчин тэдгээрийн явдлыг сонсож өгүүлрүүн: Аллах мэдтүгэй . Энэ үнэхээр гайхалтай жигтэй хэрэг ажээ . Надад энэ нуруу муутыг үзүлэгтүн хэмэн түүний толгой өдөр дээрээ тавин үзээд, гэдрэг унатал инээж өгүүлрүүн: Зхэл бол сонин боловч энэ нуруу муутын үхлийг алан үсгээр тэмдэглэлтэй хэмээсэнд хурсан бүхэн гайхаж , хаан асуруун: Цөөн үгт чи юү хэлэв гэсэнд үсчин энэ нуруу муут худалчийн гол нь арай тасраагүй байна гээд өврөөс нэгэн хайрцаг гаргаж түүнгий дотроос савтай тос авч , нуруу муутын хүзүү хоолойнд түрхэж хоёр төмөр дэгээг аманд чихээд нуруу муутын хоолой дотроос

цус бо[illegible] мах яс гарсанд [illegible] нүүрийг илбэн өгүүлрүүн: А[illegible] мэн хэмэн залбир[illegible] унагал инээж, үхсэн хүн дахин амьдрахыг та нар үзэв үү хэмээн энэ сонт явдлыг алтан үсгээр бичүүлж хаан сандаа хадгалаад еврей , эрхүүд тогоочийын дарга гуравт үнэ ихт хувцас шагнан өгч үйлчинд бас хувцас шагнаж цалин пүнлүү тогтоон хааны үйлчин болгож, нуруу муут лугаа эвлүүлэв. Нуруу муутад бас хвцас шагнаж , цалин дүнлүү тогтоон хааны идэнээс идэлцэх хЁшиг хүртээв. Үсчнийг хаан лдугаа хамт архи уулцах ,улсын үсчин болгож бүгдээр жагалыг эвдэгч , хурал чуулганыг цүүлсдүүлэгч үхлийг ирэн иртэл найр найдмаар цэнгэлдэн жаргажээ . Таж-аль-Мулук нэг өдөр олон дагуулаа дагуулж авд мордоод дөрөв хоног явж нэг их сайхан ургамал, устай , ан гөрөө элбэг газар ирээд “За энд саал тор таьвж холуур дүгрэн хумьсагуй” гэхэ нь бараа бологчид нь за гэж ёсоор үйлдвэзс зөндөө олон зээр гөрөөс бужигналдан нохой, ирвэс, шонхор зэрэг тавьж өөрсдөө басхүү харваж үй айгүй намнан яах иийхийн зуургүй өдий төдий гөрөөсм алж, олз омог ихтэй боллоо . Таж-аль-Мулук усан дээр очиж бараа бологчид ангийн олзыг хуваaж аль, сайныг эцэг Сулейман –шах хаанд илгээж үлдсэнийг нь бусдад хуваан өгөөд тэр шөнө мөнөөхөн усан дээр хонов. Өглөө болтол тэрхүү усан дээр олон аянчин буусан байжээ . Таж-ал ь- мулук энэ хаанахын юун улс ирснийг мэдээд ир ! гэж хүн зарсанд мөнөөхөн буудаллсана аянчид ийн өгүүлрүүн: “Бидний аянчид хол газраас яваа бөгөөд Сулейман шах хаан , түүний хөвгүнд илтгэх тул энэ сайхан ургамал устай газар дайралдаж буудаллав . Нэр бүхий хааны ойролцоо нутаг газар бидний амь насанд аюулгүй гэж бил мэдэх бөгөөд басхүү хаан хөвгүүн Таж-альМулук зориуд их үнтээй эд бөс тээж явнам ” гэжээ . Зардсан хүн буцаж хаан хүүд эл учрыг айлтгаваас Таж-аль Мулук, “Хэрэв надад сайн эд бөс бараа авч яваа бол би заавал биеэр очиж үзнэ” хэмээн мордон бараа бологчдоо дагуулан очвол худалдаачин тосож марыг айлтгаад сайныг ерөөв. Тэнд бэлхнээ сувд эрдэнийн чулуу хатгамал шигтгсэнэ улаан торгон асар шааж, голд нь басхүү маргад шигтгээтэй торгон хивсэн дээр хаан ширээ тавьжээ . Таж-аль-Мулук хаан ширээндээ залраад худалдаа·инд авч яваа бараагаа үзүүлсэнд Таж-аль-МУлук дуртайгаа шилж аваад арван талны саран мэт өргөн магнайтай , цэвэрхэн царайтай гоё хувцастай , голшиг нэг залуу эр нүдэнд тусчээ . Лавлан харюал ийм сайхан эр байж, амрагаас хагцасан боллотой царай цонхигор хоёр нүднгий нулимс асгаруулсан гаслан ёолж шүлэглэх нь: Холын өнгө хагацасан байьалд гуниг айдас төгсгөлгүй Хоёр нүдний нулимс горхи адил шожигноноБид хоёр салахын цагт сэтгэл зүрх халуун билээ . Бие ганцааро болохын цагт итгэд ч алга сэтгэл ч алга Аяа байзаараа та минь, амрагтайгаа салаадахъяАливаа үг нь өвчин ба эмгэгт эм болдодг юм аа . Гээд цурхиртал уйлан нэгэн үе цухаан алдаж, нэгэн үе сэхэж байхыг Тааж-Аль—Мулук үзээд ихэд гайхан хөвгүүн нэгэнтээ сэхээ авч хаан хүүгийн өмнө сөхрөн унаха Таж-аль-Мулук “Чи энд бараагаа юунд эс үзүүлнэв?” гэсэнд залуу хөвгүүн өгүүлрүүн: “Аяа эзэн минь, жаргалтай чиний сэтгэлд нийцэх эд бараа над үгүй билээ” гэхэд нь Таж-аль-Мулук өгүүлрүүн: Чиний ямар эд авё явааг заавал үзнэ . Бас чиний царайг харахад сэтгэл санаа ихэд зовуурьтай нь ил байна. Эл учрыг яригтун . Хэрэв чамайг хүн гомдоосон бол тэрхүү шудрага бус ёсыг таслан барагдуулна. Хэрэв

чамд өр авлага байваал бидб асхүү барагдуулан төлнө. Чамайг хараап өрөвдөж байна гэжээ . Таж-аль-Мулук захиран хоёр вандан тавиулж өөрөө нэг дээр нь сууж, алт ба торгоотрр чимсэн зааны ясан вандан дээр хөвгүүнийг суулгаад "За эд бараагаа гаргаж үзүүл" гэсэнд худалдаачин хөвгүүн өгүүлрүүн: "Үүн й тухай битгий дурсагтун. Эрхэм таны сэтгэл таалагдах эд надад байхгүй" гэмэн атал Таж-аль-Мулук заавал үзнэ гэж зарц боолчуудыг захиран эд барааг задланау гэжээ . мөнөөхөн хөвгүүн нэг үе уртаар санаа алдаад нэг үе хэнгэнтэл уйлан байж арга буюу бараагаа задлан ам хуй торго бөс гаргаж үзүүлсний дотор алтаар оёсон пүүсүү пээл гарсан нь хоёр мянга динар үнэтэй ажээ . Тэрхүү дээлийг дэлгэтэл дотроос нь нэг ам дөрвөлжин бөс унасанд шүүрэн авч салтаандаа хавчуулан нуугаад ийн шүлэглэрүүн: Үйлийн үртэй сэтгэлийн минь хэзээ чи нэг амраах юм бэ Үнэндээ чиний хайраас Плеяп хорвоо ойрхон байнам. Хагацал , уйтгар, хайр дурлал хийгээд Хүлээж цөхрөхөө болж хүн үхэх зовлон бий ! Хайрлан дурлаад сэхсэнгүй, хагацаж одоод үхсэнгүй би . Хамгийн хол ойрхон байна. харин чи минь холхон байна Эрс зан чамд харш, энгийн өршөөл чамд үгүй Эгэл над тум болсон энэ бие хааш одох билээ .Хайрын сэтгэл чамд хүргэх бүх зам явцуу ажаам. Хаашаа одож юу хийхийг өөрөө үл мэднэм. Гэхэд нь Таж- Аль-Мулук нэнгайхан атал учир шалтгааныг яахин мэдэх билээ . Залуу хөвгүүний с лтаандаа нуусан бөс юу юм бэ? гэсэнд хөвнгүүн өгүүлрүүн: Гагцхүү энэ ам дөрвөлжин бөс харуулахгүй гэж бид эд бараагаа үзүүлэхгүй гэсэн бүлгээ гэхэд нь Таж –аль –Мулук дөрвөлжин бөсийг заавал үзнэ гэсэнд хөвгүүн арга буюу гаргаад нэгэн үе уйлж нэгэн үе ёолж нэгэн үе санаа алдсаар шүлэглэсэн нв: Хайрты минь зүхээд яахав, хараалаас их зовдог юмХариуд би ганц үнэнийг хэлсэнд харин тэр дуулаагүй юм . Аяны буудлаас сарыг би хээр аваачиж Аллахад даатгав Агаар тэнгэрийн цэлгэр зай, түүний мандах газар боой. Амрагаас хагацсанаас аминаас хагацсан нь дээр байж Аль эсгүүл огт салахгүй хамт байвал сайхан байж ХАгацан салах өдөр намайш үүрийн гэгээ харж байгаа Хацрыг дагаж бид хоёрын нулимс урсаж байгаа Хагацанс алснаас хамаг шалтгаан тас үсрэвч Харин би түүнийг эдүгээ нэхэн суунам. Холын тэртээ нэг өдөр хагацан салснаас хойш Хоё биед амар заяа огт исэнгүй Үйлийн үрээр бидэн хоёр гашуун зовлонд унав. Үнэндээ над ч түүнд ч ямар жаргал алга Үйлийн лай өөрийн аяганд хольцгүй зовлон байжээҮзтэл бид хоёрын хэн хэн нь түүнээс уух байжээ . Энэ шүлгээ хэлж гүйцэхэд нь Таж-аль – Мулук өгүүлрүүн: "Харва с чиний сэтгэл зовуурьтай байна. Яагаад энэ ам бөс үзэхдээ гунигт автах болсноо ярьж өгнө үү!" гэсэд залуу хөвгүүн шүүрсэн алдаад "Аяа эзэн минь, миний явдал жигтэй бөгөөд энэ ам бөс түүн дээр хатгамаласан зургийн учир явдлыг гайхалтай гэж мэдтүгэй" гээд мөнөөхөн ам бөсийг дэлгэн харуулбаас доргоор оёж шижэр алтаар гоёсон шаргачингийн зураг байна . Урдаас нь бас нэг шаргачин мөнгөөр оёж хүзүүнд нь шижир алтан чимэг гурван уртхан молор зүүснээр урлажээ . Таж-аль-Мулук хараад нэн сонирхож , эдний учир холбогдлыг дуулах юмсан гэдэг хүсэл нь бадраад "аяа энэ хоёр шаргачин урлсан хүнтэй чи ямар учир холбоотойгоо ярьж өгнө үү?" гэсэнд хөвгүүн өгүүлрүүн: "Миний эцэг худалдаачин хүн, ганц хүүтэй тэр нь би билээ . Миний үеэл дүү охин эцэг эрт үхсэний учир миний эцгийн гар дээр өсжээ . Эцэг нь нас барахын өмнө миний эцэгтэй ярилцаж биднийг нас бие гүйцэхийн цагт гэрлүүлэх болсон байжээ . Нэг өдөр миний эцэг эх хоёр Азиза Азиз хоёроо энэ жил гэрлүүлье хэмээн

ярилцан тохироод хуримын юм бэлдэж эхэллээ . ТЭгэхэд би мөнөөхөн үеэл охинтой нэг өвөрт унтах атал юмны учир сан мэдэхгүй , харин тэр охин надаас илүү юмны учир начир мэддэгбайжээ . Миний эцэг ураг барилдахын холбогдолтой бүхийл юм базаагаад гагцхүү ураг ыарилдахын бичиг үйлдуэж хурим ёс хийх ажил үйллдэж өдөр судрыг тохоож баасан гаригийн мөргөлийн дараа хурим хийхээр бэлхэн болж, миний эх явж үерхдэг эмс, садангийн ул±ад цөмд дуулгажээ . Тэр өдөр манай байшингийн гантиг чулуун шалыг гялалзтал угааж, их хивч дэвсээд бас туургыг алтаар хатгамалсан бөсөөр хөшиглөв . Ингээд баасан гаригийн мөргөлийн дараа манайд улс цуглах болж миний эцэг амтта сайхан боов зууш хийсээр байлаа . Миний эх над жигтэй гоё хувцас гаргаж өгөөд халуун усанд очиж биеэ угаа гэж явуулав. Биеийг сайтар угаан мөнөөхөн шинэ хувцас өмстөл биед хачин эвгүй атал ариухан сайхан үнэртэй байлаа . Тэндээс би сүмд очих гэснээ нэгэн сайн танил хөвгүүнийг хуримандаа урьсугай гэж цааш эргэж “мөргөл тартал яваад ирте байз!” гэж бодлоо . Нэгэн үл таних гудамжнаа орто маш халууцах тул захыг эмжсэн том алчуур гаргаж дэвсээр сэрүүцэан суутал улам ч хөлс асгаран яах аргагүй болов. малгайг авч духны хөлсийыг арчих угэтэл дээрээс нэгэн цагаан алчуур унаж ирэв. Тэр алчуур салхинаас эелдэг бөвчтэй хүнийг боловч эдгээмээр тийм ялдам ажээ . Алчуур уна ан зүг дээш харвал энэхүү шаргачинг урлан оёчсон эмтэй харц тулгарлаа . Зэс сараалжтай цонхоор шагайх тэр эмийн үзэсгэлэн гоо өгүүлэвч баршгүй бөгөөд намайш хармагц нэгэн хуруугаа үнхсэнээ дунд долоовор хёроо элжгэндээ тэврэн дохио үзүллээд цааш далд оорж цонхыг хамхив. Миний зүрхэн шатаж гал бадрах мэт болоод мянгантаа санаа алдан суутал сэтгэл ихэд үймрээд нэг мэдэхнээ тэр эм юу хэлсэн , юу гэж дохисныг ухаараагүй билээ . Тэрхүү үзэсгэлэнь гоо эмийгш дахин нэг харах сэтгэл ээзэмдүүлэн наран жаргалтал хүлээтэл огт цухуйсангүй. Арга цөхрөөд мөнөөхөн өгсөн алчуурыг үзвээс заарын үнэр анхилах тул диваажингийн оронд очсо санагдах бөгөөд алчуурыг дэлгэтэл дотроос нь нэг нимгэн ¶аас гарсан нь басхүү ариухан сайхан үнэр шингэсэн ажээ . Тэрхуудас цаасан дэр шүлэг бичсэн нь : Тачъяангүй сэтгэлээ зэмлэн байж түүнд би захидал илгээвТэрхэн бичиг минь даанч турьгүй явцуухан байжээ “Хайрт минь бичиг чинь яагаадийм турьгүй болоо вэ?Харагдах төдий зургаар үсэг гарсан байна?гэхэд минь ” Үсэг минь байтугай, бие минь өдий их шавхарчээ . Үнэндээ дурласан хүн ингэж нарийхан бичдэг юм гэлээ би.гэжээ . Энэхүү шүлгийг уншаад миний зүрхэн галаар шатаж, дурлал тачъяангуйн дунд умбан дэмий л тэр эмтэй хэрхэн нэг удаа учрах аргаа мэдэхгүй алчуур ба зурвасыг авч харихад нэгэнт шөнө дөл болсон агаад миний нагауын охин намайг хүлээж уйлан суужээ .Намайг ортол нулимсыг арчаад миний хувцсыг тайлан ярьсан нв “Манайд олон улс цуглаж , шүүгч гэрчийн хүмүүс ирж ихэд будуулаад , ураг барилдахын ёс бичиг үйлдэх хэмээн чамайыш хүлээж ядаад сая тарцгаав. Чиний эцэг энэ ёслолд хамаг мөнгө барав хэмээн маш их хилэгнэн уурлаж чи бид хоёрын ураг барилдахыгш хойтон болтол хойшлууллаа . Чи яагаад ийнхүү орой болтол саатав?” гэхэд нь “Аяа үеэл минь , итйм юм битгий асууж намайг зовоогтун!” гээд мөнөөхөн болсон явдлыг нэгд нэггүй тоочин ярьж алчуур ба зурвасыг гаргаж үзүүлтэл шүлгийг уншаад хаацар дээгүүрээ нүдний нулимсыг асгарулан ийн шүлэглэрүүн: Тачъяангуйн сэтгэд анхандаа дураар байдаг гэвэл Тэр , худлаа албаар төрүүлдэг гэж хэлээрэйТэгээд

тэр эм чамд юу гэж хэлэюв, ямар дохио үзүүлэв? Гэхэд нв тэрбээр ганц ч үг дуугарсангүй гагцхүү хуруугаа амандаа хийгээд бас дунд долоовор хуруу хоёрлл нийлүүлэн элгэндээ тэврэн нэгэнтээ газар заагаад далд орсноос хойш дахин цухуйсангүй . Нэг мэдэхнээминий зүрхийш сугалан авсан тэрхүү үзэсгэлэн гоо эмийг дахин нэг харахсан гэж наран ужаргатал хүлээж цөхрөөд сая эгэж ирсэн минь энэ . Чи харин над энэ талаар тусалбаас сайнсан гэсэнд Азиза толгойг өндийлгөн “Аяа, миний авгын хөвгүүн минь ээ, хэрэв чи миний нүдийг боловч авъяа гэвэл би ухаж өгөхөдбэлэн байна. Энэ үес би чамд ба тэрхүү эмд тус бололгүй яахав. Яагаад гэвэд тэр эм ёчамд , чи тэрэнд дурлажээ” гэхэд нь би “Түүний дохиог юу хэмээн мэдвэл зохилтой бэ?” гэсэнд Азиза хэлэв. Хурууг амандаа хийдэг нь чи түүнд онц тоогдоод чамтай наргиж баймаар залуу байна гэсэн үг . Алчуур өгдөг нь чамд сэтгэлтэй болоод баярын мэнд илгээжээ . Зурвас өгдөг нь чам лугаа ойртсугай гэжээ . Хоёр хуруугаа элгэндээ наадаг нь хоёр хоноод дахин үзэгдэж сэтгэлий минь амраана уу гэсэн үг ажээ . тэр ч чамд дурлаж, чамайг итгэж буй гэж чи мэдтүгэй . хэрэв би гарч ордогсон бол чамайг нээн даруй уулзуулж хормойгоор болovч халхлан далдлах юмсан гэжээ . Азизын энэ үгийг сонсоод би түүнд тал өЈч “Бушуухан хоёр хоногболоосой” хэмээн бодоод тэр хоёр хоног гадагш ч гарсангүй , унд хоол ч идсэнгүй , гагцхүү үеэл дүүгийн өвдгөн дээр толгой тавин хэвтэхэд тэр минь миний толгойг илбэн сэтгэлээ чанга барьж зүрхээ тайван байлга! Болзсон хоног гүйцэхэд очоорой гайгүй! гэж намайг тайтгаруулах бүлгээ . Тэгээд арайхийн хоёр хоногийн нүүр үзсэнд үеэл дүү намайг сайтар хувцаслан гаргаваас би шууд нөгөө гудамжнаа хүрээд хэсэг хүлээн суутал цонх нээгдэж хүүхэн гэнэт харагдсанд миний дотор балмагдан харанхуйлаад түр ухаан алдах мэт боллоо .Арайхан зүрхмйш чангалан оножхарваас тэр нэгэн улаан алчуур , толь хоёр үзүүлээд гарын алгаар элгэндээ нэгэнтээ дарж алчуурыг цонхоор гурвантаа доош дээш болгон харуулаад цонхоор толгойгоо нэг цухуйлгаад далд орж цонхыг хаав. Миний сэтгэл нээн их хөдлөөд юу гэсэн дохои болохыг эс мэдэх тул дотор аягүй болов. Мөн тэндээ үдэш орой болтол хүлээн суугаад чимээ үл гарган тул шөнө дөл босон хойно саяхариваас , миний нагацын охин хоёр нүдний нулимс асгаруулан шанаа тулаад ийн өгүүлрүүн: Чамаас болж муугийн хараал идэх ямар лайтай юэ би?Чамайгаа харахад туяхан мөчир шиг агаад санаа амрах аргагүйе! Санаа сэтгэлийг минь булаагаап сэмхэн арилсан албин минј Сайхан хүүхнээс салах ёс , Азар хүнд үгүй билээ . Хав хар нүд нь хайрын зүрхийг зүсэх нь Хамгийн хурц сщмэснээс болovч илүү ажъямЧамайгаа хайрлаад үйлийн үрд харагдах хэрэг үү би? Чадал минь алдраад цамцаа болovч эс даан ядарнам би?“Хайрласан хүний чинь нүдэн , хатгах мэс болно” гэж Хараалчийн үгийг сонсоод цусаар уйлнам би. Дорой буурай цогцсоороо л би чамтай адил гэхээс бус Дотор сэтгэл минь чинийхдээ хүрдэг ч болоосой доо!Үзэх нүд чинь бошго, хөмсөг чинь сахиул билээ ноён минь Үзэмж гоод үнэн шудрагыг мэдэх хүслэн, үгүй ажаамуу . Чухам саханд түмэн Юсуф ч эс хүрэх ажъям Хортноос эмээн, хонгор чамаас холдъё гэвч Хойшид хэдий болтол ийнхүү тулих билээ би чинь Энэхүү шүлгийг сонсоод сэтгэл улам хүнд дотор аягүй болоод өрөөний нэгэн буланд алдлан унаваас Азиза ухасхийн босож миний хувцсыг тайлж, нүүрийг угаагаад “За юу болов ” гэхэд н би саяын болсныг цөмийг ярив. Азиза өгүүлрүүн “Аяа хайрт минь , таван

хуруугаа элгээ тэвэрдэг нь таван хоногийн дараа ирсүгэй гэжээ . Толь гаргаж улаан алчуур гурвантаа дохиод цонхоор толгойгоо цухуйлгадаг нь ” Намайг хүн илгээтэл энэ гудамжнйы будагчны үүдэнд сууж хүлээсүгэй Гэсэн дохио байна гэхэд н миний зүрхэн булиглан “Аяа миний нагацын охин чиний хэлдэг яах аргагүй зөв ажээ . Яагаад г гэвэл тэр гудамжнаа нэгэн еврей будагчин байхыг би үзсэн билээ” гэв. Сэтгэл ихэд хөдлөөд нуоимс өөрийн эрхгүй асгарч миний нагацын охин намайг тайгаруулан ийн өгүүлрүүн: “Сэтгэлээ тайван зүрхээ чанга баригтун! Бусад охин янагийн халуунд хэдэн жил тэсвэртэй байдаг атал яи нэгэн эмд тавхан хоног дурлаад ийнхүү тэсэж эс чадах нь юу билээ?” хэмээн элдэв үгээр намайг тайтгаруулан тайтгаруулан хоол авчирч өгвөөс би идье хэмээн бодтол эс чадав. Ийнхүү нойр хоолноос гарч , нүд хонхойн царай алдаад . Дурлалын халуун гэдгийг урьд амсаж үзсэнгүй анх удаа үзвээс туйлын айхтар юм билээ . миний нагацын охин Азиза бие бас сульлдсан атал сэтгэлтэй болсон эр эм хоёрын үлгэр ярьж намайш унтан унттал сахин сууж заримдаа сэрэхэд мөн л унтаагүй хоёр нүдний нулимс асгаруулан суудаг. Арай хэмээн таван хоног болсонд Азиза намайш халуун усанд сайтар угаагаад шинэ хувцас өмсгөөд “За одоо оч! Аллах чамайг өршөөх болтугай сэтгэлтэй босон хүн лугаа очиж хүслээ хангагтун!” гэлээ . Би гэрээс гарч шууд мөнөөхөн будагчны үүдэгд очвол хаалттрай байлаа . тэнд суухаар атал нар жаргах дөхөж оройн мөргөлийн харанга дэлдэж би басхүү шөнө болтол хүлээн суугаад согтуу мэт гуйвалдсаар гэртээ ирвээс Азиза туургын хадааснаас нэг гараар барьж нөгөө гараар элгийг тэврэн ганцаар уйлан ийн шүлэглэх нь: Арабын их цөлд удын дотор хаягдсан Араб нүүдэлчний охин тачъяангүй сэтгэл заяажээ . Амраг сэтгэлийн галаар замын хүнийг хангаж Асгарах нүдний нулимсаар хөхүүр юугий нь дүүргэнэ. Хайрын халуун сэтгэлээ би, ганцхан хүнд өгтөл Харин янаг дурлалы минь нүгэл гэж тооцъюу Хэмээн шүлэглэн байснаа намайг үзээд нулимсаа арчин инээж, “Аллах чамайг өршөөн соёрхсоор атал, амрагтайгаа хамт унтаж хүсэл юугаа юунд эс хангав?” гэхэд нь би элэг рүү нь өшиглөтөл хаалгын тотго мөргөөд унахдаа хадаасанд духаа шалбалан учиргүй их цус гоожуулсан атал нэг ч үг дуугарсангүй нэгэн бөсийн өөдөс авч духыг боогоод хивсэн дээр асгарсан цусыг арчиж огт юм бологүй мэт инээж, эелдэгхэн дуугаар ингэж өгүүлрүүн: “Аллах тэнгэо өршөө! Би чамаас тйинхүү асуухдаа дооглон шоолсон нь огт бус миний толгой өвдөөд жаахан цус ханаж авъяа гэж байтал ашгүй нэлээд цус асгараад одоо намдаж таатай болов . Чи юу юу болсноос яриач!” гэлээ . Тэр өдөр юу болсныг фцөмийг хоёул баахан уйлтал Азиза өгүүлрүүн“ Чиний сэтгэлчлэн бүтэх нь гэж баярлаж явагтун . Өнөөдөр чамд эс харагдсан нь чамаас зориулд нууган , над үнэхээр дурлаж уу үгүй юу ер нь хэр үнэнё тууштай эсэхийш шалгах гэжээ . Маргааш хуучин заасан газарт очиход чинь биеэр харагдаж чиний гунисан сэтгэлийг амраах биз!” гэжээ . Тэгээд Азиза намайг аль болохоор тайтгаруулах гэ элдэв уран сайхан үг хэлж, оройн зоог барихад нь эмст сэтгэлээр унасан хүн амтат хоол идэж , тавтай нойрсохгүй гээд би өшиглөн унагсанд хамаг таваг хага үзсэрлээ . Азиза “Энэ үнэхээр эмст дурлласан хүний шинж мөн!” гээд тавгийг хагархай цуглуулан хаяад , над амрагийн тухай сайхан үлгэр ярьсаар маргааш өгдөө болгов. Би шууп явж мөнөөхөн эмийн цонхны дэргэд хүлээн суутал миний дурласан хүүхэн цонхоор цухуйж нэгэнтээ инээгээд далд орсноо нэг толь уут,

домбо, ногоон өвс, дэнлүү авчраад толийг харуулан уутанд хийж цааш хаяад үсээ задлан нүүр рүү унжуулж дэнлүүгээр ногоон өвс гэрэлтүүлээд харж буй байдал үзүүлээд далд орж цонхыг хаав. Энэхүү битүү таавар дохио юу гэж багаа бол гэхээс зурхэн булиглан хөдлөөд түүнээс нэг ч үг сонсоогүй атал дурлах сэтгэл минь жолоогүй болов. Тэндээс сэтгэл маш гунигтай уйлан хайлан харихад миний нагацын охин Азиза буруу харан суужээ . Жөтөөрхөх сэтгэлд цээжинд нь багтаж ядан маш уйтгар гунигтай авч намайг өөр хүүхэнд ухаангүй дурласныг мэдээ, өөрийн хайр дурлалыг над зүрхлэн хэлж чадахгүй . Толгойгоо хоёр давхар боосон нь нэгнь өчигдөрийн духаа шалбалсан шарх нөгөө нь уйлсаар байгаад нүд нь өвдөөд бас боожээ . Царай нь иихэд алдаад уйлан хайлан байж ийн шүлэглэрүүн: Охин Лейлад* Аллахын заасан хархүүг Орь би эзэмдэн эс чадъюу Бурхан, Лейлад бусдыг заяагаад хайрыг над илгээжээ Бусдыг над, тачъяангуйг Лейлад юунд эс заяав даа? Гэж шүлэглээд намайг харж нулимсыг арчсан атал сэтгэл нь нээн хөдөлснгөөс үг хэлж эс чадаад нэлээд дуугүй байсны хойно “За өнөөдөр юу болов?” гэхэд ь би цөмийг тоочин яриваа: Янагтайгаа учран явдал хүслээ хангах цаг чинь гадаа иржээ . гагцрүү өдрийн хугас тэсэж үзэгтүн! Т®ль гаргаж уутанд хийдэг нь наран жаргахаар ирээрэй гэжээ . Үсээ нүүр рүү задлан унжуулсан нь шөнийн харанхуйгаар учрья гэжээ . Ногоон ургамал харуулсан нь цэцэрлэгт оч! гэсэн үг . Дэнлүү харуулсан нь нэгэн ху°ц гэрэлтэй байшин бий түний хажууд очоод намайг хүлээгтүн миний хайр дурлалд хязгаар алдав Гэж хэмээнэ . Азизын энэ үгийг сонсоо би тэсвэр алдан: “тэрхүү сэтгэлийн амрагтай уулзуулна гэж чи хичнээн гоё үг хэлнэм?” Чиний тайлан өгүүлэх нь үгэнд зөв юм алга! гэв. Миний нагацны охин өгүүлрүүн: “Чи ганцхан өдрийн хугас тэвчин үз Наран жаргаж харанхуй болохын төдий чи сэтгэлийн хүнтэй учран золгож , амттайяа жаргах болно . Энэ бол худал биш хамгийн үнэн үг гэж мэдтүгэй!” гээд. Өдрийн нугалаа төдийхнийг хүлээгээч!Өдөржин гэрт санаашран суух юун!Аливаа үйл бүтээхэд хялбар биш аталАгшны дотор жагал ирэх нь амархан гэдэг. Гээд уян зөөлөн үгээр миний сэтгэлийг засах авч хоол идсүгэй гэвэл намайш басхүү уурлах бий гэж эмээгээд гагцхүү хувцсыг минь тайлж, өдрийг товчлохын тулд чамд сайхан үлгэр ярьж өгье. Өдөр өнгөрч , шөнө болохын төдий чи сэтгэлийнхээ янагийн хажууд ийнхүү суух болно ! гэх зэргээр ятгасаар авай . Би түүнийг харах ч дургүй хүрээд гагцхүү “Энэ шөнө бушуу түргэн өнгөрөөсэй!” хэмээн бодон бодон суутал ашгүй наран жаргав. Намайгш гар· явахаар завдтал миний үеэл дүү нэгэн ширхэг заарын үр өгч “Сэтгэлийн янагтайгаа учран жаргалын дээдийг эдлэхийн цагт энэ өчүүхэн үрийг амандаа хийгтүн. Тэгээд амрагтаа энэ хоёр мөр шүлэг өгүүлсүгэй” гээд зааж өгсөн нь: Амраг хүүхэнд дурласан эрийн ааш нь ямар байлаг вэ? Амраглан ханилсан нөхөд минь арга буюу хэлж өгнө үү Гээрэй гэхэд нь би за гээд гарч одлоо . тэндээс их цэцэрлэгт хүрч очвоос хаалга үүд нь нээлттэй ажээ . Дотор орж хартад цаана нэгэн их угэрэл цацарах зүгт хүрч очвоос том гулдан хаалгатай , зааны яс, зандан модоор зүйж хийсэн бунхан бүхий сайхан байшин байна . Дотор нь ороход алтан мөнгөн эмжээртэй торгон хивс дэвсээп өрөөний дунд алтан хатгууртай зул бадарч байна. Бас гол дунд нь зүйл бүрийн амьтныг дүрсэлсэн усан оргилуур цацарч , хажууд нь нэгэн их ширээ засаж , торгоор бүтээгээд дэргэд нь том ваартай дарс алтан шигтгээтэй болор хундага тэргүүтэн тавьжээ . Хажууд нь буй нэгшэн мөнгөн их цар сөхөн хартал: Инжир

анар усан үзэм, жүрж, нимбэг, зүйл бүрийн жимс өрж , завсар завсарт нь : сарнай мэлрэг_ нохой хошуу зүсэн зүйлийн сайхан үнэр анхилах цэцэг тарьжээ . Эл бүгдийг үзээд тэсгэлгүй баярлах атал агуу их Аллахын заясан амьтан хүн эс үзэгдэхгүй дор гайхах бүлгээ . тэнд хүний урманд тэр сайхан байшин, тэр сайхан эд зууш тэргүүтнийш харах хамгаалах нэгээхэн ч боол шивэгчин эс үзэгдэнэ. Би амраг хонгор бүсгүйг хүлээн шөнө дүл өнгөртөл сууваас хэн ч ирсэнгүйд сэтгэд бэрдэвч , амрагийн сэгэлээс болоо хэдэн хоног хоол амсаагүй тул гэ¤эё маш их өлссөнөө сая ухаарлаа . Энэ сайхан байранд амрагтайгаа хоёул жаргах ажээ гэж бодохоос сэгэл санаа нэгмөсөн амраад басхүү олон сайхан зуушны үнэр гарах тул хорхой хүрч зассаг ширээнээ тухлан суугаад нэгэн шаазан тавагт буй тахианы шүүрхий махнаас огтьлон идээд анарын үртэй боов амтат бал бурам тэргүүтнээс цөмөөс идэн амтат ба исгэлэн ундаа ээлж уусаар гэдэг цадаад гэнэт тэнхээ алдран ирлээ . Босож гарыг угаагаад бяцхан хажуултал олон хоног нойыр муутай хоносны уршгаар таг унтжээ . Наран учиргүй шарж сая сэрвээс дэвсгэр ч үгүй гантиг чулуун шалан дээр тас гэдрэг харан унтсан байж , миний гэдсэн дээр давс нүүрс хоёр орхисон байжээ . Босон харайж хувцасаа гүвээд ийш тийш харваас нэгээхэн бээр хүн эс үзэгдэхэд тул ичихийн ихээр ичиж зовсонд нүдний нулимс өөрийн эрхгүй хоёр хацар даган урсав. Тэндээс гэртээ хариваас миний нагацын охин хоёр гараар цээжийг дэлдэн хурмастаас буух элбэг бороон адил нулимс асгаруулан шүлэглэх нь: “Нутгийн салхи яасаар илбэн үлээхүйеНууцгай амрагийн сэтгэлийг хөндөн хөдөлгөнөмДорнодын салхин чи! Бидэнд түргэн ирээч!Дотно янаг бүхэн хувьтай зохиолтой билээ Аяа, би чамайг тэврэн адил тэврэх билээ Ахын царайг харж нэгэнт суухгүйгээс хойш Амьдрал баясгаланг цөм Аллах тэнгэр автугай Алаг зүрх нь харин , миний адил хайлж : Амрагийн галаар дүрэ«зэн буйг мэдэх юмсан! Гээд н майг харангуут нулимсыг арча д эелдэг зөөлөн үгээр ийн өгүүлрүүн: Аяа миний авгын хөвгүүн, амрагийн сэтгэлэр дүрэлзэн байхад чамайгш Аллах тэнгэр өршөөж хайрттай чинь янаглуулах ажээ. Тэгэхд би чамайш үгүйд нулимс ба гунигийг дотор хөвөн суунам, хэн намайш зэмлэн , хэн н майш аргадах билээ? Гэвч миний төлөөнөө Аллах чамайг бүү яллах болтугай” гэж даруй инээмсэглэн миний хуюцсыг тайлаад, “Чамд чиний янаг хүний үнэр шингэсэн мэт байнам! Юу болсныг над ярьж өгнө үү!” гэлээ . Би урьд шөнө болсон явдлаа нэгд нэггүй тоочин яриваас Азиза хорсолтойгоор инээвхийлэн, "Үнэндээ миний зүрх шимшрэн өвдөнө. Чамайш ийнхүү сэтгэлийн зовлонд унагасан хүн үхвээс зохилтой . тэр эм чамд дурлажээ . Үүнээс болж чиний биед муу юм болох бий гэж би айна. Чи нойронд дарагдан унасан нь дур гутам муу хоол лугаа адил утгатай болжээ . Нэгэнт идсэн хоолыг буцаан бөөлжихгүйн тул давслах хэрэгтэй буйзаа! Чиний бие дээр давс үрсэн нь ийм учиртай гэж мэдтүгэй . Чи түүндп эрхэм дээд сэтгэлээр дурласан гэх атал нойрыг илүүд үзсэн нь хуурмаг төдий сэгэлтэй ажээ . Тэр эм чамд үнэхээр хайрлан дурласан аваас чамайг унтаж буйд сэрээх ёстой атал эс сэрээсэн нь басхүү хуурмаг дурлалыг илтгэсэн байнам: Нүүрс тавьсан нь ямар учиртай вэ гэвэо чи түүнд үнэн сэтгэлтэй гэсэн мөртөө бага хөвгүүдийн зан гаргаж зөвхөн идэх уух, унтахын эрхэмлэсэн тул Аллах ч майш залхааж нэрий чинь үүний адил харуулсугай гэжээ . Гэвч Аллах чамайг өршөөх болтугай!” гэжээ . Энэ үгийг сонсоод би цээжийг урж, “Аяа Аллах тэнгэр минь энэ туйлын үнэн үг ажгуу : Амраг сэтгэлтэй хоёр янаг нойрыг эс тоох байтал би

унтаж хоцроод өөрийн биеийг өөрөө гомдоов. Одоо би яах билээ? Гагцхүү чи л арга зам зааж өгсүгэй гэж Аллахыг ам алдан уйлан гуйхад минь Азиза над ц аглашгүй хайртай болоод ийн өгүүлрүүн: Би чамд заавал тус болсугай . хэрэв би гарч орж болддогсон бол та хоёрыг дур хүслийг хангуулах билээ гэж үүний урьд олонтоо өгүүлсэн дээ . Энэ бол гагцхүү ёчиний хүслийг хангахыг тул болно. Аллах өршөөх аваас одоо ч та хоёрыг дуртайяа учруулна. Гагцхүү чи миний үгийг шууд дагах ёстой . Юу гэвэл чи энэ үдэш очдог газраа хэвээр оч . Храин амтат зууш бол бие алдруулан нойрсуулдаг тул битгий зоогло! Гагцхүү тэвчээртэй хүлээн суувал чинь шөнийн хугас төдий өнгөрөхөд тэр эм чам дээр бэлхнээ очих тул Аллах чамайг сэтгэлийн зовлонгоос гэтэлгэх болно гэжээ . Энэ үгийг сонсоод ихэд баярлан Аллахт залбиран шөнийг бараад маргааш орой тэрхэн цэцэрлэгт очихоор гарахад Азиза , “За чи хэрэь тэр эмтэй учирвал миний захисан хоёр шад шүлгийг заавал уншаарай” гэхэд ньв би “За” гээд гарч одлоо. Төдөлгүй тэрхүү цэцэрлэгийн байшинд очвоос урьдын адил амттан зууш дарс, үнэртэн цэцэг тэргүүтнийг цөмийг өржээ . хоолны сайхан үнэрт хорхой хүрэх боловч анхандаа идсэнгүй атал сүүлдээ тэсэхэS байж ширээний бүтээлгийг сөµөж үзвээс тахианы шарсан мах, элдвийн сайхан амттат боов боорцог байх тул цадтал идээд бас гүргэмийн шүүс ханатал уутал юу юугүй нүд анилдан ирэв. Нэгэн дэр авч хэсэг хажуулдтал таг унтжээ . Наран гарсан хойно сая сэрвэл хажууд ясан даалуу тоглоомын таяг, хасарваанийн чавгын яс, хөх тарианы амтат самар тавьсан байлаа . Эргэн тойрон ажваас хүн ирсэн шинж алга ажгуу . Тэндээс гэртэ харивал миний нагацын охин урт уртаар шүүрс алдаж . Хамаг бие суларч, халуун зүрх минь шархаджээ . Хайрыг дагаад нүдний нулимс горхи мэт урсана. Хайрт минь намайг хатуухан яллавч Харин сайныг үйлдвээс сайхан хэрэг тэр минь !Гаарах хүслээр зүрхийг пиг дүүргэлээ чи Гашуун нулимсаар нүд минь өвчлөв. Гэж шүлэглэн би амь муугаар хараасанд Азиза нүдний нулимсыг арчаад , намайгш үнсэж элгэндээ тэврэх гэхэд нь би завдан зайлав. Азиза, “Чи энэ шөнө бас унтан хоцров уу?” гэхэд нь би , тэгжээ өглөө сэрвээс нэгэн даалу, тоглоомын таяг, хасарваанийн чавгын яс, хар будааны амтат самар тавьсан байна. Энэ юу гэсэн утгатай дохиой тэмдэ болохыг над сайытар тайлан хэлж тус болно уу?! гэсэнд тоглоомын модон таяг орхисон нь чиний бие хэдийгээр ирсэн боловч сэтгэл чинь ирсэнгүй . Янагийн сэтгэл тийм байдаггүй юм гэжээ . харсаваанийн чавгын яс орхисон нь хэрэв чи үнэнхүү сэтгэлээс надад дурласан бол янаг дурлал хасарўаанийн чаваганаас илүү амттай байдаг тул чиний зүрх янагийн галаар бадарё унтах нойрыг эс тоох байсан гэжээ . Хар будааны самар орхисон нь амрагийн зүрхэн алж ав. чи Ион хэрхэн тэсвэрлэснийн адил нэгэн өдөр тэсэж үзэгтүн!гэсэн үг гэлээ . Энэ үгийг сонсоод сэигэд гал бадраад зүрхэнд гуниг дүүрё “Би заяагүй болохоор Аллах намайг унтуулжээ . аяа миний нагацын охин Азиза намайг түүнтэй уулзуулах ямар нэгэн арга заль бодож үзээч! “ гэсэнд Азиза өгүүлрүүн: Миний бодол сэтгэл багтан яда боловч гагцхүү гарган өгүүлж эс чадна. Ямар ч болов чи энэ үдэш дахин мөнөөхөн цэцэрлэгт оч. Хэрэв чи унтахгүй байж чадвал хүсэл юугаа биелүүлнэ. Гэхэд нь Аллах тэтгэх юм бол унталгүй чиний заасан ёсоор үйлдсүгэй гэсэнд Азиза олон сайхан хоол аювчирч “Чи энд сайн хоол цадтал идвээс тэнд очоод юм идэхгүй болно”гэхэд нь би авчирсан хоолыг цадтал идээд Азизын гаргаж зэхсэн гоё хувцас өмсөж одохыг

завдтал минийзаасан шүлгийг заавал хэлээрэй гэж захилаа. Цэцэрлэгт очоод шөнө унтахгүйг хичээн нүдээ хуруугаар тэвхтэн байтал сүүлдээ ядарч гэдэгс өлсөхөөр нь мөнөөхөн олон тавагтай хоолноос идээд, арван аяга дарс уугаад салхинд цохиулаад үхсэн мэт унтжээ . Өнлөө сэрээд би цэцэрлэгийн гадна хэвтэж байв. Миний элгэн дээр нэгэн хурц хутга , төмөр зоос хоёр тавьсан байхыг үзээд хирдхийн цочиж тэр чигээрээ гүйсээр гэртээ оронгуут багтран унасан ажээ . А°айхийн сэргээд, "Бисансандаа эс хүрэв" гэж Азизад ярьсанд "Чамайг унтаж болохгүй гэж би эс хэллүээ . Чи миний үгэнд орохгүй хойно одоо яая гэхэв " гэхэд нь би , "Энэ хутга төмөр зоос хоёр орхидог нь ямар учиртайг хэлж өгөөч!" гэсэнд Азиза миний төлөө ихэд санаа зовж ийн өгүүлрүүн: Төмөр зоос орхисон нь өөрийн баруун нүдийг заажэ . Дхаин ирэхэд нь чамайг унтаж байвал энэ хутгаар дүрж аллна хэмээн Аллах тэнгэр болон өрөөсөн нүдийг ам алдан өгүүлсүгэй гэсэнх үг ажээ . тэр эмийн энэ хорон санаанаас би чиний төлөөнөө айнам. Одоо чи түүнийг ирэхэд унтахгүй хүлээж чадвал хүсэл юугаа хангана. Хэрэв түүнийг ирэхэд чи унтьаж байвао тэр эм чамайг огтлон алах болно гэлээ . Тэгэд одоо чи яах билээ ? Энэ шөнө чи л нэг тус болж үз! гэсэнд Азиза өгүүлрүүн: Заавал тус болсугай . харин чи миний үгэнд орж юу хэлснийг ягштал дагавал янагтайгаа жаргалыг эдэлнэ. Хэрхэвэл зохихыг чиний яг явахад хэлж өгнө гээд ор засөаж намайш хэвтүүлэн миний хөлийг илбэн унтуулаад толгойн хажууд суун , дэвүүрээр сэвэн сэвэн өнжжээ . Үдэш болсон хойно сэрээж, дэьвүүр барин уйлан суусннаа намайг босоход нүдний нулимсыг арчаад зоог барив. Би идэхгүй гэсэнд, чи миний хэлсэн үгэнд заавал орно гэсэн шүү дээ гэж над албадан хоол идүүлээд жимсний чихэртэй ханд уулган гары минь угааж сарнай ¶эцгийн уусмал цацаж өгсөнд бие сэргээд бүрий болмогу хувцаслан явахыг завдтал "Аяа миний авгын хөвгүүн Азиз минь энэ шөнө сэтгэлийг сэргээн бүү унтагтүн Тэр эм үүр цайхын өмнөхөн ирэх бий . Аллах өршөөж чи түүнтэй энэ шөнө учрах болно . миний захисныг битгий мартаарай гэхэд нь чи юу захилаа даагэсэнд түүнтэй учраад салахдаа миний заасан шад шүлгийг заавал хэлэЅрэй гэхэд нь би за гээд нээн баяртай хүрч очлоо. Бие хэдий сэргэлэн атал тэр шөнө жил мэт удах бөгөөд үүр цайхын өмнө гэдэё маш өлсөх тул мөнөөхөн ширээнээ сууж баахан хоол идтэл бие сулраад ноыр хүрч эхлэв. Энэ үес ашгүй холоос нэгэн дэнлүүгийн гэрэл гарч сайхан эм арван шивэгчин дагуулан гарч ирэх нь одддыгдунд саран мандах адил үзэсгэлэн гоо ажээ . Шижир алтан хатгамалын ногоон пүүсүү дээл өмссөн нь : Заам задгай , үс бужгар, ногоон дээлт хүүхэн Залуу амрагуудаа их л бардамнан гайхуулах ажээ . "Алдар нэр хэн бэ?" гэж би түүнээс асуулаа . Амрагчлагч бүхний зүрхийг шатаадаг нь би байна гэлээ . Хайрын сэтгэлд автагдана гэж би түүнд өчлөө . Хад чулуу боловч уйлдаг ёсыг чи мэдэх үү? Гэлээ тэр!Хад чулуу - чиний сэтгэл байжээ гэж би хэллээ . Харин аллах, чулуунаас ус гоожуулж байс чадна Гэжнэгэн яруу найрагчийн шүлэглэсэнтэй туйлын адилхан харагдах ажээ . Тэр эм намайг хараад инээж, "Чи энэ шөнө яаж эс унтав? ɥнаглан амраглагч нар шөнийн нойрыг юман чинээ эс тоох учраас энэ шөнө унтаагүй сэргэлэн байхыг хараад үнэхээр амраглан дурласныб чЁнь мэдэв гээд мөнөөхөн арван ёивэгинг нүдээр ирмэн явуулж Үид хоёр янаглан үнэсэлцуэв. Ийм жаргалтай шөнийн тухай нэг шүлэгчийн өгүүлсэн нь: Хундага тавилгүй наргин хонох ийм шөнийг Хувьд би зуун жилд эс үзлээ . Шөнийн турш хүний урманд цурам хийлгүй өнгөрөхд Шилбэнд зүүсэн

чимэг нь зэмгийн тус газар нийлсээр байв Гэжээ . Бид хоёр өглөө болтол жарган жарган хэвтээд босож харих гэтэл тэр эм намайг угзарч , байзаарай ярих хэлэх юм бий гээд нэгэн ам өс өгснийг дэлгэн үзвэл энэ хоёр шаргачин гөрөөс хатгамалсан ажээ . Бид хоёр шөнө болгон тэрхүү цэцэрлэгт учран байхаар болзоод хачин баярлаж сэтгэл хөөрөөд мөнөөхөн миний нагацын охин Азизын хэлээрэй гэж захисан оүшүлгийг хэлэхийг мартжээ . Харин тэр эм хочр шаргачин гөрөөсний зурагтай ам бөс өгөхдөө , үүнийг миний эгч Нур-Аль Худа урласан юм . Сайтар хадгалж яваарай гэлээ . Тэнгдээс гэртээ харьтал миний нагацын охин босож, гүйн ирж намайг үнсээд за чи миний хэлээрэй гэсэн шүлгийг хэлэв үү гэхэд нь Ай харлаа энэ гайхалтай уран зургийг хараад мартжээ гээд мөнөөхөн ам дөрвөлжин бөс үзүүлэн Азиза нүдний нулимс асгаруулан ийн өгүүлрүүн: Хагацал Тийш тэмүүлэх гайгүй шүү! Халуун өвөрт битгий хууртаарай Үйлийн үр ямагт худал хуурмаг байдаг юм Үнэн найрамдал тасарарвал үүрд хагацал ирдэг юм . гэлээ . Азиза энэ шүлгийг хэлээд тэрхүү ам дөрвөлжин бөсийг бэлэг болгохыг гуйсанд би өгч орхилоо. үдэш болоход би явахыгш завдтал Азиза, сайхан жаргаарай . маргааш өJлөө миний захисан шүлгийг бүү мартаарай гэхэд нь би за гэж ам өгөөд мөнөөхөн цэцэрлэгт ирвээс тэр эм ирээд намайш хүлээж байв. Намайг үзээд баясан инээж, бид хоёр өвөр дээрээ сууж амтат зууш дарс уун наргиж басхүү урьд адил ертөнцийн жаргал эдлэн хонов. Би өглөө явахдаа Амраг хүүхэнд нэнэн дурласан эрийн ааш нь ямар болдог юм?Амраглан ханилсан нөхөд минь аргагүй хэлж хайрлана уугэсэнд тэр эм нүдний нулимсыг сагаруулан байж:Тачъяангуй дур сэтгэлийн нууцыг ямагт хадгалж Тэсвэрлэх үйлэнд ямагт хүлцэнгүй бат ажээгэлээ . Би тэр хоёр шад шүлгийг тогтоо аваад нагацын охины захисныг биелүүлэв гэж ихл баяртай харьтал Азиза хэвтэж миний эх сахин сууж, намайг үзээд ай , үеэл дүүгийн бие муу байхад ганцаары нь орхин явдагш юутай муу хүн бэ гэлэ . Азиза бас өндийж , чи миний кахисныг хэлэв үү? Гэхэд нь хэлсэн . Тэр сонсоод уйлж өөдөөс ийнхүү шүлэглэв гэж мөнөөхөн эмийн өгүүлсэнд шад шүлэг хэлбээс Азиза гашуунаар уйлж : Тачъяангуй сэтгэл нь үхэлд аваачиж зүрхтнь урагдан байхад Тийм хүн яахин нууцыг хадгалж чадах билээ . Амрагийн сэтгэл хүлцэнгүй байхыг тэр хүсэвч Алжаасан дурлал сэтгэл юугий нь өвтгөдөг биз! Гээд за чи дахин очоод энэ хоёр шад шүлгийг хэлэрэй гэхэд нв би за гэ шөнө дахЁн очиж түүнтэй жаргалыг хэрхэн эдэлснийгш өгүүлэх юун! Маргааш өглөө мөнөөхөн хоёр шад шүлгийг өгүүлтэл , хүүхэн нулимсыг асгаруулан ийн өгүүлрүүн: Тэвчээр алдаж нууцыг задлах аваас тэр,Тэр даруй үхвэл таарна гэж би бодномГэжээ. Энэμүү шад шүлгийг сайтар тогтоон аваад гэртээ харьтал Азиза ухаан алдаад миний эх сахиж байв. Азиза нэгэн үе ухаан орж, хэлснийг хэлэв үү? Эхэд нь би хэлэв гээд “Тэвчээр алдаж…”гэж байна хэмээн мөнөөхөн хүүхний шүлэглэснийг өгүүлтэл Азиза дахин ухаан алдсанаа бас сэргээд. “Мэдлээ сонслоо! Одоо би нэгэнт үхэж болов Миний жаргалыг тасалсан хүнд баяр дамжуулаарай!Зол жаргалтай нэг нь энх тунх байх болтугайЗовлонд хатсан нэг нь гашууныг залгих учиртай ажээ . гэлээ. Үдэш болмогц би аанай цэцэрлэгт очиж намайш хүлээн суусан түүнтэй жаргалыг эдлэн хоноо маргааш өглөө Азиза хэлсэн шүлгийг хэлтэл тэр эм муухай орилон: Аяа энэ шүлгийг хэлсэн эм одоо нэгэнт нас өөд болжээ . тэрхүү сүүлчийн хоёр шад шүлэг хэлэгч хүнтэй чи ямар хамаатай хүн бэ? гэхэд нь тэр болбоос миний нагацын охин болой гэтэл , Ай

Аллах тэнгэр минь чи юутай худал хэлнэм. Хэрэв тэр эм чиний нагацын охин байсан бол чи түүнд , түүний нэг адил сэтгэлтэй байх ёстой билээ . Түүнйг гагцхүү чи үхлдийн зовлонд унагжээ . Одоо Аллах чамайг үхлийн зовлонд унагаваас зохилтой !хэрэв чи үеэл дүүтэйгээ хэлсэн бол би чамд хэрхэвч эс ойртох билээ гэхэд нь Ай чиний битүүгээр хэлсэн дохиог гагцхүү тэр минь тайлж , чамд хэрхэн ойртох яаж учрах арга замыг над зааж өгсөн билээ . тэргүй бол би чамтай ийнхүү жаргаж чадахгүй байла агэж би хэлсэнд , чи бид хоёрын эл явдлыг тэр мэддэг байжээ гэхэд нь , би тиймээ мэдэж байсан юм гэлээ . мөнөөхөн хүүхэн дуу алдан өгүүлсэн нь чи түүний залуу насыбг хөнөөсөн болохоор Аллах тэнгэро чиний идэр насыг хөнөөх болтугай . одоо гэртээ харьж үз! гэлээ . Тэндээс би өөрийн суудаг гудамжнаа хүртэл улс амьтан уйлалдан байхыбг үзээд юу болов гэсэн Азиза хаалганы ард үхсэнийг оловв гэцгээжээ . Гэртээ ортол миний эх аашилж: “Аяа их нүгэл чиний толгой дээр буух болоосой!”гэлээ .Миний эцэг ирж бид Азмзаг хувцаслаад дамнан оршуулж , булшин дээр нь карон судраас уншин тэндз гурван хоног гашуудал үйлдэн буцаж харьцгаалаа . Би Азизаг санан гуниглаж суутал миний эх орж ирээд, за чи тэр охины цөсийг гаргах ямар хэрэг үйлдсэн юм бэ? Би түүнийгсэрүүнтунгалаг ахуйд , чи юунаас болж тийнхүү өвчлөв гэж асуун ядсан боловч над нэгч үг хэлсэнгүй байсаар насан эцэсллээ. Одоо чи надад ярьж өг! гэхэд нь би юу ч хийгээгүй гэж хариулав. Азизын нас эцэслэсний хариуг Аллахш тэнгэр чамаас авах болно. Тэр нэгэн юм нууцлан б айсан боловч надад хэлэлгүй өнгөрсөн. харин үхэхийн өмнө чамайш уучлаад надад хэлсэн: Аяа миний авгын эхнэр минь ээ, намайш нас эцэслэхэд чиний хөвгүүн ямар чгэм хийгээгүй болов. Миний амины төлөөнөөс элдвийн хариу болох хэрэггүй . Аллах харин намайш энэ хорвоогоос хугацаат амьдралаас хожмын ертөнцийн мөнх амьтан болго гэсэн шүүү. Тэгэхлээр нь би , чи юунаа болод ийн өвчлөв ? гэж хичнээн дахин асуусан ыоловч нэг ч үг хэлсэнгүй харин инээмсэгдэн , за та хүүдээ ингэж хэлээрэй . Мөнөөхөн очдог газраа очвол “Үнэнч сайхан , урвагч муухай” гэж хэлээрэй гэвэл чиний хөвгүүнийг амьд байхдаа өмгөөлөн байсан үхсэн хойноо ч өмгөөлөх ы болно гэдгийг над нэгэн зүйл өгч , за хэрэв хүү чинь учиргүй уйлж унжаад байвал үүнийг гаргаж өгөөрэй гэсэн дээ . хэрэв чамайг эхэр татан уйлбал тэр нэгэн зүйлийг чамд өгнө гэж эх хэллээ . Тэр нэгэн зүйл юу байсныг үзүүлнэ үү гэж би эхээсээ хичнээн гуйвч үзүүлсэнгүй , удалгүй би Азизыг мартаж орхилоо . Юу гэвэл би даанч гэнэн хонгор байсан болоод өөр хүүхэнд ухаангүй сэтгэлтэй болсноос тэр байжээ . Арайхийн үдэш болгоод мөнөөхөн цэцэрлэгт хүрэлцэн очвоос нөгөө эм намайг хүлээж зүүн дээр суусан мэт тогтож ядан байжээ . Намайг очингуут хүзүүдэн тэврээд, чиний нагацын охин яасан бэ? гэхэд нь би “Тэр насан эцэс болоод өнөөдөртэй таван хоног болов. Бид оршуулан ёслол үйлдээд Коран судраас уншиж ёсыг гүйцэтгэв”Гэсэнд тэр эм орилон чарлаж “Чи түүнийг алав” гэж чамд би эс хэллүү? Хэрэв чи эл учрыбг түүний нас эцэслэхээс өмнө хэлсэн бол тэр над тус болсны адил би түүнд тус болох байлаа . тэр над тус болсны у·ир чи бил хоёр ийнхүү учирчээ . Чи нэгэнт нүгэл үйлдсэн болохоор чамд золгүй явадл тохиолдолх бий гэж би айж байна гэхэд нь би. “Тэр үхэхийн өмнө миний нүглийг наминчилсан байна” билээ гээд эхийн ярьсныг хэлтэл тэр эм өгүүлрүүн: “За тэр эм ямар эд зүйл өгсөн болохыг Аллахыг бодож, эхээс олж мэдсүгэй!” гэхэд нь бас намайг очдог газраа очихдоо “Үнэнч сайхан , урвагч

муухай!” гэж хэлээрэй гэсэн байна билээ гэв. Энэ үгийг сон±оод тэр эм дуу алдаж : Тэр чиний аминд оржээ . Чамд би хор хүргэх хэмээн бодож явсан одоо хор хүргэхийг болоив гэхэд нь би ихэд гайхан “Чи бид хоёр нэгэнт янаг сэтгэлтэй байтал над юуны учир хор хүргэх гэж бодож байв” гэсэнд “Чи над хэдийгээр янаг сэтгэлтэй боловч нас чинь бага , хар хор гэж байхгүй, бидний эмс охид ямар хорон санаа агуулж хүнийг далдуур хөнөөхийг бодож явдгийг чи үл мэднэ. Хэрэв тэр чинь амьд байсан бол чамд их тус болж чамайг ямар чгсээн үхлээс аврах байсан даа . Харин одоо чамд нэг зүйл хэлэхэд, эл учрыг залуу хөгшин хэнд ч бүү ярь. Чи гэнэн залуу учраас эмсийн , хүнийг далдуур хөнөөх хорон санааг эс мэднэ. Чиний нагацын охин нэгэнт насан эцэс болсон болохоор чамайг чамайг золгүй лай үйлэнд орвол өөр хэн аврах билээ . Чиний нагацын охин нэгэнт насан эцэс болсон болохоор чамайг золгүй лай үйлэнд орвол өөр хэн аврах билээ . Чиний нагацын охиныг би ихэд хайрланам. Хэрэв чи түүнийг амьд ахуйд хэлсэн бол тэр над их тус болсныг нэг адил, би түүнд сайныг бүтээх байлаа . Би булшин дээр нь очиж Аллах тэнгэрт мөргөх болно. Тэр өөрийн далд сэтгэлийг сайтар хадгалан өөрийн мэдсэнийш боловч гаргаж хэлдэггүй байснаас чи бид хоёр ийнхүү учран золгожээ . Одоо би нэгэн зүйлс хүснэ гэхэд нь би “Ямар зүйл?” хэмээвээс түүний булшин дээр намайш дагуулан очтугай . Би толгой дээр нь хэдэн хэдэн шад шүлэг сийлэн үлдээсүгэй гэхэд нь их Аллахын өршөөлөөр маргааш хоёул очъё гэлээ . Тэр шөнө байн байн өгүүлэх нь Чи эл учрыг үхэхийн өмнө хэлэх чинь даанч яав даа гэнэ. –“Үнэнч сайхан урвагч муухай! Гэсэн юу гэсэн үг вэ? гэж би олон дахин асуусан боловч огтхон ч хариу хэлсэнгүй . Тэр эм маргааш өглөө босож уут дүүрэн динар зоос хийгээд за би түүний булшин дээр бунх босгож өглөгч буян үйлдсүгэй гэлээ . Тэгээд гудамжнаа гарч “Янагийн далд сэтгэлээ үхлийн аягнаас уун уутал хэлээгүй хадгалсаар агсан Азиза хүүхний төлөө буян үйлдэж байна!” гэж үглэн динар зоосыг улс амьтанд тараан өгч бараад булшин дээр очтол мөнөөхөн хүүхэн уйлан хайлан сууснаа ган болд цүүц бяцхан алх гаргаж Азизын толгойн тус газар тавьсан чулуун дээр жирийтэо шүлэг сийлсэн нь: Доройхон ядуу цэцэрлэгийн дунд нэгэн булш байнаДолоон ширхэг яргүй цэцэг түүний дээр ургажээ . “Энэ хэний булш вэ?” гэж би газраас асуулаа . “Эрхэм сэтгэлт хүн нойрсож буй, эелдэг байхгүй”гэж газар хэллээ”“Дурлалын золиосонд очсон чыамайг Алах өршөөжДиваажингийн оронд өндөр ууланд төрүүлтүгэй!”Амаргийн сэтгэлд нј автсан таминь золгүйяа!Аль хэдийн нь иартагдсан шарил тань доор булаастай бий Болдогсн бол чиний тойронд гоёмсог цэцуэрлэг тарьж Боловсрох үрий нь элбэг нулимсаара услах сан! Гэж сийлээд уйлсаар явахад нь би хамт явлаа . мөнөөхөн цэцэрлэгт очоод “Аллах тэнгэрийг бодож намайг бүү орхиороо” гэхэд нь би за гэлээ . Түүнээс хойш би дандаа тэр хүүхний хамт хоножтэрнад нэн эелдэг билээ . харин чиний нагацын охин үхэхийн өмнө эхэд чинь юу гэж хэлсэн гэлээ гэж асуух бүрийд би давтан өгүүлдэг билээ . хувцасны сайныг шилэн өмсөж , хоолын сайныг сонгож идэж, янаглан тэврэлдсээр байтал би улам таргалан бүдүүрч гуних зовох юмгүй тул үеэл дүү охиноо хэдий нь иартжээ . Ийнхүү жил торйч жил жилийн эхээр нэг өдөр халуун усанд ороод , дараа нь нэгэн цом дарс уусанд бүхий л хувцаснаас минь янагийн сайхан үнэр анхилад сэигэл маш тэнүүн тул цагийн эрхээр аз заяа эргэхийг яахин мэдэх билээ . үдэш болсон хойно мөнөөхөн хүхэн дээр очъё

хэмээн гартал согтоод хаашаа яваагаа эс мэдэн атал нэг мэдэхнээ Даргын гудамж хэмээх гудамжнаа хүрчээ . харваас миний урдаас нэгэн эмгэн ирж явах бөгөд нэг гартаа бамбар, нөгөөгартаа нугалаастай захидал барьжээ . ойртон ирэхийг ажиглан нүдний нулимсыг асгаруулан ийнхүү шүлэглэх нь: Элчээр ирсэн чи тавтай морилох болтугай !Энгүүн үгий чинь дуулахад надз нэн таатайяа!Аяа чи энгүй хайртаас минь баяр ¤амжуулсанд Салхин үлээж байс н цагт Аллах чамайг өршөөг!гэж шүлэглээд намайгхарж, Ай хүүминь чи бичиг дуудаг уу? гэхэд нь чаднаа эмээ минь хэмээтэлд өврөөс нэгэн захидал бичиг гаргаж энэ захиаг дуудаад өгөөч! хэмээлээ . Бичгийг авч унштал алс холын гүрнээс хайрт нь бичсэн захидал байлаа . Эмгэн тэсгэлгүй баярлан миний сэтгэлийг ганц амраав! Гэж ерөөж би нэгэн газар орж шээгээд хормой буулган гарч иртэл мөнөөхөн эмгэн дахин гарч ирж мэхийн ёсолж гары мнь үнэсээд Ай ноён минь , сахан залуу насны тэтгэх болтугай ! Тэр хаалга хүртэлд хэдхэн алхам газар очоод аль! Чиний саяны уншдагийг гэрийнхэндээ хэлэхээр тэд үнэмшихгүй байх. Чи очоод хаалганы наанаас энэ захиаг дуудаад өгвөл чамд туйлын баярлах билээ гэхэд нь “Энэ юун захидалд болой?” гэсэнд эмгэн өгүүлрүүн: Аяа хүү минь, энэ захидал аянд яваад арван жил босон хүүгээс минь иржээ . Тэр анх өдий төдий бараа авч харийн оронд яваад сураггүй болж лав үхжээ гэж бодон атал сая энэхүү захидал иржээ . охин дүү нь түүнийгээ санаж өдөр шөнөгүй уйлах нь бэрх болов. “Ах нь сайн яваа юм байна шүү дээ” гэсэнд үгүй заавал энэ захидал дудах хүн олж ир гэлээ . Өөрийн чихээр дуулахаас нааш санаа амрахгүй гээд байгаа юм . Хүү минь хайртай хүн заавал хайртай гэдгийг чи эс андах билээ . Минийохинд энэ захидлыг хаалганы цаанаас боловч дуудаж өгвөл их буян болох билээ Хорвоогийн олон зовлонгийн нэг зовлонгоос гэтэ«гэсэн хүнийг Аллах зуун зовл®нгоос гэтэлгэдэг , эсвэл хорвоогийн олон зовлонгийн нэгнээс өөрийн ах дүү гэтэлгэсэн хүнийг Аллах ням гаригийн олон зовлонгоос далан хоёроос гэтэлгэн өгдөг гэж Аллахын сударт бадаг юм . Би чамд найдаж ирсэн тул чи минй найвларыг хөсөрдүүлэхгүй бизээ! Гэхэд нь би за гэж даган явтал нэгэн том улаан байшингийн их хаалганы ирж, эмгэн харь гүрний гаж буруу нэрээр хашгиран дуудвaас нэгэн залуу эм хөнгөнөөр гүйн гарч оготор хормой нь дэрвэн дэрвэн хоёр хөлөө гялалзахуй дор миний сэтгэл хачин болод явчихлаа . Хоёр хөл нь үнэндээ цагаан гантиг адил бөгөөд эрдэнийн чулуун шигтгээтэй алтан чимэг хоёр шилбэндээ хийжээ . Ханцуйн тохойд хүртэл шамласан нь бугуйы царвуу нь басхүү цагаахан том том сувдтай хоёр бугуйвч хийж, хүзүүндээ очир алмаасан чимэг зүүжээ . Чихэнд нь хос сувдан ээмэг байна. Бас эрдэнийн чулуугаар гоён эмжсэн судалтай хоргой алчуур зангидаад , сая гэрийн ажил хийж байсан бололтой цамцны хормойг бүсэндээ хавчуулсан байжээ нэгэн үгээр хэлбэл наран мэт сайхан эм тул би хирдхийн гайхаж зогосж ялдам зөөлөн дуугаар “Ээжээ, энэ хүн захидал дуудаж өгөх гэж ирэв үү?” гэхэд эмгэн “тийм ээ!” гэлээ . Хүүхэн үүдний цаанаас гар сунган захидлыг над өгч би хаалганы завсараар толгой цээжийг оруулж мөнөөхөн өгсөн захидал бичгийг дуудахыг завдтал эмгэн гэнэт миний арас толгойгоор түлхээд нэг мэдэхнээ би том байшинд орчихсон эгэн үүдийг түгжих гэж сандран гүйж харагдлаа . Хүүхэн намайг тэврэн авч ганцхан эгж унаган гэдсэн дээр мордож хоёр сугаруу гараа оруулж тэюрэн дээрээс дарах тул би яаж ч чадахгүй байлаа . Тэгснээ намайг хөтлөн явахад эмгэн лаа барьж

өмнө зам гэрэлтүүлнэ. Долоон нүх дамжин нэгэн том өрөөнөө орвоос морьтой хүн бөмбөг тоглож болохуйц уудам ажээ . тэр их ордныг дан гантиг чулуугаар бартж дотор нь дан торго хоргой дэвсжээ . Бас түшлэг , жинтүү тэргүүтэн байна. хоёр зэс вандан , эдэнийн чулуу шигтгэж , сувдаар чимсэн алтан рч байна . Ер нь чам шиг хаан хүн л сууж баймаар тийм эрхэм дээд ордон ажээ . “аяа, Азие минь , чи үхэх дуртай юу, амьд явах дуртай вy?” гэж хүүхэн асууж би амьд явах дуртай гэлээ . Тэгвэл чи надтай гэрлэгтүн гэхэд нь чам шиг юмтай гэрлэхийг жигшинэм гэсэнд хүүхэн дуу алдан өгүүлрүүн: Хэрэв чи надтай гэрлэвэд “мэхт Далила эмгэний охины гараас аврагдах болно гэхэд нь мэхт Далила эмгэний охин гэж ямар хүн бэ?” гэсэнд “Тэр бол чиний өнөөдрийн өдөр хүртэл -эг жил дөрвөн сар явсан хүүхэн даруй мөн . Түүнээс илүү хорон санаат эм хорвоод үгүй гэж Аллахыгш ам алдан өгүүлсүгэй! Чамаас өмнө хичнээн хүн алж, хичнээнийJ үйлий нь үзэв дээ! Харин өдий удаан явахад чамайг яагаад эс хөнөөж яагаал чамайг зовлонд эс унагав. Жигтэй юм байна” гэлээ . Энэ үгийг сонсоод бинэнгайхаж “аяа хатагтай , чи үүнийг хаанаас олж мэдэв?” гэсэнд “Эргэх цаг, үзэх зовлонг сайн мэдэхийн адил би түүнийг сайн мэднэ. Харин чамайг яагаад амьд байлгаад байгааг мэдье. Хэрэг явдлаа цөмийг ярьж өгөөч! гэлээ . Би тэр хүүхэнтэй хэрхэн учирсан хийгээд Азиза хэрхэн үхсэн тухай нэгд нэггүй ярьсанд , миний үеэл охин дүү Азиза хүүхн й үхсэнийш дуулаад нүдний нулимс гаргаж “Түүний сайхан залуу насыг замын т дунд хөнөөжээ! Түүний төлөөнөө Аллах чамайг өршөөн тэтгэх болтугай . Чиний үеэл Азиза хүүхэн Далила эмгэний охиныгараас чиний амь насыг аварчээ . Тэргүй бол чи өдийд үхсэн байх билээ . Түүний хорт муу санаанаас чи амьд гарч чадахгүй байх гэж би эмээх боловч энэ талаар үг хэлж эс чаднам” гэхэд нь би “Ийм л явдал болсон юм даа, Аллах минь!” гэсэнд хүүхэн толгой сэгсэрч “Азиза шиг хүүхэн одо хаанаас ч олохгүй дээ!” гэхэд нь Азиза яг үхэхийн өмнө “Үнэнч сайхан урвагё муухай!” гэж тэр хүүхэнд хэлэрэй гэж над гэрээслэн захиж билээ гэж би ярилаа . Хүүхэн миний эн үгийг со-асоод “аяа Аллах тэнгэр минь , эл учраас чи тэр эмийн гарт одоо хүртэл эс хөнөөгдөн байна шүү. одоо сая миний санаа амрав. Чиний үеэл Азиза амьд үхсэний алинд боловч чиний амь насыг даасан учир одоо тэр эмд чи хөнөгдөхгүй ажээ . Чамайг би анх харсан өдрөөс олж авахыг нээн хүссSэр атал өнөөдөр сая нэг арга зохион гэртээ оруулж авлаа . Чи эм хүний хо°он санааг , эмгэн хүний мэхийгмэдэхгүй даанч балчир байна даа . Үхсэний хохь амьдын зол гэж байдаг тул чи одоо сэтгэл санаагаа түвшин байлгаж . Чи туйлын хээнцэр гоё залуу байна. Аллахыбн шудрага тогтоолоор би чамайг эзэмдэх болно. над мөнгө ба эд бөс юу л бол цөм бэлхнээ байна. идэх боов тавагт уух ус домбонд ямагт бэлхнээ байх тул чи гагцхүү азарган тахианы үүрэг гүйцэтгэх болно” гэхэд нь Азарган тахиа юу хийдэг юм бэ?! хэмээвээс мөнөөхөн хүүхэн унан тусан инээж гэдрэг хараад “Ай чи азарган тахиа ямар үйл хийдгийг эс мэднэ гэж үү ?” гээд азарган тахиа бол сайтар уугаад эмийш гишгээ л байдаг юм даа!! гэсэнд “Тийм ээ! ОДоо чи бүсийг чангалан чин зоригийг барьж над үнэн дурласугай . Өөр юм хэрэггүй” гээд эхийг дуудан , мөнөөхөн улсаа оруулаад ир!! гэлээ . Эмгэн бзрэн эрхийн дөрвөн гэрчийн этгэд ам дөрвөлжин торго авчрав. Тэгээд дөрвөн лаа ноцоож, хүүхний нүүрийг битүүлэн ггэрчийн этгээд бидний ураг барЁлдах ёслолыг номын ёсоор үйлдсэнд хүүхэн өмнөх хийгээд хойчийн инж бэлги йг цөмийг авса- гэж батлаад энэ хөвгүүний

түмэн мөнгөн зоосыг хариуцан хлээн авлаа гэж гэрчийн өмнө хүлээж тэдэнд зохих шан хөлсийг олгож гаргав. Чингээд хамаг хувцсаа тайчин намайг хөтлөн мөнөөхөн шижир алтан орон дээр гарч цуг унтлаа . Маргааш өглөө босож би явахыг завдтал хүүхэн хойноос ирж учиргүй инээгээд “Угаалгын газар орсон хүн гадагий адил санав уу? Чи намайг басхүү Далила охины эмгэнтээ адил бодно уу? Чи одоо миний номын ёсоор үйлдсэн эр нөхөр болов. Ухаан чинь согтуу бол эрүүл болж үз! Энэ байшингийн их хаалга жилдээ ганц удаа нээгддэг гэж мэдтүгэй” гээд том хаалгыг заасныг шүзвэл том том хадаасаар бэхлэн хадсан байлаа . Хүүхэн өгүүлрүүн: Ай Азиз минь бидэнд гурил будаа инжир жимс, чихэр боов , хонь тахианы мах тэргүүтэн цөм бэлхнээ бий . Энэ байшингийн их хаалга жилдээ ганцц удаа нээгддэг гэсэн билээ. Одоо хойтонгийн яг өдийд нээгдэнэ гэхэд нь би аяа, Аллах тэнгэр! Би одоо ядаг билээ ! гэсэнд “Миний ярьсан ёсоор чи азарган тахианы үүрэг гүйцэтгэн хэвтэхэд энд у нь муу байх билээ” гэлээ . Бид хоёр зэрэг инээж хүүхний хэлсэн ёсоор гүйцэтгэн өгөв. тэр өдрөөс хойш гагцхүү ууж идэн амраглаж би азарган тахиа адил түүнийг гишигсээр атал нэг жил болоход тэр хүүхэн хөвгүүн төрүүлэв. Жил гарч мөнөөхөн том хаалга нээгдээд га¤наас улс тариа будаа, чихэр оруулж байна. Би гарч явахыг завдтал “Чи энд нэгэнт үдэш орж ирсэн тул үдэш болсон хойно гарагтун” гээд арайхан үдэш болбоос “Энэ шө-ийн дотор их хаалга түгжихийн өмнө эгэж ирсүгэй хэмээн Аллахыгш дурда- ам алдахаас нааш чамайг гаргахгүй” хэмээсэнд б арга буюу зөвшөөрч эс ирвээс ургийн барилдлагаа салсугай* гэж тангаргалав. Тэндээс мөнөөхөн цэцэрлэгт очюоос хаалга үүд нь цэлийтэл нээгдэн хүлээн буйг хараад “Аяа энд нгэн жил эс ирсэн атал одоо хүртэл хаалга нь нээлттэй ажээ . одоо нэгэнт үдэш болсон тул эхдээ очиж уулзахын өмнө үүгээр заавал орж ирье ” гэж дотроо бодоод цэцэрлэгт орж, мөнөөхөн тусгай зассан байшинд орвол мэхт Давила эмгэний охин , шанаа тулж өвдөг дэрлэн шаналан хүлээн суух ажээ . Ажиглаваас царай ихэд алдаад нүдэн нь хонхойжээ . намайг үзээд “Аллах тэнгэр чамайг аварч өршөөв үү” гээд ухасхийн босох гээд чадсангүй үхэдхийн унахад нь би тосон авё үнэсээд “намайг өнөө орой ирнэ гэдгийг чи яаж мэдэв ” гэсэнд “Чамайгш өнөөдөр ирнэ гэж мэдээгүй, би чамд шинэ сайхан хувцас гаргаж өгөөд чи халуун усанд биеэ угааж ирнэ гэж гарсан тэрнэгэн үдшээс хойш би шөнө болгон чамайг хүлээсээр одоо болов. Энэ завсар идэх хоол, утах нойрыг алдан суунам. Энэ болбоос сэтгэл бүхий хүний зан төрх даруй мөн. Чи юуны учир ийнхүү жил тойрон алга болсноо яриач ! гэлээ . Би учир явдлаа нэгд нэггүй ярјсанд намайг өөр хүнтэй гэрлэснийг мэдээд царай нь хачин болжээ . “Би өнөөдөр чам дээр ирэв. Өглөө болохын өмнө заавал явах ёстой” гэсэнд мэхт Далила эмгэний охин дуу алдан өгүүлрүүн: “Тэрбээр чамайг мэхлэн чамиай гэрлээд жил тойрон талхилсан атал эс ханаж уу? Өглөө болохын өмнө Sc ирвээс салсугай гэж ам танJараг авсан нь чамайг төрсөн эхтэйгээ буюу надтай нэгэн шөнө боловч хамт уж ргуулах сэтгэлгүй ажээ . Ёсыг дагаж чамайг би түүнээс өмнө олж мэдсэн атал, тэр чамайг дэргэдээ бүтэн жил байлгаад ганц шөнө бинээс харамлах ажээ . Харин чиний нагацын охин Азизаг Аллах тэнгэр тэтгэх болтугай! Азиза хүүхэн бүхнээс илүү сэтгэлийн зовлон эдлэн чамд ихэд гомдон үхсэн билээ . Тэр надаас чиний амийг аварсан билээ . Чамайг над сэтгэлтэй гэж бодоод тэр нэгэн үдэш явуулсанаас биш огт гаргалгүй талхилж талхилж эцэст нь хөнөөж би бас чадах байсан даа гээд гашуудан хормон уйлж ,

намайг ихэд жигүин харахад хормой нь чичирээд махчин адил аймаар би ч галд орсон шош адил боллоо. Далила эгэний охин дахин хорсон гомдон өгүүлрүүн: “Чи нэгэнт өөр эмтэй гэрлээд хүүхэдтэй болснос хойш над хэрэггүй болжээ . Эхнэртэй э бидэнд нэмэргүй , гагцхүү гоонь эрийг хэрэглэх гэсэн болно. Чи намайг энэ хэдэн өмхий цэцэгнээс худалджээ . Чамайш над ч үгүй , тэр муу садар эмд ч үгүй болгож орхъё” гэж хорсон занаж нэгэнтээ чанга дуу гартал арван шивэгчин гүйн ирж намайг даран автал Далила эмгэний охин хутга гаргаж , “Муу хувхайг ямаа мэт алъя. Энэ бол намайг гомдоосон хийгээд, өөрийн нагацын охиныг гомдоосны яинь хувьд хамги©н наад залхаалт ” гэж өгүүлээд хцутга билүүдэж гарлаа . Би одоо өнгөрчээ гэж мэдээд амь авраач гэж хичнээн гуйвч улам догширч наад муугаа хүлэгIүн гэж захиран зандартал шивэгчингүүд намайш хүлж гэдсэн дээр мордоод гар хөлийг дарж байгаад нэвширтэл балбан занчих тул “ингэж занчуулсанаас үхсэн нь дээр!” гэж бодод “аяа Аллах тэнгэр минь өршөөгөөч! гэж бархирсаар атал эцэст хоолой таг болж дуугарч чадахгүй боллоо. “наадахаа нүцэглэгтүн!” гэх үгийг сонсоод аргаа бараад шаналан хэвтэж байтал мөнөөхөн миний нагацын хэлсэн үг санаанд орж, “аяа, хатагтай минь! Үнэнч сайхан, урвагч муухай шүү!” гэсэнд тэр миний үгийг сонсоод “аяа Азиз чамайг Аллах өршөөж диваажингийн оронд төрүүлэх болтугай! Азиза хүүхэн ёамд амьд ахуйдаа ч үхсэн хойноо ч тус болж миний гараас чиний алтан амийг олонтаа аврах ажээ . Гэвч чамайш яасанч зүгээр орхихгүй, чамайг надаас нуусан тэр эмийн төлөө заавал зовлонд учрулна! Гээд миний хоёр хөлийг хүлүүлээд “Гэдсэн дээр нь мордоод бай!” хэмээн захиран өгүүлээд цааш орж гал дээр байсан зэс тогоонд тос хийж бяслаг шарж ирээд, миний бэлэг эрхтнийг утсаар оосорлон татаж хурц тонгоргоор огтлон засаж намайг яг эм хүн болгон тэрхэн үес би нэгэнтээ ухаан балартжээ . Миний бэлэг эрхтнийг огтолсныг угийг мөнөөхөн бяслагаар шарж нунтаг эм хийсний хойно сая ухаан орвол цус нь тогтсон байлаа . Миний хүлгийг тайлж аяга дарс уулгаад ийн өгүүлрүүн: З чи одо яв. надаас ганцхан шөнө боловч харамласан мөнөөхн хүзүүхэндээ оч доо. Нууцыг эс задлан чиний амийг олонтоо аварсан чиний нагацын охиныг Ал«ах тэнгэо тэтэгэх болтугай ! хэрэв чи сая түүний хэлсэн үгийг хэлээгүй бол чамайг би магад алах байжээ . Сая огтолсон хаясан ганц юм над хэрэгтэй байсан блд одоо над хэрэгтэй байс н юм чамд алдга болсон тул дурта зүгтээ яв. ! гээднамайг өшиглөн хаяв. Би босож явахад төвөгтэй тул аяархан хөлийг зөөсөөр харьтал ашигүй мөнөөхөн том хаалга онгорхой байж оронгуут ухаан балартан унажээ . миний гэрг й үзээд өргөн байшинд оуулдж намайг яг эм хүн лүгээ алилхан болсныг үзээд мөнөөхөн их цэцэрлэгийн хаалганын тус газар аваачиж хаясан байжээ . тэндээс арайхан мөлхсөөр төрсөн гэртээ харивaас миний эх “Хүү минь аль газар яваа бол доо?” гэж намайг мөрөөдөн санаж уйлан суух ажээ . намайг очсон хойо сая таньж, бие муу царай муухай болсныш үзээд сүйд майд болов. Миний нагацын охин үнэхээр над сэтгэлтэй дурлан ямагт сайн санаж байсныг сая чин сэтгэлээс мэдээд ихэд гашуудан уйлтал миний эх бас хангинатал уйлж миний эцгийг нас барсан учрыгхэлээд миний дотор бүр ч аягүй болж нэгэн үе ухаан балартав. Би шөнө дөл болтол гашуудан улйж, миний эх: Эфцэг чинь өнгөрөөд өнөөдөр яг арав хонов гэхэд нь би: наJацын охиноос өөр хэнийг ч бодох завнад алга. Тэр над хайртай байтал би хайрлахгүй байсаар ийм гай зовлонд учрав гэсэнд чи ямар гайд учрав?

Гэж эх минь надаас асуулаа . Би өөрт тохиолсон үйл лайг нэгд нэггүй ярив. Миний эх сайхан хоол цай хийж намай тэнхроүүлээю бас эм тан уулгаж асран асарсаар байтал миний бие илэрхий сайн боллоо. Тэгээд эх мин нэгэдөр за хүү минь , үеэл дүүгий чинь над хадгалуулсан юмыг одоо би чамд гаргаж өгье. Чамайг өөр бусад хүүхнүүдээс арагийн холбоог таслаад муу үеэл дүүгээс чинь үнэнч вмгүй болж дурсан санахын цагт өгөөрэй гэж надаас ам шүд авсан билээ . Тийм цаг нэгэнт болсон байна гээд аврыг уудлан ам дөрвөлжин бөс гаргаж ирсэн нь мөнөөхөн миний бэлэглэсэн хоёр шарогачингийн зурагтай алчуур ажээ . Авч үзтэл дээр нь ийм шүлэг бичсэн байна. Хэн биднийг хая гэв үзэсгэлэн гоо минь Хэт хайртай учир шалансан нэг нь алагджээ . Хагацсан өдрөөс хойш чи намайг мартсан бол Харин би хэзээ ч мартаагүй шүү Аллах мэднэ . Хатуу сэтгэлээр намайг тамлавч харин над таатай балаа . Хайрлаж хэзээ чи нэг надтай учрах вэ? Тачъяангуйн сэтгэл биднийг зовооно гэж урьд би мэдсэнгүй Тэрхүү шаналал ирнэ гэж дурлахын өмнө санасангйү. Хайрын сэтгэл зүрхийгш эзэмдэн тэр цагас хойш Халуун хүсэл минь янагийн олз боллоо .Хайр дурлалыг минь хараад муу улс өрөвдөнө.Харин хэнд чи намайшаа эс хайрлана уу!Ямар ч болов би Аллахыг мөрөөвөдч тайтгаруулахгүй нь Янагийн халуунаар үхсэн ч чамайгаа би умартахгүй Энэ шүлгийг уншаад нүүр амаа урж би Јашуудпаг уйлж байтал мөнөөхөн лчуур дотрос бас нэг зурвас бичиг унасныг үзвэл : Аяа миний авгын хүү Азиз минь мэдэгтүн! Миний өчүүхэн амины төлөөнөөс Аллах чамайг хэлтрүүлэн янаг сэтгэлтэй хүнтэйгээ нийлэхдээ тэтгэх болтугай! Гэвч мэхт Далила эмгэний охиноос болж чамд ямар нэг гай тотгор тохиолдвоос түүнтэй юмуу өөр хүүхэнтэй битгий хавьтаарай . Чиний заяаны нас чинийхээс богинохон зкаяажээ . Чамд баярыг уламжилья! Энэ алчуурыг би чиний эзгүйд дандаа харж суудаг байса болохоор минийсэтгэл шингэжээ . Эл учир чи энэ алёуурыг биеэс ямагт салгалгүй халгалж яваарай . Хэрэв чи энэ шаргачинг хатгамалан урласан хүүхэнтэй дайралдваас сэтгэлээ өгч бүү гэрлээрэй :. Тэр эм жил болгон ийм хоёр адилхан шаргачин оёод алс холын улс гүрэнд гаргаж, өөрийн алдрыг ба хорвоогийн хүнд ховор заадаг урнаа түгээн мэдүүлэх бүлгээ . Чиний сэтгэлээр унасан хүүхэнд нэг нь олдсоноор бусдад ямагт үзүүлж гайхуулах ажээ . “Энэ алчуурыг миний эгч оёжээ” гэсэн ьн огт худал бөгөөд эл учир түүнийг Аллах залхаах болтугай! Чамд миний захих зүйл энэ! Алчуурыг чамл үлдээсний учир юу бэ гэвэл намайг үхсэний хойно хорвоо уужим боловч чамд давчуу болох бий үүнээс болж чи харийн орноор бяданг явж байтал магадгүй энэ чуур оёсон хүнийг олж сонсоод үзэх юмсан гэсэн сэтгэл төрж болхийм. Тэгвэл чи миний хэлснийгдурсан санах бизээ . миний сайхан сэтгэлтэйг чи үхсэн хойо минт мэдэх болно гэж мэдсүгэй!” гэжээ . тэр хуудас бичгийн учрыг мэдээд би ихэд гиншин уйлахад миний ээж хамт уйлсаар шөнө дөл болов. ийнхүү жил тойрон болтол манай нутгийн (одоо энэ яваа) худалдаачингууд харь газар аянд мордох болтол миний эх : “Хүү минь чи эдэнтэй алс гүрэнд аянюп явбаас наад зах нь хоёр гурван жил болох тул энэ завсар сэтгэл чинь онгойж ухаан чинь саруул болох биш үү!” хэмээн ятгасаар байгаад ийнхүү явуулсан билээ . тэгэвч энэ завсар миний нулимс хатсан нь үгүй бөгөөд буудаллахад болгонд би энэ алчуурыг гаргаж, түүн дээр зурсан хоёр шаргачинг үзэх бүрийд нагацынхаа охиныг ихэд санах ийнхүү уйлахы минь чи нүдээр үзнэм биш үү. Тэр охин над үнэнхүү сэтгэлтэй байтал надаас болж нас баржээ . над

ÌÝÍÃÝÕ ÄËÀ-ÀÄ-ÄÈÍÜ ¯ËÃÝÐ

сайн үйл хийсээр атал , би түүнд муу үйл хийжээ. Эд худалдаачингийн хамт харт гүрэн орсод хамт буцах санаатай явнам. Тэрхүү эрхэм хүнээс хагацсанаас хойш одоо нэг жил болох нь! Баа Камбар арал дайран гарахын цагт баскүү ихгунигт дарагдаад байнам. Болор хэрэм хийгээд тэрхүү долоонг арлыг Шахраман хаан захирах бөгөөд Дуния гэдэг охинтой ажээ . Энэ охин шаргачин урлан оёдог бөгөөд чиний алчуу дээрб айгаа хоёр шаргачинг энэ охин урласан юм гэж улс хэлэлцэнэ. Энэ үгийг сонсоод би галаар бадрах мөрөөдлийн их тэнгист өөрийн эрхгүй умбан нээн их гашудан уйлав. Ийм сайхан эмийш хүсэх сэтгэл над байвч эр хүнд заясан бэлэг эрхтнээ санахад ямар ч арга байхгүй маш бэрх ажээ . Камбар арлаас нааш гарсанаас хойш хоёр нүдний нулимс тувт асгараад зүрхэнд шимүирэн өвдөх тул хартж хөгшин эхийнхээ хажууд хүрч үхэж чадах нь уу , үгүй юу гэж зов¦ явна. Амьдралд би ийм зовлон амсаж явна” гээд мөнөөхөн алчуурыг харан харан эхэр татан уйлж :Бидэн хоёрын хагацсан цагаас хойш Аллах мэднэБишгүй их гашуудан уйлж, би нулимсыг орлов. “Тэсэж үз! Санасандаа хүрнэ чи” гэж мууд дурлагчид хэлнэ “Тэр тэсвэр хаана байна?” гэж би тэндээс асуух бүлгээ гэж эртний шүлгээс өгүүлээд Ай хаан миний явдал энэ дээ. Илүү жигтэй үлгэр дууль чи сонсож суухдаа Ситт Дунья охин түүний үзэсгэлэн гоог сэтгэлчлэн бодохдоо сэтгэл зүрх нь хөөрч билээ . Эрт урьд цагт Киар хэмэх хотноо Шамас ал-дин гэдэг худалдаачин байжээ . Албат зарфц олонтой , эд агуурс элбэгтэй туйлын үнэнч хүн тул Киар балгадын бүх худалдаачдын тэргүүн нь бүлгээ . Худалдаачин гэргийдээ, эрдээ хэдий их хайртай боловч дөчин жио ханилан суухад гэргий нь нэгээхэн бээр ч үр хүүхэд заяасангүй ажээ . мөнөөхөн худалдаачин нэг өдөр наймааныхаа газар суугаад харж байтал бусад худалдаачин болгон нэг юм у хоёр хүүтэй , тэд нар нь эцэгтэйгээ зэрэгцэн наймаа худалдаа хийж байх ажээ . Тэр өдөр сугар гариг байсан тул шашны ёсоор угаал хийж нэг үсчний толинд царайг ажиглан хартал сахадд цагаан үс байхыг үзээд үс бууралтана гэдэг үхэх болсны шинж гэж өөрийн эрхгүй тэнгэр бурханд залбирчээ . Гэртээ харихад нь нэргий нь мөн угаал хийж биеийг зэхээд “Тавтай сайн уу?” гэж мэндийг асуухад худалдаачин тавгүй байна гэжээ . Тэгэхээр гэргий нь зарц шивэгчин нарыг захиран сайхан хоол авчруулаад ноётон хоолоо зоогло гэсэнд би хоол идэхгүй гээд ширээг өшиглөн өнхрүүлж буруу харжээ . “Чи энэ өдөр юуны учир ийнхүү гунигтай болов?” гэсэнд чамаас болж уйтгарт оров гээд юуны учир билээ? гэсэнд би өнөөдөр дэлгүүрээ нээгээд ажиглаж байвал худалдаачиэ болгон нэг юмуу хоёр түүнээс олон хүүтэйы, тэд нар эцгийн адил худалдаа наймаа хйхийг хараап над үлдэх үр сад байхгүй ажээ гэж бодохоос ихэд гуниглав. Би анх чамтай ханилан суухдаа чамаас өөр хүнтэй хавьсахгүй татвар эм шивэгёин авахгүй гагцхүү чамтайгаа цунтаж байна гэж ам тангараг өгсөн биз ээ. тэгвэл чи ямар ч үргүй яг хад чулуу шиг ажээ гэсэнд гэргий нь Аллах тэнгэрийг ам алдан дурсаад: Чиний үр дусал даанч ус шиг тунгалаг билээ гэхэд нь тийм тунгалаг бол яадаг юм? гэсэнд тийм тунгалаг эм хүнийг ыбие давхар болгож эс чадна гэжээ . тэгвэл юугаар тийм тунгалаг биш цэгээн болгох билээ гэхэд нм нь будгийн худалдаачинд очиж сурвал болно гэж гэргий нь өгүүлжээ . Тэр шөнө худалдаачин гэргийгээ дэмий зэмлэв гэж мөн гэргий нь эрийгээ дэмий зэвмэл гэж хоёул гэмшин хоножмаргааш нь худалдаачин эр будаг зэрги йг зардаг хүн дээр очиж амгалан айлтга д эр хүний үрийн дуслыг

цэгээн болгодог юм байна уу гэж сургаласанд уул нь байсан юмсан одоо нэгэн дуусчээ гэсэн бөгөөд мөн нэлээд хэдэн хүнээс иим хариу дуулжээ . Тэр зээлийн газар хар тиахи идэн согтуурч Мухаммед Симсим гэгэч нэг ядуу хүн байдаг бөгөөд лэнсий эдийн наймаачдын дарга нэртэй ажээ . Тэр хүн өглөө болгон мөнөөхөн худалдаачны дэлгүүрт ирж амгалан айлтгадаг билээ . Энэ өгдөө мөн ирж амгаланг байн уу? гэсэнд худаодаачин ихэд ууртай байх тул Аяа ноёнтон та энэ өглөө юуны учир ийнхүү ууртай бана? Гэсэнд худалдаачин өгүүлрүүн: Би гэрлээд дөчин жил болсон байтал надаас болод миний гэргий нэг чхүүхэд гагасангүй , тэгээд миний үрийн дусал хэт шингэн тунгалаг учир үр тогтож эс чадна гэж миний гэргий өгүүлэхэв би тийм үр тогтоож эс чапна гэж миний гэргий өгүүлэхэд би тийм дусал цэгээн болгох эд эрээд олсонгүй гэсэнд Мухаммед “аяа ноёнтон минь ээ, та гэрлээд дөчин жил болсон боловч хэрэв би таныг үр тогтоох чадалтай болговол та яах вэ” гэхэд нь тэгвэл яамд туйлаас бишрэн их хишиг хүртээнэ гэжээ . Тэгвэл над динар зоос өгөгтүн гэсэнд худалдаачин хоёр динар зоос өгснийг аваад бас нэг шаазан таваг авч явжээ . мухаммед өвё цэцэг худалддаг газар очиж , хоёр лан хятал кубейбын ханд, нэг лан Ион газрын олсны тослон хандл, нэг лан шинэ лиш, нэг лан Серендиб газрбн улаан эла , таван цэн энэтхэг гаа, таван цэн повари , таван цэн Аралын чинжүү , нэг лан энэтхэг гоинд , таван цэн уулын тимиан худалдан аваад тэдгээрийг чадамгай холтж шигшээд цэвэр бал хольж таван ширхэг заар , нэг лан загасны нүдсэн төмс сарнай цэцэгйг шингэн шүүс хольж тавганд хийгээд авчирч :Энэ бол эр хүний үрийн дуслбг цэгээн болгогч эр даруй мөн. хонь , тагтаа , шувууны мах, халун чёанарын ногоотой сайтар хольж цөмийш идээд чихэртэй хандаар даруулыал болно гэжээ . Худалдаачин , нөгөө бэлтгэснийг хонины мах, тагтаа шувууны хамт гэргийдээ явуулж сайхан хоол бэлдээд бай гэж хэлүүлжээ . Худалдаачнийг харихад гэргий нь сайхан хоол бэлдсэн байсанд урьдаар махыг идээд дуслыг цэгээн болгогчийг амсаж үзвэл их л амьай тул цөмийг идсэнд авааль гэргий нь тэр шөнө бие шалтгаантай божээ . Тэр шөнөөс хойш гэргий нь хөд хүндэрч , сарын хэр саатаад хоногийн хоногийн тоо гүйцэхэд нярайлахаар өвдөж орь дуу болсонд нэгэн эмгэн хүүхдийг боож авлаа . Гурав хоног дээр, исгэсэн гурилан боорцог хийж, долоо хоног дээр түгээж ёсыг гүйцэтгээд эцэг нь ирж Аллах тэнгэрийн хишиг хаа байна гэж хүүгээ үзсэнд хосгүй цэвэрхэн байсан бөгөөд долоо хоног болсон гэхэд ойндоо хүрсэн юм шиг тийм томсайхан хүүхэд байжээ . Хоёр хацартаа мэнгэтэй саран мэт сайхан хүүгээ үзэн баясаж эцэг “Чи хүүдээ хэн гэж нэр өгөх вэ?” гэсэнд охин хүүхэд гарсан бол би нэр өгөх билээ . Хүү гарсан у·раас заавал эцэг нь нэр өгөх ёстой шүү дээ гэж эх нь хэлжээ . Дэргэд нь байсан нөхөр нь “Аяа , Ала-ад-дин минь” гэж дуу алдсанаар эцэг нь хүүдээ мэнгэт Ала-ад-дин гэдэг нэр хайрлаад асрах хүн гарган, хоёр жил болоход хаа ч явдаг болов. Долоон нас хрэхэд нь эцэг нь элдэв муу нүднээс далддлан “Эрүүндээ бавгар сахалтай болтол нь бүү гарга!” гэж байшингЁйн зооринод оруулаад хүнс зөөх боол, тэгээд хоол хийж шивэгчин гаргажээ . Тэгээд үс авах найр хийгээд , бичиг сурё ном судар уншдаг эрдэмтэй хүн болгох гэж багш гаргаж өгчээ . Нэг өдөр боолчууд хүүд хоолд зөхийн цаг хаалгыг онгорхой орхисондп Ала-ад-диан сэм гарч эхийн өрөөнд орвол эх нь дээдсийн олон эхнэртэй хамт сууж байжээ . Нэгэн туйлын хөөрхөн жаал орж ирэхийш тэд үзээд нүүрийг дарж орь дуу

тавихад “Аяа, Аллах тэнгэо чамд ийм сайхан үр заяадаг болоосой чи яагаад ийнхүү хүний жаалыг оруулж ирэв? Сүзгээс ичгүүр төрдгийг чи эс мэдэх үү? Гэцгээхэд “аяа Аллах минь энэ бол үнэхээо миний төрүүлсэн хүү, худалдаачин нарын тэргүүн манай Шамас-ад-дины үр билээ” шэсэнд бид чамайг үнэхээр ийм үртэй гэж мэдэхгүй билээ гэцгээхэд нь Ала-ад-дины эх өгүүлрүүн: Эцэг нь муу юмны нүдэнд өртөх бий гэж газар дор зооринд тэжээжэ байгаа юм . Тайган нар үүдийг сул орхисон учир гараад ирсэн бололтой . Уг нь бид сахлы нь ургахаас нааш гаргахгүй гэсэн юм гэсэнд мөнөөхөн олон эхнэр Ала-ад-дины эхэд тал өгөцгөөн. Ала-ад-дин тэндээс гарч цэцэрлэгийн сүүдэрт сцуутал нэгэн боол эцгийн нь илжгийг авчрахыг хараад энэ илжгийг хаанаасс авчрав ? гэсэнд чиний эцгийн дэлгүүрт бараа зөөгөөд авчирлаа гэхэд нь “Миний эцэг ямар ажил хийдэг вэ? гэсэнд_ чиний эцэг бол мисир газрын худалдаачин нарыбн тэргүүн суурьшсан араб нарын султан билээ ” гэлээ . Ала-ад-дин гэрт орж миний аав ямар ажил хийдэг бэ? гэж ээжээс асуусанд чиний эцэг бол мисир газрын худалдаачин нарын тэргүүн, бүх суурин араб нарын султан хүн . Түүний зарц нар мянга юмуу, түүнээс дээш динар зоосны үнэтэй барааг чиний эцгээёё асуу худалдахаас биш , доогуур үнэтэй барааг өөрсдөө мэдэн худалдддаг юм .Харийг орноос ирэх бзх бараа, харийн орон явах бүх бараа гагцхүү чиний эцгийн гараар орно. Аллах тэнгэр чиний эцэгт тооловч баршгүй их мөнгө заяажээ гэсэнд хүү нь Аяа эх минь ээ, миний эцэг бүх суурин султан, худалдаачин нарын тэргүүн байтлаа намайг юунд газар дор зоринл цоожтой суулгана вэ? гэсэнд муу нүдэнд өртөх бий гэж айхдаа кооринд суулгав. 0Ер нь нас эцэслэсэн хүний олонхи нь муу нүдэнд өртсөнөөс болжээ гэхэд Ала-ад-дин өгүүлрүүн: “Аяа хүн нэгэнт заясан тавилангаас хаашаа зайлах билээ болгоомжтой түүнээс гарахгүй ошүү дээ . Цагийн эрхээр эцэст насан эцэс болохын цагт “Би худалдаачин Шамас ад-дины хүү байнаа” Јэж хэлэхэд улс амьтан үнэмшихгүй “Бид Шамас-ад-диныг хүүтэй ч гэж мэдэхгүй , охинтой ч гэж мэдэхгүй ” гээд ±ан хөмрөгөөс эцгийн хөрөнгийг дураар авах боно. “Эр нөхөр нь үхэхийн цагт эд хөрөнгө нь үрэгдэж , жигшилтэй эмсийн олз болдог гэж Аллах сутргасан биш үү. Аяа ээж минь м ргааү намайг дагуулан зээлийн газар очиж дэлгүүр нээж худалдаа наймаанд сургана уу гэж эцэгт хэлж өгөөрэй гэсэнд эх нь заа тэгье гэжээ . худалдаачин гэртээ ирвэл мэнгэт Ала-ад-дин эхийн дэргэд байхыг хараад Чи түүнийг юуны учир зооринoос гаргав?” гэсэнд би гаргасангүй , зарц нар зоорины үүд хаахыш мартжээ . намайг айлын эхнэрүүдтэй сууж байхад орроод ирсэн юм гээд хүүгий хэдснийш цөмийш ярьсанд Шамас-ад-дин өгүүлрүүн: Аяа, хонгор хүү минь ээ, маргааш чамайг зээлийн газар авч очъё харин чи юм болгон дээр томоотой, буурьтай байгаараа гэжээ . Ала-ад-дин эцгийн үгэнд ихэдб аярлан хонод өглөө ыб болсонд Шамас-ад-дин хүүдээ угаал хийж, гоё үнэтэй хувцас өмгөж , өглөөний хоол идээд өөрөө нэг луус унаж хүүдээ нэг луус унуулж хөтлөөд зээлийн газар очинЗээлийн газар очиход худалдаачдын тэргүүн тийнхүү гэнэт арваг тавны сар шиг сайхан хүү хөтлөөд явахыг улс харж “Энэ хөвгүүнийгхарав уу . манай тэргүүн худалдаачин хөгшин хүн атлаа яасан муухай дотортой тусгүй хүн билээ” гэлцэв. Дээр өгүүлсэн мухаммед Мимсимийн өгүүлэх нь “Та минь бидний худалдаачид ийм хүнээр хойшид тэргүүн байлгах ёсгүй ” гэнэ. Уг нь худалдаачин нарын тэргүүн зээлийн газрын морилон ирэхэд бус д худалдаачин бараалхаж, тэнЈэрийн судрын нэг

бүлгийг уншаад тэргүүн худалдаачинд ерөөл хэлсний дараа тус тусын дэлгүүрт тархан наймаагаа хийдэг ёстой байжээ . Тэгтэл энэ өдөр худалдаачныг тэргүүн дэлгүүртээ ирсэн хойно нэг ч худалдаачин бараалхаж ирсэнгүйд зээлийн дэргэ болох мөнөөхөн мухаммедийг дуудаж ”Худалдаачин юуны учир цуглаж ирэхгүй байна?” гсэнд “Би хэдийгээр хов хэлэх дургүй боловч үнэнийш хэлэхд тэд таныгш тэргүүнээс буулгана. Танд тэнгэрийн судраас уншихгүй гэж байна билээ” ш гэхэд нь “Юуны учир тэр билээ?” гэсэнд “Энэ юун хөвгүүн билээ? Чиний албат зарц буюу чиний гэрг йн төрүүлсэн хүүхэд алин болохыг мэдэхгүй байна. Харвал чи их л ахйр ай бүлгээ” гэжээ . Шамас-ад-дин өгүүлрүүн: Чи Аллах тэнгэрийг бодож дуугүй байвал барав. Энэ бол миний төрсөн хөвгүүэ билээ гэсэнд бид чиний хүүг үзээгүй шүү дээ гэхэд нь “Чи тэр жил надад эр хүний үр дуслыг цэгээн болгодог юм авчирч өгсөн шүү дээ . Би түүнийг хэрэглэснээр миний гэргий х хүүхэд олж энэ хөвгүүн төрүүлсэн юм . Тэгээд муусайн амьтны нүднээс далд зооринд өгсөж, барим сахалтай болтол нь гаргахгүй гэж шийдсэнээ эх нь энэ хөвгүүннийг зээлийн газар аваачиж , дэлгүүр гаргаж наймаанд сурга гэж гуйсаар өнөөдөр авчрав гэв. Зээлийн дарга эл учрыг бусад худалдаачдад айлтгасанд тэд цөм цуглан ирж тэнгэрЁйн судраас уншаад сайхан хүүтэй болсонд цөм таатай байна гээд бидний үр үндсийг бурхан сахих болтугай : Ядуу айл ч гэсэн хүүхэд гаргахаар ах дүүс , айлын хүнээ урьж оог бартдаг биш үү. Тэгвэл чи ер тэгэхгүй юм гэсэнд тэгэлгүй яах вэ? маргааш цэцэрлэгийн дотор цайлах болно гэжээ . Маргааш өглөө нь зарц нараа захиран цэцэрлэгийн дотор хоёр газар хивс дэвссэн их ширээ засулж хонины мах, тос тэргүүтэн сайхан хоол бэлтгүүлжээ . Тэгээд Шамас-ад-дин хүүгээ хэлсэн нь : Ай миний хүү буурал настай улсыг би тосож байшинд засаан ширээнээ урина . Сахлагүй багачуудыг чи урьж асарт кассан ширээнээ суулгаарай гэсэнюд “Аяа эцэг минь ээ, чи юуны учир том хүнд нэг янз хүшхэд бага улсад бас нэг янз хоёр ширээ заснам? Гэхэд нь “”Аяа хүү минь , томчуулын дэргэд суухаа багачуул ичингүйрдэг юм” гэсэнд хөвгүүнг сайшаан зөьвшөөрчээ . Худалдаачин иргэп цуглан эхлэхэд Шамаыс-ад-дин найстайчуулыг байгинд урьж, Ала-ад-тин багачуудыг асарт урьж суулгасанд зочид хоол зооглож , дарс ууцгааж , өвгшөд хөгшид нь хөөрч гарлаа . Тэр газар, харахад лал хүн атал муу магууч удамтай Махмуд аль-Бальхи хэмээгч нэг хүн буй бүлгээ . тэрбэээр муу санаатай бөгөөд хүүхдэд дурладаг хачин зантай ажгуу . Махмуд аль- Бальхи Ала-ад-дины шүр мэт тунгалаг царайг хараад ихэд дурлан байн байн санаа алдан сэтгэлийн тачъяадан автагдаад аясыг харж байгаад Ала-ад-дин шээхээр гарахд хүүхдэд хандаж өгүүлрүүн: хэрэв та нар Ала-ад-дин»г надта анд яв гэж ятгаж чадвал цөмд чинь гоё хувцас авч өгнө гэж хэлээд явжээ . Ала-ад-диныг гарч шэЅгээд орж ирэхэд хүүхдүүд дундаа өндөр ширээнээ суулгаж нэг хөвгүүн нэг нөхөртөө өгүүлрүн: Аяа Сиди Хасан чи хаанаас мөнгө олж наймаа хийх бараа зэхэж өгөөч гэсэнд , ай хүү минь над бэл байхгүй , чи өөрөө нэгэн худалдаачин хүнээс мөнгө зэхэж аваад бараа авад тэдгий хамт Дамаск орж худалдаж хоёр дахин их олз олоо цааш Багдад балгад орж наймаа хийсээр одоо миний мөнгө нэг түмэн динар зоос болов. гэж ярьжээ . Хүүхдүүд цөм иймэрхүү юм ярьж Ала-ад-дины ээлж болоход би газын дор зооринд өссөн сая баасан гаригт гарч ирэв. Одоогоор дэлгүүр гэр хоёроос өөр газар мэдэдхгүй байна даа гэхэд нь чи гэрт суусаар байгаад аянд явахын амтыг үзээгүй ажээ . Эр хүн заавал аянд явах

хэрэгтэй гэсэгд би аянд явахгүй , тийм хөрөнгө ч байхгүй гэхэд нь энэ хүү яг загас шиг уснаасаа гарвал үхэх юм бана гэж нэгэн хөвгүүн элэглэн өгүүлсэнд бас нэг нь : ”Аяа Ала-ад-дин минь ээ, баяжихын тул аян хийхгүй юм бол худалдаачин хүний хүүхэд гэж байсны хэрэггүй” гэсэнд Ала-ад-дин ихэд хорсон гомдож уйлсаар луусаа унаад харьжээ . Эх нь хүүгээ уйлсынг үзээд , аяа хүү минь чи юуны учир уйлав? Гэсэнд баяжих гэж аянв явахгүй юм бол худалдаачны хүүхэд гэж байсны хэрэггүй гэж хүхдүүд хэлж байна гэхэд нь аяа миний хүү чи аян хий дуртай байна уу? гэсэнд дуртай гэжээ . тэгвэл миний хүү аль хот роох санаа байна гэхэд нь Багдад балгад орно, тэнд хүрсэн хүн хоёр дахин их олз олог гэнэ гэхэд нь Ала-ад-дины эх өгүүлрүүн: - “Миний хүү эцэгт чинь их мөнгө бий . Хэрэв эцэг чинь чамд бараа авч өгөхгүй бол би чамд бараа авч өгнө” гэж сйан үйлийг сааргүй ыббүтээвэл дээр гэдэг хэрэв тийм бол одоо үтэр түргэн зэхэж өгөөч гэсэнд эх нь боол зардасныг дуудаж зээл рүү явуулж арван боодлд бараа боолгож зэхжээ . Эцэг нь нэг харсан ячинь цэцэрлэгин дотор хүү эс үзэгдсэнп сураглавал Ала-ад-дин харьсан байжээ . худалдаачин харьж ирээд боодолтой бараа зэхсэнийг үзээд учрыг асуувал эх нь саяны болсон явдлыг нэгд нэггүй өгүүлсэн , эцэг нь өгүүлрүүн: “Харийн оронд очсон хүнийг Аллах таалдаггүй , нутагтаа байж, заяагаа дэлгэсэн эр хүн жаргалтай гэж Аллах өршөөдөг! Урьдын цагт бол нэг бээр газар боловч битгий яв! гэсэн байдаг юм . Чи аянд заавал явахаар хатуу шийдэв үү? Гэсэнд би Багдад балгад заавал бараа авч явна . Эс тэгвэл бадарчингийн нөмрөг өмсөөд ертөнцийг хэсэж, бадарчилна гэхэд нь би чамайш бадарчлуулахыг тэвчихгүй , харин ч над мөнгө хөроөнгө их бий гээд бараа таваар хөрөнгө хогшлоо үзүүлээд бас тусгайлан дөчин боодол бараа үзүүлсний тус бүр дээр нь “мянган динар зоосны үнэтэй” гэж бичсэн байжээ . Эцэг нть худалдаачин өгүүлрүүн: Энэ дөчин боодол барааг эхийн бэлтгэсэн арван боодлын хамт аваад яв даа .Харин ч мд чинь арслангийн нэрт шугуй, нохойн хөндий нэртэй хоолой хоёр айхтар газар бий . Тэнд хүнийг өршөөлшзй хөнөөдөг юм . ганцхан түүнээс л айх юм даа гэхэл нв “Яагаад тэр билээ, эцэг минь” гэсэнд тэнд зам тоссон Ажлан хэмээх нүүдэлчин араб бий юм гэхэд нь хэрэв заяа байвал Аллах тэнгэрийн өршөөлөөр гай зовлон тохиолдохгүй биз гэж хүү нь хэлжээ . Тэгээд эцгийын хамт ажлын малын зээл дээр очтол нэгэн тэмээтэй хүн буун харайыж, тэргүүн худадалдаачны нарыг үнсээд “Ай ноёнтон минь та худалдааны хэрэгт биднийг хөлслөхгүй буюу?” гэсэнд Шамас-ад-дин би өөрийн мэдэлтэй , өөр ийн зарцтай даа . Өвдгөө шүргэсэн цагаан сахалтай Өвгөн тэнүүлч хэсүүчлэилж явнаЯагаад нуруу чинь бөгтийв? гэж Ярианы далимд би асуувЗалуу насаа хорвоод гээчээд Зайж хайсаар бөгтийв гэлээ ”гэж урьд нэгэн хүний хэлснийг Аллах ихэд таашаажээ гээд одо миний хүү ийм аян хийхийг хүснэ гэсэнд тэмээтэй хүн “Үйлс нь бүтэх болтугай” гэжээ . тэгээд тэргүүн худалдаачин тэмээтэй хүнтэй хэлэлцээ хийж чи үүнээс хойш миний хүүгийн эцэг болно гээд хүүгий минь сайн авч яваарай гэж зуун динар зоос өгчээ . тэргүүн худалдаачин жаран луус, бамбар , бас Абдаль Задир Гилены шейхийн шарилд тавих бүтээлэг авч өгөөд хүүдээ “За хүү минь миний үгүйд энэ хүн чиний эцэг болно , үгэнд нь орж яваарай!” гэжээ Тэр үдэш Абдаль КадирГиляны шейх «амыг хүндэтгэн бурхан судраас уншиж маргааш өглөө нь тэргүүн худалдаачин хүүдээ түмэн динар зоос өгөөд “Багдад балгадад наймаа сайн байвал юмаа зараарай, наймаа

гүйхгүй байвал энжэ мөнгөө зараарай"гэжээ . Тэгээд Ала-ад-дин луусаа ачуулж , хань нөхөдтэй салах ёс хийж аянд хөдөлжээ . Бас махмуд –ал-Балхи мөн Багдад орохоор хөгсөө ачаалж хотын захад асар майхнаа шаагаад "Тэр хол газар хов хэлэх, ул шагайх хүнгүй тул энэ жаал хүүтэй нийлэн жаргах цаг иржээ" гэж боджээ . Хүүгийн эцэг махмуд-аль-Бальхитай данс бодож , наймааны үлдэгдэл мянган динар зоосыг , миний хүү Ала-ад-динд өгөөрэй гээд миний хүүг өөрийн хүү шиг сайн харж яваарай гэжээ. Ала-ад-дин махмуд – аль- Бальхитай уулзсанд тэр бээр хөвгүүний аяны нь улсы нь хамт дайлаад цааш замд хөдлөв. Махмуд-аль-Бальхи Киар, Дамаск, Халеб, Багдад балгадад тус бүр дөрвөн гэртээ бөгөөд тэд их цөлийг туулж Дамаск хүрэхийн хамт Махмуд –аль-Бальхи , Ала-ад-дин хүүд хүн яьвуулж, морилон ирж зоог барихыг урьсанд Ала-ад-дин очих эсэхийш тэмээт Кемаль-адинаас асууваас "очиж хэрэггүй" гэжээ. Лараа Дамаскаас Халеб орох болж Махмуд-аль-Бальхи бас найр хийэ Ала-ад-диныг урьсанд даамал эцэгтэйгээ яриад бас очсонгүй . Халебасс гарч Багдад хүрэх замд махмуд-аль-Бальхи бас найр хийж Ала-ад-диныг урьсанд Ала-ад-дин мөнөөхөн жингийн даамал тэмээт өвгөний хорьсоор атал заавал очно гэж хувцсан дотроо юлд бүслээ хүрээд очжээ . Махмуд-аль-Бальхи босон харайж амрыг айлтгаад сайхан ширээ засаж найрласны хойно гарыг угаагаад Ала-ад-диныг үнэсэн таалан сүйд болохуй дор"Чи яах гээд багаа юм?" гэхэд нь энэ газар чамтай хүслийг хангах гэж дуудсан билээ гээд. Өндөг шарж , ямаа саахын зуур Өөр чи бидэнтэй уулзаадТалх тариаг олдохын хэрээр идэжТөгрөг мөнгийг чадахын хэрээр авч болох уу? Чимхч бай, атга ч бай хамаагүй Чи хүсвэл хэдийг ч аваачсан бэрх бишгэж юу гэсэн үг болохыг ярилцана даа гэж хөвгүүнийг хүчирхийлэх гэсэнд Ала-ад-дин юлд гарган далайж, "Буурал толгойдоо гшэмш бурхан тэнгэро хатуу залхаадгийг чи эс мэдэх үү!Цагаан юм хар авахдаа амархан бадаг билээЦал буурад толгойгоо бузарлахаас эс айна уу чиГэж байдаг юм шүү гээд үнэндээ гэхэд миний энэ бол Аллах тэнгэрийн заясан зардаггүй бараа . хэрэв зардагсан бол өөр хүнд алтан зоосоор худалдах юм гэхэд чамд блд мөнгөн зоосоор худалдах байлаа . муу санааи минь одо бид хоёр хэзээч нөхөр биш гэж хэлээд эргэж ирээд Камель-ад-дин өгүүлрүүн: Тэг хүн бол яах аргагүй садар самуун хүн байна. Би хэзээч нөхөрлөхгүй : Цуг ч явахгүй гэлээ . Камель-ад-дин, битгий оч гэж хэлээгүй юу даа гээд харин одоо салж явахад бидэнд үхдийн аюулд учрах тул нэг жингээр хамт явъя л даа гэхэд нь түүнтэй яасан ч зам нийлэхгүй гээд ачаалж цааш хөдөлжээ . Явсаар нэгэн хөндийд ирэхэд Ала-ад-дин энд хоноглоно гэсэнд Каимель-ад-дин энд хонох хэрэггүй шалавхан явж чадвал Багдадын хэрмийын хаалга хаахаа± урьд хүрье гэлээ . Тэр үес Багдад балгададынхан Рафидитуудаас (Мусульман шашны) эсрэг нэг айж хэрмиын хаалгыг өглөөний нарнаар нээж үдэш наран жаргадахд хаадагбайжээ . Ай эцэг минь ээ, бид тэр газраас энэ хотод ирэхдээ намаа хийх гэж ирнээс харийн орон үзэх гэж ирээгүй гэхэд нь чиний амь нас, чиний эд хөрөнгөнд нүүдэлчин арабууд гай болно шүү дээ гэсэнд Багдадын залууст гайхуулж заавал өглөө болсон хойно орно гэхэд нь за яахав өөрө мэд би харин сануулсан гшүү гжэ Камель-ад-дин цөхрөн өгүүлжээ . Тэгээд ачаагаа буулгаж хураагаад асар майхнаа шааж хонох болжээ . Шөнө дунд Ала-ад-дин гарч шээхдээ алсад юм гялалзахыг хараад ай тэр юу гялалзаад байна? гэсэнд Кемаль-ад-дин гарч хараад төмөр жадны үзүүр байна. Нүүдэлчин арабууд ойртож ирж

ачаа бараа хурааа байхыг хараад “Энэ шөнө олзтой” гэж өөр хоорондоо ярилцахад ажээ .Кемаль-ад-дин энэ үгийг сонсоод “өөдгүй арабууд тонил!” гэж хашгирсанд Абу Нанб жадаао нэвт сүлбэсэнд Кемаль-ад-дин майхын аманд үхэдхийн унахыг Ала-ад-дин харсаар байжээ . дээрчмчид бусад хүүүмсийн нь хүйс тэмтрэн алаад бараагий нь аачаалж яваад өгсөнд Ала-ад-дин би энэ луус, энэ хувцаснаас амь алдах нь гэж ахамг хувцсаа тайчин хаяад майхны аманд алагдсан хүний цусанд хутгаж үхсэн мэт болж хэвтлээ . Нөгөө Ажлан цааш явж байтал “Энэ жин Багдадаас Киар орж яваа юм уу? ” гэж бусдаасаа а±уухад “үгүй Киараас Багдад орох гэж яваа бололтой гэхэд нь буцаж, үхсэн улс дэр очигтун , жингийн эзэн амьд байж магадгүй гэсэнд хэдэн араб буцаж очоод үхсэн улсыг дахин сэлэм жадаар хатгалсаар Ала-ад-динд хүрээд “Чи худлаа үхсэн болж хэвтэнэ үү гүйцээж орхино доо!” гээд жад сунгасанд Ала-ад-дин Ай Абдаль Кадир Гилян бурхан өршөө гэж залбиртал нэг гар жадны үзүүрийг татсанд Кемаль –ад дины цээжинд дахин шааж тэд яваад өгчээ . Ала-ад-дин харсаар байтал луус дээр ачаалал хээрийн шувуу олзоо аваад нисэн одохын адил цааш явтал дээрэмчдийн тэргүүн Абу Нанб гэнэт, “Тэр нэг цагаан юм юу вэ” гэсэнд бусад нь Ала-ад-дины оргож яваг бас хараад “Чи бидний гараас амь гарахгүй” гэлцэн морьдыг давирч нэхэн хөөсөнд Ала-ад-дин зугтаасаар нэг цөөрөмд тулж, усны хаалтын их төмөр сараалжинд авиран гараад унтагч болж хэвтээд “Хутагт Нафис минь өршөө” гэж залбиран нэг араб хүн торон дээр гарч гар сунган хилэнцэт хорхойд хатгуулан орьдуу тавин мориноос ойчсонд бусад нь дахин мордуулаад чи яасан ? гэсэнд хилэнцэт хорхойд хатгуулав гэхэд нь үг дуугүй хөтлөн яваад өгчээ . нөгөө Махмуд аль-Бальхи мөнөөхөн газраас ачаалан хөдөлж Арслангийн тогоо хэмээх газар хүрээд Ала-ад-дины бүх зарц нар алагдан байхыг үзээд дотроо баярлан цааш хурдавчлан явсаар мөнөөхөн цөөрөм дээр ирж усны хаалтын тэнд луусаа услах гэсэнд луус нь Ала-ад-дины усанд туссан дүрсийг хараад үргэсэнд Махмуд-аль-Бальхи тэргүүнээ өргөн Ала-ад-дин сараалж төмөр дпээр гагцхүү дотуур хувцастайгаа нүцгэн байхы олж хараад чамайш хэн ингэж муугий нь үзэв? Гэсэнд “Нүүдэлчин арабууд ингэв” гэхэд нь “Ай хүү минь ээ , чиний луус, ачааг цугий нь авсан уу. гэвчЭр хүн толгой мэнд гарсан цагтЭд агуурс хумсын харын төдий гэж байдаг юм хүү минь айлтгүй буугаад ир”гэжээ .Тэндээс Махмуд Аль-Бальхгийн луусын унаж Багдад балгадад ирвэл тэр биеийг угаагаад “Ай хүү минь чи алдсан юмаа эргүүлэн олоход хялбар, хэрэв чи миний үгэнд орвол эд мөнгий чинь хоёр дахин их болгож өгнө” гэжээ . Ала-ад-дин угаал хийж гүйцсэнд гоё хувцас өмсгөөд алтан дотортой тасалгаанд оруулж ширээ, засаж сайхан хоол өгөөд махмуд аль-Бальхи хөвгүүнд наалдан гарыг үнэссэнд “Чи одоо бас л намайш мунхруулах гэж байна уу? Би энэ барааг хэрэв худалддагсан бол бусад хүнд алтан зоосоор чамд бол мөнгөн зоосоор өгнө гэсэн биш үү? Гэхэд би чамд энэ луус хувцас хунарыг , мөнгө өгөхдөө гагцхүү тачьянгуйгаан эрхээр өгсөн билээ” гээдХайрлаж дурласан сэьгэлийг Хавьтан ойртохгүйгээр хангадаггүй . Гэж нэгэн мэргэн хүн хэлжээ гэсэнд Ал-ад-дин гарч явахад нохой нь хойноос нь хуцаж хоцорчээ . Харанхуй гудамжаар орж нэг сүмийн үүдэнд тулаад дотогш орж нуугдвал төдөлгүй хоёр боол бамбар барьж хонйоос нь улаан нүүртэй өвгөн бас нэг залуу , хоёр худалдаачин дагах бөгөөд сонсвол залуу нь “Аллах тэнгэрийг бодож нагац ахын охиныг над эргшүүлэн өгөөч!”

гэхэд нв өвгөн “Би чамд оон хэлсэн боловч чи ариун номоос болоод энэ шүү дээ“ гэжэS . Тэгээд өвгөн худалдаачин саран мэт сайхан залуу г гэнэт харж “Амгаланг эрье” гэж мэндлээд Ала-ад-дины хариу мэндэлсэнд “Хүү минь чи хэн гэдэг вэ?” гэхэд нь Би Киар хотноо тэргүүн худалдаачин Шамас-Адит-дины хүү Ала-ад-дин гэдэг байна. Эцэг эхээс тавин боодол ачаа бараа, авч түмэн динар зостой нааш аянд гартад энүүхэн Арслангийн тогоо гэдэг газкар нүүдлийн арабууд дайран дээрэмдэж ачаа, бараа мөнгийг цугий нь авлаа . Тэгээд энэ хотод ирээд хонох газаргүй гайхан яьтлаа энд орж нуугдав гэсэнд “ААй хүү минь би чамд мянган динар зоос, мянган зоосны хувцас , мнган зоосны луус зэргийг зүгээр өгвөл чи яах вэ? ” гэсэнд нь “Яалаа гэж тэр билээ” гэсэнд өвган өгүүлрүүн: “Энэ надтай яваа хүү бол миний дүүгийнх ганц хүү билээ . Би ятгачин Зубейда нэртэй туйлын үзэсгэлэнь ганц охинтой юм . Би охиноо энэ архүүд гэргий болгон өгсөнд энэхүү миний охинд хайртай атал охин үүнийг үзэж чадахгүй юм . Тэгээд энэ хархүү гурвантаа салжээ . Одоо дахин суулгаж өгөөч гэж салахгүй тул би нэг уаа орлогч* хүн олох ухэрэгтэй гэж байгаа юм . Бид өнөөдөр ямар нэгш харийн хүнээр орлогч хийе гэж ярилцсан байсан . Чи нэгэнт харь газрын хүн болох тул одоо хамт явъя . Чи охинтой минь гэрэ хийж , энэ шөнө хоноод маргааш өглөө салбал чинь чамд дээр амалсныг өгье ” гэжээ .Ала-ад-дин Гудамжинд унтаснаас байшинд дотор оро- дээр залуу хүүхэнтэй хонох -ьдээр Гэж бодоод зөьшөөрлөө . шүүхийн түшмэл дээр очиход тэр түшмэл Ала-ад-диныг хараап дурлах сэтгэл өөрийн эрхгүй төрсөн бөгөөд “Ямар хэрэгтэй ирэв?” гэж охины эцгээс асуухад “Би энэ залууг охинтойгоо орлон суулгах гэсэн юм . Сүя бэлэгт нь түмэн динар зо®с авах гэрээ хийгээд хэрэв энэ шөнө миний охинтой хоноод маргааш өрлөө салах юм бол би энүүнд хувцас хунар, мянган динар зоос өгөх хэрэв салахгүй гэвэл энэ над түмэн динар зоос өгөх учиртай ” гэжээ . Өьгөн ингэж гэрээ хийгээд хөвгүүзүнийг хувцаслан дагуулж охины гэрийн үүдэнд хүлээгээд дотогш орж охиндоо өгүүлрүүн: “Би Ала-ад-дин нэртэй нэгэн голшиг залуу суулгах гэрээ хийв. Сайхан байгаарай гээд бичгийг өгч гэртээ харьжээ . Нөгөө дүүгий нь хүү зуучлагч эмгэнд хишиг хүртээдэг тул ийм өгүүлрүүн: “Ай эмгэн эм минь ээ, миний нагацын охин хэрэв энэ голшиг залууг үзэх юм бол дахин надтай суухгүй болно. Тэгэхрээ ямар нэг арга саам хийж энэ шөнө ойртуулахгүй байгаарай” гэжээ . Тэгээд эгэн Ала-ад-дин дээр ирж “АЙ хүү минь , би их Аллах тэнгэрийг нэрлэн чамд нэг юм захъя. Энэ шөнө охинтой хавьталгүй унтвал тустай дээрсэн , миний үгэнд орно биз дээ гэхэд нв “Яагаад тэр билээ?” гэсэнд “Охины бүх бие нь уяман өвчтэй тул чамд халдах бий гэж айна” гэхэд нь “Би түүнтэй ойртохгүй ” гэлээ . Эмгэн охинд очиж энэ үгийг хэлсэнд охин ч “Би хаьтахгүй ” гэлээ . Зубейда шивэгчин нарыJ дуудаж архүүд ширээ засаж хоол өг гсэсэнд Ала-ад-дин тавьсан хоолноос цадтал идээд , бурхны судрын нэг бүлгээс уянгалуулан лалын шашин Давид лугаа туйлын адилхан нээн сайхан уншихыг зубейда сонсоод, энэ залуу уяман өвчтэй гэж эмгэний хэдсэн нь юу билээ . Хэрэв тийм бол хоолой нь яасан ч ингэж гарахгүй . Тэр худал үг гэж бодод Энэтхэг газар хийсэн ятга хөгжмийг авч хөглөн сайхан дуудалахд нь огторгуйд яваа шувуу боловч зогсож чадахгүй сайхан байлаа . Зубейда дуулсан нь: Хав харанхуй нүдэт янзагахан чамд сэтгэлтэй би Харагдах бүрийд чинь удын мөчир боловч атаархана за Өөрий минь голооё , өрөөл нь түүнд хэмээх Өглөгийн таалсандаа хүртээдэг дээрхийн хишиг ажаам. Ала-ад-дин

үүнийг сонсоод хариу дуулсан нь: Саран шиг мандан удын адтл туялзанам Согоо шиг тольдон хүжсийн адил анхилнам Харшил зовлонд зүрх минь дурладаг адилХагацсан цагт л хамт болдогт гайхна. гээд Охин нэнэ үзэсгэлэнтэй хасыг хавчин нахилзан өнгөрөхд хоёул бие биесиыг ширтэн мянгантаа санаа алдан охины харц залуугийн зүрхэнд нэвт шаах тул хөвгүүн ийнхүү шүлэглэсэн нь: Тэнгэрт мандсан сарыг хааад би . Тэр нэгэн шөнө чамтай цуг байснаа сананамТэгэхэдбид хоёр сарыг харахдаа Тэр миний нүдээр, би түүнийхээр харж билээ . гээд охин улам ойртон хоёр алхам үлэхэд хөвгүүн: Хар үсээ гурасалж задл ад тэрээр Харанхуй шөнө дөрөв дэх шөнийг залав. Тэргэл сар руу бүсгүйг ширтэн болгоохуйд Тэнгэрийн саран хоёр болон над харагдав. гэв. Тэгээд охины ойртон тулж ирэхэд Алла-ад-дин “Битгий ойртогтун, чиний өвчин халдана!” гэсэнд хоёр гарыг тэнийлгэ- харуулсан нь цалхн цагаан мөнгөн адил онц үзэмжтэй ажэ . Охин нь бас “Чи над битгий ойрт чиний уяман өвчин над халдана!” гэсэнд хөвгүүн : “Намайг тийм өвчтэй гэж хэн чамд хэлэв?” гэсэнд охин, “Эмгэн хэлэв” гэсэнд хөвгүүн “Над бас эмгэн хэлэв” гэжээ .Хоёул гар ба биеийг ил гагасанд хөвгүүний бие цалин цагаан мөнгөнөөс цагаан байсан тул хоёул яг тэврэлдэн озолдвоос хөвгүүний бэлэг гантайтал босоод ялалтын хаалгаар залж хоёр биеийн халуун янагийн гал ноцож эх эцгийг боловч умартаат ертөнцийн жаргалыг эдлэн эдлэн амрав. Маргааш өгдөө нь Ала-ад-дин босож”жаргал ханасангүй. Түүнийг нэгэн хэрээ шүүрэн аваад нисэн оджээ ” гэсэнд “Энэ чинь юу гэсэн үг вэ?” гэхэд нь “ая, хатан минь ээ , би чамтай ганцхан цаг суух хугацаа үлджээ” гэсэнд “Хэн хэлэв?” гэхэд нь “танай эцэг чиний сүй бэлэгт түмэн динар зоос авна” гэж бичиг үйлдсэн билээ . хэрэв тэр зоосыг олж өгөхгүй бол би өнөөдрийн дотор гянданд орох бөгөөд одоогийн хувьд над тал зоос гаргах бэл алга гэсэнд “Ай ноёнтон минь одоо чи миний эр нөхөр үү, аль өөр хүн үү?” гэхэд нь “Одоо би чиний эр нөхөр мөн” гэж “Ала-ад-дин хариулжээ . Зубейда өгүүлрүүн: “Энэ тун хялбар хэрэг санаа зовох хэрэггү© . Май энэ нэгэн зуун динар зоосыг чи ав. Над өөр зоос алга э Миний эцэг ээз хүүдээ хайртай учир хамаг мөнгийг түүний гарт аваачжээ . Тэр байтугай миний хамаг гоёлыг хураан авчээ . Маргааш чамайг дуудан аваачаад “Салагтун!” гэвэл”Энэ үдэш гэрлээд маргааш өглөө салдаг хаанахын ёс вэ?” гээд шүүхийн түшмэдийн гарыг үнэсэж бэлэг бариад бас гэрчийн хүмүүсийн гарыг үнэсээд арван арван динар зоос бариарай : Тэгвэл тэд цөм чиний талд орно. “Чи яагаад салж , урьд хэлэлцсэн ёсоор мянган динар зоос хувцас тэргүүтнийг авахгүй байна?” гэвэл “Түүний ширхэг үс болгон над мянан динар зоосны үнэтэй юм. Би яасан ч салахгүй , мөнгө , хувцас өөр юу ч авахгүй” гээрэй . Хэрэв тэгвэл “Сүм бэлгийг өг” гэвэл “Одоогоор би их хэцүү байна. Жаахан азнатал арга байна гээрэф . Тэгвэл тэд чинь чамайг хайрлаж хугацаа сунгах болно” гэжээ . Ингэж ярилцаж байтал хаалга дэлдэн тахар зарлага ирээд шүүхийн том түшмэл дээр хадам ээцэг чинь дуудаж байна гэжээ . Ала-ад-дин тэр тахарт таван динар зоос өгөөд “Ай түшмэл ээ, орой нь нийлээд өглөө нь салдаг ёсон хаанахын ёсон бэ?” гэсэнд “манай ноёнд тийм ёсгүй билээ . Хэрэв чи хууль ёс мэдэхгүй бол би тус болно ” гэлээ . Тэндээс шүүхэд очтол шүүхийн түшмэл өгүүлрүүн: “Чи юуны учир тогтсон ёсоор энэ өвгөний охиноос салж хэлцсэн юмаа авахгүй банаа билээ?” гэхэд нь Ала-ад-дин гүйн очиж гарыг үнэсээд тавин динар зоос барьж “ й хамгийг эзэлсэн түшмэл ээ, орой нь нийлээд өглөө нь салдаг ямар сургаал байна?”

гэсэнд албадан салгах ёс манай лал шашинд байхгүй дээгэхэд нь охины эцэг хажуугаас "Тэгвэл чи охины минь инж бэлэгт тавин түмэн динар зоос өгөх боно доо" гэхэд нь Ала-ад-дин , "Гурван хоногийн хугацаа олгоно уу " гэсэнд шүүхийн түмэл гурав хоногийн хугацаа багадана. Арав хоногийн хугацаа тавина биз гэжээ . Ингээд нэг бол арав хоногийн дотор инж ыббэлэг барих, нэг бол салахаар хэлэлцээд тэндээс з зээлийн газар очиж мах, цагаан будаа, хашуин тос тэрүүтэн авч өгдөө хүүхнийд ирээд саян болсон явдлыг цөмийг өгүүлтэл , нэг өдрийн дотор гайхалтай үйл явдал болно шүү гээд. Зовлонгийн түргэн, жаргалын удаан гэжЗолгүй явалд орвол тэвчээртэй бай!Манай насанд амьдралын шөнө жирэмсэлж Маш хачин юм төрөхийг үзэх бий гэжээ . Зубейда босон харайж хоол хийж, хоёулаа суугаад идэж ууж жарган цэнгэж байтал Ала-ад-дин нэг сайхан хөгжим дарж өгөөч гэж хүүхнээс гуйсагд Зубейдаа ятга хөгжим авч дарсанд нь чулун хана туурга боловч баясахаар хөг аялгуу нь "Аяа, хайрт минь ээ!"гэж хэлэх адил байв. Тийнхүү наргиж жарга жарган батал хүн хаалгыг дэлдсэнд "Хэн ирэв, хар!" гэж хүүхэн хэлжээ . Ала-ад-дин очиж хаалгыг нээвээё дөрвөн бадарчин байлаа . "Тануус ямар хрэгтэнй явнам?" гэхэд бадарчингууд "Айа ноёнтон минь , бид харь орны бадарчин улс билээ . Бидэнд яруу ая, ялдам шүлэг хоол болдог юмаа .Танайд амарч хоноод өглөө замаараа явцгаая . Бид хөгжмийн сайхан аянд их дуртай , бас шүлэг мэднэ гэсэнд Ала-ад-дин оруулах эсэхийг хүүхнээс асуухад "оруул" гэжээ . Ала-ад-дин хаалгыг тайлж и " морилон орогтун" гээд хоол унд өгсөнд "Аяа ноёнтон минь, Аллах тэнгэрийг зүрхэндээ саанаж сахан дуу чихээр сонсвол бидний хоол тэр! гээд. Аяа чамтай учрахыг бидний гагц боддог мааньАдгуусанд боловч байдаг онцлогийн нэг мөн билээ . Бид сая ялдам хөгжим сонссон атал ороод ирэхийн цагт дуугүй болдог юун билээ . Саяын хөгжим дардаг хүн чиний шивэгчин буюу хамаатангийн чинь охин уу? гэхэд нь Ала-ад-дин "Энэ бол миний гэргий" гээд уг болсон явдлыг цөмийг яриад "миний хадам эцэг түмэн динар зоосныц инж нэхэж, арав хоногийн хугацаа олгов гэсэнд нэг бадарчин өгүүлрүүн: "Санаа битгий зов. Муу юм бодох хэрэггүй. Би бол дөчиэ бадарчингин ахмад нь юм . Бид тэндээм түмэн динар зоос бадарлаж өгье. ХАрин гэргийгээ сайхан дуу даруулж бидний сэтгэлийг сэргээн соёрхоно уу . Хөгжим гэдэг арим хүнд хоол, зарим хүнд эм билээ" гэжээТэр дөрөв бадарчтн бол Харун-Рашид Халиф, түүний шадар сайд Жафар –аль Бармак,Абу-Новас* цаазны алуурч Масрур нар байжээ . Халифын дотор нь бачимдаад "Ай тэргүүн сайд аа , дотор бачимдаад байна салхинд хотоор явъя" гээд цөм бадарчин дэвшийн хувцас өмсөж явтал, энд сайхан хөгжим дарахыг сонсоо¤ ирсэнб айжээ . Дөрвөн бадарчин шөнөжин наргиж хоноод мөргөлийн хивсэн ширдэг дор зуун динар зоос байна. Бадарчин нар бидэнд мэдэгдэлгүй хивсэн дор хийжээ " гэсэнд Ала-ад-дин авч зээлийн газар очиж мах цагаан будаа, хашин тос тэргүүтнийг авчрав. Маргааш орой нь мөнөөхөн бадарчингууд өгнө гэсэн зосоо авчирч өгсөнгүй . Гуйланчин улс шивдээ гэж гэргийдээ ярьж байтал үүдийг тайлж оруул гэжээ . Ала-ад-дин үүдийг тайлж, бадарчингууд орж ирэхэд "Авчирч өгнө гэсэн мөнгөө авчрав уу? " гэсэнп Аяа, бид олсонгүй. Гэвч битгий эмээгтүн . Хэрэв болохгүй бол Аллах тэнгэрийн өршөөлөөр чамд ид шидээр коос хийж өгнө биз. Харин эхнэрээ хөгжим даруулаач и. Бид хөгжимд нэн дуртай тул сэтгэл сэигэдэг юм гэжээ . Зубейда ятга хөгжмөө авч дарсанд ургаа чулуу боловч хөдлөх шиг

болсон бөагөөд тэд хөхөлдөн наргиж өөр хоорондоо үлгэр түүх ярьж хоноод өглөө болоход ширдэг дор зуун динар зоос хийж , Ала-ад-динтай салах ёс гүйцэтгэж гарч одлоо Шөнө болгон ирж, зуун динар зоос орхисоор найман хоног өнгөрч ес дэх хоногтоо тэр бадарчингууд ирсэнгүй . Юу гэвэл мөнөөхөн халфи нэгэн том худалдаачинд хүн илгээж "Киар хотоос ирдэг бараа тавин боодлыг бэлтгэ. Боодол тус бүр нь мянган динар зоосны үнэтэй босон нь хамаагүй . Бас нэг боол ирүүлээрэй“ гэж зарлиг буулгажээ . худалдаачин захисан завъяа, замын хүнс өгч Киарын тэргүүн худалдаачин Шамас–ад-дины өмнөөс захиа бичиж нөгөө боолд өгүүлрүүн: “За чи энэ тавин хөсөг ачааг аваад тэргүүн худалдаачлдын очоод тАла-ад-дин гэдэг хүн хаана байдгийг сураглаж оч” гэж явуулжээ . Яг энэ нөгөө хуучин сууж байсан хархүү охины эцэг дээр очиж , хүүхнийш Ала-ад-динаас салгаж авахаар хоёул гарлаа . Охины байшингийн тэгд нэг араб тавин луус ачаатай сууж байхыг үзээд “Энэ хэний бараа вэ? ” гэсэнд манай ноён Ала-ад-диных . Эцэг нь ачаа бараа өгч Багдад балгад явуулсанд замд нүүдэлчин арабууд дайрч ачаа бараа мөнгө зоомыг дээрэмдсэн сураг дуулаад эцэг нь дахиад ачаа бараа бэлдэж бас ваадантай , их үнэтэй хувцас, булган дээл , алтан завъяа надаар явуулав гэсэнд лохины эцэг дуу алдан “Тэр чинь миний хүргэн хүү болсон . Би чамд гэрий нь зааж өгье” гэжээ . Энэ үеэс Ала-ад-дин сэтгэл ихэд зовнин сууж байтал, хаалгыг хүн дэлдсэнд “Ай Зубейда минь ээ, энэ лав танай эцэг тахар илгээж гшүүхийн газар дуудаж бөайгаа бололтой” гэсэнд хүүхэн нь гарч хар гэжээ . Ала-ад-дин хаалгбг нээж хараад Зубейдагийн эцэг,и тэргүүн худалдаачин бас нэг нүдэнд дулаахан абиссын боол хоёрб айжээ . мөнөөхөн боол яаран Ала-ад-дины гарыгц нүсээд “Чи ямар хэрэгтэй явнам!” гэсэнд “Би бол Мисир газрын худалдаачин нарын тэргүүн Шамас-ад-дины хөвгүүн мэнгэт Ала-ад-дины зарц боол билээ . Эцэг чинь намайг илгээв ” гээд захиа барьсныг үзвэл. Аяа энд чи хайрт хүүтэй минь уулзаад Өлмий дор сөдөн гутал юугий нь үнэсээрэй Санах сэтгэл, с рвайх гары минь чилээсэн Сайхь хүнтэй чи саадгүй тухтай чриарай . гэжээ .Тэр захианд эцэг Шамас-ад-дин хүү Ала-ад-дины амар мэндийг эрээд: Аяа хүү, минь мэдэгтүн! Чиний авч явсан хүмүүсийг алж эд агуурсыг дээрэмдснийг дуулаад чамд тавин луус ачаа, хувцас , булган дээл, алтан завъяа тэргүүтнийг явуулав. Гай болно гэ битгий эмээгтүн . Хүү минь чамайг аврах мөнгө явуулсан шүү . Эх чинь төрөл садангийн хүмүүс цөм сайн . ХАрин чамайг сайн суугаарай гэж ерөөж буй. Ятгасачин хүүхэнтэй чамайг суух болсон гэж дуулав. инж бэлэгт өгөх тавин т?мэн зоосыг Селим боолоор хамт хүргүүллээ гэжээ . Ала-ад-дин захиаг уншаад ачааг хүлээн авч, хадас эцэгтээ “”Ай эцэг минь ээ, Зубейда охины инж блэгэт таван түмэн динар зоос авагтүн ! Бас энэ ачаа барааг авч наймаал. Ашиг хонжоог та өөрөө ав. Харин үлдсэнг бэл хөрөнгийг над өгнө шүү” гэсэнд “Үгүй би юу ч авахгүй инжийн тухай гэвэл охинтой өөрөө ярь ” гэхэд нь хоёул ачаа барааг дотогш оруулав. Зубейда харж “Аваа энэ хэний ачаа вэ?” гэхэд нь эцэг нь “Энэ чиний эр нөхөр Ала-ад-диных, нүүдэлчин арабуудад дээрэмдүүлсэн юмы нь оронд эцэг нь таван түмэн динар зоос , ваадын хувцас , булган дээл , луус , алтан завъяа явуулжээ. Инж бэлэгт юу авахаа чи өөрөө мэд” гэжээ . Ала-ад-дин авлрыг нээж Зубедад инжийг өгөхөд нөгөө хуучин хар хүн хөвгүүн , ай эцэг минь ээ, миний хүүхнийг Ала-ад-динаас салгаж өгнө үү гэсэнд “Тэр нэгэнт сүйы бэлэгт эр нь болох тул ямар ч аргагүй ” гэжээ . Тэгэхээр

нь мөнөөхөн хуучин хархүү нь ихэлд гутарч өвчлөн хэвтсээр нас баржээ . Ала-ад-дин зээлийн газар очиж уртай зууш худалдан авч йнайрлав Үдэш болохо “нөгөө худалч бадарчин нарыг харав уу . Өгнө гэснээ авчирсангүй” гэж Ала-ад-дин өгүүлтэл “Чи тэргүүн зэргийн худалдаачны хүү атал мөнгөгүй ядаж байсан шүү . тэр хэдэн бадарчин аргагүй биз дээ? ””Үнэн , тэгэвч биднийг Аллах тэтгэн зовлонгоос гэтэлшэжээ . Одоо тэднийг ирвэл хаалгыг нээж өгөхгүй” гэхэд нь “Тэдний ирж байсны ачаар бидэнд золтой явдал тохиолсон шүү. Тэд наад зах нь манай ширдэг доогуур зуун динар зоос хийж байсан даа . Тэднийг ирвэл нь бид зээвэл хаалгыг тайлж өгөх ёстой , гэжээ .Үдэш болж, дэн барихын алдад Ала-ад-дин “Ай Збуейда минь ээ , сайхан хөгжим дарж өгөөч” гэтэл хаалгыг хүн дэлдэж талж өгвөөс мөнөөхөн хэдэн бадарчин дэрвиш байжээ . Ала-ад-дин , “Аяа худалч бадарчингууд морилон орогтун!” гэж сайхан хоол унд тавьж өгсөнд тэд наргин байтал ийн өгүүлрүүн: “Ай ноёнтон минь ээ, чамайг яаж байгаа бол гэж бидний сэтгэл ихэд зовнин байлаа” гэхэд нь “Аллах тэнгэр бидний хүслийг ёсоор болгов” гэж Ала-ад-дин өгүүлэв. Бадарчингууд өгүүлрүүн: “Бид нар чиний төлө хичнээн эмээвч мөнгө олдсонгүй” гэхэд нь “Миний эцэг таван тзмэн динар зоос тавин луус ачаа, алтан завъяа явуулжээ . хадам эцэг бид хоёр эвлэрч хүүхэн минийх босон доо”” Гэж Ала-ад-дин өгүүлэв. Мөнөөхөн Халиф гадаалахаар гарахад шадар сайд Жафар Ала-ад-динлд бөхийж “үнэн шашинтны их хүн байхад битгий томоогүй аашлаад бай” гэсэнд “Би яагаа вэ? Та нарын хэн тань тйинхүү үнэн шашинтны их хүн юм бэ? ” гэхэд Жафар өгүүлрүүн: “Саяын чамтай ярилцаж байгаа гардаг бол их Харун-Рашид Халиф Ўи бол шадар сайд Жафар , энэ бол цаазын масрур , энэ Абу-новас гэдэг улс байна. Ала-ад-дин чи бодоод үз. Киараас Багдад хичнээн хоножирэх вэ” гэхэд нь Ала-ад-дин “Дөчин таван хоног болно” гэсэнд “Тэгвэл чи ачаа бараага алдаад дөнгөж арав хоногийн байхад хэдийдээ чиний эцэг дуулж хэдийдээ өдий олон луус ачаа бараа явуулах билээ? ” гэхэд нь “Тэгвэл ноёнтон минь энэ юм хаанаас ирэв” гэсэнд “Үнэн шашинтны их хүн Халиф чамд хайртайн учир илгээв” гэж Жафар хэлжээ . Ийнхүү ярилцаж байтал Халиф орж ирэхэд Ала-ад-дин босон харайж өмнө нь сөгпөн мөргөж “Ай үнэн шашинтны их хүн таныг Аллах тэнгэр өршөөх болтугай?” гэсэнд Халиф “Ала-“ад-дин минь ээ, чиний үйлс бүтсэний учир Зубейдаар сайхан хөгжим даруулж соёрх” гэжээ . Зубейда ятга авч дарсанд чулуун хана туурга боловч баярлан мишээж , ятгын яруу аялгуу “аяа , хайрт минь !” гэж дуугарч байжээ . Маргааш өгдөө нь Халиф Ала-ад-дин “маргаашү ихсийн хуралд очоорой!” гэхэд нь “Аяа үнэн шашинтны их хүн к зраилгийг ёсоор дагая . Их Аллах чамд эрүүл энхийг соёрхох болтугай!” гээд маргааш нј арван их царанд бэлэг хийж очвоос Халиф хаан ширээнээ злран суухыг үзээд Ала-ад-дин Атаатан чамд хичнээн хорсох атугай Ажил чинь ямагт бүтэх болтугай!Дайсны хувьд өдөр болгон бараан Таны хувьд өдөр болгон гэгээн байг!Гэсэнд Халиф “Ай Ала-ад-дин тавтай морилогтун!” гэхэд нь авчирсан бэлгээ бариваас аваад хүндэтгэлийн хувцас өмсгөөд бүх худалдаачин нарын тэргүүн болгож , хуралд суулгатал Зубейдагийн эцэг орж ирээд ,”Аяа цагийг эзэлсэн их хаан минь энэ залуу юуны учир миний суудалд суув?” гэхэд нь “Би үүнийгхудалдаачидын тэргүүн болгов хааны алба халаатай гэж чамайг огцруулав. ” гэхэд нь “Бидэнд сайн хээрг болжээ . Бидний дотроос аль сайныг тэргүүн болгоюоос бидний үйля бүтэмжтэй байх билээ . Хичнээн хүн

багаасаа аугаа их хүн болов даа" гжэээ . Тэгээд халиф Ала-ад-дин бичиг шийтгэн олгож түшмэл гаргаж өгсөнд тэр түшмэл бамбар баричг гаргаж , тэр "Мэнгэт Ала-ад-динаас өөр тэргүүн байхгүй . Түүний хэлснийгш үг дуугүй дагаж хүндлэн өргөмжлөгтүн!" гэж хуралд залан тунхаглав. Хурав тармагц нэгэн карлан тунхаглагч хүн Ала-ад-дины өмнө явж "мэнгэт Ала-ад-динаас өөр тэргүүн байхгүй. Түүний хэлснийг үг дуугүй дагаж хүндлэн ө өргөмжлөгтүн!" гэж хуралд зарлан тунхаглав. Хурал тармагц нэгэн зарлан тунахаглагч хүн Ала-ад-дины өмнө явж "Мэнгэт Ала-ад-динаас өөр тэргүүн үгүй!" гэж бүх Багдад балгадаар зарлан тунхаглав. Ала-ад-дин маргааш өглөө нь нэг дэлгүүр гаргаж мөнөөхөн боолыг суулгав. Өөрөө өдөр болгон морь унаж яам хуралд суудаг боллоо . Нэгэн өдөр яам хуралд сууж байтал нэг хүн орж ирээд Халифт сөгдөн "Аяа, үнэн шашинтны их хн минь , танай хамт зоог барьдаг хүн Аллахын таалаар нас баржээ ." гэсэнд Халиф Ала-ад-дин хаана байна? гэж дуудаад дээд ёслолын хувцас өмсгөж , сард мянган динар зоосны пүнлүү өгч байх зкарлиг буулгаж өөрийн хамт сууж зоог барьдаг хүн болгожээ . Бас нэг өдөр зарц ирж‌ Халифт өгүүлрүүн: "Аяа, үнэн шашинтны их хүн минь, таны жаран цэргийн дарга өнөөдөр нас барав" гэсэнд Халицт Ала-ад-дин ямбын хувцас өмсгөж жаран цэргийн дарга болгов. Халиф алчуурыг гаргаж сэгсрэн дохисноор яам хүрэл тарах болж Алаад-дин гарвал түүний дөрөөний дэргэд Халифын баруун жигүүрийн дарга Ахмед ад-Данаф дагуул дөчин эрийн хамт нөгөө талд нь Халифын зүүн жигүүрийн дарга Хасан Шуман дагуул дөчин эрийн хамт ёслон зогсож байжээ . Ала-ад-дин Хасан Шуман, түүний дагуул эрчүүдэд өгүүлрүүн: "Тануус Ахмед-ад-Данафыг гуйж үзээч. Намайг ачлахын ивгээлээр үрчлэн авч магад" гэжээ . Ахмед-ад-Данаф, дуртайя зөвшөөрч , Би дөчин дагултайгаа өдөр болгон ёчиний өмнө очиж амь сахина Гэжээ . Ала-ад-дин Халифын албанаа зүтэж хэд хоног нэг үдэш хурал тараад Ахмед-ад-Данаф, түүний нөхийг явуулж гэртээ хариад байтал орой болжээ . Зубейда хүүхэн гэгээ бариад шээхээр гар±ны дараа , гадаа хүн муухай чарлах дуу гасранд Ала-ад-дин гүйн гарваас ягасчин Зубейда хөсөр унасанд очиж үзвэл үхсэн байжээ . Зубейда хүүхний эцэг ойрхон суудаг тул хүн орилохыг дуулаад гүйн гарч "Аяа, Ала-ад-дин минь , юу болов?" гэхэд нь "Аяа эцэг минь , юу болов?" гэхэд нь "Аяа эцэг минь та охиноосоо хоцрох учирта© ажээ. Зубейда хүүхэн үхжээ" гэжээ . маргааш өглөө Зубейдаг газарт булж , эцэг хүү хоёр бие биенээ тайтгаруулав. Ала-ад-ин бэлбэсрэлийн хувцас өмсөж , яам хуралд очсонгүй , уйлан гашуудан суутал Халиф учрыг сураглавал , шадар сайд нь өгүүлрүүн: Зубейдын хойноос уй гашуу болон сүйд болжээ гэсэнд "Ай зайлул бид цугаар очиж эмгэнэхээс дээ" гэжээ Халиц шадар сайдаа , бас хэдэн зардсан авч Ала-ад-динийд очлоо .

Ала-ад-дин харад тосон очиж газар хүртэл мэхийн мөргөсөнд ХАлиф хаан Ала-ад-дин хоёр харилцан Аллах мөнгөрйг дурдан мэндэлсэнп Халиф, Чи юуны учир яам хуралд үл очном? Гэхэд миний эхнэр Зубейдаа нас барж намайг уй гашууд унагавгэхэд нь чиний эхнэр Аллах тэнгэрийн тааллаар нас баржээ . Гашуудах нь нэмэр болхгүй гэсэнд би шхэж газарт хамт булагдсан цагт сая уй гашуунаа ангижрана гэхэд халиф өгүүлрүүн: Хамаг амьтныг гагцхүү Аллах тэнгэр мэдэх тул арга , заль алт мөнгөөр үхлийг тайтгаруулах учир байхгүй гээд Эхнэр болж төрөөд их жаргаыг эхлэвч Эцэст хэзээд бөгтгөр дамнуурганд хэвтэх болногэсэн

байдаг гэжээ •алифын иймнхүү Ала-ад-дин тайlгаруулаад , яам хуралд очиж байсугай гээд явлаа . Ала-ад-дин ч маргааш нь морийг унаж яам хуралд чуулахаар очиж Халифын өлми йдор мөргөвөөс Халиф тавтай морилогтун! гээд чи өнөө орой манайд айлчлаарай гэжээ :. Тэндээс их орондоо дагуулан очоод Кут-аль-Кулуб нэртэй нэг шивэгчин дуудаж: Энэ Ала-ад-динд Зубейда нэртэй сайхан хүүхэн байсан эь орхин одоод энэ залууг их уй гашуудалд унагажээ . тэр хүүхэн бурхны таалаар нас эцэслэв. Чи оронд нь ятга хөгжимд хүний уй гашуу арилнам сайхан дуу дарж өг гэжээ . Шивэгчин гайхамшигтай сайхан хөгжимдөхөд Халиф “За ямархан хоолойтой бүсгүй байна даа?” гээд, “Хоолой нь Зубейдын хоолойнд хүрэхгүй атал, ятга хөгжим тун уран дарах тул чулуун туурга боловч баярлах мэт болном гэхэд нь “Энэ бүсгүй чиний сэтгэлд таалагдаж байна уу?” гэж ХАлифц асуужээ . “Ай үнэн шашаинтны их хүн, таалагдаж байна гэсэнд би чамд энэ бүсгүйг шивэгчиэн аягачны хамт өөрийн толгой, эцэг дээдийн булшийг ам алдан бэлэг барьсугай”гэжээ . Ала-ад-дин анхандаа тоглоом хийж байна гэж болтл Халиф Кут-аль-Кулуб дээр очиж “Би чамайг Ала-ад-дин бэлэглэв” гэсэнд цаадахи нь хөвгүүнийг үзээд дурлаж байсан тул ххэд барлажээ. Халиф хаан ордноос яам хуралдаа очоод үүрэгч нарыг дуудаж: Кут-аль”Кулубийг шивэгчин нарбн жуузанд суулгаж Ала-ад-динд аваачиж өг гээд өөрөө хэрэг ялгах өргөөнд сууж орой болсон хойно сая тарж харьжээ . Кут-аль-Кулуб эд агуурё , дөчин шивэгчний хамт Алал-ад-диний өргөөнд ирээд хоёр тайганд “Та хоёр ордны хааганы баруун зүүн хоёр хатавчинд зогсо¦ Ала-ад-диныг ирэхэд гары нь үнэсээд , “Хатан Кут-аль-Кулуб таныг урьж байна. Халиф түүнийг шивэгчин нарын хамт танд бэлэглэжээ” гэж хэлээрэй гэжээ . Ала-ад-дин өргөөнөө иртэл Халифын хоёр тайган байхыг хараад “Энэ миний өргөө мөн үүе Өөр ямар газар байдаг билээ ? гэж гайхаад хоёр тайган гары нь үнэсээд “Бид хоёр Кут-аль-Кулуийн зарц нар билээ . ХАтагтай таны амгаланг айлтгаж урьж байна” гэхэд нь “Та өөрөө тавтай морилогтун ” гэж хэл , би очихгүй яагаад гэвэл ноёдын юм харцынд зохихгүйгэж хүүхэнд очиж хэл. Харин Халифтай байхад өдөрт хичнээн зоос зардаг байсан бэ? гэж асугаарай гэж, хоёр тайган явж асуугаад “Өдөрт зуун динар коос хэрэглэж байсан гэхэд нь Ала-ад-дин : “Халиф надад Кут-ал-Кулубыг бэлэг болгож , би өдөр зуун динар зоос зарж байх ямар хэрэг байына даа , гэвч яая гэхэв дээ” гэж бодоод , өдөрт болгон зуун динар зоос өгч хэд хоног болов. Нэг өдөр Ала-ад-дин яамлах хуралд очсонгүйд Халиф , “Шадар сайд аа, би Ала-ад-дины сэтгэлийг тайтгаруулах гэж Кут-аль-Кулуб өгсөн билээ . тэр яагаад ирэхгүй байна? ” гэхэд нь “Сэтгэлтэй хнтэйгээ уичирсан хүн нөхрөө мөртдөг ” гэдэг их үнэн үг шүү гэсэнд “Ирэхгүй байгаа нь учир шалтгаантай байж мэднэ. Юу боловч очиж үзье” гэжээ. Үүнээс хэд хоногийн өмнө Ала-ад-дин “Би ятгасан Зубейдагийн бодохоос уйтгарланам гэж Халифт хэлсэнд Кут-аль-Кулубийг над бэлэг болгон өгсөн юмаа” гэж Халифын шадар сайд ярихад “Халиф чамд даанч хайрта тул бэлэглэжээ . Чи тэгээд хавьтаж байна уу? ” гэхэд нв үгүй гээд “яагаад тэр билээ?” гэхэд нь “Ноёдын юм харцад зохихгүй шүү дээ” гэж Ала-ад-дин хэлсэнб айжээ . Тэгээд одоо Халиф, Жафар хоёрыг ирэхийг Ала-ад-дин үзээд босон очиж гарыг үнэсэхэд Ала-ад-дины царай нь мөнөөхөн уйтгартай хэвээрб ай тул "Ай , Ала-ад-дин чи юуны уяир иймнхүү уйтгартай байна?Кут-аль-Кулубтэй одоо хүртэл хавьтаагүй байна уу? " гэхэд нь “Аяа , үнэн шашинтны их хүн минь, ноёдын юм

харцад таарахгүй юм . Би энэ талаар хвьтах нь байтугай урт өргөн хоёрыг ялгаж чадаагүй байна. Намайг ангижруулж соёрхоно уу" гэсэнд Халиф би Кут-аль-Кулубтэй өөрөө уулзъя гээд хүүхэн дээр оров . Кут-аль-Кулуб газар үнэсэв. "Ала-ад-дин чамтай хавьтаагүй юу?" гэсэнд "Үгүй, би цурьсан боловч ирээгүй" гэжээ . Халиф хүүхнийг ордондоо буц гэж Ала-ад-диныг "Биднээс битгий хөндийрөгтүн " гэжээ . Маргааш нь Ала-ад-дин, Халифын яамхуралд очиж жаран цэргийн даргын суудалдаа хэвээр суужээ . Харин Халиф тэ өдөр шадар сайд Жафарыг дуудан түмэн динао зоос гаргаж өгүүлрүүн: Энэ түмэн зоосыг авч зээлийн газар очиж Ала-ад-дин дор нэгэн шивэгчин дагуулан шивэгчдийг худалдаалах газар очив. Тэр өдөр ба Багдадын хэрэг ялгагч түшмэл эмир ноён Халид гэг хүүдээ шивэгчин эм худалдан авахаар зээлийн газар очижжээ . Түүний эххнэр Хатун нэг хүү төрүүлсэн нь туйлын царай муутай бөгөөд Хабазлам Базаз нэртэй билээ . хорин нас хүрэхэд морь унаж чадахгүй дорой байхад эцэг нь далайд морьтой орж шөнө тулалддаг их зоригтой хүн байжээ . Нэг өшөн Базаза унтан зүүдлээд эхдээ ярьсанд эх нь баярлаж эцэгтээ өгүүлрүүн: "Хүү гэрлэх нас болжээ, гэрлүүлье гэсэнд "Энэ хөвгүүн зэрлэг хүн шиг царай муутай хулмастай учир нэг хүүхэн тоохгүй гэсэнд "Тэгвэл шивэгчин худалдан авч өгте " гэжээ . Тэр өдөр Халифын шадар сайд , Ала-ад-дин зээлийн газар очиход Эмир ноён бас хүүгээ дагуулан очсон бөгөөд яг энэ үес нэгэн гоц хөөрхөн, гоолиг шивэгчин харагдсанд шада сайд "Энэ шидэгчинг мянган динар зоосоор авъяТэр зуучлагч хүүхнийг дагуулан эмир ноёны дэргэдүүр өнгөрөхөд Хабазлам Базаза хараа мянгантаа санаа алдаад сэтлэг нь нэгмөсөн татагдан "Ай Аваа энэ шивэгчнийг надад авч аль" гэжээ . Эмир ноён "Энэ хүүхний нэр хэнб э?" гэсэнд "Миний нэр Ясмин " гэж хүүхэн хариулжээ . "Энэ ямар үнэтэй бэ?" гэхэд "Мянган динар зоос " гэсэнд Эмир ноён мянга нэгэн динар зоос гээд Ала-ад-диныг үнэ хаялцуулахр ээлж болоход хоёр мянган динар зоос өгчээ . хэрэг ялгах түшмэлийн хүү нэг нэг динараараа үнэ нэмэхэд Ала-ад-дин ямнга мянгаaар нэмэх тул Базаза уурсан, хэн ийнхүү миний эсрэг үнэ нэмнэм гэсэнд "Халифын шадар сайд Жафар, мэнгэт Ала-ад-динд авч өгөх гэж бана" гэлцэв. Ала-ад-дин түмэн динар зоосоор авъя гэсэнд зуучлагч аргагүй өгсөнд Ала-ад-дин шивэгчинд "Их Аллах тэнгэрийн өршөөлөөр чамайг би эрх чөлөөт хүн болгоё" хэмээн өгүүлээд ургийн барилдлага хийж гэртээ аваачив. Зуучлагчийн мөнгөө аваад ирэхэд зарга ялгах түшмэлийн хүү "мөнөөхөн шивэгчин яасан бэ?" гэж асууна. "Ала-ад-дин түмэн динар зоосоор аваад эрх чөлөөтэй болгоод ураг барилдав" гэсэхд тэр залуу ьуйлын их гуниг уйтгарлаж , тэрнээсээ болоод өвчин тусч унтах нойр , идэх хоолнос гарчээ . Эх нь үзээд , "Ай хүү минь чи яагаад өвдөв?" гэсэнд "Аяа ээж минь ээ над Ясмин авч аль! гэхэд нь "Цэцэг худалдах хүн дайралдвал чамд сагс дүүрэн мэлрэг авч өгөмз" гэлээ . "Үгүй тийм мэлрэг цэцэг биш , Ясмин нэртэй шивэгчин хүүхэн байсныг аав эс авлаа" гэсэнд хүүгийн эцэг Эмир ноён халидаас : Чи тэр шивэгчин эийг юунд эс авав гэсэнд "Ноёдын юм харцад зохиџгүй . Түүнийг жаран цэргийн дарга Ала-ад-дин авав" гэжээ . Мөнөөхөн хөвгүүний илаарь болохгүй бүр дордоод унтах нойр, идэхр хоолноос бүр хагацсанд эх нь их сэтгэл нэн зовох болов.Нэгэн өдөр хүүгийн төлөө гайхаш тасран сууж байтал "Хулгайч Ахмед Камакамийн эх" нэртэй нэгэн эмгэн орж иржээ . Энэ эмгэний хүү байшингийн туурга цоолж, байшингийн туурга өөд авирч гараад хүний нүднээс юм хулгай хийж чаддаг суу зантай агаад

харуулын дарга хийж байгад юм хулгайлж зарга яллагч түшмэлд баригдаж Халифт хүргэгдсэн байжээ . Халиф цаазаар хороох зарлиг буулгасанд Ахмед Халифын шадар сайдад гүйж очсонд шадар сайд өмгөөлсөн ажээ чи Халифт Хүмүүст хор хийдэг энэ хөөрхий амьтныг чи юуны учир өмрөөнө гэсэнд “ай үнэн шашинтны их хүн минь ээ, та түүнийг гянданд хийж орхи. Гяндан бол амьд хүнд авс, дайсан этгээдэд баяр учраас их ухаантай хүн гянданг гаргажээ . ” гэхэд нь Халиф Ахмедийг гинжлэн , гинжин дээр нь “Насны турш ярганы ширээнэс хадаж орхв” гэж бичээд гяндад хий гэж зарлиг буулган байжээ . Тэр эмгэн эмир ноён Халидынд очдог байсан ба гянданд буй хүү дээрээ очиж “Чи ингэж хоригдохоос гараасай” гэхэд нь “Аллах тэнгэр хүртэл ингэж хэлнэ. Ээж минь та эмир ноён Халидын гэргийд очиж гуйхгүй юу” гэсэн байжээ. Эмгэнийг орж ирэхэд зарга ялгагч түшмэдийн гэргий маш уйтгар гунигтай байхыг хараа¤ “Чи юуны учир гуниглав?” гэсэнд “Миний хүү Хабазлам Базаза үхэх гэж байнаа” гэхэд нь “ Яагаав” гэж асуусанд мөнөөхөн гэргий уг болсон явдлыг нэгд нэггүй эмгэнд ярьжээ . эмгэн дуулаад “Хүүгий чинь аварвал чи яахав?” гээд “Над хулгайч Ахмед Камакин нэртэй, нэгэн хүү бий билээ . Одоогоор үүрд хадав гэсэн гинжтэй гяндангаа сууж байгаа. Тэгэхлээр чи хамгийн гоё хувцасаа өмсөөд хамаг гоёлоо зүүгээд туйлын ялдам зангаар энэ орой эр нөхрөө угтагтун. Эр нөхөр чинь чиний сайныг хараад дур хүсэл нь хөдөлэ чамтай унтах гээл түүний хүслийг хангахын өмнө ингэж хэлэгтү “Ай Аллах минь, юм юутай хачин юм бэ? Эр хүн эмийг хүсвэл , хүслийг даруй хангаж чадна. Харин эмийн гуйсныг эр хүн хангах нь ер үгүй ” гэхэд чинь чи юу хүснэм?” гэж асуух бий. Тэгэхлээр нь чи өмнөө сөгдүүлж , хэрэв миний гуйсныг эс биелүүлбэл сална гэдэг ам өчиг авагтүн. Тийм ам аваад : “Чиний гянданд Ахмед Камакин гэдэг хүн бий . Эх нь ирж газар мөргөн “Чамайг халифцт гуйж, хүүгий минь гаргуулж өгөөч гэж гуйв гээрэй” гэжээ . Шөнө орой зарга ялгагч түшмэл эхнэртээ орвол эмгэний захиснаар үйлдэж ам авсны дара ссая жарган жарган хонов. Карга ялгагч маргааш өгдөө нь угаал хийж мөргөлийн үйлдээд гяндаднд очиж: Ай хулдгайч Ахмед чи одоо гэмшин хашрав уу? т гэсэнд “Би Аллах тэнгэрийн өмнө залхаагдав. Аллахын өршөөлийг үнэн сэтгэлээс хүснэм” гэхэд нь гянадангаас гарган Халифын яам хураолд дагуулан орж газар үнэссэнд Халиф “Ай эмир ноён халид чи юу хүснэм?” гэхэд Халид Ахмедийг хөтлөн оруулбал Халиф үзээд “Ай, Камакин чи одоо хүртэл амьд байгаа юм уу ” гэсэнд Ахмед “зовлонтын насан барагддаггүй гэдэг билээ . ” гэв. Халиф зарга ялгагч түшмэлд хандаж : Аяа эмир ноён чи үүнийг юуны учир авчрав?” гэсэнд “Ай үүнэн шашантны их хаан минь ээ, энэ хүүд хөөрхий ядуу ганц бие эмгэн бий . тэр хүн чиний болын өмнө газар мөргөн , хүүгий миьн гинжнээс салгаж өгнө үү гэж гуйж өгөөч гэсэн юм аа. Энэ хөвгүүн ч одоо залхлаа гэх тул та өршөөн соёрхож , урьдын адил харуулбн дарга болгож хайрла!” гэсэнд Халиф Ахмедад хандаж, “Чи одоо хашрав уу? ” гэсэд Ха “Би Аллахын өмнө залхлаа ” гэхэд нь дархныг дуудаж Ахмедын гинжийг авагтун гэж зарлиг буулгав. Тэгээд Халиф дахин битгий хэрэг төвөг гарга гэж Ахмедад тушаагаад харуулын дарга болгосонд Ахмед халифын гарыг үнэсээд харуулыбн даргын хувцас өмсөж тэндээс гарахад зарлагч хүмүүс түүнийг харуулахын дарга болов гэж хашгиран зарлав. Хэд хоноод эх нь зарга ялгагчийнд иртэл гэргий нь “Аллах тэнгэрийн авралаар хүү чинь гяндангаас мэнд гарсан билээ . Ясминыг миний хүүд авчирч өгөх талаар арга бод гэж түүнд одоо

хүртэл юунд эс хэлнэм?” гэхэд нь Эмгэн би “Одоо хэлье” гээд хүү дээрээ ирээд гагцхүү карга ялгагчийн гэргийн хүчээр чмайг гяндангаас гаргасан билээ . Одоо чи оронд нь мэнгэт Ала-ад-диныг алж, шивэгчин Ясминыг Хабазлам Базазад аваачиж өгөх болж дээ гэхэд нь “Энэ бол туйлын амархан . Би энэ орой явж гйцэтгэе ” гэж Ахмед хэлжээ . Энэ шөнө шинийн нэгний шөнө тул Халиф шивэгчин юмуу боол зардас хүнийг чөлөөлж Зубейда* хатантай унтдагш бөгөөд хаан хуюцсаа тайлж, чичлүүр хутга эрих бөгж , тэргүүтнийг цөмийг зочдын өсрөөний залардаг ширээнээ тавьж орхидог заншилтай байжээ . Халифт бас алтан гинжтэй эрдэнийн чулуу шигтгээтэй , зулын алтан хоргтой , түүндээ их хайртай ажээ . Түүнийг бусад бүх юмтайгаа тайгнаар мануулаад Зубейда хатан дээрээ очсон байжээ Хулгайч Ахмед Камаким шөнө дөл болохыг хүлээж, мичид марал гарахын цагт амьтан хүн тагунтсан үеэр баруун гартаа илд барьж нөгөөгартаа төмөө дэгээтэй олсон шат авч Халифын зочны өрөөнд гэтэж օрод олсон шатаар туургыг давж ороод унтаж байгаа тайганыг согтууруулан ухаан алдуулаад Халифын эрхи, хутга, алчуур, бөгж , чулуун шигтгээтэй хорго тэргүүтнийг авч орсон газраар, гарч Ала-ад-диныг руу явлаа . Энэ шөнө мэнгэт Ала-ад-дин мөнөөхөн хүүхэнтэй хурим хийгэд дараа нь жирэмсэн болгосон байжээ . Ахмед Замаким Ала-ад-дины өрөөнд орж гантиш чулуун шалыг ховхлон нүх малтаад Халифын эд вмны заримыг хийж орхиод гантиг чулууг хэвээр бүрхэж орсон газраар гарч “Энэ сайхан дэнгийн хоргыг өмнө тавьж гэрэлд сайхан цай ууна даа” гэж бодсоор харьжээ . Маргааш өглөө нь халиф зочны өрөөнд орвол тайган нь с®гтууран унтасныг сэрээсэн атал хувцас, эрхи , ыбөгж, хутга, алчуур, дэнлүү, цөм алга болсон байхад Халиф маш их хилэгнэн , хилэнгийн улаан хувцас өмсөж, яамлах хуралд очсонд шадар сайд нь ирж өлмийн дор газар үнэсэж, “Үнэн шашинтнй их хаан таны хилэнг Аллах сарниах болтугай!” гэсэнд “Би их ууртай байна” гээд юу болсоэн учрыг асуувал халиф цөмийг дурдан ярьжээ . Гэтэл карга ялгагч түшмэл иржь, дэргэд нь Ахмед бас байв.Халиф их ууртай Багдад балгадыг байдал тайван ууу? Гэхэд нв цөм амгалан таван гэсэнд “Худлаа!” гээд “Яагаад тэр билээ?” гэхэд нь уг болсон явдлыг яриад “Тэр бүгдийг олж ир!” гэжээ “Аяа үнэн шашинтны их хаан цуугд орсон өт гарч чадахгүй гэдэг Лав гаднаас хүн ороогүй нь лав биз ээ” гэж Халидын хэлэхэд Халиф Миний эд юмыг олж ирэхгүй бол толгойгий чинь авна гэсэнд Хамид “Энэ Ахмед Камаким хулгайч, луйварчин улсыг андахгүй тул, хэрэь олохгүй бол надаас урьдаар үүний толгойг аваарай” гэлээ . Ахмед босож “Хэн хулгайлсаныг олохыг би хариуцна. Ул мөрийг заавал олно. Харин над хоёр шүүгч, хоёр гэрч гаргаж өгнө үү. Тэр авсан хүн хэнээс айхыг өнгөрсөн хэрэг. ” гэхэд нь “Чиний хүссэнийг ёсоор болгоно. Харин эхлээд миний ордонд дараа нь шадар сайдын ордонд , дараа нь жаран цэргийн даргын ордонд нэгэжээрээй” гэсэнд “Аяа үнэнё шашинт-ы их хаан таны зөву. Тэр авсан хүн их хааны ордонд ирээд хүний зэрэгт хрсэн юм ууу , амь сахиулын хэн наг ч байж магадгүй” гэж Ахмед хэллээ . Халиф “Тэр эд юмыг авсан хүний миний хүүч байсан хамаагүй заавал ална гэж Аллахын нэрийг барьж ам алдъя” гэжээ . тэгээд Ахмед Камакин айлд орж нэгжих эрхийн бичиг шийтгүүлэн дөрвөн хүний хат гарлаа . Ахмед Камаким , гурваныб нэг нь төмөр таяг барьж эхлээд, Халифын ордныг дара нь шадар сайд Жафарын ордныг нэжгээд Ала-ад-диныд очихоор явлаа . Ала-ад-дины хүний хөлий чимээ сонсож, тосон гарч

хаалгыг нээтэл зарга ялгагёч их л ууртай ажээ . “Аяа , эмир ноён Халид ямар хэрэгээр ирэв?” гэсэнд Халид үг болсон яввдлыг яриад Ала-ад-дин “Миний гэрт орж нэгжин үзэгтүн” гэхэд нь “Өршөөгөөрэй ноёнтон минь , чи нэгэнт үнэнч хүн тул тийм муухай юм үйлдэх ёсгүй биззээ” гэсэнд “Үгүй , заавал нэгжин үзэгтүн” гэжөээ . ЗКарга ялгагч түшмэл шүүгч, хоёр гэрчийн хамт орж нэгжих зуур Ахмед Камаким мөнөөхөн нүх малтаж юм нуусан газар зориуд таягийг алсанд чулуун шал няц үсэрч дор юм гялтагнахад “Аяа Аллах тэнгэрийн авралаар яг бидний ирэхээр энд их өв хөрөнгө нээгдэв” гэж дуу алав, юу байна орж үзье гэлээ . Шүүгч гэрч нар үзээд Халифын алсдан эд юмсыг эндээс цугий нь олж, данлаад тамга дарж хавсаргав. Ала-ад-диныг бартж аьаад хэргэмийн малгайг мултлан авсанд Ахмед Камаким шиюэгчин Ясминыг шүүрэн барьж “Зарга ялгагчийн эхнэр хатунд ваачиж өг” гэж эх эмгэнд өгчээ . Эмгэн Ясмины хүүхнийг тэднийд авчирсанд Хабазлам Базаза үзээд даруй бие илээрь болж ихэд баярлан хүүхэнд ойртох гэсэнд Ясмин бүсний цаанаас хутга сугалан “Зайл!” Эсвэл чамайг , эсвэл өөрийгөө ална гэсэнд Хатун эх “Садар эм чи миний хүүгийн хүслийг хангагтун!” гэхэд нв”Ай өлөгчин чи ямар ёсонд нэг эм хоёр эртэй байх билээ?. Арслангийн байранд нохой оруулж болох уу?” гэжээ .Нөгөө залуу сэтгэл ихэд хөлөснөөс бие цулам муудаж хэвтэрт орохд эх нь Ясминд өгүүлрүүн: “Ай садар самуун эм чи, намайг юунд ийнхүү утгарт оруулнам? Чамайг үргэлж тамлан зовоож Ала-ад-диныг заавал дүүжлүүлнэ дээ ” гэж занахад “Би үхэвч түүнд хайртай хэвээр үхнэ ” гэжээ . Базазын эх Ясминаас торгон дээлийг тайлж , эрдэнэ чимгийг мулталж аваад зотон өмд , таран цамц өмсгөж аягачин зарцаа болгоод “Чамайг түлээ хагалуулж , ногоо арилгуулц , гал түлүүлж зовооно доо” гэхэд нь “Би ямар хатуу ажил хийж зовсон ч гагцхүү чиний хүүг нэг нүдээр харахгүй” гэжээ .нөгөө Ала-ад-диныг Халифын алдсан юмны хамт Яамлдах хуралд хүргэж ирэхэд Халиф хаан ширээнээ залран байтал гэнэт хараад “Миний юм хаанаас гарав?” гэхэд нь “Энэ мэнгэт Ала-ад-диний байшингаас гарав” гэсэнп Халиф хаан маш хилэгнэн эд юмаа үзвэл алтан дэнлүү нь алга байжээ . “Ай, Ала-ад-дин чи дэнлүү яасан бэ? гэхэд нв “Би хулгай хийгээгүй, мэдэхгүй , үзээгүй , дуулаагүй” гэсэнд Халиф х, “Луйварчин! Хүн сайнб айхад чи юуны учир зугтана вэ, хүн итгээд байхад чи юуы учир мэхлэнэ вэ?” гээд дүүжил гэж зарлиг буулгажээ . Гадагш зардан тунхаглагч “ “Чин шудрага Халифыг мэхэлсэн хүнийг хэрхэн цээрлүүлдэгийг үзэгтүн” гэж хашгирахад улс дүүжлүүлрийн дэргэд цуглав. Энэ үес Ала-ад-дины үрчилсэн эцэг цэцэрлэгт наргиж байтал нэг ус зөөгч өвгөн ирж “Ай Ахмед –аль-данаф чи энд наргиж байхад цаана чинь гайтай юм болоод байна шүү!” гэхэд нь “Юу болов ? гэсэнд Аллахын ёсоор чиний үрчилсэн хүүг дүүжлүүрийн газарт хүгэжээ” гэжээ. Данаф эргэн Хасан Шуманд хандаж “Аяа Шуман хасан чамд ямар арга байна” гэсэнд “Ала-ад-дин энэ хэрэгт ямарч хамаагүй буй заа , гагцхүү дайсны хийсэн зальт арга мөн ” гэхэд нь “Чи яаж аврая йгэж байна” гэсэнд Хасан Шуман: “Бид аврахаас л өөр аргагүй ” гээд гянданд очиж “Хүний амины золионд гаргах нэг хүн аль” гэсэнд мэнгэт Аль-ад-динтай яах аргагүй а адилхан нэг хүн гаргаж өгмөгц толгойгий нь бүтээж , Ахмед-ад-Данаф , Киарын Али Зейбак Ала-ад-диныг Данафийнд аваачиж . Тэднийг орж ирэхэд Ала-ад-дин “Ай бурхан минь чи яаж байгаа чиэнь энэ бэ? Хэрэв чи луйварчин байлаа ч гэсэн хүн чамд итгэвэл түүнийг битгий хуур гэж байдаг юм . Халиф чамд эрх ямба олгож хамгийн итгэмжтэй хүн гэж тооцож байхад чи юунд

эд вмы нь авав?" гэсэнд "Аяа, өвгөн аваа , Их Аллахын өмнө тангаргалая: Би тийм хэрэг үйлдсэн нь огт үгүй тийм хэрэг үйлдсэнийг ч би мэдэхгүй " гэхэд нь "Ямар ч нэгэн илт дайснаас зайлахгүй тэр хүн ямар чгэсэн тэнгэрийн залхаан үзэх болно. Харин чи ямар ч гэсэн энэ Багдад балгадад байж болохгүй. Хаад ихсэтэй дайсагнаж болдоггүйн учир их хэцүүднэ" хэмээхэд "Би тэгээд хайчиах билээ" гэсэнд "Би чамайг Аль-Искандри** балгад хүгэж өгнө. Энэ балгад бол аж төрөхөд их буян хишигтэй газар даруй мөн гэжээ . Тэгээд Данаф Хасан Шуманд хандаж "Чи сэрэмжтэй байгаарай, Халиф намайг асуувал дэлхий тойрохоор явсанц гээрэй" гэжээ Тэндээс АхмҐд-ад-данаф амь сахиулсын татвар нэхээд , "Бид хоёр чамд юун татвар төлөх ёстой билээ ?" гэхэд нь "Би энэ хөндийн манаач байна" гэжээ . Тэр хоёр зуу зуун динар зоос гаргаж өгмөгц дор нь алж орхиод хоёр луусыг нэг нэгээр нь унаад цааш явлаа . Тэндээс Айяс балгад хүрч хоёр луусаа нэгэн хашаанд хийж тэнд , хоноод маргааү өглөө нь Ала-ал-лины луусыг зарж, өөрийнхөө хүнд захиж орхиод Айясын усан боомтooос хөлөг онгоцноо сууж Али-Искандарин оржээ . Хоёул зээлийн газар очиход нэгэн өрөө бүхий дэлгүүр есөн зуун тавин динар зоосоор зарна гэхэд нь мянган зоосоор худалдан авч дотор нь орж үзвэл хивс дэр дэвсэж зооринд нь хөлөг онгоцны далбаа , шураг мод, олс, аргамж , авдао тампуутай дун хальс , олом , сүх, муна, хутга, хайч тэргүүтэн байжээ . Мэнгэт Ала-ад-дин тэр өрөөний эзэн болон суусанд данаф "Ай хүү минь чи энэ дэлгүүрийг эзэгнэж сууж, найм а хийсүгэй!Аллах чамайг өршөөх тул санаа зовох явдалгүй" гэжээ . Данаф тэнд гурав хоноод явах болжээ : "За чи энд ингээд амьдарч бай. Би явж хэн тийм хэрэг үйлдсэнийш учрыг олоод Халиф өршөөн соёрхс®н тэр цагт эргэж ирнэм" гэжээ . Тэндээс Данаф буцаж Айя балгад дайрч луусаа аваад Багаддаа иржж хасанаас : "Аяа , Халиф намайш сураглав уу?" гэсэнд "огт асуусангүй" гэхэд нь хэвээр адбандаа орж шинэ сонин юм сураглан авай . Ажиглан байвал халиф нэгэн өдөр шаюар сайд Жафарт: "Шадар сайд ааа, Ала-ад-дин тун муухай хэрэг үйлдсэн дээ" гэхэд нь "Та түүнийг дүүжлэн алсан нь зохих залхаалыгүзүүлжээ . " гээд "Би тийнхүү дүүжлэгдэн байгааг очиж хармаар байна" гэхэд нь "Өөрөө л мэд" гэжээ . Тэгэд хоёул цаазын газар очтол халиф, "Энэ Ала-ал-лин биш байх чинь " гэсэнд "Яагад та , биш гэж байна" гэхэд нь "Ала-алд-дин бол богино , энэ урт хүн байна" гэсэнд "Дүүжлэгдсэн хүн болгон сунадаг гэхэд нь Халиф: "Ала-ад-дины царай цагаан атал энэ хүнийх хар ажээ ." гэж, "Үхсэн хний нүүр харладаг гэж тар арай үл мэднэ гэж үү?" гэсэнп халиф тэр хүнийг дүүжүүрээс буулгуулсанд хоёр хөлийн өсгийд өөр хоёр хааны нэр бичээстэй ажээ . Түүнийг үзээд халиф: Ала-ад-дин сунни аталу энэ хүн рафид ажээ . " гэхэд нь ш шадар сайд: "Ала-ад-дин энэ мөн бишийг Аллах мэднэ" гэжээ . халиф Ала-ад-динийг газарт булулсанаас хойш түүнийг мартаж орхижээ . Нөгөө зарга ялгагчийн хүү Хабзалам Ба§азаз сэтгэлийг даасангүй нас баржээ . харин шивэгчин Ясмин нь хөд хүндэрсээр нярайлж а арван тавны саран мэт гэрэлтэй сайхан хөвгүүн төрүүлжээ . "Чи хэнгэж нэр өгөх вэ?" гэж бусад нь асуухад "Эцэг нь мэнд сайн байсан бол нэр өгөх байжээ . Би Аслан гэж нэр өгье" гэжээ . Эхийн цагаа сүү хөхөж хоёр жил болоход хөлд орж нэг өдөр эхийнхээ гал тогоонд байх хойгуур хүү шатаар дээш гарч эмир ноёны халидын өрөөнд орвол Халид хүүг бэлэгшээн тэвэрч өвдөг дээрээ суулган эрхлүүлэх зуур ажиглавал мэнгэт Ала-ад-динтай туйлын адил хүүхэд байжээ . Ясмин хүүг эрхж дээш гарвал эмир ноён

Халидын өвдөг дээр сууж байтлаа эхээ харж сарвалзахад ноёнтогн э Ясминыг дуудаж “Энэ хэний хүү вэ?” гэсэнд “Миний хүү , миний дур сэтгэлийн үр” гэсэнд нь “Эцэг нь мэнгэт Ала-ад-дин байтал одоо таны хүү болжээ” гэв. “Ала-ад-дин зальт луйварчин байсан даа ” гэхэд “Аллах тэнгэр минь, үнэнч шудрага хүн хэзээ ч луйварчин байж таарахгүй билээ” гэж Ясмин дуу алдан өгүлжэ . “Энэ хүүг том болоод эцэг минь хэн бэ?” гэж асуувал: “Чи эмир ноён Халидын хүү шүү дээ” гэжхэлж байгаарай гэхэд Ясмин за гэжээ . Түнээс хойш эмир ноён халид хүүг сайхан асарч, багш авчран ном заалгасанд удалгүй Коран судар ббагш авчран уншдаг болж, халидыг “аав” гэдэг божээ . Дараа нь Асланд жадаар, сэлмээр хэрхэн байлдах аргыг арван дөрвөн нас хрэхэд моринд сайн , зэвсэгт мэргэ болж эмир ноёны зиндаанд хүрчээ . Аслан нэг өдөр хулгайч Ахмед Камакимтай дайралдаж, найзлаад нэгэн уушны газар орсон Камаким өврөөс эрдэни©н чулуу бүхий дэнлүү гаргаж тавиадгэрэлд нь юм ууж байх тул Аслан: “Дарга минь энэ дэнлүүш над өгөөч!” гэсэнд “Үүнийг чамд өгч болохгүй ” гэв. “Юуны учир тэр билээ” гэсэнд “Энэ бол хүний амины хэрэгт холботой юм” гээд “хэний аминд төлөө тонилсон бэ?” гэхэд Ахмед: “Мэнгэт Ала-ад-ди- хэмээх нэгэн манай энд ирж жаран цэргийн дарга бөгөөд энэ дэнлүүнээс болж үхсэн юм” гэсэнд “Ямар түүхт намтартай хүн бэ? Ямар цчир шалтгаантай үхсэн юм бэ? ” гэж Аслан асусанд Ахмед: “Чиний ах Хабазлам Базаза гэгэ ч арван зургаан нас хүрч гэрлэх болоод зээлийн газраас нэгэн шивэгчин эм худалдан авахыг эцгээсээ нэхдэг б айжээ . ” гээд үг болсон явдлыг эхнээс нь адаг хүртэлд нэгд нэггүйярихдаа Базаз өвчилж Ала-ад-дин хилс шийтгүүлснийг хүртэл ярьжээ . Аслан: “тэр Ясмин гэдэг миний эх мэнгэи Ала-ад-дин гэдэг миний эцэг болохоос зайлахгүй” гэж дотроо боджээ . Аслан тэндээс ихэд гунигтай явтал Ахмед-аль-Данаф дайралдаж “Бас хачин юм даа!” гш гэхэд нь Хасан Шуман: “Ай та юу харж гайхав?” гэхэд Данаф : “Энэ Аслан гэдэг хүүхэд мэнгэт Ала-ад-динтай жигтэй адил юм” гээп Асланг дуудаж: “Чиний эхийг хэн гэдэг вэ? ”гсэсэнд “Шивэгчин Ясмин ” гэхэд нь “Аслан минь элгээ дэвтээж нүдээ нээ: Чиний эцэг мэнгэт Ала-ад-дин болохоос зайлахгүй ” гэж дуу алдав. Эх нь уйлж : “Хүү минь , энS тухай хэн ёаид хэлэь?” гэхэд нь “Над Ахмед-аль-Данаф дарга ярилаа” гэсэнд эх нь “аяа хүү минь үнэн учир нь ил болжээ мэнгэт Ала-ад-дин чиний эцэг мөн боловч эмир ноён Халид чамаг өсгөж хүн богосонд гэж мэдтүгэй . харин чи Ахмед –ад-Данаф даргатай дахин дайралдвал : “Миний эцгийг алсан хүнSэс өшөө авч өгөтүн!” гээрэй ” гэжээ . Аслан тэндээс Ахмед-да-Данаф дарга дээр очиж гарыг үнэсэнд : “Асланчамд юу хэрэгтэй?” гэхэд нь “Миний төрсөн эцэг мэнгэт Ала-ад-дин болох нь илэрхий боллоо . Харин та миний оронд тэр яргагчийн эцгийн өшөөг авч өгнө үү” гэсэн “Чиний эцгийг хэн алсан юм?” гэхэд “Хулгайч Ахмед Камаким!” гэхэд нь “Үүнийг чамд хэн хэлэв?” гэжээ . Аслан өгүүлрүүн: “Халифын эд юмтай хамт алга болсон эрдэнийн чулуутай дэнлүү Ахмед Камакимд байхыг үзээд : “Над аль! Гэсэнд “Энэ дэнлүүнээс болж нэг хүний амь хорсон юм” гээд тэр эд юмсыг хулгайлж, миний эцгийнд нуусан юм” гэж тэр ярив гэжээ . Ахмед –ад-Данаф өгүүлрүүн: “ЗА чи , эмир ноёны цэргийн хувцас өмсөхөдп ньн над бас адилхан хувцас өмсгө! Гэж гуйгаад ёсоор өмсөн , Халифын өмнө очиж байлдааны нэг гайхамшигтай сургууль хийж үзүлэгтүн. ТэгэхээрХалиф сайшааж: “Чи надаас юу авах вэ?” гэнэ. “Миний орлнд эцгийн минь алсна хүнээс өшөөг авч өгөхийг хүснэ” гээрэй. “Чиний эцэг амьд, энэ эмир

ноён шүү дээ" гэвэл нь "Миний эцэг  бол мэнгэт Ала-ад-диэ  мөн, харин энэ  эмир ноён  Халидын  ачаар  өссөн  юм" гээп  хулгайч  Камакимий- тухай цөмийг яриад"Үнэн шашинтны их  хаан , түүнийг нэгжих  зарлиг  буулгана іу?" гээрэй. Тэгэхэд нь Камакимийн  өврөөс  дэнлүү  гаргаж ирнэ" гэсэнд Аслан за  гэжээ . Эмир -оён Халифын  яам хуралд  очих гэж  байгааг Аслан хараап "намайг ийм хувцас  өмсүүлж дагуулж яваач" гэж гуйёсанд эмир ноён  адил хувцаслан дагуулж  явлаа . Халиф цэргийн хамт хотын  захад  гарч асар  майхан  шааж  алхаар  бөмбөмг  цохих цэргийн  сургуул хийлгэж  байжээ . Цэрггийн дотор  Халифыг  адах гэсэн нэг тагнуул байж , ирсэн  ыббөмбөгийг  урдаас  алхаар  цохихдоо  яг  Халифыг  чиглүүлсэнд Аслан  завдан тосож  хариу  цохисонд  мөнөөхөн хүний цээжинд  онож түүнийг алав. Халиф:  "Аслан  чамайг  Аллах  өршөөх  болтугай  Мориноос  буцугаан  нөгөө бөмбөгөөр  Халифыг онох гэсэн хүнийг авчир ! гэж Халиф  тушаа.  Тэгээд  "Чамд ингэ гэж хэн хэлэв.  Чи манай хүнт үү дайсаны хүн үү?" гэхэд  нь нөгөө хүн  "Би дайсан чамайг  алахыг  завдав" гэхэд нь  "Ямар учиртай билээ? Чи лал хүн  баж" гэсэнд "Үгүй би Рафид " гэжээ .  Халиф түүнийг  алагтүн гэж  зарлигдан Асланд хандаж  "Аслан чи надаас  юу хшүснэм?" гэсэнд Аслан "Миний оронд  эцгий минь  хариуг  авч  өгөхийг хүснэм" гэхэд нь  "Чиний эццэг энэ амьд  зогсож байна" гэсэнд , "Миний эцэг  хэн юм?"гээд "Эмир ноён Халид " гэхэд  нь Аслан "Үнэн шашаинтны  их хаан энэ бол намайг  өсгөсөн  эцэг даруй  мөн.  Миний төрсөн  эцэг  бол мэнгэт Ала-ад-дин мөн" гэжээ . "Чиний  эцэг  зальт   луйварчин  байсан  даа"  гэхэд   Аслан:  "Үнэнч"  хүн луйварчин  болох   ёсгүй.  таныгш   яаж  мэхлэв?"  гэсэн¤  Халиф:  "Миний   хувцсыг хулга©лсан юм" г гэхэ¤  ньАслан "Аяа  ноёнотон минь  та  хувцасаа  алдаад олоход дэлүүгээ  олсон уу?" гэсэнд "Олоогүй  билээ" гэжээ . Аслан өгүүлрүүн:  "Тэр дэнлүүг хувлгайч Ахмед Камакимд  байхыг би үзсэн  "Над өгөөч " гэж гуйхап  "Энэ дэнлүүнээс болж  нэг хүниы  амь  алдсан юм" гээд эимр  эмир  ноён  Хабала Базаза  шивэгчин хүүхэнд  дурлаж  хэрхэнөвчилсөн , өөрөө бас  гинжнээс хэрхэн мултарсан зэргийг цөмийгнад  ярив.  Тэгэхлээр   та энэ  яргачинаас эцгийн минь  өшөөг авч  өгнө үү" гэсэнд  "Ахмед  Камакимыг   баригтун"  гээд   "Үүнийг  нэгжин   үзэгтүн!"  гэж   Данафт тушаав . Данаф, хулгайчийн  өврийг уудалж  дэнлүү гаргасанд  Халиф: "Луйварчин чи  нааш ир  !  Энэ   дэнлүү   хаанаас авав?"  гэсэнд  "Үнэнч   шашинтны   их   хаан  , би хүнээс худалдан  авав" гэсэнд "Миний адил  дэнлүүтэй  адилыг  зарах хүн  хэн бөайх билээ?"  гээд  Камакимийг   нэвширтэл   зовсонд   Халифын  хувцас  дэнлүүг  авснаа хүлээжээ .  Халиф: "Луйварчин чи  юунд  ийм бузар хэрэг үйлдэж  үнэнч  шудрага мэнгэт  Ала-ад-диныг  хөнөөв"  гэж   ихэд  хилэгнэн  Ахмед  Камаким  ,  зарга    ялгагч хоёрыг  ыбаригтун  гэхэд Халид  өгүүлрүүн:  "Аяа үнэн  шашинтны  их хаан минь , би энэ   явдлыг   мэдэлгүй  таны  зкарлигийг   ёсоор   түүнийг  дүүжилсэн  билээ  .   Энэ хэргийг Ахмед Камакимын эх-эмгэн , миний гэргий  хоёр  зохион  үйлдсэнийг  би мэдсэнгүй.  Ала-ад-дин  чи  намайг   өмгөөлөн   явна   уу!"  гэсэндАслан   түүнийг өршөөхийг  халифт  гуйв. Халиф  эмир ноёнд хандаж  "Энэ хүүгийн эхийг  яасан бэ?" гэхэд нь  "манайд бий" гэхэд нв "Чи гэргийдээ  хэлж энэ  хүүгийн эхийн гоё  хувцас, чимэг   зүүлтийг   урьдын  адил  хэрэглүүлж  ,  хотны  зэрэгт  оруулагтүн!"  Ала-ад-дин гэрээс   тийз   ьамгыг   авч   мөнгө эд агуурсыг  хөвгүүнд  нь  шилжүүлэгтүн  гэсэнд Халид  за  гээд   тэр   харьж   эхнэртээ   тушаал  өгч   Ясминыг   хуучин   ёсоор   нь хувцаслуулж  ,  Ала-ад-дины   гэрийн   тийз   тамгыг  авч   түлхүүрийг   Асландд  өгөв. Халиф   нүдний  нулимс   гаргаж:  "Чиний  жэцэг   дүүжлэгдэн   амь  алдсан   нь  лавтай

боллоо. Гэвч хэрэв Ала-ад-дин амвд мэнд гэсэн сайхан мэдээ дуулгаж намайг баярлуулах хүн гарвал би юу хүсэний нь өгнө" гэсэнп Данаф: "Аяа үнэн шашинтны их хаан, намайш алахгүй гэж ам алдагтүн!" гээд "Чиний амь насанд аюулгүй " гэхэд нь Ала-ад-дин амьд мэнд буй гэж хэллээ . халиф "Чи юу хэлнэм?" гэж дуу алсанд , Данаф : " Миний үг үнэн! Би түүнийг зайлүгүй цаазаар авхуулах тавилантайы нэг хүнээр сольж аваад Али- Искандари балгад руу явууллаа . Аслангийн эцжг мөнөөхөн мэнгэт Ала-ад-дин хамаг юмыг зараад ганцхан тампуу юм үлдсэнийг тайлж үзвэл алтан гинж бүхий атгын чинээ таван талтай чулуу байсны тал болгон дээр нэр бичиж мөлхөж буй шоргоолж шиг зангиа зурсан тийм чулуу байжээ .Ала-ад-дин таван тал болгоныг үруж үзээд "магадгүй энэ чулуу энгийн мөртөө үнэтэй эд байж магадгүй" гэж бодоод дэлгүүртээ дүүжлэн тавьжээ . Нэгэн элчин* хүн явж ыбайтал тэр чулууг гэнэт харж, "Ноёнтон , энэ чулууг зарах уу" гээд, "Миний ганц зарах юм энэ дээ" эхэд "НАдад түмэн динар зоосоор өJөх үү? " гэсэнд "Аллахын өршөөлөөр арай тиймд хүрээгүй байнадаа" гэсэнд нь "ыбуман динар зоосоор ав" гэсэнд "Таны энэ Аль Исзандрид хулгайч ихтэй учир мөнгө авч явж болохгүй юм . Надтай хамт хөлөг онгоцоор очвол чинь мөнгөн дээр чинь боодол унгас, толгой торго , толгой хилэн, толгой цэмбэ нэмэн өгье гэхэд нь Ала-ад-дин , мөнөөхөн чулууг элчин дор өгч, дэлгүүрүүдийг хаагаад түлхүүрийг айлдаа таьвж "Би энэ элчингийн хамт хөлөг онгоцоор явж мөнгө авчирна . хэрэв би саатаж , эзгүй хойгур намайг энд буулгасан Ахмед –аль Данаф гэдэг хүн ирвэл энэ түлхүүрийг өгөөд эл учрыг хэлээрэй" гээд мөнөөхөн элчингийн хамт хөлөг онгоцнд нь очиж суутал , нгэн сандал тавьж өгөөд "хөлсийг төлөгтүн!" гэхэд нь өөрийн амлсан таван толгой даавууг өгнө гэжээ . "Ай ноёнтон минь , та нэг зүсэм юм идэж балга ус ууна уу?" гэхэд ньв Ала-ад-дин , "Ус байвал ууя л даа" гэсэнд элчин ус авчруулж өгсөн нь согтууруулах эмтэй байсан тул Ала-ад-дин ухаан алдаад тас гэдрэг унажээ . Тэд хөлөг онгоцны аргажийг тайлж далбааг татсанд салхин хөдөн их далайн дунд оров. Хөлөг онгоцын ахмад шоронгоос Алал-ад-диныг гаргаж ир гэж тушаасанд Ала-ад-динд эм үнэртүүлэн сэргээж авчирваас: "Би хаана байна?" гэж гайхан асуутал, "Чи миний хамгааллын дор явнам биш үү!" Хэрэв чи тэр чулууг дахин үнэ асуухап "Аллахын өршөөлөөр болно" гэсэн бол би бас л үнэ нэмэх байсан гэжээ. Тэгэхээр нь Ала-ад-дин "Чи ерр нь ямар үйл эрхэлдэг хүн бэ" гэхэл нь "Би хөлөг онгоцны ахмад чамайг миний сэтгэлийг далласан газарт аваа·на" гэжээ . Ийнхүү ярилцан байтал өөр нэгхөлөг онгоц үзэгдсэнд ахмад онгоцыг тийш залж очоод төмөр дэгээгээр гохдон зкогсоогоод дээр гарч , тэр онгоцонд суужявсан дөчин лал худалдаачныг дээрэмдэн олзлоод Генуя балгад яиглэн цааш явжээ . Ахмад тэнгэс далай руу харсан нгэн их ордн хаалгыг чиглэн хүртэл, толгойгоо бүтээсэг хүүхэн хамт авчрав уу? гэхэду нв нөгөө ахмад "Авчирсаан" гээд хаана байна% Гэхэд нь мөнөөхөн эдщрдэнэйиг авч өглөө . тэгээд хөлөг онгоцыг гарамд зааж энэ ахмадп сайн явж ирснийг тэр газрын хаанд мэдэгдэн үхэр буугаар хэдэнтээ буудав. Хаан угтан гарёч ирээд "За ямар шиг олзтой Явж ирэв?" гэхэд нь ахмад: "Дөчин нэгэн лал худалдаачин бүхий нэг хөлөг онгоцу авчирлаа даа" гэсэнд "Гаргаад ир!" гэж хаан тушаав. Цөм гинжтнй худалдаачингууын дотор Ала-ад-дин бас байлаа . Хаан, ахмад хоёр морь унаж мөнөөхөн худадаачлдыг туусаар хааны ордонд ирээд хоёул зэрэгцэн сууж , худалдаачин нарыг нэгнэгээр нь дуудан оруулж "Муу лал чи аль газрын хүн бэ?"

гээд “Али-Искандрийнх ” гэхэд “Ай , зандаочин үүнийг алагтун” гэхэд мөнөөхөн зандалчин хүн сэлмийг далайн толгойгий нь тас цавчсаар дөчин худалдаачны толгойг авав. Хамгийн сүүлд Ала-ад-дин ээлж болсонд заяангпаа ихэд гуньж “Аяа Аллах тэнгэр өршөөх бол®осой. Алда-ад-дин чиний амь өнгөрчээ” гэж дотроо залбиран байтал: “Чи ль орны хүн бэ?” гэхэд нь Би Али-искандрийнх хүн хэмээсэнп “Ай зандалчин энэ хүнийг ал!” гэж мөнөөхөн зандалчин сэлмийг ¤алайтал нэгэн эрхэмсэг эмгэн гэнэт орж ирвээс хаан босон хүндэтгэн ажээ . Эмгэн: “Ай хаан хүү, чи ахмадыг явж олзны хүн олж ирэхэп хоёр хүн сүмийн ажил хийлгэхээр , өгнө гэсэн чиньяасан билээ” гэсэнд Хаан: “Ай ээж минь жаахан түрүүн ирэх чинв яав? Энэ үлдсэн ганц олзны хүнийг аваад яв!” гэжээ . Эмгэн эргэж Ала-ад-диныг хараад: “Чи сүмд зарц хийх үү, эсвэл толгойгоо авахуулах уу?” гэхэлд “Би зарц хийнэ” гэсэнд эмгэн хөвгүүнийг дагуулан сүмийн газар очювоос Ала-ад-дин :”Би ямар ажил хийх вэ?” гэсэнд эмгэн өгүүлрүүн: За чи өглөө болгон эрт босоод таван луус авч ойд очиж хуурай түлээ хөрөөдөж хагалаад сүмийн гал тогооны газар оруулаад сүмийн хивсийг хуйлж шүүрдээд чулуун ба гантиг шалыг угааж ,дахин хивсийг дэвсэнэ. Тэгээд хоёр лүү улаан буудайн гурил шигшиж гар тээрмээр тээрэмдэж чанан. Тэгээд дөрвөн ган ус зөөж гурван зуун жаран гурван тавагт хийж , мөнөөхөн боовыг дэвтээж зарам бүрж лам болгонд өгөх хэрэгтэй . Тэгэд бас…” гэхэд нь Ала-ад-дин: “Тэгвэо намайг хаандаа аваачиж өг! Ийм их ажил хийснээс үүхсэн нь дээр!” гэсэнд эмгэн “Хэрэв чи хий гэ эн ажил хийгэSд л байх юм бол үхлээс аврагөдана. Хийхгүй бол хаандаа аваачиж алуулна. ” гэжээ . Ала-ад-ди- мөнөөхөн суулгыг зөөж өгсөнд дотор нь бааж , “Май баас аваачиж хая!”гэхэд нь баасыг аваачиж хаяваас тэр лам : “Ай хөвгүүн чи, их нигүүлсэнгүй болтугай!” гэжээ . Гэтэл нөгөө эмгэн Ала-ад-диныг харж “Чи юунд сүмийн ажил хийхгүй байна?” гэхэд нь “Би ийм олон ажил яахин кэрэг хийж чадах билээ?” гэсэнд эмгэн “Ухаан муут чамайг гагцхүү ажил хийлгэхийн тул авчирсан билээ” гээд ай хөвгүүн чи энэ ттаягийг авч гадгаш гаря энэ хотын карга ялгагч түшмэдийн дайралдахаар “Зовлон тонилгогч ихсийн тусын тул сүмд очиж ажил хийгтүн!” гээд үг зөрөхгүй бол нь улаан буудай шигшүүлж , заарuулж боов хийлгэгтүн, тэр хүн эсэргүүвэл нь хэний ч хамаагүй занчигтун!” гэжээ . Ала-ад-дин за гэж түүнээс хойш арван долоон жил их ба бага хүнийг ийнхүү албадан ажил хийлгэх болжээ . Нэг өдөр сүмд очиж байтал эмгэн орж ирээд “Чи энэ сүмээс одоо зайлагтун” гэхэд нь “хаашаа ” гэсэнд “Цайыныб газар буюу таньдаг айлдаа очиж хоногтун!” гэсэнд “Юуны учир чи намайн ийнхүү сэмээс хөөнөм!” гэхэп “Энэ хотын хаан Юханнын охин Хусх мариан сүмд морилон ирэх тул замд нь боловч саад болон сууж байж болохгүй ” гэжээ . Ала-ад-дин босож, тэндээс гарч явах гэж байгаа хүний дүр үзүүлэвч дотроо: “Эндхийн хааны охин манай газрын хүүхнүүдэс сайханюм бол уу? Би үзэхээс нааү эндээс явахгүй ” гэж бодоод сүм руу харсан цонх э бүхий нэг өрөөнп орж нуугдав. Гэнэт харваас үүлний цаанаас бултаах саран мэт сайхан хүүхэн харагвах тул Ала-ад-дин хараад өөрийн эрхгүй мянгантаа санаа алдав. Бас хааны охин лугаа хамь нэгэн хүүхэн байв. Хааны охин нөгөө хүүхэнд хандаж: “Ай Зубейда чи миний сэтгэлийг хөгжөөж өгнө үү?” гэхэд нь харваас өөрийн нь эхнэр, мөнөөхөн үхсэн ятгачин Зубейда мөн ажээ .**Хааны охин:** “За бидэнд ятгадаж өгөөч!” гэсэнд Зубейда : “Чи амласнаа биелүүлж _ миний хүссэнийг гүйцэтгэхээс нааш би ятгадахгүй” гэхэд нь “Би юу амласан

бүрч гайхжээ . Абу-Сир хаанд айлтган арван сахан залуу хөвгүүд гуйж авчр ад хүний би? илэх эрдэмд сургав. Иймнхүү яг бэлэн болсон хойно зарлан тунхаглагч: "Ай буянтан Халуун усанд орогтун! Султан хааны халуун ус нээгдэв" гэж гудамжаар зарлан тунхаглав. Орсон хүний биеийг зарц боолчууд сайтар угааж, дараа нь үе мөчийг илж, ямар ч хөлс авалгүй гаргаад байжээ . Улс амьтан гурав хоног иймнхүү халуун усанд орж дөрөв дэх өдөр хааныг урьсанд хаан морь унаж, эрхтэн дархтан нара дагуулан иржээ . хаан хувцсыг тайлж халуун усанд орход Абу-Сир цуг орж зүлгүүрээр биеийг сайтар зүлгэвэл тогооны хөө адил хир гарч биед гар хүрэхэд нь нугисэн зөөлөн болжээ . Абу-Сир хааны биеийг угаагаад сарнай цэцгийн усаар булхаж, зарц боолчуудаар биеийг илүүсэнд хааны би? ухаан сэргэж хүжийн анхилам үнэрт сэтгэл маш таатай болжээ Энэ сайхан үйл биеэр үзсэн хаан: "мөнөөхөн халуун ус гэдэг чинь энэ үү?" гээд "Ай, манай хот энэ халуун устай боснор дээдийн тансаг ахот болно" гээд "Чи орсон хүнээс ямар харамж авч байна?" гэхэд нь Абу-Сир, "Та хэдий шан харамж авч байя гэвэл төдий авна" хэмээсэнд "Энд ирж биеийг угаасан хүн бүрээс мянган динар зоос авч байгтун!" гэхэд нь Абу-Сир өгүүлрүүн: "Ай цагийг эзэлсэн хаан минь хүн болгон өадилгүй баян хүн ч бий, ядуу хн ч бий тул хн болгоноос мянган дЁнар зоос аьбал халуун усны газар хаагдахад хүрнэ . Ядуу хүн мянган динар зоос гаргаж чадахгүй шүү дээ!" гэсэнд Хаан: "Чи бол ямар үнэ хөлс авъё гэж бодож байна. Баян хүн бол бэлийнхээ хэрээр, ядуу хүн бол бас өөрийн үзэмжээр өгөхийг тэдний сэтгэл санаанд захируулж оривол манай ажил үйл бтэмжтэй олон иргэдэд хүндтэй болно. мянган динар зоосыг хаан хүн өгч чадна. Хүн болгон өгч чадахгүй шүү" гэжээ . хааны эрхтэн дархтан Абу-Сирийг сайшааж "ай цагийг эзэлсэн хаан аа , энэ хүний хэлдэг туйлын зөв. Ай алдарт хаан та хүн болгоныг өөртэйгөө адил бодож бана уу" гэжээ . Хаан өгүүлрүүн: "та нарыг хэлдэг зөв боловч, энэ хүн харь гүрний ядуу хн тул бид тус болох ёстой . Энэ хүн бидний насандаа үзээгүй сайхан угаалгын газар бий болгож, манайы ахотыг үлэмж ариун тансаг болгов. Энэ хүний сэтгэлийг хүндэтгэсэн хичнээн юм өгсөн ч ихдэхгүй дээ!"гэхэд нь "хэрэв та энэ хүнийг тйийнхүү хүндэтгэж өөрийн мөнгөнөөс өгвөл чиний төлөө энэ хүн Аллахад залбаирах болно. Бидний хувьд гэвэл, бид тус бүр мянган динар зоос өгч байх зүрх хрэхгүй байна. Ялангуяа ядуу улс бол яаж өгөх юм бэ?" гэцгээхэд н хаан : "ай ямбаиан минь тануус ямар чгэсэн энэ удаа тус бүр зуун дтнар зоос нижгээд боол, нижгээд зарц нижгээд шивэгчин өгөгтүн!"Гэхэд нь "Энэ удаа таны хэлснийг өгцгөе. Хойшид биеийг угаасан хүн өөрийн үзэмжээр өгч байх биз" гэжээ . Хааны эрхтэн дархтан цөм Абу-Сирт зуун динар зоос нижгээд боол, зарц, шивэгчин өгөв. тэр өдөр хааны хамт дөрвөн зуун ямбатан бие угааса болохоор дөрвөн дүмэн динар зоос, дөрвөн зуун боол, дөрвөн зуун зарч, дөрвөн үуун шивэгчин өгчээ . Абу-Сир хааны өлмийд сөгдөж: "Ай жаргалыг эдэлсэн хаан минь, би өдий олон боол зарц, шивэгчинг хэрхэн авч байх билээ?" гэсэнд хаан өгүүлрүүн: "Би чамд их мөнгө цугларахын тул тийнхүү хэлсэн билээ . Чи хэзээ нэг цагт нутаг гүрнэ санаж, орон гэртээ харихын цагт базаалттай мөнгө хөрөнгтэй явбал эх орондоо очоод амь зуухад чинь амар байх билээ" гэхэд нь "Ай цагийг эзэлсэн хаан аа, тийм бол над боол, зарц, шивэгчин цөм хоол идэж, хувцас өмсөх тул над хичнээн хөрөнгө цугларсан ч энэхүү цэрэг адил олон хүнийг тэжээ яахин чадах билээ" гэсэнд хаан инээж" "Аяа Аллах! Чиний хэлдэг зөв буй заа. Тэд үнэхээр цэрэг адил олон бол чи

яахин авч байх билээ . Чи над тус бүрийг зуун динар зоосоор худалдана уу?” гэхэд нь Абу-Сир зөвшөөртөл хаан их сангийн нярвыг дуудаж,мөнөөхөн олон боол шивэгчинг үнийг төлөөд боолчуудын эздэд өгүүлрүүн: боол, зарц, шивэгчин нараа таньж авцгаагтун. Би тануust бэлэг болгон өгье гэжээ. Хааны эрхтэн дархтангууд Абу-Сир өгсөн боол шивэгчингээ таньж авмагц Абу-Сир: “Гагцхүү Аллахаас өөр хүн тэжээ дийлэхгүй энэ олон хүниг ангижруулж өгсөнд чинь гялаалаа” гэхэд хаан пөг пөг инээсээр ордондоо буцав. Абу-Сиртэр шөнө алтан зоосыг тоолж уутанд хийв. Абу-Сирт хорин боол, хорин зарц, дөрвөн шивэгчин үлдсэн байв. Маргааё өглөө халуун усанд газрыг нээж: “Халуун усанд орж биеийг угаах улс хөлсийш өөрсдийн сэтгэлээр төлөгтүн!” гэж зарлан тунхаглсан дэргэд нэгэн авдао тавьвал усанд орсон хүн болгон түүнд мөнгө зоос хийсээр удэш болоход диг дүүрсэн ажээ . Хааны хатан халуун усан орно гэсэнд Абу-Сир хуьиар хийж, үд хүртэл эр улс, үдээс хойш эмс оруулах болгож, дөрвөн шиьвэгчин бие угаах ёсыг сайтар заан сургажээ . Хатан хаан халуун усанд биеийг угааж, бие сэтгэл нэн хөнгөрөөд мянган динар зоос өгч харьжээ . Абу-Сирийн алдар хот дүүрэн түгж, баян хоосонгүй их хишиг хүртээх бүлгээ . хааны шадар дотно хүмүүс цөм сайн танил болсон бөгөөд хаан өөрөө долоо хоногт нэгэн удаа халуун усанд орж мянган динар зоос бэлэглэх болжээ . Нэг өдөр хааны хөлөг онгоцны дарга иржусанд орохол нь Абу-Сир хамт орж биеийг сайтар угааж туйлбн сайхан зантай хүндлэн бас ундаа ба цай барив. Хөлөг онгоцны дарга шан харамж барих гэсэнд Абу-Сир эсс авсанд тйинхүү эелдэг сайхан хүндэтгэн ёсолсны хариуд шагнах юм олдхгүй ихэд ичингүйрэн гарч оджээ . Энэ үес хотын иргэд халуун ус гэж ярилцан энэ газар дэлхий халуун усанд биейиг угаах шиг ачтай юм алга. Маргаа нь очиж орцгооё гэж хэлэлцэхийг Абу-Кир сонсоод, тэр хүний ухаан санаагш эзэмдсэн халуун усны газрыг очиж үзье гэж бодоод хамаг гоё хувцсаа өмсөн луус унаж ар өвөртөө дөрвөн боол дөрвөн зарц дагалдуудан очвоос үүдний дэргэд хүрэхэд хүжийн үнэр анхилан, том жижиг олон хүн урт бандан дээр зээглэн сууж харагдах ажээ. Дотор орвол Абу-Сир харж баярлан тостол Абу-Кир: “Үнэнч сэтгэлтэй хүн чам шиг байдаг уу? Би энэ хотод будгийн газар гаргаад хаантай танилцаад жагалтай ихэмсэг аж төрөх атал чи, намайг дурсаж юунд эс очив. Би бол чиний хойноос боол зэрдэс явуулж хичнээн эрж сураглавч сураг гарахгүй байхаар ихэд цөхрөв” гэхэд нь Абу-Сир: “Би чам дээр очоогүй гэж ?” гэсэнд: Намайг чи хулгайч гэж зарлан олны дунд зодож нэр гутаасан биш бил үү? Гэсэнд “Би чамайг зодсон гэж үү? Би чамайг таньсангүй” гэж мянгантаа гэмшин өгүүлж, “Чамтай туйлын адилхан нэг хүн өдөр болгон хүний бөс хулгайлаад байса юм . Би түүнийг л гэж бодов гэжээ . Абу-Кир нэн ч гаслан, “Аугаа их Аллахаас чүётэй юм үгүй билээ . Би чамайг ихэд гомдоожээ . Ч юунд би бана гэж өөрөө эс хэлэв. Чиний эс хэлсэг нь басхүү ичгүүртэй_ Би олон ажилд самгардан мунгинаад таньсангүй ажээ” гэхэд нь “Ай Аллах чамайш уучлах болтугай” гэж хувсцгы тайлж, биеийг угааж амрагтун! ” гэсэнд Абу-Кир “Ай Аллахыг бодож, намайг уучлаарай!” гэжээ . Абу-Сир: Энэ нүглээс Аллах чамайг аврана буй заа . Миний тавилангаас болсон биз! гэсэнд Абу—Кир : “Хэн чамайг ийнхүү их хүн болгов?” гэхэд нь, “Чамд тус болсон хүн надад тус болжээ . Би хаанд бараалхаж халуун ус гэж юу байдаг учрыг ярьсанд хөрөнгө гаргаж над энэ байшин бариулав” хэмээвээс “Энэ хааныг чибас таньдаг уу?” Би бас танина. Аллах ивгээвэл

би хаанд айлтгаж чамд илүү иххүндэтгэл үйлдүүлнэ. Абу-Сир бол миний анд нөхөр тул түүнд илүү их хишиг хүртээ гэж хэлсүгэй гэжээ . Абу-Сир өгүүлрүүн: "Тийнхүү хэлэххэрэггүй . тэртэй тэргүй эр хаан би түүний эрхтэн дархтан намайг сайнаар үзэж тийм тийм юм хайралсан гээд уг болсон явдлыг цөмийг яриад, "Одоо чи хувцсыг талж халуун усанд ортугай. Би хамт орж биеий чинь сайтар зүлгэж угаана" гэсэнд Абу-Кирхувцсыг тайлж орвоос Абу-Сир хамт орж биеийг угаан, угаан арчин, арчин ихэд хүндэтгэхийг хажуугийн улс үзээд ихэд гайхжээ . Абу-Кир гарч шан харамж өгөх гэсэнд Абу-Сир асвангүй, "аяа чи бид хоёр ах дүү улс ямар ялгаа байх билээ" гэжээ . Абу-Кир Абу-Сиртэ өгүүлсэн нь: "Ай нөхөр минь, чиний энэ халуун усны газар тун сайха болж, ганцхан юм дутжээ гэхэд нь "Юу дутав " гэсэнд "Нэгэн зүйлийн эм буюу өөрөөр хэлбэл хүнцэл ба шохойн исгэмэл хийвэл хүний аливаа үсийг арилгана . Тэгээд хааныг усанд орхоод хэрэглүүлбэөл хаан тусгай болохыг үзээд чухам улам их хишиг хүртээх болэо" гэхэд нь Абу-Сир "ЗҮйтэй би тийм эм хийнэ" гэжээ . Абу-Кир тэндээс хаанд бараалхан "Ай цагийг эзэлсэн хаан% би чиний үнэнч зөвлөгч билээ" гээд "За юу хэлэх вэ?" гэхэд нь "Чи нэгэн халуун усны газар бариулсан ураг дуллаа" гэсэнд хаан өгүүлрүн: "Тийм ээ! нэрэн харь гүрний хн ирсэнд би чамд т будагчны газар бариулж өгсөнтэй нэгэн адил халуун усны газкар бариулав. Тэр хадуун ус үнэндээ манай хотын чимэг болов" гэхэд нь та орж үзэь үү? Гээд "үзэв" гэсэнд Абу-Кир, "Ай, тэрхүү буруу номт, усчны гараас Аллахч амайг аварчээ" гээд яагаад тэрг билээ. юу болов? гэхэд нт "үүнээс хойш тх тэр халуун усанд орвол үхнэ гэж мэд" гэжээ. Тэр халуун усны газар бариулдаг нь гагцхүү чамайг хорлохын тул болно. одоо ахиад очиж халуун усанд биеийг угаахад чинь нэг эм авчирч : "Энэ эм бол хүний хэрэгтэй үсийг амархан арилгадаг эм гэх бий! Тэр бол эм биш, хүнийг үхүүлэх хор гэж мэдтүгэй. Түүний эхнэр хүүхдийг Христос мөргөлтний Султан хаан барьж аваад хэрэь чамайг алах юм бол эхнэр хүүхдий нь эгүүлэн өгнө гэсэн байжээ . Би бас түүний хамт тэр гүрэнд олзлогдон байсан атал мөнхүү будагчны газар нээж бас барааг элдэв өнгөөр будгийн будаж өгсөнд хааны сэтгэл уярч "Чи надаас юу хүснэ" гэхэд нь гагухүү суллан тавихыг хүснэ гээд тэндээс мултарч энд ирсэн билээ . Сая тэр хүнийг халуун усны газар байхыг үзээд "Чи яаж гарч ирэв?Эхнэр хүүхдээ яаж аврав?" гэхэд минь, тэр өгүүлрүүн: "Миний эхнэр хүхэд одоо хүртэл олзонд хэвээр бий . Христос мөргөлтийн хаан нэг өдөр шадар сайд түшмэлд нараа бүгдийг цуглуулан элдэв олон түүхэн намтао ярилцан байтал энэ хотын хаан нэг гарахап христос газрын хаан санаа алдаж, тэр нэг хотын хаанаас өөр намайш дийлэх хүн ертөнцөд үгүй билээ . Түүнийг элдэв аргаар алдсан хүнийг би суллан тавьж юу хүссэнийн нь өгөх билээ " гэхэднь хэрэв би тэр хааны ямар нэг аргаар албөал намайш болон миний эхнэр хүүхдийг суллах уу" гэсэнд "Суллан тавихаар үл барам юу хүссэний чинь өгнө" гэжээ . Би ингэж яярилцан тохиртол намайг хөлөг онгоцонд суулгаж энэ хот руу явуулсан юм . Би эндхийн хаан бараалхаж нэг халуун усны газар байриулж авлаа . Одоо гагцхүү түүнийг алах үлдээд байна. тэгээд чхристос газрын хаанзд очиж эхнэр хүүхдээ авна даа" гэж ярьж байна. "Ямар аргаар хааны алах санааиай байна?" гэж миний асуусагд "тэр туйлын амархан нэгэн сайн хор бэлдэд хааныг халуунусанд ороход нь "Энэ эмийг илүүц үстэй газар түрхвээс үс нь арилваг" гэж хэлээд, тэр эмийг хэрэглэвэл нэг өдөр нэг шөнийн дотор хор би энд нь тарж ззүрхэнд харвахын цагт зайлшгүй үхүүлнэ"

гэж байна шүү гэжээ . Хаан энэ үгийг сонсоод ихэд хилэгнэж”Ай будагчин чи энэ нууцыг хэнд ч бүү хэл!” гээд туршин үзэхээр халуун усанд очив. Абу-Сир урьдын адил нүцэглэн биеийг сайтар зүлгэн угааж өгөөд, “Ай цагйг эзэлсэн хаан, би хүний биеийн илүүц хэрэггүй газрын үсийг арилгадаг нэгэн зүйл эм хийв” гэсэгп хаан, аваад ир!” гээд үнэхээр муухай үнэр ханхлах тул нээрэн хор гэж итгэж ихэд хилэгнэн шадар дотно хүмүүсээ дуудаж”Наадахаа бариад ав!” гэжээ . Хаан машид хилэнтэй байсан тул юуны учир хилэгнэснийг хэн ч зүрхлэн асуусангүй ажээ. Хаан, хувцслан яамлах хуралд очвоос Абу-Сирийг хоёр гары нь хүлж оруулан ирвээс, хаан хөлөг онгоцны даргыг дуудаж, өгүүлрүүн: “Чи энэ бузар амьтныг түүхий шохойтой цуг нэг шуудайд хийж амыг боогоод завинд тавиад миний ордны цонхон тушаа аваад ир! Тэгээд “Усанд хаяхгүй уу?” гэж надаас асуугаад нмайг “Хаягтун” гэхээр усанп чцулуудагтун. Усанд ормогц түүний шохой шатаж, Абу-Сир түлэгдэн үхэж усанд живэх болно ” гэжээ . Хөлөг онгоцны пдарга “За” гэж гараад Абу-Сир ийг хааны ордны цаад арал дээр аваачиж “Ай эрхэм хүн, би нэг удаа чиний халуун усанд орход чи намайг ихэд хүндэлэн надаас шан харамж хүртэл аваагүйд чин би чамд туйлаас баярлаж , чамд хайртай болсон билээ . Чи хаанд ямар муу юм хийснээс хаан ийнхүү машид хилэгнэн чамайг энэ муухай үхэлд оногдуулж байгаагийн учрыг ярьж өгнө үү?” гэсэнд Абу-Сир өгүүлрүүн: “Аллахад ам алдсугай Би ингэж алуулах ямар нүгэл хийснээ өөрөө боловч эс мэднэ ” гэхэд нь дарга: “Чи манай хааныы дэргэд хэнд ч олдоогүй эрхэм суудал хүрч, алиаа жаргалтай хүн атаарахмаар болжээ . Магадгүй хэн нэг хэн чиний жаргалтайд атаархаж хаанд ямар нэг муу үг хүргэсэнд хаан тийнхүү хилэгнэн байж мэднэ. Гэвч би чамд ямар ямарч муу юм хийхгүй. Анх танихгүй байхдаа, чи намайг ихэд хүндэлснийг бодож чамайг би ямар ч гэсэн суллана. Харин чи миний хамт энэ арал дээо байж нэгэн цагт танай гүрэн рүү далбаат онгоц явахад чамайг нутаг явуулна гэжээ . Абу-Сир энэ үгийг сонсоод хөлөг онгоцны даргад туйлын баярлан гарыг үнэсэж тал өгсөнд дарга нэг шуудайд түүхий шохой хийж хүний дайтай чулуу хийж “Аллах мэдтүгэй!” гээд явахдаа. “За чи, энэ өгөөш торыг усанд тавьж §агас барьж байсугай. Би өдөр болгон хааны хоолны загас барих атал өнөөдөр би явж чадахгүй болов. хааны тогооч загас гээд ирвэл яана, чи хэдэн загас барьсан байвал болох нь тэр. Би явж хааны ордны цонхон тушаа очиж чамайг усанд хаясан болъё” гэжэ . Мөнөөхөн дарга шуудайтай шохой чулууг завинд ачиж хааны цонхны тушаа очиж харвал хаан сууж байх тул “Одоо усанд хаях уу?” гэхэд “Хаягтун!” гээд гараар дохиход нь нэг юм гяласхийн далайд унажээ. Энэ нь хааны бөгж далайд унасан хэрэг байжээ .Тэр бөгж илбэ шингээсэн учир хуруугаар дохихын төдий мөнөөхөн бөгжнөөс үл үзэгдэх цахилгаан гарч нөгөө хүний толдгой өнхрөн унах бүлгээ . хаан гагцхүү энэ бөгжийн хүчээр их цэрэг захиран байсан юм . Хаан бөгжийг усанд алдаад хүнд хэлж чадсангүй . Учир нь их цэрэг мэдвэл урдаас нь босон хөдөөж хааныг алах байжээ . Энэ үеэс Абу-Сир өгөөш торыг далайд дахин дахин тавьж зөндөө их загас бариад, ойрдоо загас идээгүйгээ санаж, нэг том тарганыг шилээд “Онгоцны даргыг ирэхээр энэ загасыг шаруулж үдийн хоолонд идье” гэж боджээ . Мөнөөхөн загасны загалмайг хагалтал хутга тээглэхийг үзвээс хааны бөгж байжээ . Хааны бөгж усанд унамагц загас залгиж азаар энэ тоходй ирж торонд орсон байж. Абу-Сир бөгжийг увидсыг эс мэдэн чигчий хуруундаа зүүтэл тогоочийн явуулсан хоёр хүн ирж, “Онго¶ны дарга

хаана байна?”гэхэд нть “Мэдэхгүй” гээд бөгжтэй гара өргөтөл тэр хоёр хүний толгой өнхрөн унажээ. Абу-Сир, “Энэ хоёр хүннийг хэ- алчихав” гэж гайхаж тагнаад учрыг олсонгүй. Онгоцны дарга ирвэл Абу-Сир зөндөө загас барьж хоёр хүн алаад хааныб бөгж зүүсэн байхыг үзээд, “Ай ах минь, бөгжтэй гараа битгий хөдөлгөөрэй. Хөдөлгөвөл би үүхнэ шүү!” гэхэд нь Абу-Сир ихэд гайхжээ . Энэ хоёр хүнийг хэн алаь? Гээд,, Ай Аллах би огт мэдсэнгүй гэхэд нт онгоцны дарга: “Чиний мэдэхгүй гэдэг чинь зөв. Гэвч энэ бөгж хаанаас олсноо яригтун! Хэмээвэл: “Энэ загасны загалмайд байв” гэжээ . Онгоцныб дарга “Чиний хэлсэн зөв. Хаан чамайг усанд “Хаягтун” гэж дохиход нь цонхоор нэг гялгар юм үсрэн далайд унахыг би нүдээрээ үзсэн билээ . тэр нь хааны бөгж сугаран далайд унасныг загас шүүрэн залгиж, Аллах чамайг ивгээснээр энд ирж торонд оржээ . Энэ бөгжийн увидсыг чи мэдэх үү?” гэхэд нь Абу-Сир”Мэдэхгүй” гэсэнд онгоцны дарга өгүүлрүн: Энэ бөгж далдын илбэтэй бөгөөд манай хаан гагцхүү энэ бөгжийн хүчээр их цэрэг захирах ажээ . Хаан ямар нэг хүнд уурлан алахыг хүсвэл энэ бөгжтэй гарыг ддохиход нөгөө хүний толгой тасран унана. Учир нь нь энэ бөгж цахилгаан хүчин гарч их хор уур болон хүнийг алдаг юм гэжээ . Абу-Сир үгийг сонсоод маш баярлан, “Намайг хотод буцааж хүргэгтүн!” гэхэд нь онгоцны дарга өгүүлрүүн: “Хаан чамд, олдоо муу юм хийж чадахгүй учир би чамайг буцааж хүргэсүгэй. Учир нь хэрэв чи хааныг алая гэвэл нэгэн хуруугаар зангах төдий хааны толгой мөрөн дээрээс өнхрөн унах бөгөөд яи өөрөө төдий сууя гэсэн ч түүний бүх цэргийг нэгэн зангах төдий цөмийг устгах тул над айх юм алга ” гэжээ . Онгоцны дарга Абу-Сирийг завьд ёсуулгаж, хот руу хүргэсэнд Абу-Сир шууд хааны ордонд орлоо. Хаан, түүниф дайчиэ эрс цөм ё суух атал хаан бөгжөө алга болгосноо хэлж чадахгүй их л гуниглан байлаа . Хаан, Абу-Сирий орж ирэхийг үзээд: “Чамайг бид далайд хаясан биш үү? џЧи яагаад гараад ирэв?” гэхэд нь Абу-Сир өгүүлрүүн: “ай цагийг эзэлсэн хаанг минь, чи намайг далайд хая гэж тушаагаад , танай онгоцны дарга намайг тэртээ арал дээр аваачаад “Чи манай хаанд ямар муу юм хийв хаан чамайг ямар учир алах болов?” гэхэд нь би: “Аллахыг ам алдан, би ямар му юм хийснээ өөрөө боловч үл мэднэ” гэхэд минь, олнгоцны дарга “Чи манай хааны дэргэд онцгой хүндэт суудалд эзлэх тул ямар нэг хүн чамд хорсон атархаж, хаанд ямар нэг хов хүргэснээс хаан ихэд хилэгнэсэн ажээ. Харин чиний халуун усанд миний нэг удаа орход чи намайг машид хүндэтгэсэнд тул чамайг сулд тавьж нутагт чинь буцаасугай” гээд миний оронд шуудайд чулуу хийсэнд чи намайг ус руу хаясугай гэж дохихдоо бөгжийг далайд унагасныг загас залгижээ . Энэ үес би тэртээ арал дээр олон загас барьж нэгийг шарж идье гэж гэдсийг хагалтал энэ бөгж байсан тул авч зүүлээ . Тэгтэл танай тогоочийн илгээсэн хоёр хүн загас авя гэж очиход нь эл бөгжийн увидсыг эс мэдэн хуруугаар ангатал т толгой нь өнхрөн унасан бөгөөд даруй онгоцны дарга очиж бөгжийн далд увидастайг ярихад нь чамайг над туйлын их буян хишиг хүртээсэгийг бодож авчрав. Чи бөгжөө ав! харин ыби чамд алагпах ямар муу үйл хийсний минь ярьж өгнө үү . үнэхээр чамд тийм муу үйл санасан байвал намайг алагтун!” гээд бөгжийг бариваас, хаан бөгжийг авч хуруунд хийгээд сая санаа амарч Абу-Сирийг тэврэн: Ай чи, Аллахын шилдэг хөвгүүдийн нэг даруй мөн Чамайг далайд хаяулсны минь уучилна уу. Чамаас өөр хүн энэ бөгжийг олсон бол өгөхгүй байсан гэхэд нь Абу-Сир: “Ай цагийг эзэлсэн хаан, би ямар нүгэл хисний учир хилэгнэн намайг алах гэсэн учраа хэлбэл би

чамайг бас уучлана” гэсэнд хаан: “ай Аллах! Чи над ийнхүү их буян үйлдсэн тул ямар ч буруу, ямар ч нүгэл байхгүй гэж бат өгүүлрүүн: гээд будагчин Абу-Кирийн ярьсныг цөмийг ярьужээ . Абу-Сир энэ үгийг сонсоод “ай цагийг эзэлсэн хаан, Аллахыг ам алдан өгүүлсүгэй. Би насандаа христос мөргөлтний газар очиж, христосын гүрний хааныг эс үзэв. Чамайг алах санаа трөрсөн нь огт үгүү . бөгөөд тэрхүү будагчин бид хоёр Искагөдари балгадад айл суудаг атал аж амьдралаа баахан хавчигдаад хэн ажил хийсэн маань нөгөөг тэжээх ам тангар г тавьж энэ газар ирсэн билэS гээд будагчин Абу-Кир хэрхэн мөнгийг авч цоожлон явсан байшингийн эзэ- хэрхэн асарч биеийг эрүүл богосон, тэндээс зээлийн газар үвтал хэрхэн Абу-Киртэй дайралдаж, будагчны үүдэнд очтол Абу-Кир түүнийг хэрхэнхулгайч гүтгэж доромжлон нэвширтэл зодсон зэргийг цөмийг яриад, “ай цагийг эзэлсэн хаан, Абу-Кир миний халуун усны газрыг үзээд тун сайхан болсон атал гагцхүү хүний хэрэггүй үс арилгах эм дутжээ гэж тэр өөрөө хэлсэн билээ Үнэхээр манай гүрэнд халуун усны газар тийм эм байдаг бөгөөд энэ бол хүний биед хортой биш гэж мэдтүгэй! Харин би түүнийг мартсан байтал будагчин Абу-Кир ирж өөрөө сануулсан хэрэг юм . та одоо миний сууж байсан байшингийн эзэн хийгээд будагчны бүх улсыг авчран миний саяын ярьсан үнэн худал алин болохыг асууя” гэжээ .Хаан тэдгээр хүмүүсийг дуудаж асуувал тэд уг болсон ядлыг ярьсанд хаан “Будагчин Абу-Кирийг гарыг хүлээд малгайгүй, хө нүцгэн авчирсугай!” гэж зарлиг буулгажээ . Будагчин энэ үес Абу-Сирийг алуулав гэж гэртээ их л маадгар хэвтэж байтал хааны дотны эрс дайран орж шил рүү нь цохиж унагаад гарыг сушгиж хаанд хүргэж ирвэл Абу-Сир хаан лугаа суудао зэрэгцэн сууж, мөнөөхөн байшингийн эзэн, будагчны газрын ажилчид бас байжээ . Абу-Кирийг хааны өмнө авачиж сөгдүүлээд байшингийн эзэн мөнгийг хулгайлаад манай байшинд өвчтэй орхидог нөхөр чинь энэ биш үү? Гэж асуухад будагчны ажилчид: “Чи энэ хүнийг биднээр бөариулж зодуулсан биш үү?” гэцгээв. Хаан, Абу-Кирийн бузар булайг нэгмөсөн мэдэж, МункарНакир хоёроос илүү тамалвал таарах хүн гэж үзээд “үүнийг хотын зээлээр хэсүүлж олонд үзүүлээд шуудайд хийж далайд хаягтун!” гэхэд нь Абу-Сир: “Аяа хаан минь ээ, энэ хүнийг өршөөгтүн: Түүний бүх үйлдсэн хSргийг би уучилна” гэсэнд хаан: “Чи өөрийн тул уучлах боловч би чиний төлөө уучилж эс чадна. Аваад гар!” гэжээ . Тэгээд Абу-Кирийг шохойтой шуудайнд хийж далайд хаясанд түлэгдэн үхэж их далайд живжээ . “Ай Абу-Сир чи надаас юу хүснэ вэ” гэж хаан асуусанд Абу-Сир: “Энэ газар суур хүсэл над алгаа. Намайг орон нутагт минь буцаана уу?” гэсэнд хаан: “Чи миний шадар сайд бологтун!” гээд Абу-Сирийг эс зөвшөөрсөнд, урьдыхаас илүү их хөрөнгө мөнгө шагнаад тусгай хөлөг онгоц гаргаж нутагт нь буцаах болов. Абу-Сир хаантай салах ёс хийж, өөрийн хөлөг онгоцтой, өөрийн далайчидтай гарч явсаар искандари их балгадад эсэн мэнд хүрч иржээ . Искандарийн боомтод хөлгийг татаж, хуурай газар дээр гартал эргийн захан нэгэн шуудайтай юм байхыг далайчин үзээд: “ай ноён минь энэ эрэгт нэгэн их хүнд шуудайтай юм байна. Дотор нь юу байгааг эс мэднэ” гэхэд нь Абу-Сир очиж амны боолтыг тайлж үзвээс Абу-Кирийн хүүр далайн давалгаанд туугдан ирсэ байжээ . Абу-Кирийг Искандарийн орчим газар малтаж хөрөнгө гаргаж булж оршуулаад булш авсны таг дээр: Эрхэм сайн эрийг үйл явдлаар нь ялган танина Эдний үйлийн заа ямагт сүр жавхлантай ажээ . Өөр бусдыг бүү буруушаагтунӨгүүлсэн яриа тэр чигээр байх нь ховор шүү!Хав нохойг хүнд эрхэм

гэж бид гэртээ байлгадаJХарин догшин арслан ухаан мунхагийн учир ямагт гинжтэй хэвтдэг Үхдэл хүүр дэлгэйн дээр хонгионоос урсан хөвөхөд Үнэндээ эрдэнэ сувд нь түүнээс доор нуугдана Бор шувуу хчит харцагатай тэмцэлдвэлБодлогогүй тэнэгийн харгай даруй мөн болно “Эрхэм сайн үйл бүтээсэн хүн эрхмийг олно” гэж Эрт тэнгэрийн худаснаа бичээстэй байдаг билээ . Анарын модноос чихэр гаргах гэж бүү оролдогтунАмьтны хувьд нэгэн төрөлд хоёлуу багтанагэж сийлжээ . Хэдэн жилийн дараа Абу-Сир насан өөд болоход түүний нөхөр Абу-кирийн хажуд оршуулсанаар Абу-Кир, Абу-Сир нэрт газар бий болсон атал одоо Абу-Кир гэж алдаршсан билээ. тэр хоёрын намтар ийм бүлгээ . Гэвч өдөр ба шөнийг гагцхүү үнэн мөн ялгах болтугай! Эрт урьд цагт хэрэмт Миср хотноо гуталчин Маруф гэгч нэгэн хүн амьдардаг байжээ . Түүний гэргий айшхи эм Фатима туйлын ярдаг хэрүүлч хүн ажээ . Фатима эр нөхрийг дийлэн зовоож өдөрт мянгантаа хараан загнах атал Маруф угаас нэр сүрийг бодох саруул ухаантай хүн тул эмээн сүрдсээр суудаг байв. маруф уулын ядуу хоосон хүн, олсныг эхнэр нь үрэн таран хийхийн хамт бас шөнө болгон хариу авах мэт биеийг зовоох нь их тул үргэлж их л зовлонтой хонох бүогээ. Өөрөөр хэлбэл Фатима бол:Амраг гэргийн өвөрт олон шөнө унтлааАмар заяа үзсэн удаа огт үгйү би«ээ . Өвөрт нь орохдоо болдогсон бол хор аьч ороод,Өөрийн эрхгүй амь юугий нь холох билээгэж шүлэгчийн хэлсэнтэй туйлын адилхан эм билээ . Нэг өглөө Фатима өгүүлрүүн: “Ай муу маруф чи, орой ирэхдээ зөгий болтай боов авчиртугай” гэхэд нь Маруф “Аллах чамайг харж боовны мөнгө хайрлах аваас авчирсугай. Бурхан өршөөн хэлтрүүлэх бий!” гэсэнд Фатима: “Тэрхүү хэлтрүүлэх эс хэлтрүүлэх гэдгий чинь би мэдэхгүй. Ямар ч гэсэн орой зөгийн балтай боов эс авчирвал энэ шөнө унтахгүй гэж мэдээрэй” гэжээ . Маруф гуталчин, Аллахын нэрийг дурдаж гэрээс гараад сая ссэтгэл амарч, өглөөний мөргөл үйлдээд мухлагийг нээж, “Аяа энэ минь өнөөдөр боовны үнэ олж, ирэх шөнийн зовлонгоос ангижрах юмсан” гэж залбиран үд өнгөртөл суутал нэг ч хүн иржгутал загнуулсангүй. Маруф эхнэрээс эмээхийн эрхэнд мухлагийг хааж нэгэн боовны дэлгүүрийн дэргэдүүр доголон нулимстай, уруу царайтай гартал, бооны намаачин: Ай Маруф чи юунд уйлав? Гэхэд нь эхнэрийн хэлснийг яриад “миний эхнэр туйлйын хатуу сэтгэлтэй хн тул орой заавал боов авчраарай гэсэн атал үд өнгөртөл нэг чхүн гутал загнуулахаар эс ирсэнд, одоо би эхнэрт аваачих юмгүй яана!”гэжээ . Худалдаачин чи хичнээн жин боов авах гэсэн юм? гээд “таван жин” гэхэд нь “Над шар тос бий боловч зөгийн бал байхгүй. гэвч нишингийн бал түрхсэн тул зөгийн балаас хэрхэвч доргүй” гэжээ . Маруф бэлхнээ төлөх мөнгөгүй санаа зовох боловч “За яахахв нишингийн балта боод авъя” гэсэнд захисаан боов дор нь хайрч нишингийн бал түрхсэн нь эрхэм хаадын зооголдогоос доргүй сайхан боов байжээ . Бас “Боорцог, бяслаг авах уу?” гэхэд нь авъя хэмээвээс мөн жинлээд “Дөрвөн тал мөнгөн зоосны боорцог, нэг тал мөнгөн зоосны бяслаг, арван тал мөнөн зоосны боов бүгд арван тадан тал мөнгөн зоос болов. Эхнэртээ аваачиж санаагий нь амрааж үз. хоёр гурав хоногийн дара мөнгөтэй болсон цагтаа үнийг өгөөрэй” гэжээ . Маруф саaa амарч, “Энэ яасан буянтай хүн бэ?” гэ залбиран харьтал эхнэр нь за чи авчрав уу? гэсэнд авчрав гэд өмнө нь тавьаал нишингийн балтай боов байхы үзээд “Би зөгийн балтай боов авчир гэсэн биш бил үү? Чи миний үгийг эс тоож, нишингийн балтай боов авчирав уу?” гэжээ . Маруф уучлалыг эрж, “Би бас заал авлаа шүү дээ” гэсэнд

ÃÓÒÀË×ÈÉÍÀÐÓÓÏ ËÃÝÐ

Фатима , “Над ямар хамаа байна. Би заавал зөгийн балтайг иднэ!” гэж ихэд уурлан Маруфийн хацрыг тасхийтэл алгадаад “Муу зжжч чи одоо явж өөрийг авчир!” гээд бас эрүү рүү нь нударгалан хоёр шүдийг булга цохиж, их цус асгаруулсанд Маруф уур хүрч, аяархан сөргүүлтэл сахлаас зууран, Ай лалын шажинтан амьтан ах дүү нараа! гэж учиргүй бархирваас айлын улс гүйлдэн ирж салгаад Фатима хүүхнийг зэмлэн “Хүн болгон нишингийн балтай боов дуртайя иддэг байхад чи энэ муу ядуу эрийг юунд ийнхүү сүрхий загнана вэ? Чи яасан булай эм бэ?” гэж үглэсээр эвлэрүүлэн явтад Фатима тэр боовыг аясан ч идэхгүй гэжээ . Маруф ихэд өлсөх тул, за яахав чамайг эс идвээс би идсүгэй гээд идэж гарсандп Фатима үзээд “Наад боовондоо хордож иүхнэ дээ!” гэжээ . Чи нэгэнт яасан ч идэхгүй Јэсэн тул яая гэхэв. Аллах өршөөх юм бол маргааш чамд зөгийн балтай боов авчирч өгье Чи ганцаараа идээрэй гэжээ . Фатимад шөнөжин хараалгаж хоноод маргааш өглөө нь болоход Фатима Маруфийг зодох гэж ханцуй шамалсаар байв. Маруф сүмд очиж мөргөл үйлдээд мухлагийг нээж дөнгө суутал зарга ялгагчийн илгээсэн хоёр хүн ирж “Зарга ялгагх түшмэл дуудаж байна. Чиний эхнэо зарга мэдүүлжээ” гэхэд нь очвол Фатимын хоёр гар боолттой, толгойн бүтээлэг дан цус болсон эхэр татан уйлж ыббайжээ . Зарга ялгагч түшмэл “Ай чи Аллах тэнгэрээс э айдаггүй юм уу! Чи юунд энэ эмийн хоёр гарыг хугалж шүдийг булга цохив?” гэхэд нь Маруф өгүүлрүүн: “хэрэв би энүүнийг зодож шүдийг нь булга цохисон бол намайг дураар залхаатугай . Харин энэ намайг зодсонд айлын хүмүүс ирж салгаж билээ” гээд уг болсон хэргийг эхнээс нь адаг хүртэл яривал зарга ялгагч их сайн тул дөрвөн динар зоос өгч “Үүгээр зөгийн балтай боов авч өгөөд та хоёр эвлэртүгэй” гэсэнд Маруф, “Үүнд өгөтүн!” гэжээ . Фатима мөнгийг авав. Заргя ялгагч өгүүлрүүн: “Чи ч эр нөхрийнхөө үгэнд орж, чи ч эм хүнийг аятай байлгах хэрэгтэй” гэжээ . Тэндээс Маруф Фатима хоёр гарт тус тусын замаар ороод Маруф мухлагтаа иртэл зарга ялгагчийн хоёр элч ирж хөлс нэхсэнд Маруф: “Зарга ялйгагч надаас хөлс аваагүйгээр барахгүй над дөрвөн динар зоос өгсөн шүү дээ” гэхэд нь тэр хоёр “Зарга ялгагч мөнгө авсан буюу өгсөн нь бидэнд хамаагүй . Чамайг өгөхгүй бол булааж авна даа” гээд чирэх тул Маруф арга буюу багажаа худалдан тал динар зоос өгөв. Тэгээд ажил хийе гэтэл багажгүй болж шанаа тулж гунигтай сууж байтал өөр хоёр элч ирж: “Чамайг зарга ялгагч дуудаж байна. Эхнэр чинь манай түшмэлд зарга мэдүүлжээ. ” гэсэнд Маруф: “Зарга ялгагч саяхан бид хоёрыг эвлэрүүлсэн билээ” гэвэл Үгүй өөр түшмэл дуудаж байна гэжээ . Арга ялгагч түшмэд дээр очвоос Фатима байх тул Маруф”Ай чи үнэнч хүний охин бол сая чи бид хоёрыг эвлэрсэн билээ” гэсэнд Фатима, чи бид хоёр хэзээ ч эвлэрэхгүй гэжээ . Маруф зарга ялгагч түшмэлд хамаг учраа тоочвол “Саяхан нэгэн түшмэл биднийг эвлэрүүлсэн билээ” гэсэнд” түшмэл Фатимад өгүүлрүүн: “Ай садар самуун эм” чи нэгэнт эвлэрсэн атал дахин вунд заргалдана? Гэсэнд Фатима “Энэ бас дахин намайг зодов” гэжээ . Зарга ялгагч: “За та хоёр эвлэртүгэй. Чи ч дахин үүнийг битгий зод, чи ч эр нөхрийнэлдвээр бүү өд” гээд хоёр элчийн хөлсийн төлсүгэй гэсэнд Маруф байдаг мөнгөө шавхан өгөд мансууртал гашуудан гуталчны газар очвол даруй нэгэн хүн ирж: “Ай Маруф чи явж нуугдагтун! Эхнэр чинь бүр дээд шүүхэд зарга мэдүүлжээ “ гэсэнд Маруф яаран гарч Ялалтын хаалганы зүг санд мэнд зугатжээ . Маруфт багажаа худалдсанаас үлдсэн тавхан мөнгөн зоос байсанд дөрвөн зоосны боорцог, нэг зоосны бяслаг аваад Фатимаас оргон зайлав. Энэ үе

бол тэр нутгийн өвлийн өдөр ид өнгөрч байлаа . Маруф нэгэн их хог дээр очтол бороо хувингаар юулэх адил асгаж шалба цохиулаад Киарын сүмд ортол хаалгагүй хуучиэ зоринд орж үер бороонoос хоргоджээ . “Аяа энэ саміун эмээс би хаашаа зугтаадаг билээ . Тэнгэр таалж намайг ү« гүйцэгдэх харь оронд авачдаг болоосой!” гэж залбиртал өөрийн эрхгүй нүдний нулимс асгарна Иийнхүү гашуун уйлж байтал хэрмийн туурга хага үсэрч дотроос нь үс нь хөлийн өлмийд хүрсэн өндөр хий юм гарч ирээд “Ай чи энэ орой болсон хойно намайг юунд үймүүлнэ . Би энд хоёр зуун жил оршин суухад ч хүн ирээгүй билээ . Би чамайг ихэд өрөвдөх тул чи юу хүсвэл дуртайяа биелүүлье” гэхэд нь чи хэн болохыг би үл мэднэ хэмээвэл, би энэ газрын эзэн гэжээ . Маруф үнэн учраа түүнд нэгд нэггүй ярьсанд “Аяа чамайг хүсэх аваас эхнэрий чинь яагаад ч эс олох гүрэнд хргэе” гэхэду нь за тэгье гэжээ . Тэр хүн дүрст хий юм . за чи миний нуруун дээр морд! гэжээ . Мөнөөхөн хий юм Маруфийг унуулж үдшээс өглөөний үүр шөнө хагацтал нисээд нэгэн өдөр уулын оройд бууж, за чи эндээс нэгэн өндөр уулын оройд бууж, за чи эндээс доош буутал бэлд нээн их хотын дүүрэг залгана. Тэр хотод орвол эхнэр чинь хэрхэвч эс олно гээд алга болжээ . Маруф наран мандтал сэтгэл зовнин суугаад, “Энд дэмий сууж юу хийнэ” гэж бодоод уулнаас буутал өнөдр хана хэрэмтэй, орд харш, лон гоё барилгатай тансаг сайхан хот байжээ . Маруф хэрмиын хаалгаар ортол сэтгэл сэргэж, гудамжаар ортол улс амьтан шавж , хувцас хунары нь машид гайхацгаах ажээ . нэг хүн, Ай чи харийн хүн үү? Аль гүрнээс ирсэн бэ? гэхэд нь жагалтай Миср балгадаас ирдээ гээд нутгаас гараад удаж байна уу? гэхэд нь өчигдөр үдээс хойш гарлаа гэсэнд тэр ихэд инээж:”Ай таминь нааш ир, үүний ярихыг сонсооч!” гэжээ .Нөгөө хүн өгүүлрүүн: “Энэ хүн өчигдөр үдээс хойш Миср балгадаас гарлаа” гэх юмаа гэхэд нь улс амьтан инээлдэж, Ай хүн чи, баахан ухаан солиотой ажээ . “Эндээс Миср балгад орход жил явдаг атал чи өчигдар орой гараад ирлээ гэнэ. ” гэцгээхэд нь харин та нар ухаан солиротой ажээ . Худлаа гэвэл өчигдөр авч гарсан боов хатаагүй байна үзүүлтэл үнэхээр харь гүрний боов байхыг үзээд нэн гахжээ . Луус хөллөж, хоёр боол дагалдуулсан нэгэн худалдаачин ирж: “та нар харийн хүнийг шавж дооглон инээлдэж байхаасаа ичихгүй юу!” гэж цөмий нь аашлан хөөж тараагаад , “ай дүү минь нааш ир!” гэж дагуулан уудам саруул бөайшинд орж хааны адил түшлэгтэй сандалд суулган авдрыг уудлан тэр газрын худалдаачны сайхан хувцас гаргаж өмсгөвөл Маруф үнэхээр тэргүүн худалдаачин байрта божээ . Мөнөөхөн худалдаачин ширээ засаж сайхан хоол унд тавьсанд Маруф цадтал идэж уулаа . Тэгээд худалдаачин асууруун: “Чиний нэр хэн бэ?”,“Миний нэр Маруф хүний хуучин хувцас гутал загнаж амьдардаг” гэхэд нь чи аль гүрний хүн бэ? гэсэнд, би Миср балгадынх гээд, ямар хороонд суудаг вэ? гэхэд нь чи бас Миср балгадыг мэддэг юм уу. Улаан гудамжнаа суудаг гэсэнд : Худалдаачин : Ай би тэнз төрсөн хүн ОдооУлаан гудамжнаа ямар айл суудаг бол? гэхэд нь Маруф тийм тийм айл суудаг гэж тоочлоо. “Чи эм, будгийн наймаачин шейх лам, Ахмедийг таних уу? гэхэд нь манайх айл суудаг юм гээд тэлнийх сайн уу? Хэдэн хүүдэтэй вэ? Хүүхдүүд нь ямаршуу байна гэхэд нь сайн. Мустаф, мухаммед, Али хэмээх гурван хүүхэдтэй билээ . Мустаф нь ”эрдэмтэн багш болсон: Мухаммед хүү нь эм будгийн наймаачин болоод эцгийн хажууд бас нэг дэлгүүр гаргажээ . Гэрлэсний дараа Хасан нэртэй сайхан хүүтэй болсон доо гэхэд нь худалдаачин: Аллах чамайг таалах болтугай! Чи

их сайн амтай хүн байна гэхэд нь Маруф өгүүлрүүн: Би багадаа тэр Алитай үерхэн тоглодог билээ . Бид христос мөргөлийн хувцас өмсөж, сүмд ороод христросын ном хулгайлан зарж чихэр авч иддэг баж: нэг өдөр бид баригдаж, Алийг эцэгт нь чирч аваачаад “Энэ хүүхдээ захирхгүй бол хаанд мэдүүлнэ” гэхэд н эцэг нь хүүгээ нэвширтэл ззодсонд Али тэр чигээрээ оргож сураггүй алга болсон юм . тэр цагаас хойш хорин жил болж байна гэхэд нь худалдаачин дуу алдан “Шейх лам Ахмедийн хүү Али би мөн байна Чи миний нөхөр Маруф ажээ ” гэсэнд хоёул тэсгэлгүй баяралдан тэврэлцээд худалдаачин асууруун: “Ай Маруф чи ямар учраас Миср балгадыг орхин энд ирэв?” гэсэнд Маруф, өөрийн эхнэр айшхи эмтэнй хэрэлдсэн учраа яриад “Тийнхүү тэсхүйе бэрх болмогц би зүгатааж ялалтын хаалганы зүг одвоос учиргүй их бороо асгараад нэгэн эвдэрхий зооринд орж уйлан суутал тэр газрын нэг бирид ирж учрыг асуувал би цөмийг ярьсанд намайш и унуулж шөнөжин ниссээр нэгэн өндөр уулын оройд буулгаад энэ хотыг зааж өгсөн юм . Тэндээс энэ хотод орж ирэхэд олон хүн шавж асуугаад байхаар нв “Би Миср балгадаас өчигдөр гарав гэхэд тэд үнэмшихгүй байтал чи ирж хөөж тараагаад гэртээ авчирлаа . Миср балгадыг минь орхисон учир нь . Харин чи яагаад ирсэн бэ?”гэжээ . Худалдаачин өгүүлрүүн: “Би найман настай балчрын харгаагаар нутгийг огоорч, айлаас айл, хотоос хотыг дамжин хэссээр энэхүү Ихтиян аль Хатан хэмээгдэх хотод ирсэн билээ . Энэ газрынхан эрхэм буянтай улс, ядуу хүнийг өрөвдөн итгэж зээл мөнгө өгдөг. “Би худалдаачин хүн атал хсмгөөс түрүүлэн ирэв. Аянаа хураах газар байна уу?” гэхэд минь эд тийм байр гаргаж өгөв. “Над нэгэн мянган динар зоос зээл өгөх хүн байна уу. Би хөлөг ирэхээс өмнө жаахан юм авахаар байна”” гэхэд нөд мянган динар зоос өгсөнд би зээлээс эд бөараа авч дамлаад таван зуун динар зоос хожиж бас эд авч зарсаар баяжтал би ч тэднийг хүндэлдэг, тэд ч нарад сайн боллоо . “Магтах мэхлэх хоёр бол энэ ертөнцийн амьдрал юм . Хүн танихгүй газар юу санаснаа хийж болно” гэж мэргэн үг бий гэж мэдтүгэй. Хэрэв чи “Би гутал загнадаг ядуу хоосон хүн, эхнэртSэ хөөгдөөд өчигдөр Миср балгадаас ирлээ” гэж яриад байвал хэн ч үнэмшихгүй.Бирид унаж ирлээ гэвэл чинь “Биридтэй нөхөцсөн хүнтэй ойртвол гай болно” гэж айгаад улс чамаас бүр зайлах болно. Тэгвэл тэд намайг Мисрийн хүн гэж мэдэх тул бид хоёрын хэн хэнл амаань муу юм болно гэжээ . “Тэгвэл чи яавал тарах вэ?” гэж Маруфийн асуусах Али өгүүлрүүн: “Яахыг би чамд зааж өгье. Би чамд мянган динар зроос, унах луус, бараа болох боол өгнө. Маргааш олон худалдаачны байдаг зээлийн газар очиход чинь би тосон очиж амрыг эрээд, гары чинь үнсэж хэргэм цолы чинь өргөмжлөн “За та тийм эв авчрав уу” гэж асуух бүрий “зөндөө гээд байгаарай”, Тэд надаас асуувал би чамайг магтан аргамжилж, “Энэ хүнд дэлгүүр эд хураах газар хөлслөгтүн!”гэнэ. хэрэв гуйланчин хүн ирвэл өглөг их өгөөрэй. Тэгвэл миний үгийг үнэмшиж , чамайг их өгөөмөр баян хүн гж эрхэмлэн хүндлэх болно. Тэгээд чамайг тэднийг би гэртээ урьж танилцуулах тул чи тэдэнтэй наймаа ярилцан удахгүй их баяжих болно гэжээ . Маргааш өглөө нь Али Маруфт мянган динар зоос, өгч луус , бараа болох боол гаргаад: “Чи нэгэнт минй сайн нөхөр учир би чамд их тус боох ёстой. Чи сэтгэлээ талибун байлгаж эхнэртээ хөөгдөв гэж хэнд ч бүү яриарай” гэсэнд Маруф : “Чамайг Аллах өршөөх болиугай!” гээд луусыг унаж, бооолоор хөтлүүлэн зээлийн газар орвол бүх худалдаачин байх ба Али ч бас тэнд ирчихсэн байлаа . Али угтан босож ирээд:

ай баян худалдаачин Маруф ирдэг өнөөдөр юутай ерөөлт өдөр билээ гээд гарыг үнэсэж_ "ай эрхэм худалдаачингууд аа! Худалдаачин Маруфт ирсэн нь бидэнд баяртай хэрэг болжээ!" гэсэнд зээлийн олон худалдаачин Маруфийг их хүн хэмээн бодож цөм мэндэлж ихэд хүндрэл гарлаа. "Энэ худалдаачин хүн үү?" гэцгээхэд нь Али өгүүлрүүн: Үнэхээр энэ хүн х мгийн том худадачин бөгөөд миср балгадад нэртэй гурван үеийн баян хүн билээ . Энэ хүн Энтхэг,Жагар Йемен газар боловч олон танилтай, асар өглөгч билээ. Эрхмүүд эл учрыг мэдэж хүндлэгтүн! Худалаачин маруф энэ хотод ирэхдээ наймаа хийх гэсэн нь огт бус гагцхүү харийн хот балгадыг үзэх гэж ирсэн биз. Яагаад гэвэл энэ хүн ахрь газар ирж наймаа худалдаа хийхийн хэрэгцээгүй их мөнгөтэй ажээ. Би бол энэ хүний нэг зарц билээ гэж Маруфийг дайлж, хотын тэргүүн худалдаачин боловч биеэр морилон ирлээ . Ийнхүү олон худаладачны нүүрэн дээр Али асууруун: "Ай Маруф чи тийм бараа авчрав уу?" гэхэд нь Маруф"Зөндөө"гэжээ. (Али түүнд элдэв үнэт хямд эд бараа бөсийн нэр зэргийг хэдий нь зааж өгсөн байжээ ) Нэгэн худалдаачин: Ай ноён минь минь шар либэ авчрав уу? гэхэд нь Маруф "Зөндөө" гэжээ: "Зээрийн цус мэт улаан өнгийг авчрав уу?" гэхэд нь "Зөндөө" гэж ер нь бөс асуух бүрийд "Зөндөө" гээд байжээ. Тэгэхэд нэг худалдаачин өгүүлрүүн: Аяа Али танай нутгийн энэ хүн мянган бооволд сайн эд авчиръя гэвэл авчрах хүн шив дээ? гэхэд нь "Өөрийн олон зоорины нэгээс нь гаргахад цаана огт хоргодох шинжгүй үлдэнэ" гэжээ .Тэгтэл нэг гуйланчин ирсэнд зарим нь нэг мөнгөн зоос хаях бөгөөд ихэнх нь юу ч өгөхгүй байтал Маруф атга алтан зоос өгсөнд будаг худалдаачин нар хараад, "Хаан хүн л ийм ихийг тоолохгүй хайрладаг билээ . Гуйланчингуудад ийнхүү атга атгаар алтан зоос хайрлаж байхыг үзэхэдэ цаанаа лав их юмтай хүн" гэж эрхбиш боджээ Нэг ядуу эм ирж, Маруф түүнд атга алтан зоос өгвөөс тэр эм буян ерөөж бусаддаа, очиж хэлжээ . Цаадуул нь цувран иртэл Маруф атга тагаар өгсөөр мянган динар зоосыг дуусч алгыг гүвээд энэ хотын ардын олонхи нь ядуу гуйланчин улсад түгээн өгөх байжээ . Би ядуу хүнд өглөг эсц өгч үл чадна. Одоо авч явсан алтан зоосыг барав. Ядуу хүн хүрээд ирвэл юу хэлдэг билээ" гэхэд нь "Аллах хайрлаа буй заа!" гэхгүй юу гэж тэргүүн худалдааин өгүүлбээс Маруф: "Би тэгж сураагүй юм . миний ачаа хөсөг иртэл над мянган динар зоос зээлсүгэй" гэхэд нь тэргүүн худалдаачин зарцыг дуудаж мянган динар зоос авчруулаад өгөв. Маруф дэргэдүүр өнгөрсөн ядуу болгонд өгсөөр байтал үдийн мөргөлийн харнга дэлдэв. Хүмүүс сүмд орцгоон үдийн мөргөл үйлдэхэд Маруф үлдсэн зоосыг тэдний толгой дээр тараан цацсанд хуран угларсан Маруфийг ерөөн, харж байсан худалдаачингууд түүний өглөгч буянтайг ихэд гайхжээ . Маруф бас өөр нэгэн худалдаачинаас мянган днар зоос авч ядуу хүмүүёт тараан өгөхөд Али юу ч хэлж чадсангүй . Маруф үдшийн мөргөд болтол зоос тараагаад үлдсэнийг нь үдшийн мөгөлд ирэгдэд цацан өгчээ . ийнхүү зээл тартал таван мянган динар коос тараасан бөгөөд худалдаачингуудад "Миний ачаа хөсөг ирэхээр алт бол алт, эд бол эд аваарай" гэсээр байжээ . Орой болсон хойно Али Маруф ба бусад худалдаачин нарыг гэртээ урьж хүндэт суудалд залж дайлсанд тэд эд бараа эрдэнийн чулу ярихад Маруф "Над зөндөө бий!" гэх ажээ . Маргааш өглөө эь бас л зээлийн ядуу хүмүүст тараан өгсөөр хорь хоноход зургаан тзмэн динар зоос зээлсэн атал түүнд ачаа бараа ч эс ирнэ. Халуун хижиг ч эс тусна. Ингэтэл худалдааингууд өвөр хоорондоо ярилцан "Маруфийн хөсөг эс ирэх атал энэ хүн

хэдий болтол бидний мөнгийг ядуу гуйланчин тараах юм бэ? гэцгээхэд нэг нь "Нутгийн нь Али худалдаачинтай ярилцвал дээр биз" гэхэд нь тэд очиж "Аяа, худалдаачин Али, мөнөөхөн Маруф юу болж байна Би чамд өнгийг болго гэснээс биш бүр түлчих! Гэсэн үү?" Чи тэдгээр худалдаачин нараас зургаан түмэн динар зоос зээл авч гуйланчнуудад тараан өгчээ . Гэтэл чи нэг ч наймаа хийхгүй тул яаж төлөх вэ? гэсэнв Маруф өгүүлрүүн: "Зургаан түмэн динар зоос авлаа гээд юу болов? Миний хөсөг ирэхээр эд бол эд. Алт бол алт мөнгө бол мөнгө авна биз" гэхэд нь "Чамд тийм ачаа хөсөг бий юм уу?" гэсэнд "Зөндөө " гэжээ . Алии дуун алдаж: "Чиний энэ муу зангий чинь Аллах алхаах болтугай гэсэн үгийг над хэлээрэй гэж би чамд зааж өгсөн үү?! Тэгвэл үнэнийн чинв энэ улсад ярина шүү! гэсэнд Маруф "Олон юм ярилгүй яв. Би ядуу хн юм уу? Миний ачаа, бараа ирэхээр тэд нэг динар зоосоо хоёр богож авна биз над мөнгө хэрэггүй" гэжээ . Али уурлан : "Ай тэнэг минь над худал хэлбэл яадгийг чамд үзүүлнэ дээ!" гэсэнд Маруф, "Чи яавал яатугай. Харин тэр худалдаачин н р миний хөсгийг ирэхээр алдагдалгүй болно биз" гэжээ . Тэндээс Али уурлан одохдоо, "Би түүнийг зөндөө магтан билээ . одоо эргэж муулах юм бол би худалч болж хүнийг магтаад муулбал хоёр удаа худал хэлсэнтэй чанар нэг болно" гэж боджээ . Гэтэл худалдаачин нар ирж Алигаас ийн асууруун: "Ай чи түүүнтэй ярилцав уу?" гэцгээхэд нь Али "Би түүний өмнө ичгүүр хүлээв . Би бас мянган динар зоос өгөөд авъя гэж хэлж чадахгүй байна. тануус түүнд мөнгө өгөхдөө надаас асууж өгсөн биш өөрсдөө нэхэгтүн. Эс өгвөл энэ хотын хаанд мэдүүтүгэй" гэжээ :. Мөнөөхөн худалдаачин нар хаанд бараалхаж: Маруфийн тухай яриад: "Ай цагийг эзэлсэн хаан нь, тийм өгөөмр баян худалдаачинг яахыг бид эс мэднэ. Тэр биднээс зөндө мөнгө авя ядуу улсад атга атгар тараан өгсөн . хэрэюв тэр хүн хөрөнгө нимгэнтэй бол тийнхүү атга атгаар алтан коос өгөхөп сэтгэл үл түвдэх биз ээ, үнэхээо их баян бол түүний хөсөг ирэхээр мэдэгдэх биз. за тэр өөрөө ачаа хөсгөөс түрүүлэн ирэв хойноос удахгүй ирнэ гэх атал одоо хүртэл алга бөгөөд аливаа эд бөсийг тухай ярихадп "над зөндөө бий" гэх юм . тэ биднээс зургаан түмэн динар коос зээл авч цөмийг ядуу хоосон улсад тараажээ гэцгээгээд Маруфийн өгөөмрийг ихэд магтацгаажээ . Тэр хотын хаан Ашабаас* илүү ховдог шунахай хүн байжээ . Маруфийн баян өглөгчийг сонсоод хоювдог сэтгэл нь хөдөлж, өгүүлрүүн: "хэрэв сайхь худалдаачин бага хөрөнгөтэй бол тийм их өглөгч байж эс чадна. Хөсөг нь гарцаагүй ирнэ бий . Тэр цагт энэхүү худалдаачин нарт лав их мөнгө өгөх байх. Би бас энэ худалдаачидаас илүү их мөнгө авч адах бөгөөд юу гэвэл, хөсгийг ирэхэс урьд би дотночилон нөхөрлөж, охинтьойгоо ураг барилдуулаг өөрийн санг түүний сантай нйлүүлнэ гэхэд нь шадао сайд нь өгүүлрүүн: ай цагийг эзэлсэн хаан, тэр лав луйварчин хүн байх, луйварчин хүн, ховдог хүнийг ямагт чаддаг билээ" гэсэнд"Ай шадар сад аа, тэр үнэхээо луйварчин эсэх, үнэхээр баян эсхийг би шалгаад ориё гэхэд ньв та яаж шалгах бэ? гэхэд хаан өгүүлрүүн: "Над нэг эрдэнийн чулу бий . тэр худалдаачинг дуудаж чулууг үзүүлэхэд хэрэв таньж үнэ цэнийг андахгүй байвал үнэхээр баян хүн, хэрэв танихгүй байвал луйварчин хүн гэж мэдэж хамгийн муугаар ална" гэжээ. Хаан Маруфтхүн явуулж дагуулаад эелдэг сайхнаар амрыг эрж эрхэм хүндэт суудал Іавьж өгөөд зэрэгцэн суугаад "Чи худалдаачин Маруф уу?" гээд "Манай эндхийн худалдаачингуудаас зургаан түмэн динар зоос §ээл авсан гэж үнэн үү? Ямар уч°аас эгүлэн өгөхгүй байа"

гэсэнд Маруф өгүүлрүүн: : Миний ачаа хөсөг ирэхийг хүлээх биз. Би нэг динар зоосыг хоёр болгож, алт бол алт эд бол эд тэд юу таалбаас дуртайяа өгөх бөгөөд ядуу гуйланчин улсын дунд миний нэ° сүрийг сайтар хамгаалсан учраас мянган динар зоос зээлсэн хүнд хоёр мянган өгөх болно" гэжээ . Хаан мөнөөхөн чулуг гаргаж "Ай худалдаачин энэ ямар төрлий чулуу вэ?"(Мянган динар зоосоор авсан хамгийн эрхэм эрдэнийн чулу бажээ) гэсэнд Маруф чулууг авч эрхий хуруугаар имэрсэнд үйрчээ . хаан: "Хайран сайн эрдэнэ юунгд үйрэв" гэсэнд Маруф тачигнатал инээж, "Ай цагийг эзэлсэнг хаа энэ бол эдэнийн чулуу биш, хэсэг төмөрлөг болой . Үүний үнэ мянган динар хүрнэ. Ёстой эрдэнийн чулуу долоон түмэн зос хрэх боловч хушганаас жижиг очир алмасыг би үл тооно. Тэгэхэд чи хаан хүн байж ганц мячнган динар үнэтэй төмөрлөгийг эрдэнийн чулуу гэдэг. Үнэт эдийн сан хөмрөг байдаггүй ядуухан хаан байна даа" гэжээ . Хаан: "Чиний сая ярьдаг очир алмас хэмээх эдэнийн чулуу чамд их бий юу?" гэхэд нь "хөсөг ирэхээр, чамайг гуйсан гуйгаагүй, зөндөөнийг зүгээр өгнө" гэжээ . Хаан баярлан олон худалдаачинд "За тануус явцгаа энэ хүний хөсөг ирэхийг хүлээгтүн: Ирэхээр нь мөнгөө надаас аваарай!" гэжээ . Удалгүй хаан шадар сайдаа өгүүлрүүн: "удалдаачин Маруфийг аргадаж, миний охинтой гэрлүүлэх арга хийгтүн! Тэгвэл бид түүний бүхий л хөрөнгийг олж авна" гэхэд нь шадар сайд "ай цагийг эзэлсэн хаан минь түүний зан төрх нэг л биш лав худалч луйварчин буй заа . Охиноо дэмий алах болно" гжээээ . Уг нь шадар сайд хааны охиныг гуйхап хаан зөвшөөртөл охин нь эс зөвшөөрчээ . Хаан өгүүлрүүн: ай чи бас намайг мэхлэх санаатай юу! Урьд чи миний охиныг гуйса атал охин зөьшөөрсөнгүй , өөр хүнтэй гэрлэх замы нь хааж, эдэлгээгүй тарианы газар адил болгоод эцэст нь өөрөө авах санааай байна уу? Энэ хэрэг чамд падгүй тэр худалдаачин энэ эрдэнийн чулууг нэгэнт таньсан байхад чи түүнд дургүй гэнэ үү! Түүнд эрдэнийн чулу их, миний охиныг нүдээр үзээд сэьгэд зүрхнээс дурлах нь лав. тэгэхээр магад их хөрөнгө очир алмас тэргүүтэн ббидниййх болох биш үү. Охин бид хоёрт тийм их буян хишиг олдохыг чи эс хүснэ үү?" гэжээ . Шадар сайдп нь хааныг хилэгнэхээс эмээн дотроо "Үхэрт нохой турхирах адил гэжээ" гэж бодоод Маруфт очиж : Эрхэмсэг хаан чамайг таалжээ . өөрийнхөө хосгүй хөөрхөн охинтой чамайг гэрлүүлэхийг тэр хүснэ . "Чи дуртай байна уу?" гэсэнд Маруф өгүүлрүүн: "Сайхан үг байна. гагцхүү хөсөг ирэхийг хүлээнэ. Юу гэвэл хаан хүний охиныг авахад асар их инж хэрэгтэй ыбайтал одоохондоо над юу ч алга . наад зах нь болзооь хүүхний "хишиг 0 гэж улс амьтан тава мянган шуудай мөнгө- тараах ёёстой . Эхнэртэйгээ унтах орой ядуу гуйлагчингууда¤ мянган шуудай мөнгө, цэргийн улсыг дайлахад мянган шуудай мөнгө орно. Бас хуримаа хийгээд эхнэртээ бэлэглэх зуун очир алмас, шивэгчин тайган нарт өгөх зуун очир алмас хэрэгтэй байна. Бас хувцасгүй нүцгэн мянган хүнийг хүрээд ирвэл энэ бүхэн ву ч бимш " гэжээ . шадар сайд Маруф ингэж ингэ байна гэж хаан ярьсанд хаан: "тийм сахан юм хүсэж байгаа хүнийг чи худалч луйварчин гэнэ үү?"гэхэд нь шадар сайд "Ямар ч гэсэн тэр луйварчин хүн мөн" гэсэнд хаан уурсан: "Дахиад ийм үг хэлбэл толгойгий чинь авна. Буцаж очоод дуудаж ир би өөрөө учрыг олно" гэжээ . Шадар сайд Маруфийг дуудаж ирсэнп, хаан: "ай эрхэм худалдаачин нэрэлхэх явдалгүй, миний санд хөмрөгийн түлхүүрийг аваад дураар заргатун! Ядуу хүмүүсийг хувцаслан миний охин ба шивэгчдийн хувьд санаа зовох хэрэггүй ачаа хөсгөө

ирэхээр дуратйяа өгөөрэй гэж чи бил хоёр одо эн сацуу боллоо шүү" гэжээ . Хаан даруй шейх лам дуудаж охиыг худалдаачин Маруфтай гэрлэх номын бичиг үйлдээд хуримд бэлтгэв. Хоитыг чимж, бөмбөмр дэлдэн, алиа хошин илбэчин бүжигчин нарыг ирүүлж , Маруфт сайхан тоглоос үүүлээд баахан алт мөнгөн рагаж өгсөнд Маруф атга атгаар тараан, ядуу гуйланчин улсыг хувцаслан их л наргиан шуугиантай хурим болжээ . Хааны нярав сангаас үргэлж мөнгө зөөх тул шадар сайд зүрх шүимшрэх бловч юу ч хэлж үл чадна. Маруфийн тийм их мөнгө хайр найргүй зарж байгааг үзээд Али ихэд гайхаж, "Аллах чамайг залхаах болтугай ! Худалдаачдын мөнгийг үрсэн чинь багадаад бас хааны иөнгийг үрнэ үү!" гэхэд нь "Чамд падгүй, хөсөг ирэхээр цөмийг эгүүлэн өгнө" гэжээ . Дөчин хоног найрлаад магааш нь гэлэх ёс гүйцэтгэх эмир, ноён цэргийн дархтан өмнө нь явж Маруф алтан зоос атга атгаар улсын толгой дээгүүр цацаж маш их мөнгө үрэнтаран хийжээ Гэрлэх ёс хийж гүйцжээд Маруфийг хааны охинтой нэгэн тасалгаа хөшигний цаана үлдээсэнд Маруф алга гүвж "Аугаа их Аллахаас өөр хүчтэй үгүй билээ?" гжэ тэнгэрт залыбиртал "Чи юунд сэтгэл зовно вэ?"гэж охин асухад "Минпй эцэг чамайг хэрхэв? Гэлээ . Маруф өгүүлрүүн: "Би даанч хөсгөөс өмнө гарчээ . Ядахнаа нэгэн зуун очир алмас шивэгчин нарт түгээн өгвөөс "манай ноён хатагтайгаа анх унтах шөнөө бэлэг болгосон юм гэж дурсах бүлгээ тэгсэн бол чиний нэр сүрд аштай юу" гэжээ . Хааны охин өгүүлрүүн:"Үүнд сана зовж гуних хэрэг юун. Чиний ачаа хөсөг ирэхийг хүлээхэд бид чамд муу юм огтхон ч хийхгүй . хожим ирсэн нэгэн цагт тэрхүү эрдэнийн чулуу тэргүүтнийг авч болно биз. харин одоо чи хувцсыг тайчин магалан жаргавал зохино" гэжээ . Маруф хувцсыг нэг мөсөн тайлж хаяад эхнэрийг өвдөг дээрээ суулган тэврээд уруулыг тас шимбээс бал бурам амтагдан ирэхийн үес ичих зовох аливаа ёс аль хэдинээ мартагдан, аудалдаачин Маруфт эцгийн заасан бие махбод гандайтал өндийж хос бэлгэс учралыг эрэн эрэн тэмүүлэх нь үнэхээр учир асуухын шалтгаангүй билээ . Энэ үес Маруф тэр эмийн хоёр хөлийг бэлхүүсээр ороон сайтар тэвэрсээр хоёр бэлгэс заяагаар яв цав золготол охины бэлгийн аиун нь цочмог хөндөгдөн ёолох дуун алдан тэр шөнө хүний амьдралын тоонд эс орох тул охин сайхантай учраад өглө болтол тэврэлдэн озолдон наадсан, ноололдон байжээ . Маруф маргааш өглөө нь угаал үйлдээд хааны хувцас өмсөж хааны хуралд очвоос учирсан хүн болгон хэт их хүндлэн амрыг мэхийн мэхийн эрэх ббүлгээ . Маруф хаантай суудал зэрэгцэн суугаад хааны сангийн нярвыг дуудаж, бүх шадар сайд эмир ноёдод үнэт хувцас гаргаж өмсүүлэв. Бас хааны сангаас их мөнгөн авч, харагдсан үзэгдсэн хүн болгонд түгээн өгсөөр хорин хоног өнгөртөл мөнөхөн ачаа хөсөг нь эмс ирэх тул сангийн нярав ихэд сэтгэл өвдөж эхэлэжээ . Нэгэн өдөр Маруфийн эзгүй хойгуур хаанлд, бараалхан өгшүүлрүүн: "Ай цагийыг эзэлсэн хаан, миний хэлэхх үгийг та зSмлэх боловч арга буюу нэгэн зүйл хэлье. хааны сан бараг хоосров. Одоо дахин арван хоног илүү үрвэл таг хоосроно гэж мэдтүгэй_" гэсэнд хаан, "Ай тэргүүн сайдаа, миний хүргэний хөсөг юуны учир сурагүй саатав" гэхэд нь шадар сайд тачигнатал инээж, "Аллах чамайг өршөөх болтугай. Чи туйдын гэнэн хонгор хүн ажээ. Тэрхүү худалч луйварчинд ямар ч ачаа хөсөг байхгүй, харин чамайг мэхлэн луйвардаж, хөрөнгий чинь барж, охины чинь авчээ" гэсэнд хаан: "Үнэхээр үнэн худал алин болохыг мэдэх ямар арга байх билээ? " гэхэд нь шадар сайд өгүүлрүүн: "аяа цагийг эзэлсэн хаан минь эр хүний нууцыг

гагцхүү эхнэрээс нь өөр хүн мэдэж эс чадна. Охиныгоо дуудан хөшгийн уаана ирүүлбэл би үнэн учры нь асуун мэдсүгэй” гэжээ . хаан: “Энэ муу юу байх билээ. хэрэв тэр үнэхээр худалч луйварчин бол би аль муугаар алсугай гэж Аллахыг дурдан ам алдсугай” гэжээ .
хаан шадар сайдын хамт охины зочны өрөөнд очиж д дуудваас охин хөшигний цаана ирж, “ай эцэг минь юу гээв? гэхэд нь “Шадар сайдтай ярилц!” гэжэ . шадар сайд өгүүлрүүн: Ай хатагтай минь , чиний эр нөхөр эцгийн чинь хөрөнгийг сүйтгээд чам лугаа ирж бэлэггүй гэрэлжээ . Олонтаа ам алдах боловч нэг ч удаа амандаа эс хүрэх бөгөөд ачаа хөсөг ирж яваа сураг мэдээ алга чамд мэдэх юм байвал эцэгтээ ярь гэсэнд хааны охин өгүүлрүүн: “тэр орой ирэх богондоо эрдэнйн чулуу, үнэт эрдэнэ эд бөс бараа амлах боловч би одоо хүртэл бас олж үзсэнгүй” гэхэд нь шадар сайд: “Ай хатагта чи энэ шөнө сайтар ярилцаадп эмээх, явдалгүй, үнэн учраа өгүүлсүгэй! Чи нэгэнт миний эр нөхөр тул чамд муу юм үл хүрнэ. Ч амайг үнэнээ хэлбэл амий чинь аврах арга бодъё” гэж их л налиг зөөлөн а аргадан хэлүүлээд бидэнд дамжуулан хэлнэ үү” гэсэнд охин: “ай эцэг минь хэрхэн шалгахап би өөрө мэднэ” гэжээ . Маруф оройн хоол идсэний хойно эхнэртээ очтол хааны охин их л налигнан тосож, бал бурмын адил үгээр хууран эрхлүлээсо эрхэндээ нэгэн оруулаад өгүүлрүүн: “харах нүдний миь чимэг, хайртай зүрхний минь шим чамайг Аллах өршөөж битгий хагацуулах болтугай . Чамаас хагацах буй гэж бодохоом янагийн сэтгэлээр зүрхэн минь булиглан, таяъянгуйн гал элгий минь төөнөнө. худал хэлснээл нэгэн насбг барж эс чадах учир чи над үнэн үгээ хэлбэл зоилтой . Юу гэвэл чи миний эцгийг хэдий болтол хуурч мэхлэх вэ . миний айх нь хэрэг явдал илрэхийн цагт яах ийхийн завдалгүй чамайг баиад авбал яана! Чи үнэнээ над хэллээ гээд муу юм юу болох билээ .Чи “Миний хөсөг ирнэ” гэж ямагт бгүүлэх атал одоо болтол сураг алга. хэрэв чи худал хэлж байгаа бол үнэнээ хлэгтүн. тэгвэл бид хоёр нэгэн мэргэн арга бодож болно. Үнэн үг бол амь аврах хөсөг, худал үг бол толгой цусдах тотгор гэдэг гээд Асах галын дунд үнэн чамайг хаявч Ариун шудрага ёсыг хэзээ боловч хичээ . Боол хний тусын тул бурханыг жигших бүхэн. Бузар тэнэг хрэг учир Аллахаас өршөөл эрсүгэй . гэсэн хүнийг Аллах ихэд таалж билээ гэжээ .Маруф өгүүлрүүн: “ай хатагтай над ачаа хөсөг аврах үхэл аль нь байхгүй хүн гэж мэдтүгэй. Нутаг гүрэндээ ба©хдаа өөрийн эхнэр Фатима нэрт айшхи эмтэй хэрэлдээд тэгээд тэгээд ирсэн гэж бүхий л намтар явдлаа хэнээс нь адаг хүрІэл ярьсанд хааны охин “ай чи худал хэлэх аргад нэн уран хүн байна” гэжээ . Маруф, Аллах тэнгэрт залбиртал хааны охин өгүүлрүүн: : “Чи их хүн болж миний эцгийг сайтар хууран мэхэлсний учир эцэг нь ховдог шунахайн эрхээр намайг чамд өгчээ . Чи миний эцгийн хөрөнгийг түймэр мэь сүйтгээд шадар сайд хардаж, “Чамайг худаолч луйварчин хүн даруй мөн” гэж ямагт өгүүлэх бүлгээ . Эцэг хүний үгэнд яагаад эс үнэмшинэ гэвэл шадар сайд үүний урьд намайг эхнэрээ болгосугай хэмээн гуйсанд би эс зөвшөөрсний учир хорссон хэрэг гэж бодод шадар сайдыг үгийг эцэг эс тоох ажээ . тэгтэл энэ явдал хэрэг удх тул ээг сүүлдээ басхүү эргэлзэх болж, “намайг сайтар асуун мэдсүгэй” гэв. Би чиний нууж явсны чинь мэднэ. Миний эцэг үүний учир чамайг хөнөөхөөр хатуу шийдсэнийг би мэдэх боловч чи бид хоёр нэшэнт гэрэлсэн тул, хэрэв би чамайг эцэгтээ хэлбэл чиний үйлдсэн нүгдийг үл өршөөн чамайг цаазаар авах нь мэдээж. Түүнэ уламжлаад намайг худалч луйварчин хүний эхнэр болсон

гэдэг үг тарж миний нэр сүрийг хорлох биз. Бас чиний толгойг аваад намайг албадан өөр хүнд өгөхийг би үхэвч эс зөвшөөрөх билээ . ТэгэхлЅэр чи одоо зарц хүний хувцас өмсөөд надаас таван тзүмэн динар зоос авч нэгэн сайн морь унаж миний эцгийн нутаг гүрнээс зайлбал зохино. Хожим нууцаар элч зарж над захиа илгээвээс чамайг аль улс гүрэнд багааг мэдэж чадлын хэрээр чамд мөнгө илгээж байвал чи бидний хөрөнгө арвижиж байх болно. хожим эцгийн насан өөд болохын цагт чи алдар хндтэй ирж боох вм . хэрэв чи бид хоёрын аль нэг нь насан өөд болбол Аллах өршөөн соёрхож үхсний маань амилуулан бид хёрыг нийлүүлэн болтугай . Энэ бол хамгийн сайн ага мөн. Чи бид хоёрын хэн хэ нь эрүүл саруул байсан цагт би чамайг мөнгө захиа хоёроор таслахгүй шүү. За ингээд чи энэ шөнөөё морд. Эс тэгвэл чамайг үхлийн аюул тойрон нөмрөх болно" гэжээ . Маруф "Ай хатагтай минь, би чиний ивгээлийн дор билээ . Салахын өмнө чамтай нэгэн удаа хүслийг хангасугай" гэсэнд хааны охин дуртайяа зөвшөөрөв. Маруф тэндээс угаал үйлдээд зарцын хувас өмсөж, нгэн сай морь эмээлж унаад үүр цайхын өмнө хотоос гарч одтол тохиолдох хүмүүс султаны албан гүйцэтгэж яваа зардан гэж үзсэн билээ . Маргаа өглөө нь шадар сайдын хамт охины өргөөнд очиж "За охин минь , юу гэж байна?" хэмээвэл охин өгүүлроүн: "ай чиний шадар сайд миний нэрийг эр нөхрийн минь өмнө гутаах санаа өвөрлөн ажээ" гхэд нь "Яагаад тэр вэ?" гэсэнд охин өгүүлрүүн: "Өчигдөр үлэш ирж миний эр нөхөр ирж, би тануусын үгийг хэлж амжааЈүй атал манай тайган гаднаас нэг захидал барин орж ирээд "Гадаа ордны онхон дор арван зарц хүн ирээд манай ноён худалдаачин Сиди Маруфт энэ захидал дамжуулна уу. Бидний хүмүүс түүний ачаа хөсгийн хамт явтал ноён маанв хааны охинтой гэрлэснийг дуулаад замд тохиолдсон хэрэг явдлыг айлтгахаар одвтолгон ирэв" гэж байна гээд энэ захиа өгөв. захиаг авч үзьэл: "Эрхэмсэг ноён, худалдаачин Маруф чиний харъяа таван карц нарас чинь илгээв. Таныг биднээс түүрүүлэн явтал оон нүүднэлчин араб хүн даралдав уулаглан довтлоод тэр хоёр мянган хүн бид таван зуун хүн хоорондоо ихэд байлдаж, бүтэн гучин хоног саатав. Тэд бинээс хоёр зуун боодол эд бараа булаан авч тавин хүний маань алаь " гэжээ . Маруф энэ үгйг дуулаад "Ай Аллах тануусыг залхаатугай. Хоёр зуухан барааны төлөө тэдгээр нүүдэлчин улстай балдаад юу хийнэ? үүний учир өдий саатах гэж байх уу? хоё зуун боодол бөс бараа долоохон мянган динар зоос шүү дэ! Би биеэр явж түргэн авчирсугай. Нүүдэлчин арабуудын булаан авсан жаахан юмаар юуны хөрөнгө нимгэрэх байтугай тэдэнд бэлэг болгон өгвөл таарна" гээд эд бараа алдсан, хэдэн зарц алагдсаныг өчүүхэн ч тоолгшй гараад явлаа . Би цонроор харвaaс мөнөөхөн захиа хүргэж ирсэн зарц хүмүүс саран мэт хувцас өмсөж нь манай эцгийн хүмүсээс хосгүй илүү ажээ . Тэгдээд тэдгээр за°ц нарынхаа хамт одов. Аллахын ивгээлээр чиний хэосэн үгийг хэлж эс завдав. Хэрэв хэлсэн бол та бид хоёр түүнийг юутай муухай гомдоож, эрнөхөр минь намайг хэрхэн үзэн ядах байсан бол! Миний сайн эр нөхрийг тэгж хэлсэн чийни шада сайд бол хамгийн жигшүүрт хүн мөн!" гэжээ . Энэ үгийг сонсоод хаан өгүүлрүүн: "ай охин минь чиний эр нөхөр үзнэхээр өгөөмөр баян хүн ажээ . Чамтай гэрлэсэн цагаас хойш хоосон ядуу хүнд хичнээн их өглөг өгөв дөө! Аллах өршөөн соёрхож удахгүй хөгсийг авчирсан цагт бидэнд асар их хишиг хайлах бизээ!" гээд охиныг тайтгаруулдан шадар сайдыг ихэд хараан загнажээ . Энэ үес худалдаачин Маруф явсаар хүнгүй цөл газар хүрч

хаашаа явахыг эс мэдэн хайрт эхнэрээс хагацсандаа гуниглан уйлж ийн шүлэглэрүүн: Ханилах цагт хууртан бидэн хоёр хагацав. Хатуун үгнээс хайлж сэтгэл зүрхэн шатав. Амрагаа орхисон хүний нүдэн нулимсанд хормдог Аяө, бидэн хагацавч ахиад хэзээ ч учрах бол Аяа, алиман саран минь!Алжаасан зүрхээ тачъяангуйн эрхээр чамд орхилоо. Аяа, чинийхээ царайг мөчийн төдий хараагүй бол Нийлэн жаргаад уйтгар гунигийг амслаа . Маруф хэмээн нэгэн бээр Дунъя хүүхэнд дурлалаа . Магад сэтгэлээр үхэвч, хариун дурлал нь мөнх билээ . Амрагийн наран ивгээн соёрхож хайрлана уу?Эргэж бидэнд нийлэх цаг бий бол уу?Энгүй баярыг учран золгож олох бол уу? Амрагийн ордн бид хоёрыг баярлуулах бол уу? Аяа, алиман саран минь чи наран мэт Ариухан ното үзэсгэлэнгээрээ биднийг ямагт ивээгээрэй!Янагийн жаргал хамгийн золгүй нь үнэн боловч Яахивч би гуниг хийгээд янагийг тэвчин чадна!Ийнхүү шүлэглэж гүйцээд хорсоэ уйлж хааш явахыг үл мэдэх тул үхсэн нь дээр мэт санагдах ажээ . Тэндээс ухаантай ухаангүй явсаар жин үдийн алдад нэгэн жижиг суурин газар хүртэл хол бус нэг хүн газар хагалж байна. Маруф маш их өлсөх тул тэр хүн дээр очиж амрыг эрвээс хариу мэндлээд “ай ноён тавтай морилогтун! Чи Султан хааны зарц хүн мөн үү? ” гэхэд нь мөн гэтэл “ай би, чамайг хоол ундаар дайсугай” гэхэд н энэ лав их буянтай хүн гэж бодоод “харваас чиний энд хоол үгүй байна гэтэл чи юугаар дайлахр гэж намайг урив?” гэсэнд “Ай ноён минь, тэр амархан олдоно. Чи мориноос бууж энд хүлээж байн. Би энүүхэн сууин орж идэх юм авчръя” гэхэд нь “Энэ суурин нэгэнт ойрхон тул би өөрөө явж зээлийг газар очиж, юм худалдан авч идвэл түргэн биш үү?” гэхэд “ай ноён минь, энэ суурин бол даанч бага тогон тул зээл гэж байхгүй билээ . Их Аллахыг бодож түр саатна уу? Би нэн хурдан ирнэ” гэжээ . Маруф мориноос бууж хүлээн суух зуур “Би энэ хүү хоосон явуу хүний ажлыг алдуулжээ . гарз хохирол эс учруулахын үүднээс оронд нь газар хагалж байсугай” гэж бодоод хэдэн шар тууж газар хагалан хэсэн явтал анжис нэгэн бат юманд тээглэн яг зоссонд . үзвээс том алтан цагирагт тээгэлсэн байлаа . Алтан цагирагийг авч үзвээс дор нь тээрмийн чулууний хиртэй том гантиг байна. Маруф хүёчлэн оролдож гантигийг ховхолтол лдоош орсон шат байх тул орж үзвээс дөрвөнтасалгааны нэгд нь дүүрэн алт, нэгд нь дүүрэн маргад, сувд, шүр, нэгд нь дүүрэн бадмаараг, бадахшан газрын оюу, нэгд нь дүүрэн очир алмас бас бус нэр үл мэдSх эрдэнэ чихээтэй ажээ . дунд н тунгалаг талст авда дотор хугшганы хэртэй том том эрдэнийн члуу дүүрэн , бас нимбэгний хэртэй нээн алтан хайрцаг байжээ . Маруф нэн гайхаж үлэмж баярлан “”Энэ жижиг хайрцагт юу байдгийг үзсүгэй!” гээд нээтэл дотор нь шоргоолжын мөр шиг жижиг бичиг ба зангианы зурагтай алтан бөгж байжээ . Бөгжийг авад зүлгэн үзьэл, “Ай оён би энд байна. Чи юу хүснэм? Тосгон суурин барих уу хот балгад нураах уу? Чи юу хүсвээс бүхнийг захирагч увидсын хүчинд эс гүйцэтгэх юм нэг үгүй билээ гэж хүн дуугарах шиг болоход Маруф “Намайг ноён болгогч хэн бэ?” гэсэнд мөнөөхөн дуугарч дуу өгүүлрүүн: “Би бол энэ бөгжийн хэн зүүсэнд хүнд зарагдана. Чи юу хүсэж захиран тушаана би үг дуугүй гүйцэтгэнэ. Би хүн дүрси хий юмсы амь сахих их цэргийг захирдаг юм . Миний мэдэлд далан хоёр омгийн долоон түмэн, хоёр мянганц эрэг бий . нэг цэрэг мянган маридыг захирна . нэг марид ямнган туслах нарыг захирна. Нэг туслагя мянган ч ащөтгөр захирна. Нэг чөтгөр ямянган хий юмыг захирна. Тэд бүгдийг би захирдаг. Намайг энэ бөгжинд шүгэлсэн учир

хэн энэ бөгжийг зүүвээс би түүнд уг дуугүй зарагдах болно. нэгэнт чи энэ бөгжийг эзэн тул газар дээр далай дээр хаана ч явсан бөгжийг нэгэнтээ зүлгэвэл би хэзээд чиний дэргэд очих тул дуртайга захиран тушааж болно. Харин хоё удаа арчин зүлгэвэл бөгиж н дээр бичээстэй нэрээр намайг түлж алах тул харамсавч барахгүй хайран юм болно. Маруф "Чини© нэр хэн бэ?" гээд "Абу Саадат"гэхэд нь "ай Абу Саадат, энэ хний эрдэнийн сан бэ" гэсэнд Абу саадат өгүүлрүүн: "Энэ болбоос Адын хүү Шедаллын эрдэнийн сан, Ирем барьжээ . ертөнцөд өөр ийм эрдэнийн сан байхгүй. Би Шедаллыг сэрүүн тунгалаг ахуйд нь зарц нь байсан бөгөөд энэ бол түүний бөгж мөн. тэр хүү энэ бөгжийыг энэ эрдэнийн санд тавьсан нь одоо чинийх болжээ ." гэхэд нь "Чи энэ эрдэнийн санд байгаа бүхнийг газар дээр гаргаж чадах уу?" гэсэнд "хамгийн амархан" гэхэд нь "тэгвэл юу ч үлдээлгүй цөмийг гадгаш зөөж гаргая" гэжээ . Абу – Саадат газар руу заатао газар хага үсэрч Абу- Саадат доош орж алга болов. Удалгүй сайхан царайтай оон гоё залуучууд сагстай алт зөөөж төдхөн гүйгээд "Цаана юу ч үлдсэнгүй " гэцгээхэд Абу –Саадат Маруфт мэдэгдэв. "Энэ олон сайхан юун улс вэ? " гэсэнд "Эд миний хүүхэд энэ зэргийн бага ажилд туслагчдыг дуудах явдалгүй миний хөвгүүд хийж чадна . одо юу хийхэв" гэжээ . Олон луус авдар авчирч, эдгээ эрдэнэсийг авдарлан ачаалж чадах уу?" гэсэнд Абу-Саадат : "Энэ туйлын амархан " гээд нэгэн удаа том хашгиртал найман зуун хүүхэд нь цуглав. "Таануусын зарим нь луус бол, зарим нь ямарваа гүрний хаанд байхгүй сайхан зарц болгтун. Бас нэг нь хөсөш туугч зарц болсугай!" гэтэл долоон зуу нь луус нэгэн зуу нь зарц болон хувирав. Абу- Саадат бас Іуслагч нараа дуудаж заримыг эрдэнийн чимэгтэй алтан эмэлтэй сайхан морь болгож уяв. Маруф "Алт ба эрдэнийн чулууг тус бүрд нь ялгаж Авдарт хийгтүн!" гэсэнд төдөлгүй авдаорлаж ачаалжээ . Маруф бас өгүүлрүүн: "ай Абу саадат, чи үнэтэй үнэтэй эд бөс авчирч чадах уу? " гэсэнд "Мисир, Сири, Перс, Жагар Ром аль газрын бөс бараа хэрэгтэй вэ?" гэхэд нь "Аль алинаас нь зуу зуун боодол авчрагтун" гэжээ . Аб саадат "Би туслагч нараагүрэн тус бүрд томилон илгээвээс тээж ирэх болно. гагцхүү өчүүхэн хугацаа хэрэгтэй гэхэд нь "их хугацаа хэрэгтэй юу?" гэсэнд "ганцхан шөнө, маргааш өглөө босоход чинь хүссэюм чинь ёсоор бүтсэн байна" гэжээ . Маруф эл хэргийгтушаагаад бас тэнд захиран асар майхан шаалгаж, сайхан сайхан хоол унд тавиулж Абу саадатын хөвгүүдийг зарц зардсан болгоод хоол зооглон байтал мөнөөхөн тариачин таваг сэвэг зарам, шуудай арвай авчраад харваас ирсэн хүн асарт злран, зарц хүмүүс элэг тэврэн суухыг үзээд Султан хаан биеэр залран ирсэн гэж боджээ . Тариачин яду хоол авчиранд сэтгэл зовж "тахианы хоёр дэгдээхэй алж шүүрхий махаар өнгийг хувилнган барьдаг байжээ " гэж бодоод тийнхүү шийдэн эргэтэл Маруф дуудаж, "Энэ чинь юу вэ?" гэсэд та°иачин "танд хоол, моринд тэжЅэл аьчирлаа . таныг султан х а гэж мэдсэн бол тахианы хоёр дэгдээхэй алж дайлах байжээ" гэхэд нь Маруф өгүүлрүүн: "Би султан хаан биш боловч түүний хүргэн билээ . Би түүнд уурлан явтал хойноос оон зарц нарыг илгээжээ . Одоо хотос буцна. Чиний бэлдсэн хоол хэдийгээр сэрэм зарам боловч тааламжтай тул би иднэ. " гээд тариачин хийсэн хоолноос цадтал идээд тариачныг мөнөөхөн олон сайхан ххоол ундаар хариу дайлсанп тариачин бас цадтал иджээ . Маруф гарыг угаагаад үлдсэн хоолыг зарц нарт өгөөд тариачны тавганд дүүрэн алт хийж "май аваад харь, хожим хот ороход чинь бас хүндлэн дайламз!" гэжээ . тэр үдэш

эрдэнийн сангийн илбийн охин бүжиглэн Маруф их л зугаата жаргалтай хоножээ . Маруф маргааш өглөө бостол тэнгэрий хаяанааа улаан тоос босож удалгүй долоон зуун луус ачаа хөсөг, зарц боолууд тууж хөтөлсөөр гарчирэхэд Абу Саадат жингийн даамал адил луус унаж хажууд нь харагдав. Жингийн түрүүнд эрдэнийн чулуун чимэгтэй, дөрвөн шижир алтан пайзтай жууз дамнажээ . Абу Саадат өгүүлрүүн: "аяа ноён минь, захирсныг соор гүйцээлээ . Энэ жууз дотор хаад хаадад үгүй гоё хувцас бий . та өмсөж энэ жуузанд залраарай . Одоо юу хүснэм?" гэхэд нь Маруф өгүүлрүүн: "Ай Абу Саадат би Хитан-аль хатан хотод байдаг хадам хаан аавд захиа өгөхийг хүснэ : Чи сайхан царай зүстэй элчийн маягтай очих болно" гэсэнд Абу саадат за гээд Маруфийн битүүмж бүхий захиа аван одов. Энэ үес мөнөөхөн хаан шадар сайдтай хоёул ярилцсанд хаан: "Аяа шадар сайдаа, нүүдэлчин арабууд хүргэнийг минь алаагүй байгаа гэж сэтгэл ихэд зовном . хаашаа одсоныг мэдсэ бол цэрэг явуулах билээ . Даанч хэлсэнгүй яваад өгчээ" гэсэнд шадар сайд "аяа чи даанч гэнэн хүн билээ . тэр бол ганцхүү худалч, луйварчин, бидний сэрдэж ирэхэр шившиг болохоос эмээн оргожээ " гэжээ . Гэнэт нэгэн элч орж, ирээд хаанд сөгдөн мөргөж, "үүрд аз жаргалтай байхыг" ерөөтөл хаан, "Чи хаанаас яваа хэн бэ?" гэсэнд "Чиний хүргэн намаг элч болгон зарав. Өөрөө ачаа хөсгийг хамт энүүхэнд ирж яваа" гээд захидлыг барив. Хаан захиаг задла үзьэл хааны амрыг хүндэтгэн эрээд "Би ачаа хөсгийн хамт очиж явна. Цэрэг жагсааж тосогтун!" гэжээ . "аяа шадар сайд чиний нэр сүр Аллахын өмнө бузартжээ . миний хүргэнийг чи худалч луйварчин гэж олонтаа өгүүлтэл, одоо ачаа хөсгийг аваад ирж явна шүү харин чи мэхт хүн болохооё зайлахгүй" гэж хааныбг өгүүлэхэд шадар сайд "аяа цагийг эзэлсэн хаан минь түүнийг ирэхгүй удаад байхаар нь баахан мөнгө үрээд аога болжээ гэж эмээснээс хэлсмэн билээ " гэхэд нь хаан : "Ай зальт нохой нэгэнт түүний хөсөг ирснээс хойш түүний тэр үрсэн мөнгө юу ч биш шүү!" гэжээ .Хаан хот очиж сонсогтун! Чиний эр нөхөр ачаа хөсгийн хамь ирж явна гэж энэ захиа иоүүлжээ . одоо би угтахаар явлаа Гэхэд нь охин ямар жигтэйюм бэ? Ядуу хоосон хүн гэ¦ худал хэлж надаар тоглож шалгаж үзсэн хэрэг үү? Ямар болов· би түүний нэр сүрийг ариунаар сахижээ гэж бодов. Энэ үес мөнөөхөн Киарын Али хот орныг ихрэд чимэглэхийгш үзээд хүнээс учрыг асуувал "хааны хүргэн их хөсгийн хамт ирж яваа" гэхэд нь нэн гайхжээ . "Аллах агуу их билээ" Ядуу хоосон учир эхнэрээс зугтаан ирлээ гэсэн атал хаанаас тийм их ачаа олов? Хаа-ы охин шившгээс эмээн арга зохиож магад! Аллах түүнийг өршөөн соёрхож болтугай! Гэж бодсон бөгөөд буса худалдаачингуудп мөнгийгш эргүүлэн авах болов гэж ихэд баяралцгаажээ . хаан цэгийг жагсаан тосон мордтол Абу Саадат Маруфт очиж бүх үзсэн дуулсанаа айлтгав. Тэндээс хөсөг хөдлөхөд Маруф гоё хувцас өмсөж жуузанд алидаа хаадаас мянгантаа ямбатай заларчээ . Замын талд хаан их цэргийн хамт тосож, Маруф их султан хааны хувастай жуузанд залран явахыг үзээд гүйн ирж амрыг эрсэнд хааны шадар албаны сайдууд нэг адил ухасхийн амрыг айлтган, Маруф хуурамч биш үнэхээр баян хүн болохыг нүдээр үзэжээ . Арслангийн боловч сүнс зайлмаар сүртэй жагсаал хотод орж ирэхэд мөнөөхөн олон худадаачин тосож, Маруфийн амрыг эрж, худалдаачин Али түүнд бгүүлсэн нь: "Чи хэрээсээ илүү хэрэг үйдсэн атал харин ч сайхан өнгөрлөө . Аллах чамайг улам ивээх болтугай!" гэсэнд Маруф инээж, хааны ордонд залраалд, "Алт бүхий ачааг миний хадмын санд буулгасугай. Эд барааг

энд авчирч зарлагтун! ” гээд долооон зуун луус ачаа мөнөө задлуулж, аль сайныг шилж, нэг авдарт алт ба эрдэнийн чулууны хамт эхнэрт хүргүүлэн, “Шивэгчин таган нарт тараан өг!” гэжээ . Маруф урьд нэг мянган динар зоос зээлсэн улсад хоёр мянга, түүнээс илүү зоосны зээлсэн улсад эд бөс бараа тараан өгөөд мөнхүү ядуу хоосон хүмүүст үлдсэнийг түгээх тул хаанд хайран санашдавч яаж ч эс чадна. Маруф авчирсан эд барааг цөмийг тарааж өгөөд хааны их цэргийн улсад шүр сувд, оюу , маргад , бадмаараг , эрдэнийн чулу атга атгаар тарасанд хаан тэсгэлгүй “аяа хүү минь одо болох юм биш үү . Цаана нь бага үлджээ . ” гэсэнд Маруф “над зөндөө бий” гэжээ . Хааны сангийн нярав ирж, “Аяа цагийг эзэлсэн хаан, хаанысан алт ба эрдэнээр дпүүрэв. үлсэнийг эь хаана хийх вэ?” гэсэнд хаан : “Өөр газар хийсүгэй” гэжээ . хааны охин энэ бүхнийг үзээд гайхах баярлах зэрэгцэн, “Энэ их юм хаанаас олсныг мэдэх юмсан!” гэж боджээ . мөнөөхөн олон худалдаачин Маруфт ихэд баярлацгаан аз жаргал ерөөсөөр байлаа . Худалдачин Али, “Энэ их сан хөмрөг хаанас худал хэлж олов? Хааны охины юм байсан бол хаанаас ийнхүү ядуу хоосон хүмүүст цөмийг тараах билээ? гэж ямар ч гэсэн : Хаан чамд, хаан ширээгээ хайрлаваас Хаанас трэ билээ? гэж учрыг бүү асуу Аллах мэдээд хишиг хүртээснээс хойшАмгалан хүлцэнгүй ёсыг дуугүй сахь’ гэж сайхан хэлсэн үн бий” гэж боджээ Тэндээс Маруф эхнэр дээрээ ирвэл хааны охин эелдэг сайхан инээсэглэн угта¦, “Би эхнэрээс хөөгдсөн ядуу хоосон хүн гэж чи намайгш шалгахыг хүссэн үү? Аллахыг бодож би чиний нэр сүрийг гутаагаагүй шүү. Чи баян ч атугай, ядуу хоосон атугай ялгаагүй би чамд туйлын хайртай билээ . Чи юунд тэгж хэлсэн юм бэ? ” гэсэнд Маруф өгүүлрүүн: “Чи үнэхээр над сэтгэлтэй юм уу? Эд мөнгөний шуналаас болов уу? гэж би шалгах гэсэн юмаа . Чи үнэнхүү сэтгэлтэй, хүний сайн чанар хадгалсан хү болохыг одоо биеэр үзэж мэдэв” гээд мөнөөхөн бөгжө нэгэнтээ зүлгэвээс Абу саадат хэдий нь дэргэд эь ирж “ай ноён юу хүснэм” гэхэд “миний эхнэрт эрдэнийн сангаас хосгүй гоё хуювцас авчирсугай. Бас ижилгүй дөчин эрдэнийн чулуун хүзүүний чимэг авчраарай” гэсэнд Абу Саадат нүд ирэмхийн зуур авчирсныг үзвэл хөл гарын хоё алтан бугуйвч, эрдэнийн чулуун зүүлт, ээмэг, бүс тэргүүтэн үнийг мөнгөөр яривч гүйцэхгүй сайхан юм байр тух, “ай ноёнтон минь, энэ сайхын юмыг би найр наадмаар хэрэглэсүгэй!” гэхэд нь Маруф “үргэлж өмсөж байгтун! Над бас зөндөө бий” гэжээ . Бас гоёл бүхий олон сайхан хувцас авчруулж шивэгин нарт өмсгөөд тэнгэрийн дагинас мэт үзэгдээп хааны охин тэдний дунд байх эь оддын дунд саран мандах ажээ . хаан энэ бүхнийг үзээд туйлын их гайхаж, шадар сайддаа “Ай шадар сайдаа, энэ ер нь юу болж байна?” гэсэнд шадар сайд өгүүлрүүн: “аяа цагийг эзэлсэн хаан нминь үнэхээо хулдалдаачин хүн бол ширхэг олсыг боловч жилээр дарж заавал үнэ хргэж өгдөг учиртай Хаан хүнд боловч ховор тохиолдох энэ их мөнЈө эрдэнийн чулуу, эдб араа хаанас олж байна гэ чи бодож бана . лав нэг учир шалтгаан бий . хэрэв та миний үгэнд орох юм бол би үүний үнэнийш ил болгоъё” гэсэнд хаан: “Чиний үгэнд орно ” гэжээ . Тэгвэл чи Маруфийг дуудаж, “аяа хүргэн минь, би гагцхүү шадар сайд та хоёртоо наргихыг хүснэм” гэж аятайхан уригтун! Цэцэрлэгт ширээ засаж ихээхэндарс бэлтгэж согттол уулгаваа± ухаан алдаад бидний асуухап ун нууцыг заавал хэлэх болно. дарсанд хүн бийг худалдана. Дарс ууж бид ихэд цэнгэн наргила . Даруй нууцанд хүрэхэд “зогс” гэж би хашгирлаа!Амтат дарсанд бие

сэтгэлийг эзэмдүүлэн Ариун нандинаа олонд дэлгэхээс эмээнэ!Гэсэн нь учиртай үг билээ . Тийнхүү нууцаа бидэнд яриваас хариу яасан ч бидний ду болно. миний эмээх нь хэрэв тэр, хаан ширээнд дурлавал мөнгө хайлахгүй чулуудаж их цэргийг эзэмдэж аваад чамайг түохэн унагааж юуны магад гэсэнд, Хаан "Чиний зөв" гэжээ . Маргааш глөө нь хааны зарц адуучид их л гунигтай орж ирээд "аяа цагий эзэлсэнхаан минть, бид өчигдөр үдэш Маруфийн ачаа тээж ирсэн морьд ба луусанд тэжээл тавьж өгсөнд өглөө бостол нэг ч морь нэг ч луус байснгүйд мөнөөхөн зарц нар нь хулгайлжээ гэж очиж үзвээс адгуусан хийгээлд зарц нарын аль алин нь алга . Хэрхэн оргон одсоныг гайхавч баршгүй гэжээ . Тэдгээр морьд, луус хийгээд зарц нар Абу Саадат туслагч хий далдын юмс бол°хыг хээн яахин мэдэ билээ . Хаан уурлаж "мянган адгуус, таван боол бөөн а«га болохыг эс мэддэг яасан улс вэ? Явцгаа! Өөрсдийн ноён Маруфийг босоход эл учраа яригтун" гэжээ . үарц хүмүүс гада уруу царайлан сууцгааж байтал Маруф гэрээс гарч "тануус юунд ийнхүү гунигтай байнам? Гэж асуухад цөм алга болсон учрыг өгүүлбээс "Тийм яльгүй бага мны төлөө ийнхүү гуниглах юун! Зүгээр санаа зовох юмгүй явцгаа" гэжээ .хаан ыордонд Маруф ирж мөнөөхөн гарзыг тоох шинжгүй инээн суухад "хөрөнгө мөнгө огт тоохгүй ямар жигтэй хүн бэ?" гэж бодож байжээ.Маруфтай нилээд ярилцан байтал "аяа хүргэн минь, би шадар сайд та хоёртой цэцэрлэгт жаахан цэнгэн наргихыг хүснэ" гэсэнд "Болохгүй яахав" гэжээ . тэндээс гурвуул цэцэрлэгт очвол мөчир болгоноос хос жимс бөнжийж сувгийн усан урсан жигүүртэн шувуд донгодон их л сайхан ажээ . Цэцэрлэгийн дугд сэтгэл сэргэм сайхан өргөөнд ороод суутад хааны шадар сайд урьдын сонин намтаро түүх, шог хошиннаргианд үгс хүүрнэн байтал зоог бэлэн болж, зарц шивэгчид зүсэн зүйлийн сайхан хол амтат дарс, авчран тавьжээ . гурвуул хоолд идэж гарыг угаатал шадар сайд дарс хундаглан Маруфт бариад "Энэ бол эрд гарч үзээгүй эмнэг онгоэ эм билээ . Үүний ууваас сэтгэл зүрхэн баяр баясгалдан дүүрнэ" гээд эрхэм яруу найрагчдын шүлгээс иш татан өгүүлсэн нь : Наран адил сайхан хархүү найрын сөн барив. Нандин савтай дарс би барилаа . Сархдын онгод сайхан гэгч бүжиглээд Саран, ихэр хоёр од хацар дээр нь мялаав. Дарсн» амт сайхан, хийу нарийн билээ .Даруй биед сэтгэлийг урсаан тараадаг гэдэг билээ . Бас яруу найрагчид: Алиман сарантай тэврэлдэн шөнийг баравАяганы амсарт наран эс далд оров гэж мэдтүгэй!Муу бүхэн галд мөргөхиг би нүдээр үзэвМиний аяганаас дарсныб түсэргээн над мөргөнөАбу-Новасын хэлснийг яана:Намайг өдөөн зэмлэхийг болиочНад хүрсэн өвчнөөр миний биеийг анагаагтунАяа, шархан өнгөтэй дарс минь! Чи эмэгнэлтэйеэАмсахын төдий хөхүүн болохыг тэр мэдэхсэн дээТас харанхуй шөнө домбонп дарс хөөрнө Таслагаан дотор сувдын нь туяө сацранаҮйланд автсан эр дарс үнэртлээ Үнэн хүслий нь тэр түүнд илгээжээ . Голшиг залуу эрийн хувцастай охид дарсыг барина Лотын хөвгүүн тэнүүлчин боловч түүнд дурлажээ . "Тануус юу ч сансангүй атал олсныг бас мэдэхгүй шүү Танин мэдэхийг хүсэгчидэд өгүүсүгэйГэсэн байдаг билээ . Ибн-аль-Мутазз* үүнээс сайхан өгүүлсэн нь Моддын өтгөн сүүдэрт Жезирыг ундаалагтун. Дейр Абдун шаагисан бороонд дэвтэг! Өглөө ундааныг уу гэж намайг сэрээхэд Үүр шувуухай нисэн одоогүй эрт байдаг билээ . Хийдийн лам нарын мөргөлийн дуу уянгаланХар хувцастай улс үүрээр гашуудан уйлна. Үзэсгэлэнт царайтай хүн тэдний дунд олон ажээ Бурангуйн цамцаар халх барьж тэд нар ойртоно. Болгоох сэрэмжээр

эмээцгээн улам хурдан алхана. Харгүй замд харцгаа би тэндэнд дэвсэнэ Хар мөрөөрөө доромжлогдон амь зууна би Саран гийн бид хоёрыг арайхан эс харуулж Сайхь хумсны тайранхайд эс барьж өгөвТэгээд яасан, юу болсныг би огт ярихгүй Тэндээс яасан юм гэж буяныг бодож бүү асуугтун.Гэсэн байдаг билээ . Бас өөр нэг шүлэгчийн хэлсэн нь: Бүхнээс баянй болоод бүр жаргалыг хүлээнэ Шингэн алтыг олоод шилэн аягаар хэмжинэгэсэн байдаг билээ . Бас өөр нэг шүлэгт: Аяга дарс хоёрт нэгэн их ёс бий Аль нэгийг эс мартах нь нэгэн ёс даруй мөн. Намайг үхэхийн цагт үзмийн ёроолд булаарайНам дугжрах яс минь дарсаар ундаалж байг! Үнэндээ цөл газар намайг бүү оршуулаарайҮхсэн хойно дарс эс амсахаас эмээнэм гэсэн ч бас байдаг.Шадар сайд, Маруфт дарс уулгах хэмээн ийнхүү хичээнгүйлэн ятгаж, завсарт шүлэг зохиолоос чимж, сайхан сайхан нэр дурдан өгүүлтэл Маруф арга буюу нэгэн аяаг ууваас бие амар сэтгэл зугаатай болоод үнэн мөн алдран, юмны зөв бурууг ялгахгүй болов. шадар сайд, Маруфийг согтлоо гэж мэдэд “аяа худалдаачин Маруф аа, нэгэн зүйлд би ихэд гайхдаг. Хосрай хааны сангаас ч гараагүй тийм их үнэт эдлэл чи хаанас авчрав аа? Бид чамаас баян их мөнгөтэй худалдаачны хүн биш, хаан хүн бололтой, учрыг ярьж өгнө үү гэж Аллаыг дурдан гуйсугай” гэсэнд Маруф дарсны амтанд орж уусаа ухаан жолоогүй согтсон тул ийн өгүүлрүүн: “Би худалдаачин ч биш хаан хүн ч биш ” гэд намтар түүхээ эхнээс нь адаг хүрэл ярьсанд шадар сайд “аяа Маруф ноён, юуIа жигтэй сонин хэрэг вэ? Алив тэр бөгж чинь ямар шуу хийцтэйг үзье” гэсэнд Маруф “Үзэгтүн” гээд бөгжийыг сугалан өгвөөс шадар сайд эргүүлэн тойруулан үзээд “Хэрэв би зүлгSвээс тэрхүү зарц гарч ирэх үү?” гэсэнд “гарч ирнэ үзэгтүн!” гэжээ . Шадар сайд бөгжийыг нэгэнтээ зүлгэтэл дэргэд нь хүний дуу гарч, “нолётон минь, би бэлэн байна . Хот суурин эвдэх үү, хот балгад барих уу? Аль газрын хааныш алах уу? Чи юву хүсвээс ёсоо° бүтнэ” гэжээ . Шадар сайд Маруфийг зааж “Энэ хүү бузар амьтныг ертөнцийн аль үсгүй газар цөл газар аваачиж хаягтун! Эзгүй газар гуниглан өлбөрч үхэг!” гэсэнд зарц мөнөөхөн Маруфийг авч газар тэнгэрийн завсраар нисэ оджээ . Маруф нэгэн мэдэхнээ зайлшгүй бэрх үхлийн аюул тулгарсныг мэдээд ихэд уйлж, “Аы Абу Саадат, чи намайг хааш авачна?” гэсэнд “Аы тэнэг минь би чамай уулгүй тал , усгүй цөл авачиж хаях гэж явна. Тийм далдын их хүчтэй сахиус олсон хүн тийнхүү бусдад өгдөг үү? Ийм тэнэг амьтныг энэ өндрөөс хаявал салхин чамайг түмэн хэсэг тастан хаях атал Аллахаас эмээнэ” гэжээ Хий юм тийнхүү Маруфийг авч ниссээр хн амьтангүй нэгэн их цөлд аваачиж орхижээ . Энэ үес Шадар сайд бөгжийг эзэмдээд хаанд “Маруфийг худалч луйварчин хүн гэхэд чи үнэмшихгүй байлуу?” гэсэнд хаан, “Ай шадар сайд чиний зөв намайг Аллах тэтгэх болтугай наад бөгжөө үзүүлээч!” гэвэл сайд маш хилэгнэн эргэж µааны нүүрт хулимаад “ай тэнэг чи, одоо би нээнт чиний ноён болсон мөртөө Ўас бөгжийг өгч чиний зарц болох уу? Чамайг зүгээр орхихгүй дээ” гээд бөгжийг нэгэнтээ зүлгэж хий юм дуудаад, “Энэ тэнэг амьтныг нөгө худалч хүргэний нь цөлсөн газар аваачиж цөлөгтүн!” гэжээ . Хаан замдаа, “Би ямар нүгэл хийсэн билээ?”хэмээвээс Абу Саадат өгүүлрүн: “Би хэрхэн мэдэх билээагацхүү тэр сахиус бүхий бөгжийг эзэмдсэн хүн юу гэ захирваас үг дуугүй ёсоор болгоно” гээд Маруфийг цөлсмөн газар аваачиж орхив. Тэнд хоёул уулзвал идэх уух юм ч үгүй цөл буйд газар ажээ . Энэ үес шадар сайд хаан Маруф хоёрыг зайлуулаад хааны их цэрэг хийгээп ордныб

түшмэдийг цөмийг цуглдуулан, мөнөөхөн бөгжийн далдын их увидас хүчнийг өгүүлээд , “Хэрэв тануус намайг Султан хаан болгохгүй бол би та нарыг усгүй цөлд цөлөх тул тэнд өлбөрч, хатаж үхэх болно” гэсэнд цаадуул нь нь дотроо дургүй байсан боловч “Чамайг Султанаа болгож, үг дуугүй захирсугай. Бидэнд битгий муу юм хийгээрэй” гэж хаан болготол Абу- Саадатыг дуудаж тэдэнд хувцас хэргэм олгов. Шадар сайд хаан болж бүхний захираад хааны охинд “Өнөө шөнө очиж унтана. Бэлдэж бай!” гэж хэлүүлжээ . хааны охин: эцэг ба эр нөрөө алдсан туйлын хүнд уйтгартай байсан бөгөөд “миний биеийг ариутгах өдөр судар гүйцсэн хойно гэрлэх бичиг хийж ёсыг дагаж ирсүгэй! Гэж хариу хэлүүлтэл “Би тэрхүү биеийг ариутгах өдөр судар хийгээд гэрлэх ёсыг үл мэдэх тул заавал өнөө шөнө очно ” гэжээ .
хааны охинд шадар сайдыг чадах санаа төрж, “Морилон ирэгтүн” гэжээ . Шадар сайд хааны охинд нэн дурладаг байсан тул энэ үгийг сонсод ихэд баярлан ширээ засаж улё цуглуулаад “Энэ бол нэг ёсны минй хурим болох учир дураар идэн жаргагтун” гэжээ Гэтэл лалын нэгэн шейх лам “хааны охины ыие ариутгах хугацаа болоогүй атал чи гэрлэх бичиг шийтгүүлэлгүйрээр очих ёсгүй” гэсэнд шадар сайд”Тийнхүү бие ариутгах өдөр судартайг би мэдэхгүй . тийм юм битгий яриад бай!” гэжээ . шейх лам шадар сайдын хилэнгээс эмээн дуугй болсон атал, цэргийн түшмэдэд “Энэ заяагүй амьтан шажин мөргөлийн ёсон үл мэдэх ажээ ” гэж гомдон өгүүлжээ . Үдэ болж , шадар сайд хаан охинд очвол охин хамгийн гоё хуцвсаа өмсөөд байдаг ыбчимгээ зүүлийг зүүж, туйлын баясгалантай инээмсэглэж угтаж “ Энэ шөнө юутай буянтай шөнө вэ? хэрэв чи миний эцэг хийгээд эр нөрийн толгой авсан бол би бүр баярлах билээ” гэсэнд шадар сайд “тэр хоёрын толгойг би заавал авна” гэжээ . Хааны охин шадар сайдад сэтгэлтэй дүр үзүүлэн их л эрхэлтэл сайд ухаангүй дурлан хачин болжээ . харин хааны охин бол: Илдийн чадлаар олоогүйг эвийн аргаар оллоо . Илүү амттай үр шимийг эндээс сугалж авлаа бигэсэн үгийг санаж, мөнөөхөн бөгжийг олзлон баярласан сайдыг балчиг гунигт унагах гэж тийнхүү хуурамч энхрийлсэн байжээ .
шадар сайдын дур тэсхүйеэ бэрх болоод охиныг тэврэнаваад унтсугай хэмээвээс орхин уйлан өгүүлрүүн: “аяа, ноён минь, биднийг ширтэн буй хүнийг ·и үэхгүй байна уу? Түүний ширтэ- харсаар байтал бид хоёр хэрхэн хавьах билээ. Аллахыг бодож нүднээс далд болгог тун!” гэсэнд “ Хаана хүн байна ?” гээд “Чиний бөгжи©н дотроос өнгиж биднийг харж байна” гэхэд н шадар сайд тачигнатал инээж “Энэ бол миний захирах хүн бус ббирид болой. Битгий айгтун” гэжээ . “Үгүй би биридээс ухаангүйы айна. Наад бөгжөө надаас хол байлгагтун ” гэхэд нь сайд бөгжийг сугалж дэрэн дор хийгээд охинтой унтсугай хэмээтэл элгэн долроос нь өшиглөн унагаж шивэгчин нараа дуудан дөчин шивэгчин ирж хааны шадар сайдыг дарж , охин яаран дпэрэн дороос бөгжийг авч нэгэнтээ зүлэгвэл Абу Саадат гарч ирээд “ай хатагтай би одоо юу хийхэв?” гэхэд нь “Энэ заяагүй амьтныг төмөр гинжээр гинжлэн гянданд хаягтун! ” гэжээ . Абу Саадат шадар сайдыг гяндад хийж ирэхэд , “Чи миний эцэг хийгээд эр нөхрийг хааш нь аваачсан бэ?” гээд “Хүнгүй цөлд аваачиж орхисон билээ” гэхэд нь “Одоо явж олж ир” гэжээ . хаан, Маруф хоёр аргыг бөарж бие биедээ гомдон суутал хий юм нисэн очиж “та хоёр амарчээ!” гээд уг болсон хэргийг яриад, шадар сайдыг би гяндандаа хийв. Хааны охины тушаадаар та хоёрыг авах гэж ирлээ гэжээ .Хаан, Маруф хоёр машид баярлан

баярлан хүн бусын хамт эгшин зуур нисэн иэхэд охин баяртай угтан цай хоо өгч сайхан унтуулаад маргааш өглөө гоё сайхан хувцас өмсгөн, Ай эцэг минь, урьдын адил хаан ширээндээ суїж, миний эр нөхрийг баруун га°ынхаа шадар сайд болгож, эл учрыг цэргийн түшмэлд өгүүлэгтүн: Чинй хуучин шадар сайыд надтай гэрлэх ёсон хийхгүйгээр завхайрах гэсэн тул тэрхүү заягүй амьтан ямар ч шажин үл шүтнэ гэж өөрөө хэлсэн шүү Гэсэнд хаан, "Тэгье охин минь, харин чи тэр бөгжийг эсхүл над, эсхүл Маруфт өгөгтүн" гэхэд нь охин бгүүлрүүн: "Энэ бөгж та хоёрын хэн хэнд нь байу таарахгүй Би хадгалж байва арай дээр биз. харин та хоёр муу санах явдалгүй. харин миний нас барсны дараа өөрснөө мэдээрэй гэжээ . хаан охины хэлдэг маш зөв!" гээд хргэний хамт хурал яамандаа очихоор явлаа . Тэр шөнө хааны хуучин шадар сайд, гэрлэх ёс хийлгүйгээр хааны охинтой завхайраад, эндээс лалын шашны ариун ёс алдагдах нь хэмээн цэргийн дайчдыг дуудаж, өглөө хурал яаманд цуглууд лалын шейх ламыг аашилцгаан, "Шадар сайдыг хааныг охинтой завхайрахыг юунд эс хориглов?" гэцгээхэд, шейх лам "аяа та минь, энэ заягүй хүн нэгэн айхтар бөгж эзэмдсэн учир бидний хэн маань ч үг хэлж ёадсангүй . Гагцхүү их Аллах мэднэ бизээ бид дуугүй байсугай!" гэжээ . ийнхүү ярилцан байтал хурал яаманд Хаан, Маруфийн хамт залран байтал хурал яаманд Хаан, Маруфийн хамт залран ирвээс тэд туйлын баярладаг өмнө нь сөгдөн амрыг эрсэнд хан ширээндээ залраад уг болсон хэрэг явдлыг ярьж тэдний санаа сэтгэлийг амраажээ . Хаан шадар сайдыг гянданаас авчруулан адгийн дайсан эрс ихэд таатай байжээ . даруй толгойг авч хүүрийг шатаагаад, тамд илгээвээс: Үүний булшийг Аллах боловч бүү өршөөтүгэй.

Үүрд Накир Мункир хоёртой хамт зовох болтугайхэмээсэн хүн гойдп сэцэн хэлжээ . тэгэд хаан, Маруфийг баруун гарын шадар сайд болгоод таван жил жил амар жимэр суутал хаа ертөнцөөс хальж Маруф хаан болсон атал хааны охин мө-өөхөн бөгжиг хэвээр өгсөнгүй . Энэ үес хааны хатан бие шалтгаантай бож Јайхалтай сайхан нэгэн хөвгүүн төрүүлжээ . хүү торнин таван настай хүрэхэд эх нь хүнд өвчин тусч "аяа би бээр насан эцэс болж юуны магад . үүнд хөвгүүнээ сайхан асраарай . Бас өөрийн бие ба үр хүүхдээ бодож, энэ бөгжийг сайн хадгалж яваарай" хэмээн мөнөөхөн бөгжийг сайн хадгалд яваарай Хэмээн мөнөөхөн бөгжиыг хуруунаас сугалан өгөхв Маруф: "Санаа бүү зовогтун, Аллах харж үзнэ бизээ" гэжээ . ингээд маргааш нь хатан н өөд болов. Маруф хаан нэг үдэш орд өргөөндөө хариад унтахаар хэвтэж зүүрмэглэтэл орны хажууд хүн ирж өнгийх шиг болж даруй сэрж харвал чулууг хүний муухай дүрс байхад ихэд цочиж Аллах тэнгэрийн дурдан, "Чи хэн бэ?" гэсэнд - "Битгий айгтун!" Би чиний гэргий айшхи эм Фатима байна гэхэд сайтар лавлан харваас Фатима биеэрээ мөн ажээ . "Чи хаанаас ирэв? хэн чамайг энэ гүрэнд авчрав" гэсэнд Фатима урдаас нь : "Энэ ямар улс вэ гүрэн бэ?" гээд, Энэ бол "Хитан аль Хатан хот билээ" гэхэд нь, "Би дөнгөж сая ирлээ" гэжээ . Маруф гайхаж, "Чи яаж энд ирэв" гэсэнд Фатима өгүүлрүүн: "аяа би чамтай хэрэлдэн салаад чиний мууг үзье хэмээх хорт сэтгэл төрж дээдсийн шүүхэд гомдол гаргасанд , тэд чамайг эрээд сураглаад сураг гаргасангүйд чамаас хагацав гэж гэнэт сэтгэл шимшрэн хожимдсон байжээ . Удалгүй өчүүхэн хөрөнгө нимгэрэн нимгэрсээр эцэст нь аяга хоол гуйж илдэх болоод элдэв хүний өмнө гар тосон үйлээ үзэх болжээ . Чамайг орхин одсоноос хойш шөнө болгон хоёр нүдийг хавдтал уйлж, ингэж үйл тамаа үзэж амьтны

шившиг болж явах болсон заяандаа ихэд гомдох болсон гэж мэдтүгэй" гэжээ . Фатима тэр нэг өдрөөс хойш өөрт тохиолдслн зовлонг тоочин ярихад Маруф нүдээ бүлтийтэл чагнаж бөайлаа . Фатима өгүүлрүүн: тэгээд өчигдөр гадгаш гарч гуйлга хийвээс нэг ч хүн юм хайралсангүйдп гэдэс маш их өлсөөд гэртээ харьж цурхиртал уйлбаас гэнэт хажууд нэг хүн иржь, "ай эм чи юунд уйлнам?" гэхэд нь "над миний хүссэнийг ёсоор олж өгдөг нэгэн сайн эр нөхөр байснаа одоо сураггүй алга болж хаашаа одсоныг үл мэдэх тул үйлээ эдэлж байна" гэсэнд , "Чиний эр нөхрийн нэр хэн бэ?" гэхэд нь "Түүний нэр Маруф гэдэг" гэсэнд "Ай би түүнийг мэднэ. Тэр нэгэн хотод султан хаан болжээ . хэрэв чамайг хүсвэл би хүргэж өгч чадна" гэлээ . Ай юутай сайн хэрэг билээ . намайг хүргэж өгөөч гэсэнд намайг аван нисэн ниссээр энэхүү ордны гадаа буугаад, "Энэ өргөөнд орогтун! Тэнд эр нөхрөө чинь унтаж буй" гэлээ . Ийнхүү чамтай учрав. Би нэгнІ чиний авааль гэргий тул чамайг хаян одно гэж огт бодоогүй билээ Гэжээ . Маруф өгүүлрүүн: "Би чамайг орхисоно уу? Чи намайг хөөсөн үү, чи намайг цагдаагийн түшмэлд удаа дараа гомдол мэдүүлэн цайзын гянданлд хийлгэж байсны учир ба өөрийн эрхгүй оргосон шүү дээ" гэжээ .Маруф хэхэн энэ хотын султан хаан болсон хийгээд хааны охинтой гэрлэн суутал, насан өөд болоод одоо долоон настай хөвгүүн бийг хүртэл ярилаа . Фатима өгүүлрүүн: Бид тус бүр их Аллахын тогтоосон хувь заяагаар явжээ . Одоо би нэгэнт гэмших тул чиний ивгээлийн дор амьд явахыг хүснэ . Чи намайг орхилгүй үмх мах хоол боловч буян хишиг болгон өгч байл даа хэмээн ятган ятган өгүүлтэл: Маруфийн гомдсон нь нимгэрэн өрөвдөх сэтгэл төрөөд: "Хорт муу санаа эс өвөрлөн миний дэргэл амар суувал суугтун. Хэрэв чи дээдэст элвэр мэдүүлэх мунхаг санаа үүсгэвэл даруй толгойгий чинв авна. Одоо би нэгэнт Султан хаан болсон тул гагцхүү Аллахаас өөр хэнээс ч үл эмээнэ. Басхүү би нэгэн шидэт бөгж олж авсан бөгөөд нэгэнтээ зүглэхийн төдөө Абу-Саадат нэрт зарц бэлхнээ ирж миний юу хэлснийг ёсоор гүйцэтгэнэ. Хэрэв чи төрсөн хотноо сууна гэвэл би чамд насан турш идэх мөнгө бэлхнээ өгч явуулна. Миний дэргэд сууя гэвэл тусгай өргөө, хорин шивэгчин гаргаж сайхан хувцас, сайхан хоол бэлхнээ байх тул хааны дэргэ¤ Фатима, "Би чамтай бахыг хүснэ!" гээд урьдын бурууг гэмшин Маруфийн гарыг үнэслэв. Маруф тусгай өргөө гаргаж, шивэгчин, тайган томилон хатны зэрэгт суулгав. Гэтэл Фатима, Маруфийн хүүг өөрийнх биш гэж жигшин хажиглаж үүний улмаас хөвгүүн нь , Фатимад их л дургүйы ажээ . атима бөас ихэлд хөгшрөөд могойн хатсан хальс мэт адил хожгор муухай чавганц болсон тул Маруф эс тоогоод нэгэн шивэгчинтэй сэтгэлтэй болжээ . Энэ нь бас ч Фатима, Маруфийг ихэд гомдоосонтой холбоотой билээ . "Муу үйл хүслэнгийн хөрсийг нэвтлэн зүрхний тус газар хорсол занал тарина" гэсэнтэй утга адил. Алдарсан сэтгэлийг эгүүлэхэд нэн бэрх учир Амрагийн зүрхийг анхнаас гомдоолгүй ариглагтунХос зүрхний найзын холбоо нэгэнт тасарвалХагархай шил эс бүтэн боохтой адил буюу Хэмээн мэргэн үг бий ажээ . Фатимаг эрхэм сайн сэтгэлтэй гэж Маруф хайрласан нь огь бус гагцхүү их Аллахыг бодож тийнхүү сайхан сэтгэлээр асрах ажээ ….*** *** *** Дуньязада Шахразада эгчдээ өгүүлрүүн: "Ид шидийн их увидсаас энэ үг илүү сэтгэлийг эзэмдсэн юутай гайхалтай сайхан үлгэр вэ!" гэжээ . Шахразада өгүүлрүүн: "Хаан өршөөн соёрхож амь хэлтрүүлбэл ирэх шөнө илүү сонин нь гарах билээ" гэв. Өглөө болж гэгээ орвол энэ үлгэрт хааны сэтгэл нэн я сэргээд "Энэ үлгэрийн

төгсөглийг эс сонссон цагт энэ эмийн толгойг авахгүй" гэж бодсоор хурал яаманпаа очив. Энэ өглөө хааны шадар сайд аанай бэлбэсрэлийн хувцас сугавчилсаар ирэхэд охин нь эсэн мэнд хэвэр л байжээ . хаан өдөржин хурал яамандаа сууж хэрэг зарга шийтгээд үдэш болмогц Шахразада охинл очив… мянга нэг дэх шөнө болж хаан үлгэрийг чагнахаар орж ирсэнд Дуньязада өгүүлрүүн: "аяа эг минь . Маруфийн үлгэрийн хэрхэн амар сайхан жаргасныг ярьж өгнө үү!" гэхэд нь Шахразада өгүүлрүүн: "аяа хаан зөвшөөрвөл дуртайяа ярьсугай!" гэтэл Хаан, "Үлгэрийн эцсийг сэтгэл яаран хүлээнэм. Ярь Ярь!" гэжээ . Шахразада өгүүлрүүн: "Аяа цагийг эзэлсэн их хаан минь Маруф өөрийн эхнэртэй урьдын адил дур хүслийг хангахын тул биш , гагцхүү их Аллахын санаж асрах бүлгээ . тийнхүү өөрт эс хаьтах атал өөр бус эмтэй жарган жарган буйг үзэхдээ Фатимын дотор хорсон занах сэтгэл лав төрөөд бөгжийг хулгайлан Маруфийн толгойг авч өөрөө хатан хаан болохыг хүсчээ . Тэгээд нэг шөнө өргөөнөөсөө гарч, Маруфийн ордон руу сэм очлоо. Маруф энэ үес нэгэн хосгүй үзэсгэлэнт гоо эмтэй цуг хэвтэж байсан ба татвар эмстэй ертөнцийн жаргалыг эдлэх үедээ шидэж бөгжин дээр бичээстэй алдрбг хүндлэн авч дэрэн дээр тавиад угаал хийж бие ариун болсны хойно сая зүүүдэгш болжээ . Үүний иул Маруф урьдаар мөнөөхөн татвар эмийг захиран явуулаад дараа биеийг угаах зуур ордны бүхий л үүдийг сайтар түгжих тул гагцхүү Маруф бөгжийг зүүсний хойно сая хүн орох гарах чөлөөтэй болдог байжээ .Фатима эл бүхнийг мэдэх учир Маруфийн унтаа хойгуур харагд лгүй бөгжийг авахаар гэрээс гартал Маруфийн хөвгүүн гадаалан харанхуйд дэнлүүгүй шээж багаад Фатима, эцгийн ордон тийш түргэн түргэн алхахыг үзээд "Энэ айшхи эм шөнө болсон хойно юуны учир эцгийн ордон тийш явна вэ. Лав нэгэн учир шалтгаан бий биз" гэж бодоод хойноос нь сэм дагав. Маруфийн хөвгүүн нэгэн бяцхан сэлэмтэй түүнийг эцгийн хурад яаманд очихдоо ямагт зүүх, тул эцэг нь "ай хүү минь яасан том сэлэмтэй вэ? Гагцхүү байлдаанд явж энэ сэлмээрээ хүний Iолгой авч үзээгүй нь харамсалтай" гэж хошигнон өгүүлэхэд нь хөвгүүн: "Хэзээ нэгэн цагт энүүгээр хүний толгой авч баярлуулна" гэхэд эцэг нь ихэд инээдэг байлаа .Фатима эцгийн ордонд ормогц үүдийг дэргэд нуугпан хэрхэрийг харж байснаа, "Бөгж хаана байна?" гэж амандаа үглэн эрсээр олод шүүрэн аваад гарахын зуур гартаа атга зүлгэхийг завдмагц хөвгүүн далайсан сэлмээрэ хүкүүн дундуур буулгатал айшхи эм үхэдхэн унав. Маруф сэрж, хөвгүүн нь аваль гэргийгий нь сэлэмдэн алж цус урсгаж буйг үзээд "Хүү минь юу болов?" гэсэнд хөвгүүн өгүүлрүүн: "Аяа эцэг минь, чиний сэлэм чинь том атал байлдаанд явж хүний толгой эс хяргана гэж ямагт өгшүүлдэг билээ . Би : "Хэзээ нэгэн цагт ямар нэг хүний толгойдп хяргаж, гавъяа байгуулна гэжхэлдэг билээ . Энэ удаа ёсоор болж чиний төлөөнөө үүний толгойг авав " гэжээ .Маруф хөвгүүнээс учрыг дуулаад бөгжийыг эртэл Фатима атгаад үхсэн байлаа . Маруф бөгжийг олж зүүгээд өгүүлрүүн. –"Чи ёстой миний хүү юмаа. Энэ хорт муу эмээс намайг ангижруулж өгсөн учир Аллах одоо ба хожим чамайг тэтгэн ивгээх болтугай!Эр хүний үйлсийг Аллахтэнгэро тэтгэсэн цагт Эцсийн сансанд эс хүрэх нь огтгүйАллах тэнгэр залуу насыг эс тэтгэвчАнхны хөнөөл нь даруй түүний үйлс болно Гэсэн үг бий бөгөөд энэхүү айшхи эмийг гагцхүү шунал нь үхэлд хөтөлжээ" гэлээ Маруф хэдэн хүн дуудаж Фатимаг өөр газар аваачуулж өглдөө болсон хойно карц улсаар угаал хийлгэж уй гашуудлын хувцас өмсгөж оршуулжээ . Фатимын Миср ыбалгадаас

ирсэн нь шууд үхэлд хөтлөгдсөн ажээ .Энэ нь: Насан хутгийн заяасан замаар бид явж ирлээ .Заяа тавилангийн мөрөөё хэн ч гарч чадахгүйЯмар гүрэнд ясаа тавих төөрөгтэй бол. Яавч өөр газар үхэж тэр хүн үл чадна. Сайныг мөрөөдсөөр хэзээ газарт орохыг Сайтар товлон би өөрөө эс мэднэ. Эрчүүд эрмэлзэх минь сайн юм бол уу даа . Эсхүл муу над тийш тэмүүлнэ үүГэсэнтэй адил болжээ . Маруф хаан мөнөхөн газар хагалагч тариачныг дуудуулан авчирч баруун гарын шадар сайдаар томоохон томилоод тэрхүү тариачны хосгүй үзсэсгэлэн гоо эрхмийн дээд чанарыг хадгалсан дээд төрөлт охиныг гэргий болгон авч бас хөвгүүнээ гэрлүүлээд ажргалыг эвдэж, хурлыг цуулсдуулэн охид хөвгүүдийг өнчрүүлэн хагацуулагч үхлийг иртэл амар сайхан жаргажээ . Шахразада энэ завсар хаанаас гурван хөвгүүнтэй болжээ . үлгэрийг ярьж дуустал хааны өлмийд сөхрөн өгүүлрүүүн: цагийг эзэлсэн их хаан минь би урьдын улсад учирч байсан эрІний сургамжит үлгэр мянган нэгэн шөнө ярилаа . Сүр жавхлант өөрийн их хүний өмнө өөрийн хүслийг айлтгах эрх би осон уу? гэсэнд хаан, “Аяа Шахразада минь юу хүсэхийг хэлсүгэй” гэхэд нь Шахразада асрагч тайган нарыг дуудаж гурван хөвгүүнээ авчруулсан нь нэг нь явж, нэг нь мөлхөж, нэг нь хөхөж байгаа ийм гурван сайхан хүүхэд байжээ Шахразада хааныб өлмийд сөхрөн Аяа цагийг эзэлсэн хаан минь, энэ гурван үрээ бодож намайгш цаазаар авах ялаас өршөөн хэлрүүлнэ үү! Хэрэв би алагдвал энэ гурва хөвгүүнийг сайн хүн болгох өөр эхнэр олоход бэрх болно бизээ гэсэнд хаан хөвгүүдийг элгэндээ тэвэрч уйлан ийн өгүүлрүүн: Аяа Шахразада минь, чи бол бурхан, тэнгэрсээс эмээдэг эрхэм ариун ухаан цэлмэг хүүхэн ажээ .Би чамайг энэ гурван хөгүүн төрүүлэхийн өмнө өршөөсөн билээ . Чиний эцэг, эх охин дүү, ач гуч нарыг ямагт Аллах ивээгтүгэй.Чамайг аливаад хорлогдох аюулаас Аллахын ам алдан чөлөөлье гэхэд нь шахразада тэсгэлгүй баярлан хаан чамайг Аллах тэтгэж урт удаан наслуулан жаргуултугуй гэжээ .Хааны ордон хотын дотор баяр хөөр дамжин тараад энэ шөнө хүний амьдралын бүх шөнийн дотроос өдөр мэт гэгээтэй шөнө болжээ . маргааш өглөө хаан охины эцэг болох өөрийн шадар сайдыг үнэь хувцсаар шагнаад “Чи эрхэм охиноо над өгч сэтгэлий минь уяруулсан бусдын охин хүүхдийг алагдахаас хэлтрүүсэн учир Аллах чамайг харах болтугай : Чиний охин ухаан саруул эрхэм дээд чана°ын охин бөгөөд Аллах тэнгэр Ўид хоёрт гурван хөвгүүн заяажSэ . Энэ бүхний төлөө Аллахыг агтъя гэжээ . Тэгээд бүх шадар сайд, эмир ноён, ордны түшмэлийг цөмийг үнэт хувцсаар шагнаад ард иргэдээс нэг ч мөнгө гаргуулахгүйгээр хааны сангийн мөнгөөо бүх хотыг сар гоёж чимэх зарлиг буулган бөмбөр дэлдүүлж, бүрээ татуулан их наадам наргиан цэнгэл үйлдүүлэн, бүх ядуу гуйланчин хүмүүст хааны хишиг хүртээгээд бүх дотно шадар хүмүүсийн хамтаар удтал амар сайхан жаргажээ .

- Шахрияр Шахземан хэмээх ах дүү хоёр хааны үлгэр
- Худалдаачин Бирид хоёрын үлгэр
- Загасчны үлгэр
- Гурван алимны үлгэр
- Нуруугүй хүний үлгэр
- Дурласан дурлуулсан хоёрын үлгэр
- Мэнгэт Ала-ад-Дины үлгэр
- Хар суман морины үлгэр
- Мэхт Далила эмгэн, Киарын Зей-Бак хоёрын үлгэр
- Синдбад далайчны үлгэр
- Абу-Кир, Абу-Сир хоёрын үлгэр
- Гуталчин Маруфийн үлгэр
- Шахрияр хаан, Шахразада хоёрын үлгэр ***(Төгсгөл)***

**Эх сурвалж:** www.e-pada.com
**Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf хэлбэр уруу хөрвүүлсэн:** The Weatherman http://weatherman.blog.banjig.net/

**агуу их алдаатай юм байна, засч амжаагүйг минь уучлаарай. Засах гэж эх шинээр бэлтгэх дайны ажил болох нь. Чадах ядахаараа засаад форматыг нь ядаж хүн уншихуйц дүрсэнд орууллаа.* **The Weatherman**